



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ,  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ 2020**

Улаанбаатар хот  
2021 он




МОНГОЛ УЛСЫН  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

*Мударга ёс, хөгжил дэвшилд*

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ,  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГЖИЛТ 2020**

**ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ**  
соён гэгээрүүлэх аян



# 1 БҮЛЭГ

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	6
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ .....	9
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ .....	18
АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ .....	26
НОМ, ГАРЫН АВЛАГА, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ .....	29
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР .....	33
ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА .....	34
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР .....	37
МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА .....	43
ДҮГНЭЛТ, САНАЛ .....	47

## АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ–2020

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	58
УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА .....	59
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД (ХАСХОМ МЭДҮҮЛЭГЧ)–ААС АВСАН СУДАЛГАА .....	60
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА .....	62
АВЛИГЫН ТҮВШНИЙ ГАДААД СУДАЛГААНЫ ҮР ДҮН .....	63
110 ТУСГАЙ ДУГААРТ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ .....	66
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ .....	68
АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	69

# 2 БҮЛЭГ

# 3 БҮЛЭГ

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 2020

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2020 .....	81
--	----

## МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ




*Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдцүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.*

*Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, УИХ-ын 2007 оны 07, 2008 оны 13, 2011 оны 55, 2012 оны 55, 2016 оны 51, 84, 2019 оны 67 дугаар тогтоол, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын биелэлт болон авлигын ерөнхий нөхцөл байдал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үүгээр мэдээлж байна.*



# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



## АТГ-ЫН ДЭВШҮҮЛСЭН САНАЛ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАГДАЖ БАТЛАГДАВ



Авлигад нөлөөлж байгаа хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн албаны тогтвортой байдал, иргэдийн орлого, шүүхийн хараат бус байдал, сонгууль, улс төрийн намын санхүүжилтэд дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээний үр дүнг үндэслэн УИХ-ын дарга Г.Занданшатарт авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн авлигын эсрэг дагнасан шүүх байгуулах, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, УИХ-ын гишүүдийн тангарагт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг



хэргүүдийг тодорхой хэмжээгээр мэдээлдэг байх, мэдээлэгчийг хамгаалах, олон нийтийн зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, Авлигатай тэмцэх газрын салбар, нэгжийг орон нутагт байгуулах, хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх санал хүргүүллээ. Энэхүү саналуудаас 2020 оны 05 сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т Монгол Улсын Их Хурлын гишүүний тангарагт **"...авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая..."** гэж нэмж оруулах санал хуульд тусгагдан батлагдав.



тусгах, авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх, иргэд, олон нийтийн анхаарал татсан зарим

## ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ/ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАН УИХ-Д ХҮРГҮҮЛЛЭЭ



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, УИХ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу **Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, даган гарах хуулиуд** болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулж, Улсын дээд Шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газраас санал авч, тусган Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн. Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2-т заасан бүрдүүлбэрт хамаарах Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр гүйцэтгүүлэн тайланг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлэв.

## ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРМЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДАД ХҮРГҮҮЛЭВ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгож, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батлахаар тусгасан ба Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу **"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"**-ын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэв.

Журмын зорилго нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, албан тушаалтны ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарахаас


урьдчилан сэргийлэх, энэхүү үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоход орших бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, бүх шатны Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллага, төрийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг олон нийтийн хяналтад хамруулахаар төслийг боловсруулсан.

## ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР "ЗӨРЧИЛГҮЙ" ДҮГНЭГДЭВ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитаар **"ЗӨРЧИЛГҮЙ"** дүгнэгдэж, төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган, Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээ, тайланг хуулийн хугацаанд байршуулан ажиллалаа.



## ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ "ХУР" СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭЭ




Хайлт лавлагааны нэгдсэн системийн мэдээлэл солилцох арга, технологийг шинэчлэх, байгууллага хооронд мэдээлэл дамжуулах технологийн нууцлалыг хангах шаардлага үүссэнтэй холбогдуулан мэдээлэл дуудах сервисүүдийг "ХУР" системд шилжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Байгууллагад ашиглаж байгаа 52 сервисийг "Үндэсний дата төв" УТҮГ-т хүргүүлэн, "ХУР" системд бэлэн байгаа 20 сервисийг хүлээн авч, хайлт лавлагааны нэгдсэн програмтай нийцүүлэв.

Хур системтэй холбосноор Улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэний төрөлт болон төрөл садангийн лавлагаа, эд хөрөнгийг хаягаар хайх, эд хөрөнгийн түрээсийн гэрээний мэдээлэл, өмчлөх эрх шилжүүлсэн мэдээлэл, эд хөрөнгийн барьцааны мэдээлэл зэрэг мэдээллийг үйл ажиллагаанд саадгүй ашиглах боломжийг бүрдүүлэв.



## БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ

Авлигатай тэмцэх газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилттой уялдуулан “Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө (2020-2023)”-г баталлаа. АТГ-ын стратегийн зорилгууд нь өөр хоорондоо нягт уялдаатай хэрэгжинэ.



## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭЖ АВАХ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ПРОГРАММ ШИНЭЧЛЭГДЭВ

Үндэсний статистикийн хорооны 2019 оны А/189 дүгээр тушаалаар баталсан зөвшөөрлийг үндэслэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 30, захиргааны 6 маягт, гэмт хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ, тоо бүртгэлийн журмыг баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өргөдөл, гомдол, бичиг хэрэг, гэмт хэргийн мэдээллийн шинэчлэгдсэн программыг ажиллагаанд оруулсан.

Энэхүү тушаал батлагдсанаар Авлигатай тэмцэх газар 2020 оноос өргөдөл, гомдол, гэмт хэргийн улсын хэмжээний статистикийг албан ёсоор бүрдүүлэх боломж бүрдлээ.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДСАНД ҮНЭЛГЭЭ ХИЙВ

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан шаардлагуудын дагуу аргачлал боловсруулан 14 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийж, үр дүнг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлэв.


Хуулиар хүлээсэн үүрэг буюу мэдээлбэл зохих мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэхийг тухайн байгууллагын онцлог, чиг үүргээс хамаарч яамдыг 41, аймгийг 38 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд яамдын цахим хуудасны дундаж үнэлгээ 59,7, аймгуудынх 52,5 байна. Үнэлгээнд хамрагдсан 34 байгууллагын 21 нь буюу 61,7 хувь нь 60-аас доош оноотой үнэлэгдсэн нь Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлж байгааг харуулж байна.

Яамдын цахим хуудасны үнэлгээ



Яамдын цахим хуудсанд дахь мэдээлэлтэй танилцахад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулдаггүй, эрх, зөвшөөрөл олгож буй шийдвэр, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгааныг байршуулаагүй байна.

Аймгуудийн цахим хуудасны үнэлгээ



Аймгуудын авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, хүсэлтийг хүлээн авах болон иргэд аж ахуйн нэгжээс өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөл, боломжийг бүрдүүлээгүй, эрх

бүхий байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалт, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл, журмын хамт байршуулаагүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлээгүй зэрэг зөрчлүүд түгээмэл байна.

## ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЯНАН ҮЗЭЖ БҮХЭЛД НЬ БОЛОН ХЭСЭГЧИЛЭН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ АВАВ

Төрийн байгууллага, албан тушаалтны батлан гаргасан 18 дүрэм журамд авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал үүсгэх эрсдэл байгаа эсэхийг хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгуулах талаар санал зөвлөмж, боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Авлига гарч болох шалтгаан нөхцөлийг бүрдүүлсэн, хүнд суртал чирэгдэл, учруулсан, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх, эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй зэрэг чиглэлд бүхэлд нь хэсэгчилэн хүчингүй болгох санал, зөвлөмж хүргүүлээ.

- **Монголбанкны Ерөнхийлөгчийн** 2008 оны 316 дугаар тушаалаар баталсан “Монголбанкнаас банк, банкны ажилтнуудын үйл ажиллагаатай холбогдсон эрүү, иргэний хэрэгт магадлан шинжилгээ хийх журам”-ыг бүхэлд нь хүчингүй болгуулав.
- **БСШУСЯ-наас боловсруулсан** “Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам”-ын төсөл;
- **Монгол Улсын Засгийн газрын** 2012 оны 115 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”;
- **Нийслэлийн Захирагчийн ажлын алба болон 9 дүүргээс** “Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-аар тогтоосон төлбөрийн хэмжээ, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн баталсан журмууд;
- **Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын** 2019 оны А/146 дугаар тушаалаар баталсан Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс хураагдсан баялаг, эд зүйлийг шийдвэрлэх журам;
- **Гаалийн байгууллагын** “Гаалийн тусгай бүсийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”, “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”, “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”, “Гаалийн хяналтын бүсийн журам”, “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”, “Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх заавар”, “Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох журам”;
- **Эрчим хүчний яам** болон Диспечерийн үндэсний төвөөс хэрэглээний цахилгааны төлбөрийг тогтооход шаардлагатай дүрэм, журмууд;
- **Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас** “Төсөвт байгууллагын ахлах нягтлан бодогч нарыг томилох, чөлөөлөхдөө Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай зөвшилцөх санал авахад баримтлах журам”;
- **Зам, тээврийн хөгжлийн яам** “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын төсөл;
- **ХХААХҮ-ийн сайдын** “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл”, “Сонгон шалгаруулах журам”-ын төсөл;
- **Эрүүл мэндийн сайдын** 2006 оны 279 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Өдрийн эмчилгээ хийх журам”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А243 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн байгууллагуудын эмнэлэг хяналтын комиссын дүрэм” зэрэгт хэсэгчилэн хүчингүй арга хэмжээ авав.

## АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР САЛБАР, БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАВ

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр **10 салбарт** буюу Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Бүртгэл хяналтын төв, Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Налайх, Багануур дүүрэг, Төв аймгийн Заамар суманд ажиллав. Тухайлбал:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгодог зарим төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын 19 төрлийн эрхийн гэрчилгээ олгоход баримталдаг хууль тогтоомж, дүрэм, журам, Засгийн газрын тусгай сан болох Байгаль орчин, уур амьсгалын сангийн үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгийн захиран зарцуулалтын байдал, тус яамны харьяа “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ, “Монгол Ус” ТӨҮГ, “Монгол кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮҮГ-уудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний биелэлтийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний давхар ажил эрхлэлтийн байдлыг судлан тогтоохоор Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг гуравдугаар шатлалын хоёр эмнэлэгт давхар ажил эрхэлж буй байдалд дүн шинжилгээ хийв. Судалгаанд 2501 эмнэлгийн ажилтныг хамруулснаас 28 эмч, ажилтан давхар ажил эрхэлж байгааг тогтоож, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоо, үр ашигтай байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг “Хууль тогтоомж, бодлого судлалын төв” ТББ-тай хамтран зохион байгуулав.

Биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ашигт малтмалын олборлолт явуулж байгаа хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр Төв аймгийн Заамар суманд ажиллав.



Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төвд ажиллаж Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын баталсан 2019, 2020 оны тушаал, шийдвэр, байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагаа, байгууллагын захиалгаар гадаадад суралцагчдыг сонгон шалгаруулах, ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэх, тэтгэмж, урамшуулал олгох үйл явц, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтнуудын үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан давтамж зэргийг судлан дүн шинжилгээ хийв.

Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах орон нутгийн комиссоос гаргасан хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг магадлан шийдвэрлэх үйлчилгээнд хяналт тавьж ажиллав.

Нийслэлийн захирагчийн ажлын албаны харьяа Хог хаягдал, удирдлагын хэлтэст ажиллаж, хог, хаягдал, золбин нохой, муур устгал, сэг зэмийг зайлуулах ажилд зориулсан төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны процесст хяналт тавьж ажиллав.



## ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ, ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД АВЛИГЫН ЭРСДЭЛ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАВ

Дэлхий нийтэд тархаад байгаа “Ковид-19” вирусны халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд зориулж Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд бэлэн мөнгө, эд материал өгөх, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх зэрэг хандивыг Улсын онцгой комисс, эрүүл мэнд, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудад сайн дурын үндсэн дээр өгч буй байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх шаардлага тулгарч байгаа зэргийг харгалзан холбогдох дараах байгууллагуудад Зөвлөмж хүргүүлэв.



**Улсын онцгой комисс**



**Засгийн газрын Хэрэг эрхлэх газар**



**Эрүүл мэндийн яам**



**Сангийн яам**



**Онцгой байдлын ерөнхий газар**



**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар**



**Нийслэлийн Засаг дарга**

### Зөвлөмжид:


- ❖ Хандив, тусламжийн хөрөнгийг бүртгэх, зарцуулах гүйцэтгэлийг тайлагнахтай холбоотой арга хэмжээ зохион байгуулах;
- ❖ Орлого, зарцуулалтын талаар олон нийтэд нэг эх сурвалжаас мэдээлэл авах боломжийг олгох, үнэн зөв мэдээллээр хангах;
- ❖ Шийдвэр гаргах түвшний албан хаагчдад давуу байдал бий болгохоос сэргийлэх;
- ❖ Хандив, тусламжийн хөрөнгийг зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан авах зохицуулалтыг баримтлах;
- ❖ Хандивыг хүлээн авах, захиран зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөх;
- ❖ Тендер сонгон шалгаруулалтад ил тод байдлыг хангах, тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй нөхцөлд шууд гэрээ байгуулсан этгээд буюу гүйцэтгэгч нь улс төрд нөлөө бүхий этгээд болон түүний хамаарал бүхий этгээд биш байхад онцгойлон анхаарах, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх зэрэг асуудлыг тусгав.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЖ, ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙВ

Төрийн байгууллагуудад хяналт шалгалтаар ажиллах явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох ажлыг эрчимжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 байгууллагад 111 асуудал бүхий Зөвлөмж боловсруулан хүргүүлэв. Тухайлбал:

Нийслэл, яам, агентлаг, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох зэрэг ажлыг эрчимжүүлэх шаардлагатай нөхцөл байдал тогтоогдсон тул Монгол Улсын Ерөнхий сайд болон 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарт 7 асуудал бүхий зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 21 аймгаас гаргуулан авч биелэлтэд дүн шинжилгээ хийхэд хэрэгжилт дунджаар 71.53% биелэлттэй байна. Дархан-Уул аймаг зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлсэн бол Баян-Өлгий аймаг хангалтгүй үнэлгээ авсан.



Зөвлөмжид хэм хэмжээний актыг хуулиар эрх олгогдсон эрх бүхий этгээд тогтоож байх, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй явуулах, цахим хэлбэрт шилжүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдлыг хангах, Сум хөгжүүлэх санд тавих олон нийтийн хяналтыг бий болгох, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шийдвэрлэхэд эцсийн өмчлөгчийг бүрэн тодорхойлох, эцсийн өмчлөгчийг бүртгэхдээ татвар болон бүртгэлийн байгууллагын хамтын ажиллагааг уялдуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх оновчтой зохицуулалтыг бий болгох, өөрийн чиг үүрэгт хамаарах

өргөдөл, гомдлыг бусад руу шилжүүлэхгүйгээр шийдвэрлэж эцсийн хариуг өгдөг байх, төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх хуулийн зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, орон нутгийн өмч, хөрөнгө, төсөв, мөнгө, хүн хүчийг улс төрийн болон сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байх зэрэг асуудлыг тусгасан.

Авлигатай тэмцэх газраас байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэхдээ зөвхөн илэрсэн зөрчлийг арилгахаар үл хязгаарлан цаашид гарч болзошгүй эрсдэлийг тооцож, түүнээс урьдчилан сэргийлэх талаар арга зүйн зөвлөгөө өгөхийг зорьж ажиллалаа.



Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль болохтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасныг үндэслэн сонгуульд оролцох **Улс төрийн нам, эвсэл** (8 асуудал бүхий), **нэр дэвшигч** (6 асуудал бүхий), **Сонгуулийн ерөнхий хороо** (10 асуудал бүхий)-нд тус тус Зөвлөмж хүргүүлэв.



Хүнд суртал, чирэгдэлтэй төрийн үйлчилгээг тодорхойлох ажлын хүрээнд нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст ажиллаж, өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох үйлчилгээний чанар, хүртээмжийг судлан үзэж зарим үйлчилгээний чиглэлээр хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулах, удирдлагын санал санаачилгыг сайжруулах, үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг бууруулахтай холбогдох 6 зүйл бүхий Зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах, хэрэгжилтийг хангуулах талаар Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газарт 6 асуудал бүхий зөвлөмж хүргүүлэв.



Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх, нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад 12 асуудал бүхий зөвлөмж хүргүүлэв.



Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төвийн автомашины улсын дугаар

олголт, бүртгэлийн үйл ажиллагаа, холбогдох журам, дүрэмтэй танилцаж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тогтоож, хяналт шалгалтын мөрөөр гарсан зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцов.

Уг ажлын үр дүнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/222 дугаар тушаалаар «Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам»-ыг бүхэлд нь шинэчлэн баталж, ингэснээр автотээврийн хэрэгслийн **«азын» гэх тодотголтой улсын дугаарыг нээлттэй цахим дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр боллоо.**

*ЗТХЯ, АТҮТ-д зөвлөмж хүргүүлсний дүнд импортоор орж ирж буй автотээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгийн төлбөрийг давхардуулан тогтоосноор жилд дунджаар 30 орчим тэрбум төгрөг иргэд, аж ахуйн нэгж төлөх байсныг илрүүлэн, таслан зогсоов.*



Сонгинохайрхан дүүргийн Газрын албаны үйл ажиллагаан дахь авлига, ашиг сонирхлын

зөрчил гарах шалтгаан нөхцөл, үйлчилгээний хүнд суртлыг тогтоох чиглэлээр ажиллаж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 6 асуудал бүхий зөвлөмжийг, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд тус тус хүргүүлсэн.

## МӨРДӨГЧИЙН МЭДЭГДЛИЙН МӨРӨӨР АЖИЛЛАЖ, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ

Мөрдөгч нь авлигын гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоож тэдгээрийг арилгуулахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлд заасны дагуу мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлдэг. Мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, аж ахуйн нэгж 1 сарын хугацаанд гүйцэтгэсэн ажил, арга хэмжээний талаар хариу ирүүлэх үүрэг хүлээдэг.

Авлигатай тэмцэх газрын албан хаагчид 2020 онд 18 мэдэгдлийн мөрөөр газар дээр нь ажиллаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаарх зөвлөмжийг хүргүүлэв.



**Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт** (8 асуудал бүхий)

**Налайх дүүргийн цагдаагийн хэлтэст** (3 асуудал бүхий)



**Чингэлтэй дүүргийн цагдаагийн газарт** (6 асуудал бүхий)

**Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1 болон 3 дугаар хэлтэст** (5 асуудал бүхий)



**Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт** (5 асуудал бүхий)



**Төв аймгийн Сэргэлэн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт** (7 асуудал бүхий)

Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр арга зүйн туслалцаа үзүүлэх, албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, чадавхжуулах, үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, биелэлтийг тооцож байна.

## ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАВ



# 110

Авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах “110” тусгай дугаарт ирүүлсэн хүнд суртлын мэдээллийн мөрөөр Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Автотээврийн үндэсний төв, Драгон нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, Баянгол дүүргийн ЗДТГ, Ерөнхий боловсролын 65, 52 дугаар дунд сургууль, СХД-ийн 4, 9, 22,43 дугаар хороо, БГД-ийн Эрүүл мэндийн төв, БЗД-ийн 128 дугаар цэцэрлэг, ЧД-ийн 6 дугаар хороо, БГД-ийн Эрүүл мэндийн хөгжлийн төв, Налайх дүүрэг, СБД-ийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Захирагчийн ажлын албаны харьяа Хог хаягдал, удирдлагын хэлтэс, Нийслэлийн Хүрээ амаржих газар, Орон сууц, нийтийн аж ахуйн 10 дугаар төв, ЧД, СХД, БЗД-ийн Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг нийт **21 байгууллагад** ажиллаж, иргэдэд хүнд суртал, чирэгдэл учруулсан нөхцөл байдлыг тогтоож, зөрчлийг арилгуулахаар зөвлөмж, албан бичиг хүргүүлсэн. Тухайлбал,



Сонгинохайрхан дүүргийн 9, 4, 22, 43 дугаар хорооны албан хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүнд суртал гаргаж, иргэдэд чирэгдэл учруулж байна гэх мэдээллийн дагуу дээрх хороодод ажиллаж, зөрчил дутагдлыг арилгуулах, төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хүнд суртал, ёс зүйн зөрчил гаргуулахгүй байх чиглэлээр ажил арга хэмжээ зохион байгуулах зөвлөмжийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн, биелэлтийг тооцож ажиллав.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэдэд үйлчилгээ үзүүлж буй улсын бүртгэгчид иргэдтэй зүй бус харьцдаг, ёс зүйн зөрчил гаргаж байна гэх гомдол, мэдээлэл удаа дараа ирсэн. Зөрчил үүсэх боломжийг бүрдүүлсэн шалтгаан нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас ийм төрлийн зөрчилд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, салбарын хэмжээнд ёс зүйн зөрчилд хариуцлага тооцдоггүй, хяналт шалгалтын нэгжийг ажиллуулдаггүй нь тогтоогдсон.

## ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАВ

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх” -өөр заасан.

Энэ хүрээнд 21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны тайланд дүн шинжилгээ хийлээ.



Завхан, Сүхбаатар, Орхон, Говьсүмбэр аймгууд авлигын эсрэг чиглэлээр огт арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүй байна.

Салбар зөвлөлүүд авлигын эсрэг аян зохион байгуулах, сургалт хийх, сурталчилгааны материал түгээх, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн өмчит компаниудын дунд зөвлөгөөн зохион байгуулах, зөвлөмж хүргүүлэх, судалгаа авч дүн шинжилгээ хийх, хууль хяналтын байгууллагууд “Санамж бичиг” байгуулан төр, нийтийн эрх ашиг зөрчигдсөн, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, гэмт хэргийн болон захиргааны зөрчлийн шинжтэй санхүүгийн зөрчлийн талаар мэдээлэл солилцох, хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүд хэрэгжүүлсэн байна.

Салбар зөвлөлүүдэд авлигын гэмт хэрэг, зөрчил, шийтгэлийн талаарх мэдээллийн бааз бий болгох, ил тод байдлыг хангуулах, хууль бус шийдвэрүүдэд хяналт тавих, хамаарал бүхий этгээдийн бүртгэл, давхар ажил эрхлэлтийн судалгаа бий болгох, төрийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болгох арга механизм бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах санал хүргүүлэв.



## ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД ЗОХИОН БАЙГУУЛАВ

Дэлхий нийтийг хамарсан цар тахал тархаж, онц байдал зарлан, хөл хорио тогтоож, танхимаар сургалт, сурталчилгаа явуулах боломжгүй цаг үед төлөвлөсөн хэлэлцүүлгүүдийг цахим хэлбэрээр зохион байгуулав. Цахим хэлэлцүүлгүүдийг ажил хэрэгч, эргэх холбоо бүхий, олон нийтийн оролцоог ханган, үр дүнг эргэн тооцох боломжтой байдлаар зохион байгуулахад онцгой анхаарч ажиллав.



“Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлж, 15 байгууллагын төлөөлөл оролцуулан үр дүнг хэлэлцүүлэв. Төрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх үйл явцыг

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэв.

гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх харилцааг зохицуулсан эрх зүйн орчин, гадаадын зарим улсын эрх зүйн тогтолцоо, туршлагыг судлах, үүний үндсэн дээр бодит байдлыг тодорхойлох зайлшгүй шаардлага бий болсныг үнэлгээний үр дүн харуулж байна.

Үнэлгээний үр дүнг холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлснээр нөхцөл байдлыг олон нийтэд хүргэх цаашдын бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлох, санал зөвлөмжийг нэгтгэхэд чухал ач холбогдолтой боллоо.

2020.11.25

Олон улсын авлигын эсрэг өдрийг тохиолдуулан цаг үеийн онцлог, хүндрэлтэй нөхцөл байдал, түүнтэй холбогдон үүсч байгаа авлигын эрсдэлийг хөндсөн **“Ковид ба Авлига: Иргэдийн чөлөөт индэр”** цахим хэлэлцүүлгийг иргэний нийгэм, мэргэжлийн холбоод, судлаачдын дунд зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үр дүнд авлигын гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байгууллагуудад хугацаатай зөвлөмж өгөх, цугларсан хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад хамтран хяналт тавих, худалдан авах ажиллагаанд зориулан тусгайлсан зөвлөмж боловсруулж, төрийн байгууллагуудад хүргэх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор мэдээлэл байршуулах заавар боловсруулахаар тогтож, холбогдох арга хэмжээг зохион байгуулж байна.



2020.12.09



“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлгийг нийгмийн халамжийн үйлчилгээний салбарын мэргэжилтнүүд болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 аймгийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хийв. Энэ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт сайн байх нь ирээдүйд илүү үр дүнтэй нийгмийн халамжийн үйлчилгээ хэрэгжүүлэх боломжийг олгоно.

чиглэлийн ажлын үр дүнгийн үнэлгээ өмнө нь хийгдээгүй тул эцсийн үр дүн ямар байгаа, хэрхэн сайжруулж болох тал дээр ойлголт багатай байгаа нь судалгааны дүн болон хэлэлцүүлэгт оролцогчдын байр сууриас харагдаж байна. Иймд санал зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

2020.12.08



2020.05.15

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт хөнгөлөлттэй зээл олгохоор төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах ажиллагаатай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран **"Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор төрөөс олгож байгаа санхүүжилтийн үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах нь"** сэдэвт цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. Сургалт, хэлэлцүүлэгт Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон 21 аймгийн Хөдөө, аж ахуйн газрын төсөл сонгон шалгаруулалтын хороо, дэд хорооны бүрэлдэхүүнүүд оролцож учирч буй хүндрэл бэрхшээлийг арилгахаар хамтран ажиллаж байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ, ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ТАЛААР СУДЛАН ШИНЖЛЭВ

Төрийн улс төрийн, төрийн захиргаа, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний байгууллага салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа ёс зүйн дүрмийг судлан, ёс зүйн хорооны ажиллагаа, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийв. Тухайлбал, УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм, боловсролын салбарт мөрдөж буй ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын байцаагчийн ёс зүйн дүрэм, 21 аймгийн Ёс зүйн хороо, зөвлөлийн үйл ажиллагааны тайлан мэдээ, ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлээ.

Авлигын эсрэг хуулийн 6.1.9-д заасны дагуу Татварын албан хаагчийн ёс зүйн дүрмийн төсөл, "Дулааны цахилгаан станц-2" ТӨХК, "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ, "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан"-ийн ажилтны

дагаж мөрдөх ёс зүйн дүрмийн төслийг хянаж, санал хүргүүлэв.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийн 6.1-д "Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэд ажиллана" гэж заасны дагуу ёс зүйн зөвлөл байгуулсан эсэхийг нягтлан үзэхэд 2020 оны байдлаар 64 төрийн байгууллага Ёс зүйн зөвлөл, бүрэлдэхүүнээ байгуулсан байв. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн дарга, ёс зүйн асуудал хариуцсан ажилтны мэдээллийг нэгтгэн сан үүсгэв.

## "ЭРҮҮЛ БИЕ-ЭРҮҮЛ НИЙГЭМ" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

"Эрүүл бие-Эрүүл нийгэм" авлигын эсрэг соён гэгээрүүлэх аяныг "Үнэгүй фитнес" Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулав.

Энэ удаагийн арга хэмжээнд 10 багийн 100 иргэнийг хүсэлтээр нь сонгож, авлигын эсрэг үзлийг төлөвшүүлэх, шударга ёс, зөв дадал зуршил, эерэг хандлагын талаар мэдлэг олгох 10 төрлийн буухиа тэмцээнийг зохион байгуулж, иргэдэд авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, авлигын эсрэг үйл ажиллагаан дахь иргэний оролцоо, төрийн үйлчилгээнд хяналт тавих боломжийн талаар ухуулан таниулав.

Тус арга хэмжээг нэгэн зорилготой иргэдийн бүлгийн дунд зохион байгуулсан нь иргэдийн оролцоо, арга хэмжээний үр дүн, ач холбогдол өндөр байхад эерэгээр нөлөөлсөн төдийгүй



оролцогчдоос Авлигатай тэмцэх газрын талаар бодитой мэдээ, мэдээллийг сонирхолтой, байдлаар олж авч, иргэд, олон нийтээс авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өргөн хүрээнд оролцох, хамтран ажиллах боломж байгааг ойлгосноо илэрхийлж байв.

## СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгууллаа. Авлигын эсрэг сурталчилгааг видео болон радио контент, зурагт хуудас, нугалбар, подкаст, үзүүлэн таниулах хуудас, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл, орон нутаг дахь сурталчилгаа, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэцийн, цахилгаан шатны сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл хэлбэрээр бэлтгэн, түгээв.

### ИЛТГЭХ УР ЧАДВАРЫН НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАВ

Авлигатай тэмцэх газар, “Залуус өөрчлөлтийн төлөө” үндэсний хөдөлгөөн, “Хуулийн хөтөч” клуб хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд **“NEW GENERATION-NO CORRUPTION”** илтгэх ур чадварын нээлттэй тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулав. Уралдаанд оролцогчид бие даан нийгмийн харилцаанд оролцох, нийгэм дэх авлига, хүнд суртал зэрэг сөрөг үзэгдэлд шүүмжлэлт байдлаар хандах, асуудлыг танин мэдэх, шийдвэрлэх арга зүй, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээрээ ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Тэмцээнд нийт 125 сурагч видео бичлэг ирүүлж оролцлоо.



### “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХАКАТОН” ЗОХИОН БАЙГУУЛАВ



шилдэг бүтээл шалгарав. Энэхүү арга хэмжээ нь мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах ач холбогдолтой боллоо.

“Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал хакатон”-ыг 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд оролцогчид орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сантай холбоотой өгөгдөлд суурилан дүн шинжилгээ хийж үр дүнг танилцуулсан. Нийт 10 багаас 4

## БАГАЧУУДАД ЗОРИУЛСАН КОНТЕНТ БҮТЭЭВ

Бага насны хүүхдэд зориулсан шударга ёс, зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор “Шударга тоглоё” хүүхэлдэйн зохиомж, дунд сургуулийн сурагчдад зориулан “Шударга ёс” цувралын эхний анги болох “Хичээл дээр” теле зохиомжийг мэргэжлийн уран бүтээлчидтэй хамтран бүтээв.



## ХҮҮХДИЙН КИНО ЗОХИОЛЫН УРАЛДААН ЗАРЛАВ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Шударга ёс” хүүхдийн цуврал кино зохиолын уралдаан зохион байгуулав. Уралдаанд нийт 250 зохиол ирснээс ажлын хэсэг сонгон шалгаруулж, ялагчдыг тодруулав.


Хүүхэд багачуудыг зөв, шударга, хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн “Шударга ёс” богино хэмжээний киноны үргэлжлэл болох 2-р ангийн зохиол бичих уралдааны 8-11 насны ангилалд тэргүүн байр

эзэлсэн “Ирээдүй цогцолбор” сургуулийн 5-р ангийн сурагч, 11 настай М.Энхжингийн “Шударга ёс”, “Гар утас” зохиолоор богино хэмжээний цуврал кино контент бүтээж байна.

## АВЛИГЫН ЭСРЭГ СУРТАЛЧИЛГААНД УРЛАГ, СПОРТЫН ТӨЛӨӨЛЛИЙГ ОРОЛЦУУЛЛАА

Авлигын хор аюулыг ойлгуулах, шударга ёсны үйл хэрэгт уриалах, дуу хоолойгоо хүргэх чиглэлээр урлаг, спортын одод, алдартнуудтай нийгмийн хариуцлагын хүрээнд “Үр” богино хэмжээний кино, “Төрийн албан хаагч танаа”, “Шударга ёсны үнэ цэнэ”, Авлигын шилэн бөмбөлөг”, “Авлигын эсрэг улам олуулаа нэгдье” контент, авлигыг мэдээлэх 110 утасны сурталчилгаа, шторк бүтээж хамтран ажиллав.

Тухайлбал, жүжигчин Б.Амарсайхан, Ц.Цэрэнболд, С.Ариунбямба, Н.Ялалт, Г.Эрхэмбаяр, Р.Адъяа, хөлбөмбөгийн тайлбарлагч Б.Балжинням, “Аяллын тойрог” нэвтрүүлгийн хөтөлөгч Г.Ган-Өлзий, хөтөлөгч Э.Номин-Эрдэнэ, сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчид зэрэг олны танил хүмүүсийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд оролцууллаа.



## “ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ”



### СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЯНЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2020 оны авлигын эсрэг олон улсын өдрийг “RECOVER WITH INTEGRITY” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэв.

Дэлхийн улс орнууд нөөц боломжоо дайчлан цар тахалтай тэмцэж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллаж байгаа ч зарим улс орон шуурхай үр дүнд хүрэхийн тулд хуулийг сахин биелүүлэх, хэрэгжилтийг хянах ажлыг түр хойш тавьсан нь авлигын гэмт хэрэг гарах нөхцөлийг нэмэгдүүлдэг байна. Тиймээс НҮБ энэ онцлогийг харгалзан үндсэн уриандаа нэмэлт болгон “ВИРУСИЙГ ДАРЪЯ. АВЛИГЫГ УСТГАЯ” хэмээх уриаг дэлхий дахинаа тунхаглалаа.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар “ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ” соён гэгээрүүлэх аяныг

*“Зөв зөвд шударга зөв*

*Зөөлөн зөөлөнд эе зөөлөн”*

*Монгол ардын зүйр цэцэн үг*

НҮБ-ын уриа бүхий кампанит ажлын зорилттой уялдуулан иргэд, олон нийтэд чиглэсэн олон талт арга хэмжээ зохион байгуулав.

Аяны хүрээнд сэтгүүлчдийн дуу хоолойг нэгтгэх, хүүхэд залуучуудын оролцоог өрнүүлэх, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хүсэл зоригийг сонсох, цахим хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг нийгмийн салбар бүрд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэв.

Цар тахалтай тэмцэж буй энэ цаг үед “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь иргэд, олон нийтийн оролцоог бүрдүүлэхэд сошиал орчин дахь уриалга, дуу хоолой, дэмжлэг бодит хувь нэмэр болж чадсан хэмээн үзэж байна.

**Зөв зөвд ШУДАРГА ЗӨВ**  
— соён гэгээрүүлэх аян



“Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд олны танил эрхмүүдээс шударга ёсны талаарх ойлголт, үзэж бодлыг нь сонслоо.

### Шударга байх гэдгийг та юу гэж ойлгодог вэ?

**Ардын багш, хэл бичгийн ухааны доктор, профессор Ц.Өнөрбаян:** Шударга байвал юунд ч ялагдахгүй гэдэг сэтгэлгээ Монголчуудын үе үеийн нийгэм соёлын хандлага, хүний үнэлэмжийн дээд цэг байсаар ирсэн.

Өнөө цагт амьдрал дээрх шударга бус явдлын тухай үй түмэн зүйл ярьдаг хэр нь түүнийгээ дээрээсээ доош хүртлээ засаж чадахгүй байна. Бид зөвхөн дээд талд байгаа шударга бусыг хараад байдаг. Гэтэл энэ шударга бус байдал чинь доороосоо дээшээ халддаг зүйл.

**Эрдэнэзуу хийдийн Хамба лам Х.Баасансүрэн:** Жинхэнэ шударга ёс гэдэг хүний дотор оршдог. Гэтэл өнөөдөр дотроо худал, хуурмаг хэр нь гаднаасаа шударга харагдах гэж их хичээдэг болж. Жинхэнэ шударга байхын тулд дотроосоо, хүн талаасаа зөв байх ёстой байх

**Иргэн Б.Болороо:** Шударга байдлыг хөхиүлэн дэмжих зүйл нь хүний эрхэм чанар, нэр төр, ёс суртахуун, өөртөө үнэнч байдал юм даа.

**Комедиан Б.Идэр-Од:** Шударга ёсны мэдрэмж гэдэг зүйл нарийссаар хууль болдог. Хууль гэдэг бол нийгмийн дундаа барьдаг гэрээ, заасан хил хязгаар юм.

Нэгдүгээрт, хуулиа дээдлэх нь шударга ёсны эхний шат болно. Дараа нь хувь хүний ёс зүй, хуулинд заагаагүй ч бүгд мөрддөг, хэнийг ч хохироож болохгүй гэсэн үндсэн зарчмыг барьж амьдрах нь шударга ёс гэж боддог.

**Зохиолч, сэтгүүлч Б.Наминчимэд:** Шударга ёсыг хүн хамгийн түрүүнд өөрөөсөө л нэхэх ёстой юм билээ. Тэгэж чадахгүй бол, тийм эр зориг, тэвчээр, золиос гаргаж чадахгүй бол бусдаас нэхэж буй шударга ёсны нэхэмжлэл бүхэн өөрөө шударга бус явдал болдог.

**Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Цогтсугар:** Зөвийн талд тууштай зогсох эр зориг гэж ойлгодог. Хүн эхлээд өөртөө шударга үнэнч хандаж, өөрийнхөө төлөө үнэнч зүтгэж сурах хэрэгтэй.

# “ШУДАРГА ТОГЛОЦГООЁ”

## БҮЖГИЙН ЧЕЛЛЕНЖ ӨРНҮҮЛЭВ



“Зөв зөвд шударга зөв” аянд аймаг, нийслэлийн сургууль, цэцэрлэгийн багш, сурагч, эцэг эхчүүд нэгдэн оролцож, хүүхэд багачуудад зориулан бэлтгэсэн “Шударга ёс: Хичээл дээр..”, “Шударга тоглоё” видео контентоор “Зөв зөвд шударга зөв” #шударгатоглоцгооё бүжгийн челленж өрнүүлэн сошиал уралдаанд оролцлоо. Энэхүү уралдаанд оролцсон 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын 716 сургууль, 710 цэцэрлэгийн багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүд өөрсдийн дуу хоолой, бүжгээр шударга ёсыг илэрхийлсэн бичлэгүүдийг сошиалд түгээж сурталчлав.





# "ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ" СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЯН





Бөтөлгө Ажилтнуудын дуудлагаар Зөв Зөвд Шударга Зөв Коронавирус халдварт нийгмийн өвчин бол "Аалига" нийгмийн хорт халдвар юм. Хүүхдийнхээ төлөө ирээ... See More





## “GOOD HABITS 20” БУЮУ “ЗӨВ ДАДАЛ 20” ДИЖИТАЛ ЧУУЛГАНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулганыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Дижитал хэлэлцүүлгийн илтгэгчээр нийтлэлч, эдийн засагч Д.Жаргалсайхан, хүний эрхийн активист, зохиолч Ц.Оюунгэрэл, “Сайн сургуулийг таны дэргэд” ТББ-ын тэргүүн П.Наранбаяр, “Үнэгүй фитнес” ТББ-ын удирдах зөвлөлийн дарга

Л.Саруулбат, топ модель Э.Энхболд, рэппэр Big Gee, комедиан Н.Амаржин нар оролцов.

Зөв дадлаар өөрсдийн амжилтыг бүтээсэн салбар салбарын төлөөлөл, соён гэгээрүүлэгч, зочин илтгэгчид өөрсдийн зөв дадлаа хуваалцаж залуусыг шударга ёсны үнэ цэн, зөв хандлагад уриалсан юм. Бодол үг болж, үг үйлдэл болж, үйлдэл дадал болж, зөв дадлыг хэвшүүлсэн цагт хэрхэн амжилтад хүрч болдог талаарх илтгэгчдийн онцлох ишлэлийг хүргэж байна.



### Нийтлэлч, эдийн засагч Д.Жаргалсайхан

... Дэлхийн тал хувь нь мөрөөдөөд ч олж авч чадахгүй байгаа ардчилал, хүний эрх, чөлөөт зах зээл гэсэн гурван үнэт зүйл Монголд бий. Үүнийгээ хэзээ ч алдаж болохгүй. Муу засаглал, авлигаас болоод бид эдгээр үнэт зүйлээ үл ойшоон устгах гээд байгаа нь харамсалтай. Гэвч хэзээ нэгэн цагт шударга ёс ялдаг...



### Рэппэр Big Gee

Бид бусдаас үнэнч байдлыг шаарддаг шиг өөрсдийн бодолдоо хэр үнэнч байж чаддаг вэ? Үнэнч байх гэхлээр гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр ухарч, няцдаг, ганцаардаж эхэлдэг. Тэр тууштай байдал маань ухарч няцаад ирэхлээр өөртөө үнэнч, шударга байдал нь үгүй болоод эхэлдэг. Шударга бус байдалтай битгий эвлэр, битгий няц.



### “Үнэгүй фитнес” ТББ-ын удирдах зөвлөлийн дарга Л.Саруулбат

... Сайн хүүхэдтэй баймаар байвал сайн эцэг эх байх хэрэгтэй. Сайн эцэг байхын тулд зөв үйлдлээрээ хүүхэддээ үлгэр дуурайлал үзүүлэх хэрэгтэй...



### “Сайн сургуулийг таны дэргэд” ТББ-ын тэргүүн П.Наранбаяр

... Манай улс залуусдаа хөгжих, ирээдүйгээ төлөвлөх боломж олгодоггүй. Шударга ёсыг өгөхгүй бол залуус хөгжихгүй. Тиймээс амьдралаа өөрсдөө төлөвлөж, ирээдүйгээ бий болгоход нь бид залууст туслах хэрэгтэй. Үүний тулд хүн бүр зөв зүйл хийх нь чухал. Хүн бүр дүрмээ баримтлаад эхэлвэл, түүнийг зөрчихөд хэцүү болдог шиг олон хүн шударга ёсыг баримталвал шударга бус зүйл хийх нөхцөл бүрдэхгүй. Үүнийг зөвийн дарангуйлал гэнэ. Ийм нийгэмд шударга бүхэн ялдаг. Тиймээс өөртөө үнэнч бай. Юу ч хийсэн эзэн шиг нь хариуцлагатай, эрх чөлөөтэй байх нь хамгийн хүчирхэг сэтгэлгээ, дадал юм...



### Хүний эрхийн активист, зохиолч Ц.Оюунгэрэл

... Салаа зам та аралдахад чиний өмнө зөв замыг чиглүүлж өгдөг зүйл бол

үнэт зүйл. Үнэт зүйл гэдэг юу вэ гэхээр шударгаар, хөдөлмөрөөрөө амжилтад хүрэх, хүнтэй тэгш харилцах гэх мэт хүмүүнлэг, цөөхөн хэдэн үнэт зүйл байдаг.

Хүн төрөлхтөн бүгдээрээ тэр зүйлийг үнэлж ирсэн. Хүн төрөлхтний үнэлж ирсэн тэр үнэт зүйлийг дагаад явж байхад салаа замаар чи яг зөв замаа сонгоод яваад байдаг...




### Топ модель Э.Энхболд

Хүмүүс амьдралынхаа алхам бүрт шударга ёсны хэмжүүртэй нүүр тулж байдаг. Найз

нөхөд, ажлын гээд бүх л харилцаа итгэлцэл, шударга ёсны зарчим дээр тогтдог.

Өнөөгийн нийгмийн тэгш бус байдал нь өөрөө шударга бус байдлын хамгийн том жишээ шүү дээ. Шударга бус зүйл хийж байгаа хүн түүнийгээ мэддэггүй нь хамгийн том аюул байдаг гэж боддог.



## ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны арга хэмжээг 21 аймаг, 330 суманд зохион байгуулж давхардсан тоогоор **1,063,456** хүнд хүргэв.

Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн контент, шторк, нэвтрүүлэг, зурагт хуудас, инфографик, хөдөлгөөнт зураг, цахим ном зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал орчин, гудамж талбайн самбар, лед дэлгэцээр сурталчлахаас гадна хүүхэд залуусын дунд шударга ёсны сэдэвт гар зураг, эссе бичлэг, гэрэл зураг, цахим орчинд видео бичлэгийн уралдаан, бүжгийн челленж, “Шударга ёс, цахим хичээл дээр” сэдэвт хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулжээ.

Зөвхөн аяны хугацаанд явагдаад өнгөрөхгүй цаашид тогтмол явагдах олон төрлийн санал, санаачилгыг аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс гарган хэрэгжүүлсэн нь урьд өмнө хийгдэж байсан арга хэмжээнүүдээс чанар, хүртээмжийн хувьд ахиц гаргасан, шинэлэг ажил болов.

Тухайлбал, Говьсүмбэр аймаг Цагдаагийн Сүлд чуулгын уран сайхны удирдаач А.Амарболд, УДБЭТ-ын гоцлол дуучин Э.Отгонбат, сагсан бөмбөгийн олон улсын хэмжээний мастер У.Мөнхбаатар, волейболын спортын мастер А.Очгэрэл, аймгийн арслан Т.Пүрэвсүрэн, Дундговь аймаг Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат, сэтгүүлч С.Пүрэвсүрэнгээр гэх мэт орон нутагтаа нэр хүндтэй, олны танил хүмүүсээр авлигын эсрэг яриа таниулга, нөлөөллийн видео бэлтгэн түгээсэн байна.



## АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ

### АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТАД 13,820 ИРГЭН, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ ХАМРУУЛАВ

Төрийн албан хаагчдаас гадна иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилд зориулсан авлигын эсрэг сургалт зохион байгуулахад анхааран ажиллалаа.

Цар тахлын улмаас улс орны хэмжээнд хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан авлигын эсрэг сургалт, хэлэлцүүлгийг цахим хэлбэрт шилжүүлсэн ба 2020 онд **13820** хүнийг сургалтад хамруулжээ.

#### Байгууллага, оролцогчдын тоогоор харуулбал:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	109
Хууль зүй, дотоод хэргийн яам	7
Соёлын яам	51
Боловсрол, шинжлэх ухааны яам	10
БХЯ-ны харьяа цэргийн штаб	41
Архивын ерөнхий газар	6
Татварын ерөнхий газар	1200
Нийгмийн даатгалын ерөнхий газар	25
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	5
Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар	120
Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	406
Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар	45
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	191
Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн	10
Зам, тээврийн салбар	42

Уул уурхайн салбар	184
Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс	70
Гаалийн байгууллага	218
Цагдаагийн байгууллага	521
Автотээврийн үндэсний төв болон орон нутаг дахь салбар нэгж	156
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	44
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах хөгжлийн төв	77
СХД-ийн прокурор	35
Нийслэлийн 9 дүүргийн хороод	1657
Эрүүл мэндийн салбар	701
Яам, агентлагийн шинээр томилогдсон	318
СЕХ-ны 21 аймгийн сонгуулийн хороо	50
Монголын Уран зургийн галерей	15
Оюунлаг сургуулийн ахлах ангийн сурагч	30
Хувийн хэвшил	402
Эрчим хүчний салбар	282

6855 иргэн

6965 төрийн албан хаагч



нийт  
**13820**  
хүн

Экологийн боловсролын төв	
Иргэний нисэхийн үндэсний төв	55
Төрийн бус байгууллагын	84
МҮХАҮТ-ын дэргэдэх бямба гарагийн анги	32
9 дүүргийн шинээр томилогдсон албан хаагч	69
Өмнөговь аймаг	67
Баянхонгор аймаг	928
Говь-Алтай аймаг	259
Дархан-Уул аймаг	103
Сэлэнгэ аймаг	80
Хөвсгөл аймаг	20
Хүнс, хөдөө аж ахуйн салбар	138
Улсын бүртгэлийн ерөнхий газар	87
ХУД-ийн ЗДТГ	35
Спортын салбар	32
Үндэсний хөгжлийн газар	4
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	6
Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль	30

## ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛЧДИЙН СУРГАЛТ

Авлигын болон бусад төрлийн гэмт хэргийг эрэн сурвалжлах, хууль зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сурталчлах, сэтгүүлчидтэй нягт хамтран ажиллах арга замыг нээх зорилгоор “Авлига ба эрэн сурвалжлах сэтгүүлчид” сэдэвт бүтэн өдрийн сургалтыг зохион байгуулав. Хэвлэл мэдээлэл нь хяналт тавих, мэдээлэх чиг үүргээрээ дамжуулан авлигыг эсэргүүцэх хүчтэй салбар юм. Ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь авлигын хэргийг илрүүлэх, уг хэргийг олон нийтийн анхаарлын төвд оруулахад голлох үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүлчдийг жил бүр авлига, ашиг сонирхлын талаарх зөрчлийн сургалтад хамруулан тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлдэг билээ.



2020.10.30

## ШИНЭЭР ТОМИЛОГДСОН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ

Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдын сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн шинээр томилогдсон 424 албан хаагчийг хамрууллаа.

Авлигын эсрэг сургалт нь төрийн албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомж болон шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг таниулах, сурталчлахаас гадна төрийн албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах зан үйлд сургаж байгаагаараа ач холбогдолтой юм.



2020.09.25

## МАРКЕТЕРУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Авлигын эсрэг үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллага, маркетинг, бүтээлч үйлдвэрлэлийн салбарын залуусыг татан оролцуулах, сургах, туршлага хуваалцах, хамтран ажиллах зорилгоор байгууллагын маркетинг, сошиал медиа хөгжүүлэгчдэд зориулсан сургалтыг 2 удаа зохион байгуулав. Сургалтад MNAgency, Viral, Orgilmedia, Global Event, EMOZ agency, IDlabAgency, Boomerang Mongolia, iLAB Production, IMGGroup зэрэг 15 байгууллагын 40 хүн хамрагдав.

## ДҮҮРГИЙН ХОРООНЫ АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ

Нийслэлийн дүүргүүдийн хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, зохион байгуулагч нарт авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийн зохицуулалтын талаар тодорхой мэдлэг олгох, чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулж байгаа бөгөөд энэ хүрээнд Баянзүрх, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт **143** хорооны **1631** албан хаагчийг цахим сургалтад хамрууллаа. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэдэд улам ойртуулахын тулд нэн түрүүнд хороодын хэсгийн ахлагчдыг чадавхжуулах, тэднээр дамжуулан соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах эхлэлийг тавив.



## “ШУДАРГА ЁС-ИРГЭНИЙ ХЯНАЛТ” СЭДЭВТ ЦУВРАЛ СУРГАЛТ

Төрийн байгууллагатай хамтран ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд болон мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан “Шударга ёс-Иргэний хяналт” сэдвээр цуврал сургалт зохион байгууллаа. Сургалтад хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийг хамрууллаа. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн хяналт, оролцоог идэвхжүүлснээр албан тушаалтнуудын шударга байдлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгон сайжруулах, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.



2020.10.12



2020.12.08

## 25 СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭВ

Боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүй зэрэг зорилтот салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагын удирдлага, гишүүдийг сургагч багшаар бэлтгэв.

Сургагч багшаар дамжуулах иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоонд тулгуурлан авлигын эсрэг үзэл санааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, ялангуяа соён гэгээрүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах дэд бүтэц өргөжих боломж бүрдэж байна.

## АЛБАН ХААГЧДЫГ ТОГТМОЛ ЧАДАВХЖУУЛЖ БАЙНА

Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны Гадаад харилцаа, сургалтын асуудал хариуцсан хэлтэс Авлигатай тэмцэх газраас тавьсан хүсэлтийн дагуу цахим сургалтыг зохион байгуулав.

“Санхүүгийн хэмнэлттэй арга хэлбэрээр авлигаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга замууд” сэдэвт уг цахим сургалтаар Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлд хэрхэн ажилладаг талаар сайн туршлагаа хуваалцаж, энэ чиглэлээр хэрхэн санхүүгийн хэмнэлттэй, үр дүнтэй ажиллаж болох арга замуудын талаар зөвлөгөө өгч, туршлагаасаа хуваалцав.



2020.10.28

## НОМ, ГАРЫН АВЛАГА, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ ХЭВЛҮҮЛЭВ



Иргэд, олон нийтэд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг мэдээлэх зорилгоор ном, гарын авлага, эмхэтгэл, тойм танилцуулга бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээв.

**Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл** “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл”-ийн 2014 оны I, II боть, 2011-2012 оны шүүхийн шийдвэрийн эмхэтгэлийг 1 боть болгон хэвлүүлсэн. 2013, 2015, 2016, 2017, 2018, 2019 оны шүүхийн шийдвэрийг эмхэтгэн боловсруулав.

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хуулийн хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой юм.



### “УИХ-ын гишүүн Танаа”

Авлигын эсрэг тэмцэлд парламентын оролцоо, манлайлал маш өндөр ач холбогдолтой тул шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг таниулах, Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааг мэдээлэх зорилгоор “Улсын Их Хурлын гишүүн Танаа” гарын авлагыг боловсруулж, хүргүүллээ.



### “Засгийн газрын гишүүн Танаа”

Шинээр эмхлэн байгуулагдсан Засгийн газрын танхимын гишүүнсайд нарт зориулсан гарын авлага боловсруулж хүргүүлэв. Авлигатай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, салбарын ёс зүйн соёлыг хөгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад Засгийн газрын гишүүний хувьд баримтлах зөвлөмж, санамжийг энэхүү гарын авлагад багтаасан.



### “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Танаа”

Орон нутгийн сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч шинээр томилогдон ажиллаж байгаа Засаг дарга нарт зориулан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Танаа”, “Засаг дарга танаа” гарын авлагыг боловсруулан хүргүүлэв.



### “Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч танаа”

2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигч нарт зориулсан гарын авлага, зөвлөмжийг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран боловсруулж нам, эвсэл, бие даагч нарыг мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллав.



“Шударга ёс ба олон нийтийн итгэл” сэдэвт хуулийн байгууллагын нэгдсэн зөвлөгөөнд хэлэлцүүлсэн илтгэлийг эмхэтгэв. Ингэснээр шүүх эрх мэдлийн болон хууль зүйн салбарт ажиллаж байгаа мэргэшсэн алба хаагч, өмгөөлөгч, багш-судлаачдын байр суурийг нийтийн хүртээл болгож, нэгдсэн зөвлөгөөнд хэлэлцүүлсэн илтгэлийн агуулга, үзэл санаа, шийдэл нь авлигын эсрэг үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, хууль зүйн салбарын шударга ёсны үнэмлэмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж, эрдэмтэн судлаач, оюутан суралцагчийн судалгааны хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой юм.



**“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа” гарын авлага**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлэх, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” чиглэлийг үндсэн зорилгын нэг болгон тогтоосон.

Энэ хүрээнд Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран боловсруулав.



**Авлигын эсрэг боловсрол олгох гарын авлага**

Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт ардын аман зохиолын төрөл болох зүйр цэцэн үг, сургамжит өгүүллэгээр дамжуулан шударга ёсны үзэл хандлагыг бий болгох, шударга үнэнч зан төлөв, ёс суртахуун, нийгмийн харилцааны зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгоход чиглэгдсэн. Энэхүү гарын авлагад тусгагдсан агуулгаар “Иргэний ёс зүйн боловсрол” хөтөлбөрийн туршилт хичээлийг зохион байгуулахаар төлөвлөж байна.



**“Бодлогын хураамж: Төрийн албаны ёс зүй, ашиг сонирхлын зөрчил” гарын авлага**

Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлыг шинжлэхдээ тухайн тохиолдлыг Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн албаны суурь зарчимтай хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийж, авлигын эсрэг хууль тогтоомж зэрэг бусад хууль, дүрмийн нарийн зохицуулалтаар баталгаажуулах боломжтой.



**Монгол Улсын авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилт, тойм танилцуулга” (2019.05.02–2020.05.02) жилийн үйл ажиллагааны тайлан мэдээллийг бэлтгэн хэвлүүлж, УИХ-ын Тамгын газар болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв**

Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан ном, гарын авлага, эмхэтгэл, товхимол, тойм танилцуулга зэргийг нийтийн хүртээл болгох, оюутан, судлаачдад танилцах, судлах боломж олгох зорилгоор их, дээд сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Тусгаар тогтнолын ордон, 21 аймгийн номын сан болон нийтийн номын сангуудад үнэ төлбөргүй хүргүүлэв.



Гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчлах зорилгоор шударга ёсны сэдэвт онцлох ишлэл бүхий 20 төрлийн зурагт хуудас бэлтгэж, хэвлүүлэв.



### НУГАЛБАР ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭВ

Иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн “Авлигатай тэмцэх газарт гомдол, мэдээлэл хэрхэн гаргах вэ?”, “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?” Авлигад бид юу алдаж байна вэ?” сэдвээр нугалбар танилцуулга хэвлүүлж, иргэдэд сурталчлан түгээв.



### ҮЗҮҮЛЭН ТАРААХ МАТЕРИАЛ ТҮГЭЭВ

Авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчлах зорилгоор төрийн албан хаагч, иргэдэд зориулсан мэдээллийн самбар, постер, зурагт хуудас, хаалганы наалт, зөөврийн санах ой, тогтоогчтой бал, карт холдер, соронзон наалт, шүдэнз зэрэг тараах материалыг хэвлүүлэн иргэд, олон нийтэд түгээв.

## 1 ӨГҮҮЛБЭРЭЭР



**37** төрлийн **16.962** ширхэг ном, гарын авлага, тараах материал түгээв.



“Зөв зөвд шударга зөв” аяны зурагт хуудсыг автобусны буудлын **46** гэрэлт самбар, зам дагуух **80** самбар, сурталчилгааны **10** самбарт байршуулав.



**22** телевизээр **2397** удаа шторк, контент цацав.



**16** төрлийн ном, гарын авлага боловсруулж түгээв.



Нийслэлийн Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран **218** электрон дэлгэцээр авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааг **876.070** хүнд хүргэв.



# 1 ӨГҮҮЛБЭРЭЭР



Төрийн **20**  
байгууллагад **111**  
асуудал бүхий Зөвлөмж  
хүргүүлэв

“АТГ-Олон нийтийн  
төв” пэйж нэг жилийн  
дотор 31.115 дагагчаар  
буюу хандалт **11 дахин**  
**нэмэгдсэн**. Ингэснээр  
Монголын хамгийн  
их хандалттай  
пэйжүүдийн 2-рт  
эрэмбэлэгдсэн.



Хууль хэрэгжүүлэх  
зөрчил арилгуулахаар  
**43** албан бичиг  
хүргүүлэв.

Авлигын эсрэг  
мэдээлэл,  
сурталчилгааг  
цахилгаан шатны  
дэлгэцээр **175.214**  
**өрхийн 876.070**  
**хүнд** хүргэсэн.

Авлигатай  
тэмцэх үндэсний  
хөтөлбөрийн 192  
арга хэмжээ зохих  
хэмжээнд хэрэгжиж,  
гүйцэтгэл **58,8%**  
байна.



Сургалтын хөтөлбөр  
**6**, модуль **20** төрлөөр  
боловсруулав.

Сошиалд анх удаа  
өрнүүлсэн шударга  
ёсны сэдэвт сурагчдын  
давалгаанд аймаг,  
дүүргийн **716**  
**сургууль, 710**  
**цэцэрлэгийн багш,**  
**хүүхдүүд** хамрагдав.



Цахим орчинд  
мэдээлэл түгээх  
хүрээнд **51** подкаст  
контент бэлтгэн хүргэв.



“Зөв дадал” сэдвээр  
дигитал чуулган  
зохион байгуулсан нь  
цахим орчинд өндөр  
үнэлгээ авчээ.

Зарим төрийн  
байгууллагын үйл  
ажиллагааны зохион  
байгуулалтад тандалт,  
ажиглалт хийв.



**18** дүрэм, журмыг  
судалж, өөрчлөх,  
хүчингүй болгуулах  
талаар санал хүргүүлэв.

Гэмт хэргийн  
шалтгаан, нөхцөлийг  
арилгуулахаар  
мөрдөгчийн **мэдэгдэл**  
**103** бичсэн.

Авлигаас урьдчилан  
сэргийлэх чиглэлээр  
**10 салбарт ажиллаж,**  
шалган туслах,  
зөрчил дутагдлыг  
арилгуулахаар зөвлөмж  
хүргүүлж, хэрэгжилтэд  
хяналт тавив.



**13820** хүнд сургалт  
зохион байгуулав

Хуулийн дагуу  
сахилгын шийтгэл  
хүлээсэн **25 албан**  
**тушаалтны** талаарх  
мэдээллийг олон  
нийтэд хүргэсэн.



Илтгэх ур чадварын  
нээлттэй тэмцээнд **125**  
сурагч видео бичлэг  
ирүүлсэн нь хамгийн  
олон оролцогчтой  
тэмцээн байв.



**9** аймагт **9** мөрдөгч  
мөрдөн шалгах  
ажиллагаа явуулж  
байна.

110 дугаарын утсаар  
хүнд суртлын  
талаарх **35 гомдол**  
мэдээллийн мөрөөр  
арга хэмжээ авав.



Мөрдөгчийн  
мэдэгдлийн мөрөөр **11**  
байгууллагад ажиллав.

13 яам, 21 аймгийн  
албан ёсны **цахим**  
**хуудсанд үнэлгээ**  
**хийж,** үр дүнг Монгол  
Улсын Ерөнхий сайдад  
хүргүүлэв.

## ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР

### “АТГ-ын мэдээлэл” телевизийн нэвтрүүлгийн 17 дугаарыг бэлтгэв

Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд үнэн бодитой, шуурхай мэдээлэх ажлыг цаг тухай бүрт гүйцэтгэв. 2020 онд **243** хэвлэлийн мэдээ, **18** ярилцлага, тодруулга, **4** нийтлэл, видеографик **12**, постер **11**, өдөр тутмын сонин **3** удаа мэдээллийн дагнасан нүүр, [www.iaac.mn](http://www.iaac.mn) мэдээллийн хуудас **2** дугаар, “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлэг **17** дугаар тус тус бэлтгэж олон нийтэд түгээв. Байгууллагын сайтад 2020 онд **712** мэдээ, материал байршуулсан байна.

### Байгууллагын нийгмийн сүлжээний хаягуудыг баталгаажуулав

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, мэдээлэл, сурталчилгаа явуулж буй авлигатай тэмцэх байгууллагын нийгмийн сүлжээний хаягуудыг албан ёсны болгон баталгаажуулж (VERIFIED) тэмдэглэгээг авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Ингэснээр нийгмийн сүлжээнд тус хуудсыг ашиглан мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг явуулах, идэвхжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулахад тавигддаг хязгаарлалтууд цөөрөх, мөн албан ёсны хаяг мөн болохыг танихад хялбар, ижил төстэй хуурамч хаягуудыг хязгаарлуулах зэрэг боломж бүрдэж байна.



### подкаст сувгийн хөгжүүлэлт хийв

Цахим орчинд мэдээлэл түгээх хүрээнд сүүлийн үед түгээмэл ашиглаж буй подкаст сувгийг үүсгэж, #110 подкастын булангууд, тэдгээрийн загвар, онцлогууд, хүргэх сувгуудыг тодорхойлж, хөгжүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, авлигын эсрэг контент бэлтгэн агуулга, төрөл, хэлбэрээр ангилан олон нийтэд хүргэж байна.

### Богино долгионы радиотой хамтран ажиллав

“Гэр бүлийн радио 104.5”, “Дэлхийн монголчуудын радио 88.3”, “Таны радио 103.6”, “Зохист аялгуу 89.3” радиотой хамтран ажилласнаар “Нэг дусал”, “Радио зөвлөгөө”, “Ашигтай мэдлэг”, “Уран зохиолын цаг” зэрэг олон сонсогчтой нэвтрүүлгээр дамжуулан авлигын хор аюулыг ухуулан таниулахад чиглэгдсэн мэдээ, мэдээллийн тогтмол урсгалтай болов.



[www.iaac.mn](http://www.iaac.mn)

Авлиганы эсрэг тэмцэх газар

2007 оны 11002



## ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Хамтын ажиллагаа эхлүүлэх, өргөтгөх, харилцан туршлага солилцох, албан хаагчдыг сургах чиглэлээр БНХАУ-ын Үндэсний хяналтын хорооны Сургалтын төв, Гадаад хамтын ажиллагааны газарт санал хүргүүлээд байна.

Казахстан Улсын Авлигатай тэмцэх газартай шинээр харилцаа тогтоон, дээд хэмжээний албан ёсны уулзалт зохион байгуулж, Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар тохиролцов.



Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан “Эдийн засгийн форум”-д 2020 оны 9 дүгээр сард, 11 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн албанаас зохион байгуулсан Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын тухай тайланг дүгнэн ярилцах цахим уулзалтад УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Д. Дуламсүрэн, МШХ-ийн Албаны дарга, ахлах комиссар Д.Жаргалбаатар нар, 11 дүгээр сарын

30-ны өдөр зохион байгуулагдсан “Авлигын эсрэг олон улсын академи үүсгэн байгуулах тухай хэлэлцээр”-ийн Оролцогч талуудын ассамблейн 9 дүгээр чуулганд Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням, Гадаад харилцааны асуудал хариуцсан ажилтан Ж.Болорчимэг нар оролцож Академийн ирэх оны ажлын болон төслийн төлөвлөгөөг батлахад саналаа хүргүүлсэн.

Казахстан улсын Авлигатай тэмцэх газраас 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв.

**Оролцогчид:**

- Алексей ШПЕНДЖАЕВ**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын академи үүсгэн байгуулах тухай хэлэлцээр
- Асет Ислаханов**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв
- Найрат Желамбетов**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв
- Дашдаваа Зандраа**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв
- Ли Си**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв
- Вупт Барина**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв
- Эрик Майер**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв
- Алексей Вайкович**, Гэрээлцэгчид, Авлигын эсрэг олон улсын хуралд тэргүүн комиссар З.Дашдаваа оролцож, илтгэл хэлэлцүүлэв

2020 оны 09 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулсан Орос хэл өргөн хэрэглэдэг орнуудад зориулсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад албан хаагчдыг хамрууллаа.

Америкийн Нэгдсэн улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны Эдийн засаг худалдааны хэлтсийн дарга Бенжамин Ли Рой, АНУ-ын Сангийн яамны Монгол улс дахь Суурин төлөөлөгч Н. Клайд Роадс нартай Мөнгө угаах гэмт хэргийн асуудлаар 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр уулзалт зохион байгуулав



12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан Ази, номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээний удирдах зөвлөлийн уулзалтад оролцож, тус сүлжээний 2021-2023 орны ажлын төлөвлөгөөнд санал хүргүүлсэн. Ази, номхон далайн орнуудын авлигын эсрэг сүлжээн нь бүс нутгийн 33 улсыг эгнээндээ нэгтгэсэн ба Монгол Улс 2009 онд тус сүлжээний гишүүн болсон. Авлигатай тэмцэх газар үндэсний зохицуулагч байгууллагаар ажилладаг бөгөөд жил тутмын удирдах зөвлөлийн уулзалтад төлөөлөгч оролцуулж, олон улсын сургалт, арга хэмжээнүүдэд албан хаагчдаа хамруулан, бүс нутгийн хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй шинэ туршлага, чиг хандлагаас суралцаж, үйл ажиллагаандаа тусгаж ажилладаг.

## ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАВ

2020 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний мониторингийн үйл ажиллагаа “Ковид-19” цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор цахим хэлбэрээр явагдав. Тайлант хугацаанд тус Сүлжээ нь бүс нутгийн улсуудын авлигын эсрэг орчинд хийх үнэлгээний аргачлалыг шинэчлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд үүнд Авлигатай тэмцэх газраас тухай бүр идэвхтэй оролцож, хамтран ажиллав. Тухайлбал,

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний 25 дахь удаагийн Удирдах зөвлөлийн цахим хуралд оролцож, “Ковид-19” цар тахлын үед Монгол Улсын авлигын эсрэг орчинд гарсан өөрчлөлт, Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж байгаа онцлох үйл ажиллагааны талаар танилцуулав.

Тус Сүлжээнээс 2020-2024 онд гишүүн орнуудын авлигын эсрэг орчныг үнэлэхэд баримтлах

аргачлал, шалгуур үзүүлэлтүүдийн төслийг ирүүлснийг судлан үзэж, саналаа хүргүүлсэн.



2020 онд Авлигатай тэмцэх газрын даргын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг баталж, тус газрын хэлтэс, албадаас хэрэгжүүлсэн ажлын явцын тайланг нэгтгэв.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 2, 3 дугаар бүлгийн хэрэгжилтийг тайлагнах хурал 2020 оны 6 дугаар сарын 29-нөөс 7 дугаар сарын 1-ний өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. Энэхүү цахим хуралд Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг 10 байгууллагын 18 төлөөлөгчийг оролцуулав. арга хэмжээг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулав.

## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ СУРГАЛТУУД

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга СтАР /StAR/-аас мөрдөгчдөд зориулан “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав.



2020 оны 10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалт зохион байгуулагдаж, АТГ, УЕПГ, ЦЕГ-ийн 18 албан хаагчийг хамруулсан.

2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол Улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монголбанкны холбогдох 29 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга СтАР /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад шинээр томилогдсон 30 мөрдөгч хамрагдав.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны ахисан түвшний сургалтыг 4 дүгээр сарын 15-22, 23-30, 5 дугаар сарын 7-14-ний өдрүүдэд 3 удаагийн цахим сургалт зохион байгуулав.



## ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

### УЛСЫН ХЭМЖЭЭНД 41686 АЛБАН ТУШААЛТАН 2019 ОНЫ ХАСХОМ БҮРТГҮҮЛСЭН БАЙНА

2019 онд Мал эмнэлэг, үржлийн газар, ШШГЕГ, ОБЕГ зэрэг байгууллагуудын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон, мөн БСШУСЯ-ны харьяа Шинжлэх ухааны академийн 54 албан тушаалтан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдах 23 албан тушаалтан ХАСХОМ гаргах жагсаалтад шинээр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт мэдүүлэг гаргагчдын тоо өмнөх оноос **304** /0.7 хувь/ нэгжээр нэмэгдсэн байна.

#### ХАСХОМ гаргасан мэдүүлэг гаргагчдын тоон үзүүлэлт

Үзүүлэлт НАТ*	2017 оны		2018 оны		2019 оны		3 жилийн дундаж үзүүлэлт	
	НАТ*	Өсөлт	НАТ*	Өсөлт	НАТ*	Өсөлт	НАТ*	Өсөлт
Мэдүүлэг гаргавал зохих нийтийн албан тушаалтан /НАТ/	40073	+331	41382	+1309	41686	+304	<b>41047</b>	<b>+648</b>
Мэдүүлэг гаргасан нийтийн албан тушаалтны тоо	40067		41381		41685	-	41044	-
Хугацаа хожимдуулж Үүнээс: мэдүүлсэн	4	-	-	-	-	-	1	-
Мэдүүлгээ гаргаж өгөөгүй	2	-	1	-	1	-	1	-
Бүрдүүлэлтийн хувь	99.99	-	99.99	-	99.99	-	99.99	-

Тайлбар: \*НАТ-Нийтийн албан тушаалтан

### МЭДҮҮЛЭГ ГАРГАХ АЛБАН ТУШААЛТНЫ ТОО 648 НЭГЖЭЭР НЭМЭГДЭВ

Сүүлийн 3 жилийн дунджаар ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий **41047** албан тушаалтан байгаа бөгөөд мэдүүлэг гаргавал зохих нийтийн албан тушаалтны тоо сүүлийн 3 жилд дунджаар **648** нэгжээр нэмэгдсэн байна.

2020 онд ХАСХОМ мэдүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн 13289 буюу 31.9 хувь нь төрийн тусгай, 11021 буюу 26.4 хувь нь төрийн захиргааны, 7518 буюу 18 хувь нь улс төрийн, 4746 буюу 11.4 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 2538 буюу 6.1 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдах, 283 буюу 0.7 хувь нь төрийн өндөр болон Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг, 2291 буюу 5.5 хувь нь бусад албан тушаалтан байна.

ХАСХОМ мэдүүлсэн албан тушаалтнууд  
/Төрийн албаны ангиллаар/




Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг хуульд заасан хугацаанд <http://www.xasxom.iaas.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэв.

### ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтад оролцогчдын тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулав.

Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлтийг харьцуулбал:



## СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙН ХОМ-ИЙГ АНХ УДАА ЗАРЛАВ

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж мөрдөгдсөнтэй холбогдуулан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын цахим системд өргөтгөл, шинэчлэл хийж, Сонгуулийн ерөнхий хороотой хамтран УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн, нэр дэвшигчийн үнэмлэхээ гардан авсан нийт 606 нэр дэвшигчийн ХОМ-ийн хураангуйг "http://хасхом.iaас.mn/" цахим системд байршуулж, ил тод нээлттэй байдлыг хангав.

### 542 АЛБАН ТУШААЛТНЫ ХАСХОМ-ИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭВ


2020 онд нийтийн албан тушаалтны 542 ХАСХОМ-ийг хянан шийдвэрлэсэн. Нийт шалгасан мэдүүлгийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 161 нэгжээр буюу 42.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*ХАСХОМ-ийн хяналт шалгалт*

Он	Шалгаж шийдвэрлэсэн	Хариуцлага тооцуулсан байдал
2018	171	14 /8.2%/
2019	381	35 /9.2%/
2020	542	46 /8.5%/
<b>3 жилийн дунджаар</b>	<b>365</b>	<b>32</b>

Хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо үнэн зөв мэдүүлээгүй 46 албан тушаалтанд хариуцлага (сануулах-1, албан тушаалын цалин бууруулах-26, албан тушаал бууруулах-11, төрийн албанаас халах-8) тооцуулахаар шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал **11 нэгжээр өссөн** байна.

*ХАСХОМ-ийн хяналтаар хариуцлага тооцуулсан байдал /оноор/*






## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛД ХАМААРАХ 616 ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН

2020 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 656, өмнөх оны үлдэгдэл 48, нийт 704 гомдол, мэдээллийг хянаснаас тайлант хугацаанд 616-г хянан шийдвэрлэсэн. Хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлт **87,5** хувьтай байна.

*Илэрч буй нийтлэг зөрчлүүд:*

Зөрчлийн агуулга	2018 оны гомдол	2019 оны гомдол	2020 оны гомдол
Албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн	15,1%	15.90%	18%
Хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон	14,3%	15.60%	17%
Ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан	14,4%	34.60%	21%
Хууль бус томилгоо хийсэн	23,8%	14.80%	24%
Бусад	21,1%	19.10%	20%


*Өргөдөл, гомдол, мэдээлэл шийдвэрлэсэн байдал*



*Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хариуцлага тооцуулсан байдал*

Хариуцлагын хэлбэр	2018 он	2019 он	2020 он
Сануулсан	8	8	3
Цалинг бууруулсан	23	22	20
Албан тушаал бууруулсан	-	4	1
Ажлаас халсан	7	3	1
Нийт	38	37	25

Өргөдөл, гомдол, мэдээллийн агуулга /хувиар/



**НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН  
13030 ИРГЭНИЙ УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН**

**2020 онд** нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **13030** иргэний **хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг** хянан шийдвэрлэсэн.


Хянасан мэдүүлгийн **2033**-ыг нь цахим системээр хүлээн авсан нь нийт урьдчилсан мэдүүлгийн **35.7** хувийг эзэлж байна. 2019 онд 8 агентлаг, 5 аймгийн 40 байгууллага цахим системд бүрэн холбогдоод байсан бол **2020 онд** төрийн болон нутгийн захиргааны **884** нэгжийг цахим системд холбосон нь нийт холбовол зохих нэгжийн **80** орчим хувийг эзэлж байна.

*Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг*

он	Хянасан	Үүнээс:		
		АСЗ үүсэх нөхцөл байдал байгаа талаар анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх	Нарийвчлан шалгах шаардлагатай
2018	10381	844 /8,1%/	25 /0,2%/	10 /1.0%/
2019	8627	659 /7,6%/	28 /0.3%/	3 /0.03%/
2020	13030	848 /6,5%/	8 /0.1%/	1 /0.07%/

Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан **848**, шаардлага хангаагүй үндэслэлээр **489** мэдүүлгийг буцаан хүргүүлж, **8** нэр дэвшигч тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдож байгааг эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн байна.

## ХАСУМ хянасан байдал



### ХӨРӨНГӨ, ОРЛОГОО ХУДАЛ МЭДҮҮЛСЭН 46 АЛБАН ТУШААЛТАНД ХАРИУЦЛАГА ТООЦУУЛСАН

2020 онд ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн **46**, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн **25**, мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар **8**, нийт **79** албан тушаалтанд Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан **хариуцлага тооцуулсан** байна.

Хариуцлага тооцуулсан байдал /шалгалтын төрлөөр/

	Шалгалтын төрлөөр				
	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар	ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	ХАСУМ-ийн хяналт шалгалтаар	Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо
2018	197	14	38	2	251
2019	17	35	37	-	89
2020	8	46	25	-	79
<b>Нийт</b>	<b>222</b>	<b>95</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>419</b>


Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Татварын болон Нийгмийн даатгалын байгууллага, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллаж Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Татварын ерөнхий хуулийг зөрчсөн нийт **31.952.156.613** төгрөгийн зөрчил илэрч, **801.596.630** төгрөгийн нөхөн ногдуулалтын акт тавигдсан байна.

# МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА

## ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО

2020 онд гэмт хэргийн шинжтэй 1020 гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 126 нэгжээр буюу **14.1 ХУВИАР ӨССӨН** байна.


Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл



2020 онд гомдол, мэдээлэлд холбогдсон этгээдийг албан тушаалаар нь ангилбал:

■ Төрийн улс төрийн	364
■ Төрийн захиргааны	265
■ Төрийн тусгай	170
■ Төрийн үйлчилгээний	98
■ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн	97
■ Хувийн хэвшил, аж ахуйн нэгж, болон төрийн бус байгууллагын албан тушаалтан холбогдон шалгагдсан байна.	38


Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



### 1331 ХЭРЭГТ ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН АЖИЛЛАГАА ЯВУУЛАВ

Хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан. Үүнийг өмнөх онтой харьцуулбал **2.4 ХУВИЙН ӨСӨЛТТЭЙ** байна.

*Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан*



#### 2020 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал:

- Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах - 799 буюу **52.1** хувь
- Хахууль авах - 207 буюу **13.5** хувь,
- Хахууль өгөх - 108 буюу **7.0** хувь,
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах - 23 буюу **1.5** хувь,
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих - 41 буюу **2.7** хувь,
- Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах - 21 буюу **1.4** хувь,
- Мөнгө угаах - 30 буюу **1.9** хувь,
- Эрүү шүүлт тулгах - 48 буюу **3.1** хувь
- Бусад хэрэг 258 буюу **16.8** хувийг тус тус эзэлж байна.

*Авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээд  
/Албан тушаалын байдлаар/*

	2018	2019	2020
Төрийн тусгай албан тушаалтан	434	101	<b>116</b>
ТББ, ААН-ийн албан тушаалтан	193	143	<b>231</b>
Улс төрийн албан тушаалтан	166	48	<b>81</b>
Төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан	82	38	<b>55</b>
Төрийн үйлчилгээний албан тушаалтан	145	48	<b>116</b>
Төрийн захиргааны албан тушаалтан	204	103	<b>97</b>

## 236 ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭХ САНАЛТАЙ ПРОКУРОРТ ХҮРГҮҮЛЭВ

2019 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1300 хэргээс 156 буюу 12.0 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж байсан бол 2020 онд 1331 хэргээс **236** хэргийг буюу 17.7 хувийг шилжүүлсэн нь **5.7 ПУНКТЭЭР ӨССӨН** байна.


Мөрдөн шалгасан хэргийн шийдвэрлэлт

	Шүүхэд шилжүүлэх саналтай	Хэрэг бүртгэлтийн хэрэг хлаах саналтай	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Түдгэлзүүлсэн	Бусад хэрэгт нэгтгэсэн
2018	224	467	125	1	9
2019	156	556	80	1	22
2020	236	509	48	6	46

## 114 ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ШҮҮХЭЭР ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭГДСЭН

2019 онд тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулан шүүхэд шилжүүлсэн хэргээс 68 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2020 онд **114 ХЭРЭГ ШҮҮХЭЭР ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭГДЭЖ**, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оныхоос **67.6 ХУВИАР ӨССӨН** байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо



## МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД 35.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН


2020 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас **12,1 ИХ НАЯД** төгрөгийн **ХОХИРОЛ** учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **35,6 ТЭРБУМ** төгрөгийн хохирлыг **НӨХӨН ТӨЛҮҮЛЖ**, үл хөдлөх, хөдлөх **10,1 ИХ НАЯД** төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг **БИТҮҮМЖЛЭН ХАМГААЛСАН** байна.

*Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт*



Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт **3.1 ДАХИН ӨССӨН** үзүүлэлттэй байна.

### Олон улсын гэрээний хүрээнд мөрдөн шалгах тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүргүүлсэн улсууд



## ДҮГНЭЛТ, САНАЛ

### Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох” арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Бусад орны туршлагаас харахад төрийн байгууллагын болон эрх бүхий этгээд, өндөр албан тушаалтны зүй бус үйлдлийн эсрэг хүчтэй дуугарч нийгмийн анхааралд оруулж байгаа этгээдийг “шүгэл үлээгч” гэсэн нэр томъёоны дор тайлбарлан хэрэглэж байна. Одоогийн байдлаар 30 шахам улс орон шүгэл үлээгчийг хамгаалах талаар тусгайлсан хууль батлан мөрдөж байгаа нь нь шүгэл үлээх тогтолцоог бүрдүүлэхийг авлигаас урьдчилан сэргийлэх чухал арга хэрэгсэл гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага өсч байгааг харуулж байна.

Авлигын чиглэлээр зохион байгуулсан судалгаануудын дүн, шинжээчдийн үнэлгээ нь авлигыг мэдээлэхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах механизм бүрдүүлэх шаардлагатайг илэрхийлсээр байна. Тухайлбал, Авлигын эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлэх механизмын дагуу манай улсад үнэлгээ хийсэн олон улсын шинжээчид “мэдээлэгчийг хамгаалах хууль тогтоомж бий болгох зайлшгүй шаардлагатай байна” гэж дүгнэсэн.

Монгол Улс авлигатай тэмцэх тогтолцоогоо улам бүр бэхжүүлэхэд авлигын талаар шүгэл үлээгч(илчлэгч)-ийг хамгаалах, урамшуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Манай орны хувьд иргэдээс гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг төлбөртэй авах талаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан боловч мэдээлэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх боломж нөхцөлөөр хангах механизм бүрдээгүй, зохицуулалт хангалтгүй байна.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс хийсэн Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланд “..асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох

харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч, /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах хуулийг боловсруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.” хэмээн тэмдэглэжээ.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл батлагдсанаар Авлигын эсрэг конвенцийн 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ” гэж заасныг хэрэгжүүлэх бодит алхам болох юм.

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, даган гарах хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн тул төслийг энэ намрын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх тал дээр онцгойлон анхаарал хандуулахыг хүсч байна.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн тандан судалгаа, зардлын тооцоо, төслийн үзэл баримтлал, танилцуулга боловсруулах ажлыг хариуцан зохион байгуулж, хууль санаачлагчид уламжлаад байна.

3. Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг болон мөрдөн шалгах ажиллагааны явцад өөрсдийн илрүүлсэн Мөнгө угаах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргүүдээс үйлдлийн арга, үйлдэгдсэн нөхцөл байдал, субъектын хувьд



өөрийн онцлогтой, ээдрээ түвэгтэй, өргөн цар хүрээнд шалгалтыг хийдэг тул мөрдөн шалгахад нэлээд цаг хугацаа шаарддаг бөгөөд Мөнгө угаах, Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хувьд одоогийн үйлчилж буй хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байгаа нь практик дээр гэмт хэргийг илрүүлэн эцэслэн шалгаж шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна. Иймд эдгээр гэмт хэргийн хувьд ялын бодлогыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

4. Эрүүгийн хуулийн 18.6 дахь зүйлд Мөнгө угаах гэмт хэргийг *“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого* гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тодорхойлсон.

Энэ нь суурь гэмт хэрэг нь заавал авлигын гэмт хэрэг байхыг шаардахгүй бөгөөд Эрүүгийн хуульд заасан аливаа гэмт хэргийн замаар олсон орлогыг эзэмшсэн, ашигласан түүний хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн шилжүүлсэн, нуусан, далдалсан зэрэг идэвхтэй үйлдэл байхаар хуульчилсан. Иймд мөнгө угаах гэмт хэргийг бүхий л төрлийн гэмт хэрэгт хамаатуулан хянан шалгаж, шийдвэрлэх талаар хууль сахиулах байгууллагууд, прокурор, шүүхийн хувьд нэгдсэн нэг ойлголттой болж, практикт хэрэгжүүлж хэвших шаардлага байна.

5. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг ижил хариуцлага хүлээлгэхээр заасныг өөрчлөх шаардлагатай байна. Энэ нь улсад бодит хохирол учруулсан этгээд нь хохирол учруулаагүй этгээдтэй ижил ял шийтгэгдэхээр байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүй, төсвийн хөрөнгийг бодитоор завшихыг өөгшүүлсээр байна. Иймд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан (материаллаг бүрэлдэхүүнтэй) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, ялгамжтай байдлаар тогтоох шаардлагатай байна.

6. Нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө,

орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүй хөрөнгөжих гэж үзэхээр 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуульд тусгасан. 2002 оны Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзэхээр тусгасан байсан тул одоогийн зохицуулалтаар 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд хамаарах хөрөнгө, орлого нь их хэмжээгээр нэмэгдсэнийг албан тушаалтан үндэслэлтэй тайлбарлах асуудал яригдахгүй. Одоо мөрдөж буй Эрүүгийн хуулийн заалтыг нийтийн албан тушаалтныг өөрийнхөө гэм бурууг нотлохыг үүрэгжүүлсэн буюу Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд харшлах зохицуулалт болсон гэж үзэх үндэслэлтэй байгаа юм.

7. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-т заасны дагуу зөвхөн эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад иргэн, албан тушаалтны банкны данс, гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авах боломжтой бөгөөд нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдүүдийн банкны данс, гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргуулан авах боломжийг хуульчлан тогтоогоогүй. Энэ нь албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд томоохон бэрхшээл учруулж байгаа ба тухайн албан тушаалтны зөвхөн өөрийн гарган өгч буй мэдээллээр хязгаарлагдах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай хөндлөнгийн нотолгоог бүрэн цуглуулах боломжгүй, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн гүйцэд шалгах, нуугдмал хөрөнгийг илрүүлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн албан тушаалтан оффшор бүсэд хуулийн этгээд байгуулах, данс эзэмших, мөнгөн хөрөнгө байршуулахтай холбоотой хориглолт, хязгаарлалтын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх чиг үүрэгтэй холбогдуулан, албан тушаалтны банкны дансны орлого, зарлагын гүйлгээг хянан шалгах зорилгоор холбогдох мэдээллүүдийг шалган тогтоох зайлшгүй нөхцөл

байдал бий болж байна. Иймд Банкны тухай хуульд холбогдох нэмэлтийг нэн даруй оруулах шаардлагатай байна.

Авлига, мөнгө угаах, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг тэмцэхэд бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах шаардлагатай гэдгийг “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-ний тайланд<sup>1</sup> онцолсон байдаг. Тухайлбал, бэлэн мөнгөний хэрэглээ давамгайлсан бизнесийн орчинтой улс оронд халхавч аж ахуйн нэгж байгуулан бэлэн мөнгө хэлбэртэй гэмт хэргийн орлогыг бизнесийн орлого мэтээр банк, санхүүгийн системд оруулах эрсдлийг нэмэгдүүлж байна. Иймд бэлэн бус төлбөр тооцооны систем хөгжиж байгаатай холбоотой цаашид төсвийн байгууллагад бэлэн мөнгөөр орлого хүлээн авахыг үе шаттай бүрэн хориглох асуудлыг шийдвэрлүүлэх саналтай байна.

8. Төрийн албаны тухай хуулийн дагуу Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны ба төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосон. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.5.13-д “хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоох”, 4.1.5.14-д “хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгох”, 4.1.9.6-д “улс төрийн намын удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх”-ээр тус тус заасан.

Төрийн захиргааны ба төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэлтэй уялдуулах, үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалын жагсаалт”-ыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Авлигатай тэмцэх газар холбогдох төслийг боловсруулж байгаа бөгөөд тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг энэ намрын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай байна.

9. Сүүлийн жилүүдэд Засгийн газар шинээр байгуулагдах, сайд нар өөрчлөгдөх бүрт тухайн яам, агентлагийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж нийтийн болон төрийн жинхэнэ албан тушаалтныг томилох, чөлөөлөхтэй

холбоотой хувь хүний болоод улс төр, бизнесийн тодорхой хэсгийн ашиг сонирхол бүхий хууль бус нөлөөлөл нэмэгдэх хандлагатай байх төдийгүй тус газарт иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн ихэнх хувийг ашиг сонирхлын зөрчилтэй, хууль бус томилгооны талаарх асуудал эзэлж байна.

Түүнчлэн холбогдох мэдээлэл, судалгаанаас харахад тухайн яамдын сайд, удирдлага солигдох бүрт төрийн жинхэнэ албан тушаалтан тэр дундаа шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудыг өөрчлөн томилдог, тухайн ажлын байранд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр түр орлон гүйцэтгэгч томилж байгаа нь төрийн алба мэргэшсэн тогтвортой байх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангах зарчмууд алдагдаж, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлэх нэг хүчин зүйл болж байна гэж үзэхээр байна

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ хянах үйл ажиллагааны явцад дараахь нийтлэг зөрчил илэрч байна. Үүнд:

- ХАСУМ-ийг хянуулалгүйгээр тухайн албан тушаалд томилох;
- Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгөөгүй, эсхүл тэнцээгүй, ажлын байрны шаардлага, хуульд заасан шалгуур хангахгүй иргэдийг “түр орлон гүйцэтгэгч”, “гэрээт ажилтан” нэрээр төрийн албанд томилон ажиллуулах /АТГ 2020 онд ажлын байрны шаардлага, хуульд заасан шалгуур хангахгүй 848 этгээдийн талаар тухайн байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтанд анхааруулсан/;
- Албан тушаалын буюу ажлын байрны тодорхойлолтыг тухайн томилогдох этгээд, хувь хүнд зориулан субъектив байдлаар боловсруулах;
- Хоёр байгууллага, албан тушаалтны хооронд зөвшилцөж томилогддог албан тушаалтнуудын талаар зохих шатны удирдлагууд нь нэгдмэл байр сууринд хүрэлгүйгээр ХАСУМ ирүүлэн хянуулж, томилох /аймаг, нийслэлийн Засаг дарга нь төрийн төв байгууллагын удирдлагатай зөвшилцөж томилдог албан тушаалтны тухайд/;
- Түүнчлэн ХАСУМ хянуулахаар ирүүлж буй материалын бүрдэл хангалтгүй, хуулийн үйлчлэлд хамаарахгүй ангилал, зэрэглэлийн албан тушаалд ХАСУМ хянуулахаар болон томилох эрхгүй албан тушаалтнаас ирүүлэх, нэг албан тушаал дээр томилохоор судалж буй хэд хэдэн хүнийг сонгон шалгаруулалт явуулалгүйгээр ХАСУМ-ийг нь тус газарт

<sup>1</sup> Монголбанк. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ [https://www.mongolbank.mn/documents/cma/20161025\\_risk\\_assessment.pdf](https://www.mongolbank.mn/documents/cma/20161025_risk_assessment.pdf)

нэгэн зэрэг ирүүлэх зэрэг нөхцөл байдал гарч байна.

Иймд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшигч нь Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан болзол шалгуурыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, нөөцөд авагдсан эсэх, тухайн ажлын байранд тавигдах, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд болон төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан этгээд дахин өөр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн байдалд Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлтэй хамтран хяналт тавих, Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системтэй ХАСУМ-ийн цахим системийг уялдуулж, хяналтын механизмыг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Түүнчлэн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулалгүйгээр томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт тодорхойгүйгээс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд ХАСУМ хянуулалгүйгээр нийтийн албанд томилсон тохиолдолд томилох шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх заалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд нэмж оруулах шаардлагатай байна.

10. ХАСУМ-ийн хяналтаар 2015 онд 40, 2016 онд 39, 2017 онд 39, 2018 онд 25, 2019 онд 28, 2020 онд 8 этгээдийг тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлж, зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх практик тогтоон ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг дагалдуулан өөрчлөн найруулсан. Энэхүү өөрчлөлт нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоосон талаар албан бичиг хүргүүлсэн ч тухайн байгууллагын удирдлага нь түүнийг томилох, ашиг сонирхлын зөрчилтэй

нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх боломжтой болсон байна. Энэ нь дээрх хуулийн үндсэн агуулга, үзэл баримтлалыг алдагдуулж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.1-д заасан "...хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх" арга хэмжээтэй уялдаагүй, зөрүүтэй, Үндэсний хөтөлбөрийн 2.1.1-д тусгагдсан "шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх" зорилтоос ухарсан шийдвэр болсон байна.

Дээрх хуулийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг бууруулах буюу сахилгын шийтгэл ногдуулах хариуцлага тооцуулах хуулийн зохицуулалт хэвээр байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, салаа утгатай агуулгыг бий болгож байна.

11. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдснаас хойших хугацаанд 1072 төлөөлөгч нийтийн албанд (төрийн улс төрийн, төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний удирдах, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалд) томилогдохоор Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ээ ирүүлж, хянуулсан дүнтэй байна. Эдгээр 1072 төлөөлөгчдийн 64 нь төрийн жинхэнэ албан тушаал (төрийн захиргаа, төрийн тусгай)-д томилогдохоор ХАСУМ-ээ ирүүлсэн. Засаг даргын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, тухайн шатны төсвийг хэлэлцэж батлах, хяналт тавих чиг үүрэг бүхий ИТХ-ын төлөөлөгчид гүйцэтгэх буюу төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдож байгаа нь олон нийтэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг бий болгож холбогдох хууль тогтоомжийг зөрчихөөр байна. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д «Хуульд өөрөөр заагаагүй

бол төрийн жинхэнэ албан тушаалд дараах тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно» гээд 31.1.3-т “Хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол» хориглох зохицуулалттай байна.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5-д төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд “улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох”-ыг хориглосон. Хэдий тийм ч, дээрх хуулийн тайлбар хэсэгт “Энэ хуулийн 39.1.5, 39.1.6, 39.1.13 дахь заалт нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарахгүй” гэж заасан. Орон нутгийн сонгуулиар сонгогдсон /улс төрийн намын гишүүн, эсхүл үйл ажиллагаанд оролцож буй/ этгээдүүд төрийн жинхэнэ албанд томилогдох эсэх болон дээрх зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай байна.

12. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчлийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг тогтоон, хязгаарлаагүй. Гэвч шүүхийн практикт энэ төрлийн зөрчлийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын зөрчилтэй адилтган, хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр авч үзэж байгаа нь буруу практик тогтохоос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинж чанартай уялдаагүй, зөрчил гаргасан албан тушаалтан хариуцлагаас гадуур үлдэх эрсдэлийг бий болгон, хуулийн үндсэн зорилгыг алдагдуулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Иймд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг нэг мөр ойлгож, хэрэглэх, холбогдох хууль тогтоомжид “зөрчил гарснаас хойш 36 сар, зөрчлийг илрүүлснээс хойш 12 сар өнгөрсөн бол нийтийн албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.” гэсэн агуулга бүхий заалт нэмж оруулах зайлшгүй нөхцөл байдал бий болоод байна.

13. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг зөрчсөн тохиолдолд Нийтийн албан тушаалтанд шүүх хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байх

боловч тухайн хариуцлагыг хэрхэн оногдуулах журам хуульд тусгагдаагүйн улмаас хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх явдал хангалтгүй байна. Энэ хариуцлагыг шүүгч хүлээлгэхээр зохицуулсан байдаг ч өнөөдрийг хүртэл энэ төрлийн авлигын зөрчил шүүхээр шийдвэрлэхэд дагаж мөрдөх механизм(процесс) бүрэн бүрдээгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Мөн нийтийн албанд ажиллаж байхдаа Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчсөн иргэн ажлаас чөлөөлөгдсөн, өөр байгууллагад шилжин ажилласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй байгаа тул тухайн зөрчилд холбогдох хариуцлагыг шүүгч оногдуулдаг байх зохицуулалтыг хуульд нэмж тусгах хэрэгтэй байна.

14. Монгол Улсын өнөөгийн авлигын нөхцөл байдал, ялангуяа өндөр түвшний болон улс төрийн хүрээний авлигад нөлөөлж буй нэг том хүчин зүйл бол улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт юм. Улс төрийн намын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ” гэж заасан боловч хуулийг хэрэгжүүлэх, хариуцлагын механизм байхгүйн улмаас хэрэгжихгүй байна. Авлигын нөхцөл байдлын талаар зохион байгуулсан төсөөллийн судалгаа болон шинжээчдийн үнэлгээгээр Монгол Улс дахь улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт дахь авлига нь анхаарал хандуулах, онцгойлон авч үзэх шаардлагатай түвшинд хүрсэн байгааг харуулдаг. Тухайлбал, улс төрийн намын санхүүжилтийг бүрэн ил тод болгож, хандив өгсөн этгээд, тэдгээрийн хандивын хэмжээ болон намын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаарх мэдээллийг тусгасан санхүүгийн нэгдсэн тайлан гаргадаг болох, түүнийг ил тод болгох, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг оновчтой бий болгох; мөн Сонгуулийн ерөнхий хорооны мэргэшсэн, хараат бус байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улс дахь авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэхдээ зөвлөсөн. Энэ асуудлаар холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын механизмыг бүрдүүлэхэд Улсын Их Хурлаас тусгайлан анхаарал хандуулж ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

15. Улсын Их Хурлаас Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2000 онд, Их Монгол Улс байгуулагдсаны

800 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2006 онд, Татварын өршөөл үзүүлэх тухай хуулийг 2008 онд, Өршөөл үзүүлэх тухай хуулийг 2009 онд, Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийг 2015 онд тус тус баталсан байдаг. Эдгээр өршөөл үзүүлэх хуульд авлига, албан тушаалын гэмт хэргийг хамруулсан нь авлигыг өөгшүүлсэн, гэмт этгээдүүдэд ял завших боломж олгосон, авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн нөр их хөдөлмөрийг үнэгүйдүүлсэн үйлдэл болсны зэрэгцээ олон улсын байгууллага, судлаачдын зүгээс “Монгол Улс авлига, албан тушаалын гэмт хэргийг өршөөлд хамруулж байгаа явдал нь олон улсын хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчмыг гажуудуулсан, нийгмийн шударга ёсыг үгүйсгэсэн алхам болох”-ыг онцлон тэмдэглэдэг. Цаашид авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх талаар зарчмын шинжтэй өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлагатай байна.

### **Хоёр. Авлигатай тэмцэх газрын бүтэц зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр:**

1. Авлигын эсрэг амжилттай тэмцэл явуулахад авлигатай тэмцэх байгууллагууд хангалттай хэмжээний хүний нөөцтэй байхыг “Авлигатай тэмцэх байгууллагын Жакартагийн зарчим”-д тусгасан байдаг. Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт хамаарах ажлын ачаалал жилээс жилд өсч байгаатай холбогдуулан авлигын гэмт хэрэг, авлига ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол хянан шалгах бүтцийг эргэж харах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Авлигатай тэмцэх газарт ирүүлж буй өргөдөл, гомдлын 60 орчим хувийг орон нутаг дахь байгууллага, албан тушаалтантай холбоотой өргөдөл, гомдол эзэлдэг, тухайлбал тус газарт 2020 онд хүлээн авсан нийт 2282 өргөдөл, гомдол, мэдээллийн 40 шахам хувь нь орон нутгаас ирсэн байна. Манай байгууллага орон нутагт бүтцийн нэгжгүй тул төвөөс албан хаагч томилолтоор очиж ажилладаг. Төсөв, санхүүгийн боломж, төвд хариуцан шалгаж байгаа гомдол мэдээлэл, эрүүгийн хэргээсээ шалтгаалан ажлын хэсэг газар дээр нь урт хугацаагаар ажиллаж чадахгүй байдалд хүрэх, цөөн хоногт мөрдөн шалгах ажиллагааг хийдгээс асуудал бүрэн гүйцэд шалгагдахгүй байх, орон нутгаас бичгийн нотлох баримтуудыг гаргуулан авах, орон нутгийн хууль, хяналтын байгууллага, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан авахад хугацаа алдах, гэмт хэрэг,

зөрчлийг бүрэн илрүүлэн, шалтгаан нөхцлийг тогтоож буруутай албан тушаалтанд хуульд заасан хариуцлага тооцох, ял завшуулахгүй байх зэрэгт эрсдэл үүсч байна.

Түүнчлэн авлигын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд хяналт тавих прокурор, аливаа зөвшөөрөл олгох, хянан шийдвэрлэх шүүх нь орон нутгийн харьяалалтай байдаг нь авлига, ашиг сонирхлын шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг түргэн шуурхай шалгаж шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл, иргэд олон нийтэд чирэгдэл, хүнд суртал үүсэх сөрөг үр дагавар гарч болзошгүй байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан Авлигатай тэмцэх газрын бүтцийн нэгжийг бүсчилсэн хэлбэрээр байгуулан ажиллуулах зайлшгүй шаардлагатай байна.

2. Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлд зааснаар авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус Олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллаж байна. Энэхүү Олон нийтийн зөвлөлийн гишүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилдог. Улсын Их Хурлаас 2020 онд Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Авлигатай тэмцэх газрын даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурлаас томилдог зохицуулалтыг өөрчлөн, түүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурлаас томилохоор хуульчилсан. Энэхүү үзэл баримтлалтай уялдуулан Олон нийтийн зөвлөлийн гишүүдийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах, улс төрийн бус иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг бүрэн хамруулах, зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

### **Гурав. Авлигын хэргээр дагнан мэргэшсэн прокурор, шүүгчийг ажиллуулах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг Шударга байдлын үнэлгээний судалгаа, Улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагуудын хүрэн дэх авлигын төсөөллийн судалгаа болон бусад байгууллагуудын зохион байгуулсан удаа дараагийн судалгаагаар шүүх нь авлига хамгийн их тархсан институцуудын нэг гэж тодорхойлогддог. Сүүлийн үед иргэд, олон нийт авлигын хэргийн

шийдвэрлэлтэд шүүмжлэлтэй хандаж байна. Тухайлбал, хахууль авсан төрийн албан хаагчид харилцан адилгүй шийтгэл ногдуулсан шүүхийн шийдвэрийг харьцуулан тавьж, шударга бус явдал гэж иргэд үзэж байна. Үүний зэрэгцээ прокурор, шүүгчийг авлига, албан тушаалын гэмт хэрэгт хяналт тавих, хянан шийдвэрлэх чиглэлээр дагнан мэргэшүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Өнөөгийн Монгол Улс дахь шүүх тогтолцооны талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын шинжээчид үнэлгээ өгөхдөө шүүх тогтолцоог бэхжүүлэхийн тулд шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэхийг зөвлөсөн байдагт анхаарал хандуулах, улмаар авлигатай тэмцэх бодлогын хүрээнд Монгол Улс дахь шүүх тогтолцоог тусгайлан авч үзэх, авлигын эсрэг тэмцэл явуулж буй зарим улс орнуудын жишгийн дагуу авлигын гэмт хэргийг хянан үздэг дагнасан шүүх байгуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Бусад улс оронд дагнасан шүүх байхаас гадна хөдөлмөрийн шүүх, гэр бүлийн шүүх, патентын шүүх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн шүүх, авлигын шүүх зэрэг бие даасан төрөлжсөн шүүхүүдэд шүүгчид дагнан мэргэшин ажилладаг туршлага байна. Олон улсын туршлагаас харахад Филиппин, Пакистан, Индонези, Непал, Кени, Бангладеш, Бурунди, Хорват, Уганда Улсад авлигын хэргийн шүүн таслах ажиллагаа явуулах тусгай шүүх ажиллаж байна. 2009 онд Словак, 2010 онд Афганистан, Палестин, 2011 онд Камерун, Малайз, 2012 онд Болгар, Сенегал, 2013 онд Ботсвана, 2015 онд Мексик, 2016 онд Танзани, Тайланд Улсад авлигын эсрэг тусгай шүүхийг байгуулжээ. Авлигын хэргээр дагнан мэргэшсэн прокурор, шүүгчийг ажиллуулбал шийдвэр, захирамж, тогтоолын чанар сайжирч, хуулийг зөв хэрэглэх хууль хэрэглээний алдаа багасахад нөлөөлж, нийгмийн зүгээс шүүгчдэд өгөх сөрөг дүгнэлтийг өөрчлөх, шүүх шударга ажиллаж байгаа гэдэгт иргэдийн итгэл нэмэгдэх, гэмт хэргийн шүүн таслах үйл ажиллагаа, оногдуулах ялын бодлогод чанарын ахиц гаргахад нөлөөлнө гэж үзэж байна.

**Дөрөв. Эрх зүйн харилцан туслалцаа, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр:**

Авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт этгээдийг шилжүүлэх, гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгө илрүүлэх ажиллагааны үр дүн нь дан ганц

дотоодын хууль тогтоомж болон хууль сахиулах байгууллагын чадавхаас хамаарахгүй байна. Авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгахад бусад улс орнуудын хууль сахиулах байгууллагатай нягт хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх талаар системтэй арга хэмжээ авах, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс орнуудтай байгуулах, авлига, мөнгө угаах, терроризм, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис наймаалах зэрэг гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиглэлээр хоёр болон олон талт гэрээ байгуулж нэгдэн орох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улсад байгаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх, хураан авах, хөрөнгө буцаах ажиллагааг явуулах зорилгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэрээ байгуулах туршлага судлах, энэ чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллага /Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, хууль сахиулах байгууллага/-уудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ, эх сурвалж, хүсэлттэй холбогдсон тоо баримтуудын талаарх мэдээллийн нэгдсэн бааз, хууль сахиулах байгууллага хоорондын цахим санг бий болгож, үйл ажиллагаанд ашиглах, мэдээ, мэдээллийг тодорхой хугацаанд давтамжтайгаар шуурхай солилцох ажиллагаа болон гэрээний дагуу хүргүүлсэн мөрдөгчийн хүсэлтийн гүйцэтгэл, эргэх холбоонд тавих төрийн байгууллагуудын хяналтын тогтолцоог бий болгох, холбогдох бусад үйл ажиллагааг нэг мөр, тодорхой болгон журамлах нөхцөл бий болсны зэрэгцээ эрх зүйн туслалцааны хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагын түвшинд боловсруулах, хүсэлтэд тусгагдвал зохих мэдээ,

мэдээллийг олж авах арга зам, холбогдох бусад ажиллагааны талаар хуульчдын үргэлжилсэн сургалтын хүрээнд кредитийн сургалтад тусгайлан оруулах, холбогдох ном, гарын авлагыг боловсруулах, хүртээмжтэй болгох цогц арга хэмжээ авах хэрэгтэй байна.

#### **Тав. Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр:**

1. Шинэ коронавирусийн тархалттай холбоотойгоор эдийн засагт хүндрэл учирч байгааг холбогдох байгууллагууд илэрхийлж байна. Ингэснээр төрийн албан хаагч авлига, хээл хахуулийн гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдлийг бий болгож болзошгүй юм. Нөгөө талаас, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, иргэд, өрхийн худалдан авах чадвар буурах нь төрийн албан хаагчдын амьжиргааны нөхцөл доройтох, бодит орлого багасах үр дагаварт хүргэхээр байна. Иймд төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хадгалах, төрийн албан хаагчдын цалин, орлогыг бууруулахгүй байх, инфляц, хүн амын худалдан авах чадвартай уялдуулан цалинг нэмэх асуудлыг нэн даруй зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай байна.

2. Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тендер, худалдан авалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, авлига, ашиг сонирхлын эрсдэл арилаагүй, зөвлөмж, шаардлага хүргүүлсээр байхад доор дурдсан зөрчил, дутагдал гарсаар байна:

- хөрөнгө оруулалтын ажлуудыг зураг, төсөвгүйгээр баталсан;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаагүй хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан;
- худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр гэрээ байгуулж, тендерийн баримт бичгийг нөхөн бүрдүүлсэн;
- хэрэгжиж дуусаагүй, гэрээ дүгнээгүй ажил, арга хэмжээнд санхүүжилт олгосон;
- хууль зөрчин шууд худалдан авалт хийсэн;
- тендерт хамгийн бага үнээр шалгарсан аж ахуйн нэгж нь гэрээний хугацаанд анхны үнийг дүнг нэмэгдүүлэн, нэмэлт гэрээ байгуулж төсвийн хөрөнгө завшсан;
- төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил

үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр зохих сургалтад хамрагдаагүй, АЗ сертификатгүй этгээдийг тендерийн үнэлгээний хороонд ажиллуулсан г.м.

Иймд Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, төлөвлөлт болон гүйцэтгэлийг үр ашигтай, ил тод, олон нийтэд нээлттэй болгож, гүйцэтгэл, явцад хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг сайжруулах, дээрх зөрчлийг таслан зогсоох, цахим тендерийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, тендер шалгаруулалтыг 2 үе шаттайгаар явуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

3. Цахим тендерийн үйл ажиллагааг шинэчилж боловсронгуй болгох арга хэмжээг нэн даруй зохион байгуулах, ялангуяа дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн худалдан авах ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх өндөр эрсдэлийг бий болгож байна. Иймд төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг зөвхөн зар байршуулах, материал хүлээн авах түвшинд ашиглаж хязгаарлалгүйгээр худалдан авалтын төлөвлөлт, сонгон шалгаруулалт, үр дүн, гомдол шийдвэрлэлт, тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэл, тендер оролцогчийн түүх зэрэг мэдээллийг уялдуулан холбосон систем болгон хөгжүүлж, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шударга зохион байгуулах арга хэмжээ авах, энэ талаар холбогдох эрх зүйн зохицуулалт, механизмыг бий болгох шаардлагатай. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Ерөнхий гэрээгээр худалдан авах ажил, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар шат дамжлага, авлигын эрсдэлийг бууруулах, шуурхай байдлыг хангах нь зүйтэй.

4. Монгол Улсын Засгийн газар “Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал” [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn) системийг бий болгож эхний шатанд харилцан ялгаатай чиг үүрэг бүхий төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Цаашдаа иргэдэд үзүүлдэг 11250 орчим үйлчилгээг нэг системд төвлөрүүлэн төрийн үйлчилгээгээр хүнээс хамааралгүй үзүүлэхэд зорьж байгаа болно. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, дэд бүтцийг хөгжүүлж, цаг хугацаа, зардлыг хэмнэн, хүний оролцоог багасгаж байгаа энэхүү үйлчилгээг бүрэн гүйцэт ашиглахад, иргэд олон

нийтийг сургах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иргэдэд цахим үйлчилгээг хэрэглэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөн хүрээнд зохион байгуулах, энэ хүрээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“E-Mongolia буюу цахим Монгол хөтөлбөр”-ийн хүрээнд төрийн үйлчилгээг цахимжуулах, “ХУР”, “ДАН” системийг хөгжүүлж төрийн байгууллагуудын үйл ажиллаганы уялдаа холбоог сайжруулан, төрийн цахимаар үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж байгаа боловч зөвхөн төрийн үйлчилгээг лавлагаа, тодорхойлолт олгох төдийгээр хязгаарлалгүй, үйлчилгээний хүрээг тэлэх, төрөөс олгодог бүх төрлийн эрх, тусгай зөвшөөрөл, лавлагаа, зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх шаардлагатай байна. Иргэд цахимаар болон нэг цонхны үйлчилгээгээр дамжуулан төрийн ямар ч төрлийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; түүнчлэн төрийн үйлчилгээний, нэн ялангуяа цахим үйлчилгээний стандартыг тогтоон, хяналт тавих замаар иргэдэд тэгш, шуурхай, стандарт хугацааг баримтлан үйлчилж байгаа эсэхэд хяналт, мониторинг хийх, үйлчилгээ авсан иргэд тухайн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Тухайлбал, Азербайжан улсын төрийн үйлчилгээний цогц “ASAN” төв иргэдэд үзүүлж буй цахим үйлчилгээ бүрт програмд тодорхой хугацаа тогтоон өгч, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд иргэдэд хүнд суртал учруулсан, хууль бус нөлөөлөл үзүүлсэн байж болзошгүй гэж үздэг туршлагаас судалж нэвтрүүлэх боломжтой.

5. Байгууллага, албан тушаалтан хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад эрх хэмжээгээ хэтрүүлэн дүрэм, журам батлан мөрдүүлэх, төлбөр хураамж тогтоох асуудал түгээмэл байгаа нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, чирэгдэл учруулах шалтгаан болж байна. Тухайлбал, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “Хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг зөвхөн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон байхад дээрх заалтыг зөрчин иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гарган мөрдүүлж байгаад онцгойлон анхаарах

шаардлагатай. Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж, захиргааны хэм хэмжээний актад мониторинг, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан мэдээ гарган, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах шаардлага байна.

6. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж буй 26 жилийн хугацаанд 5 удаагийн хуулиар хэд, хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Цаг үе, нийгмээ дагаж төр, иргэний харилцаа ч мөн адил хувьсан өөрчлөгдөж байгаа тул хуулийн зохицуулалт өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэдгийг судлан үзэх шаардлагатай. Төрийн байгууллагууд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээ, чиг үүргийн талаар олон нийтэд тодорхой ойлголт өгдөггүй зэргээс хамааран иргэд тухайн нэг асуудлаар хаана, хэнд хандахаа мэдэхгүй байх тохиолдол гардаг нь иргэдийн бухимдлыг төрүүлдэг, иргэдээс төрийн эрх бүхий дээд шатны байгууллагад хандсан асуудлыг хянаж үзэж шийдвэрлэхгүйгээр шууд доод шатны байгууллагад шилжүүлэх явдал хэвшмэл болсон нь иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулах хүчин зүйл болж байна.

7. Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төрд учирсан хууль бус хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжийн зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх механизмыг бий болгох, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар зэрэг төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох, сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх чиглэлээр асуудал хариуцсан холбогдох байгууллагууд үр дүнтэй хамтран ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

8. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, батлахад



иргэдийн оролцоог хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай. Хэдийгээр багийн иргэдээр хэлэлцүүлсэн гэх боловч холбогдох материалыг архивын нэгж болгодоггүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй, үр өгөөж байхгүй ажлыг хийхээр баталдаг. Иймд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг урт, дунд болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөр, зорилттой нийцүүлэн төлөвлөх, ТЭЗҮ боловсруулсан ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, үр өгөөж нь хүртээмжтэй ажлыг хийхэд анхаарах, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хяналт мониторингийн ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, үр ашгийг үнэлж, дүгнэх, ил тод байдлыг хангуулах, олон нийтэд мэдээлэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх, хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах, сайн туршлагыг солилцох ажлыг зохион байгуулах шаардлагатай.

-oOo-



# ХОЁРДУГААР БҮЛЭГ

АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ  
БАЙДАЛ-2020



Хүүхдийн шударга  
байдлын түвшин

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Авлигатай тэмцэх газраас 2020 онд Шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагддаггүй, эсхүл хамрагдаж байгаа ч нарийвчлан үнэлгээ хийх шаардлагатай агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газар, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 9 байгууллагын<sup>1</sup> үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй, үүсгэж болзошгүй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээ зохион байгуулж, үр дүнг тухайн байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлов.

Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын хувьд чиг үүрэг, бүтэц эрх зүйн зөрчилтэй, шийдвэр гаргах үйл явц тодорхой биш, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт, төсөв санхүүгийн ил тод байдал, сахилга бат хангалтгүй, авлигын эсрэг бодлогоо тодорхойлоогүй, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл дутмаг зэрэг нь өндөр эрсдэл бий болгож байна. Тухайлбал:

- **Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой:** байгууллагын ажилтнуудын хөдөлмөрлөх эрхэд халдсан шийдвэр гаргах, төрийн албан хаагчийг орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам тодорхой бус, төрийн байгууллагад “орон сууцны зориулалтаар” газар эзэмшүүлсэн, газар эзэмших эрхийг холбогдох хууль тогтоомж зөрчин иргэн, хуулийн этгээдэд шилжүүлсэн, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагаас болон улс төрийн зүй бус нөлөөлөл их байдаг, хууль бус шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хуулиас давсан журам үйлчилдэг;
- **Төсөв санхүү, худалдан авалттай холбоотой:** худалдан авах ажиллагааг хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан

тушаалтныг олон давтамжтай ажиллуулах, үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалах харилцаанд хувийн ашиг сонирхол үүссэн;

- **Тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэцтэй холбоотой:** эрх зүйн байдлын хувьд хууль зүйн зөрчилтэй нөхцөл байдал үүссэн;
- **Авлигын эсрэг бодлого болон удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлтэй холбоотой:** авлигын эсрэг бодлого, төлөвлөгөө батлаагүй, үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл дутмаг, хангалтгүй;
- **Ил тод байдалтай холбоотой:** байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт хангалтгүй, шалгуур үзүүлэлтэд нийцээгүй;
- **Ёс зүй, шударга байдлын түвшинтэй холбоотой:** ёс зүй, хяналт, хариуцлагын тогтолцоо сул, тогтворгүй байгаа нь авлигын эрсдэлийг бий болгож байна.

Цаашид дээр дурдсан эрсдэлийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргах, холбогдох журмыг шийдвэртээ нарийвчлан тусгах;
- Тухайн байгууллагаас гаргасан шийдвэртэй холбоотой үүссэн эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, статистик гаргаж, шийдвэр гаргах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, норм, стандартын дагуу төрийн үйлчилгээ авч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тэгш эрхийг хангах;
- Хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй “эс үйлдэхүй” гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэж, ил тод мэдээлэх;
- Захиргааны ерөнхий хуульд заасан шийдвэр гаргах ажиллагааг хуульд заасан дараалал, хугацааны дагуу бүрэн явуулах, гаргаж буй шийдвэрийн хууль зүйн болон бодит үндэслэлийг оролцогч талуудад ойлгомжтой, тодорхой байлгах;

<sup>1</sup> Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Төв аймгийн Батсүмбэр сумын ЗДТГ, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Жижиг, дунд үйлдвэрийн газар

- Албан хаагчид бусдын зүй бус нөлөөлөл, дарамт шахалтаас ангид үйл ажиллагаа явуулах, тийнхүү дарамт шахалт үзүүлсэн нөхцөлд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 (“Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”)-д заасныг хэрэгжүүлэх;
- Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулах;
- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд АЗ сертификат олгох сургалтад хамрагдсан албан хаагчдыг тойргийн журмаар сэлгэж оролцуулах тал дээр анхаарч томилох;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалуулах үйлчилгээг банкуудын дунд нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлаж, чанар, үнэ /хүү/-ийн үзүүлэлтээр шалгаруулахаар холбогдох журамд өөрчлөлт оруулах;
- Авлигад өртөх өндөр эрсдэлтэй ажлын байр, албан тушаалыг авлигаас ангид байлгах, эрсдэлийг бууруулах үүднээс удирдлага, албан хаагчдад авлигын эсрэг сургалт, нөлөөллийн ажлыг идэвхтэй явуулах, авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцуулах, хянан шалгах тогтолцоог нэвтрүүлэх;
- Байгууллагын тодорхой үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, ажилтнаас шалтгаалах хүчин зүйлийг бууруулах, шат дамжлага, хүнд суртлыг багасгах;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилтийг хангах, авлигын эрсдэлтэй нэгжид эрсдэлийн үнэлгээ тогтмол хийх;
- Удирдлагын зүгээс авлигатай тэмцэх чиглэлээр идэвх санаачилгатай, манлайлалтай ажиллах, авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулах төсвийг шийдвэрлэх, тухайлбал, албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, авлигад өртөх магадлалтай албан тушаалын судалгааг гаргаж, хариу арга хэмжээ авах, албан хаагчдын хариуцлага, ёс зүй, авлигын эсрэг хандлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, цахим хуудас ажиллуулах болон фэйсбүүк пэйж, мэдээллийн самбарт хууль тогтоомжийн дагуу ил тод байх ёстой мэдээ, мэдээллийг “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн тухай бүр байршуулж, тогтмол шинэчлэн, иргэдийг мэдээлэл авах эрхээр хангах;
- Үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн ёс зүйн дүрэм батлах, ёс зүйн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, ёс зүйн хороог үр дүнтэй ажиллуулах, шаардлагатай төсвийг батлах, ёс зүйн зөвлөлийн тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйл ажиллагааг тайлагнаж байх зэрэг болно.

## УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА


Авлигатай тэмцэх газраас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г 13 дахь удаагаа зохион байгуулж, үр дүнг тооцов. Судалгаа нь авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах, авлигад автсан байдал, цар хүрээ, хэлбэрийг авч үзэх, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилготой. 2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайлан гаргаж байсан бол 2018 оноос эхлэн хоёр тусдаа судалгаа хийж байна.

Өмнө нь зөвхөн тоон судалгааны аргыг ашигладаг байсан бол 2018 оноос эхлэн чанарын судалгааны аргыг давхар нэвтрүүлж эхэлсэн. Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2018 болон 2019 оны судалгааны тоо баримттай харьцуулан 2020 оны өгөгдлийг шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тооцоолсон.

2020 онд улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс **3.98** гарч өмнөх оныхоос **0.10 пунктээр** буурсан үзүүлэлттэй байна. Тодруулбал, 2019 онд улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индексийн дундаж **4.08** гарч байжээ.


Энэ нь 2018 оны үзүүлэлттэй харьцуулахад **0.15 пунктээр** өссөн үзүүлэлт юм. Энэхүү судалгаа хийгдэж ирсэн өмнөх 12 жилийн үзүүлэлтийн дундаж **3.89** байгаа нь улс төрийн хүрээн дэх авлигын түвшин тогтмол өндөр байгааг харуулж байна<sup>2</sup>.

Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин, 2008-2020 он



2020 онд Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индексийг 2018, 2019 оныхтой ижил аргачлалаар тооцон гаргав. Энэ удаагийн судалгааны дүнгээр авлигын төсөөллийн индекс **3.82** гарч, өмнөх оныхоос үл ялиг буюу **0.04 пунктээр** буурсан байна.

Зураг 2. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын түвшин 2008-2020



Шинжээчдийн байр сууринаас дүгнэхэд нийгмийн дунд авлига байх ёстой үзэгдэл мэт болж, улмаар далд хэлбэртээ орсон байна. Монгол Улс дахь авлигын түвшинг бууруулахад улс төрчид, улс төрийн нам, томоохон бизнес эрхлэгчид, шүүх эрх мэдлийн байгууллагад хяналт тавих хууль хяналтын байгууллагуудын хүчин чармайлт, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн иргэдэд мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ур чадварыг бэхжүүлэх зэрэг асуудалд анхаарснаар ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй авлига бүрэн дуусгавар болохгүй ч харьцангуй түвшинд багасах боломж байгаа гэж үзжээ.

### ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД (ХАСХОМ МЭДҮҮЛЭГЧ)-ААС АВСАН СУДАЛГАА

Авлигын эсрэг хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд авлигатай тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгоход шаардлагатай зарим мэдээллийг цуглуулах зорилгоор ХАСХОМ мэдүүлэгчдийг хамруулсан судалгааг зохион байгуулав. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа онлайн судалгааны SurveyMonkey цахим хуудас ашигласан бөгөөд ХАСХОМ гаргадаг 4800 албан тушаалтан судалгаанд хамрагдсан.

Судалгаагаар мэдүүлэг гаргагчдаас хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн ил тод байдал болон ХАСХОМ мэдүүлэхэд учирч буй бэрхшээл, төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны үйл


ажиллагаа, авлигыг мэдээлэхэд бэлэн байдал болон мэдээлэхгүй байгаагийн шалтгаан, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл цуглуулав.

### Хөрөнгө, орлогын мэдүүлгийн нээлттэй байдал

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам”-ын 2.1-д “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр, батлагдсан маягтын дагуу жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байршуулж, иргэд, олон нийтийг энэ тухай мэдээлэл авах боломжоор хангана” гэж заасан. Энэ дагуу тус газраас хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд байршуулж ирсэн.

Судалгаанд оролцогчдоос цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг өөрчлөх шаардлагатай эсэхийг асуухад 64 хувь нь өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн байна.

*Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд (<http://хасхон.иаас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу?*




Орлогын хэмжээ нэмэгдэх тусам хөрөнгө, орлогоо ил болгох сонирхол буурч байна. Өөрөөр хэлбэл, өрхийн жилийн орлогын хэмжээ нэмэгдэх тусам “илүү хураангуй болгох” гэж хариулсан хувь нэмэгдэх хандлагатай байна.

### Авлигыг мэдээлэхэд бэлэн байдал

Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар албан тушаалтан албаны чиг үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

Энэ удаагийн судалгаагаар тухайн албан тушаалтан өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 77 хувь нь “Тийм” гэж хариулсан бол, үлдсэн хэсэг нь “Тухайн нөхцөл байдлаас хамаарна”, “Үгүй”, “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

*Өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл Та энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үү?*



Авлигыг мэдээлэхэд бэлэн буюу “Тийм” гэж хариулсан байдлыг аймаг, нийслэлээр авч үзвэл Баян-Өлгий, Дорнод, Ховд, Өвөрхангай аймгаас оролцсон албан тушаалтнуудын хувь хэмжээ харьцангуй бага байна.

### Хэрэв мэдээлэх бол хэнд мэдэгдэх вэ? (1-3 хүртэлх хариултыг сонгоно уу)



Авлигын эсрэг хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ ихэнх албан тушаалтнууд мэдэж байна. Тухайлбал, мэдээлэх болсон шалтгааныг нь авч үзвэл судалгаанд оролцогчдын 70 хувь нь “Мэдээлэх нь миний үүрэг”, 28 хувь нь “Мэдээлэх нь нийтийн тусын тулд” гэж хариулсан дүнтэй байна.


## ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА

Хүүхдийн шударга байдлын судалгааг Авлигатай тэмцэх газраас жил бүр зохион байгуулж байна. Уг судалгаа нь Монгол Улсын ирээдүй болсон хүүхдийн шударга байдал, ёс зүй, ёс суртахуун, төлөвшилтийн түвшинг үнэлэх, цаашид хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилготой.

Энэ удаагийн судалгаанд аймаг, нийслэлээс сонгон авсан түүврийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын эцэг, эхчүүдийг хамруулсан нь онцлог байв.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2020 оны судалгаагаар 4.01<sup>3</sup> гэсэн дүнтэй гарсан нь өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

### Хүүхдийн шударга байдлын түвшин оноор



Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин 9-11 дүгээр анги хүртлээ нэмэгдэж байгаад төгсөх ангидаа энэ хандлага нь буурч байна. Мөн сүүлийн хэдэн жилд эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшнээс бага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

3 Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

Шударга байх талаар хүүхэдтэй ярилцах, шударга хандсаных нь төлөө магтаж сайшаах, шударга бус зүйл хийвэл зэмлэх, шударга ёсны талаар зааж сургах, биеэр үлгэр дуурайл үзүүлэх нь хүүхэд төлөвшсөн иргэн болох эх үндсийг тавьж байна. Найз нөхдийн хүмүүжил, зөв хандлага, үлгэр дуурайл хүүхдийн шударга байдалд шууд нөлөөлж байна. Шударга ёсны тухай мэдээллийг сургуулийн орчин, сонин, хэвлэл, гэр бүлийн хүрээнд авах нь хүүхдийн шударга байдлын түвшинг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын ирээдүйг тодорхойлох хүүхдүүдийг балчир наснаас нь эхлэн зөв, шударга иргэн болгон хүмүүжүүлэх, тэдэнд авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлэхэд гэр бүлийн хүмүүжлээс гадна цэцэрлэг, сургуулийн орчин найз нөхдийн

хүрээлэл ихээхэн нөлөөлж байна. Эцэг эхчүүд, ялангуяа аавууд хүүхэдтэйгээ илүү ойр дотно байж тэдэнд байнга анхаарал хандуулах хэрэгтэй байна. Үүнээс гадна эцэг эхчүүд нас ахих тусам хүүхдэд тавих анхаарал халамж нь буурч байдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Судалгаанаас дүгнэн үзэхэд хүүхдийг төлөвшүүлж, шударга иргэн болгон хүмүүжүүлэхэд зөвхөн эцэг, эхийн үүрэг оролцооноос гадна боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг хүүхэдтэй ойр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын зүгээс шударга зөв явдлыг таниулах, үлгэрлэх, мэдээлэх чиглэлээр тодорхой үүрэг гүйцэтгэх хэрэгтэй байна.

## АВЛИГЫН ТҮВШНИЙ ГАДААД СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### Транспэрэнси интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн 2020 оны үр дүн

Берлин хотод төвтэй “Транспэрэнси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас улс орнуудын төрийн албан дахь авлигын талаарх шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэн жил бүр боловсруулдаг Авлигын төсөөллийн индексийн 2020 оны дүнг 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр дэлхий нийтэд зарласан.

Авлигын төсөөллийн индекс нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш, харин дэлхийн 180 гаруй орныг хамруулан АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, Хонконгод байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллагын судалгаа, үнэлгээний авлига болон түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч тодорхой аргачлалаар индексийг тооцон 0-100 онооны хооронд тодорхойлдог (0 оноо нь өндөр авлигатай, 100 оноо нь цэвэр) юм. Судалгаанд оролцсон улс орнуудын гуравны хоёр нь 50-иас бага оноо авсан бөгөөд дунджаар 43 оноо авчээ. Индексийн дүнгээр Монгол Улс 2020 онд 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оныхтой ижил оноотой боловч 5 байраар ухарсан үзүүлэлт болж байна.

Монгол Улсын индексийг тооцоход нийт 9 эх сурвалжийг ашигласан байна<sup>4</sup>. Үүнээс АНУ-ын “Пи Ар Эс” группээс гаргадаг Эрсдэлийн үнэлгээ 6 оноогоор, Швейцарийн “Ай Эм Ди”

байгууллагын өрсөлдөх чадварын эмхэтгэлийн үзэл бодлын судалгаа 4 оноогоор, Ардчиллын олон талт байдлын төслийн үнэлгээ 3 оноогоор тус тус өссөн бол Дэлхийн эрх зүйн төслийн Хууль дээдлэх ёсны индекс 3 оноогоор, “Глобал инсайт” байгууллагын Улс орнуудын эрсдэлийн түвшин 12 оноогоор тус тус буурчээ. Харин Дэлхийн эдийн засгийн форумын үзэл бодлын судалгаа, “Бертелсман сан” Шилжилтийн индекс, Дэлхийн банкны Улс орны бодлого, институцийн үнэлгээ, Эдийн засгийн мэдээллийн нэгжийн Улс орнуудын эрсдэлийн үнэлгээний оноо өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Дэлхийн улс орнуудын авсан онооны дундаж 43 байгаа нь өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна. Энэ оны судалгаагаар Дани 88, Шинэ Зеланд 88, Финлянд 85, Сингапур 85, Швед 85, Швейцар 85 оноотойгоор тус тус жагсаалтыг тэргүүлсэн бол Венесуэл 15, Йемен 15, Сири 14, Сомали 12, Өмнөд Судан 12 оноотойгоор сүүлийн байрт орсон байна. Бүс нутгаар нь авч үзвэл Баруун Европ болон Европын холбооны улс орнууд хамгийн өндөр үзүүлэлттэй буюу дунджаар 66 оноотой, харин Африкийн Суб-Сахарын бүсийн орнууд дунджаар 32 оноо авсан нь бусад бүсээс хамгийн бага байна. 2012 оноос хойш Грек 14, Мьянмар 13 оноогоор тус тус өссөн үзүүлэлт нь хамгийн өндөр өсөлттэй бол, мөн хугацаанд Ливан 5, Малави 7, Босни ба Херцеговина Улсын үзүүлэлт 7 оноогоор тус тус буурсан нь хамгийн өндөр уналт байна.

<sup>4</sup> <https://www.transparency.org/en/cpi/2020/results>



Харин манай хойд хөрш ОХУ-ын хувьд 30 оноо авч 129-р байрт бичигдсэн нь өмнөх оныхоос 2 оноогоор нэмэгдэж, 8 байр урагшилсан, БНХАУ-ын хувьд 42 оноо авч 78-р байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх оныхоос 1 оноогоор нэмэгдэж, 2 байр урагшилсан үзүүлэлт болж байна.

*Монгол Улсын үнэлгээнд ашигласан эх сурвалж, оноор*

Д/д	Байгууллага-судалгаа	2017	2018	2019	2020	20-21 Өөрчлөлт
1	“Пи Ар Эс» групп - Эрсдэлийн үнэлгээ 2020	32	32	35	41	6↑
2	“Ай Эм Ди”-Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл Үзэл бодлын судалгаа 2020	33	30	28	32	4↑
3	Ардчиллын олон талт байдлын төсөл /V-Dem/ 2020	35	33	31	34	3↑
4	Дэлхийн эдийн засгийн форум - Үзэл бодлын судалгаа 2019	30	31	28	28	→
5	“Бертелсман” сан - Шилжилтийн индекс 2020	41	41	37	37	→
6	Дэлхийн банк - Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2019	43	43	35	35	→
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж - Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020	37	37	37	37	→
8	Дэлхийн эрх зүйн төсөл- Хууль дээдлэх ёсны индекс 2019	36	36	36	33	3↓
9	“Глобал инсайт” байгууллага - Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019	35	47	47	35	12↓
Дундаж оноо		36	37	35	35	→

Өмнөх оны Индексээр манай улстай ижил 35 оноогоор 106-р байрт бичигдэж байсан Бразил 38 оноотой 94-р байрт, Албани, Зааны Ясан Эрэг болон Алжир улсууд 36 оноотой 104-р байрт, Умард Македон манай улстай ижил 35 оноотой 111-р байрт, харин Египет 33 оноотой 117-р байрт бичигдсэн байна. Мөн 2019 онд 34 оноотойгоор 113 дугаар байрт эрэмбэлэгдэж байсан Казахстан, Эль Салвадор улсын Авлигын төсөөллийн индекс 2-4 оноогоор өссөн нь Монгол Улсын индексийн оноо өөрчлөгдөөгүй боловч 5 байр ухрахад нөлөөлжээ.

### Транспэрэнси интернэшнл байгууллагын Дэлхийн авлигын хэмжүүр судалгаа (Global Corruption Barometer)

Транспэрэнси интернэшнл байгууллага нь 2003 оноос эхлэн 3 жил тутам Дэлхийн авлигын хэмжүүр үзүүлэлтийг боловсруулж байгаа бөгөөд дэлхийн улс орнуудын ард иргэдээс өдөр тутмын амьдралдаа авлигатай нүүр тулгарч буй эсэх талаар судалгаа авч, үр дүнг боловсруулдаг. 2020 оны Азийн Авлигын хэмжүүр судалгаанд нийт 20 мянган иргэнээс асуулга авсан бөгөөд 74 хувь нь засгийн газрын авлига томоохон асуудал болсон гэж хариулсан бол 5 хүн тутмын 1 нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авахдаа хахууль өгсөн гэж мэдэгдсэн байна.

2020 оны Дэлхийн авлигын хэмжүүр судалгаанд Монгол Улсын иргэдээс авсан судалгааны үр дүнд 69 хувь нь засгийн газрын авлига томоохон асуудал болсон гэж мэдэгдсэн бөгөөд 22 хувь нь сүүлийн 12 сард хахууль өгсөн хэмээн хариулжээ. Үүнийг хүн амын нийт тоонд харьцуулан үзвэл 704 мянган иргэн авлигад өртөх эрсдэлтэй байгаа юм.

Монгол Улсыг төлөөлөн судалгаанд хамрагдсан иргэдээс сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн гэж хариулсан төрийн байгууллагыг хүснэгт 1-т харуулав.

*Хээл хахууль өгсөн төрийн байгууллага, хувиар*

№	Төрийн үйлчилгээ	Хувь
1	Улсын сургууль	27
2	Улсын эмнэлэг, эрүүл мэндийн төв	17
3	Дэд бүтэц	10
4	Цагдаагийн байгууллага	9

Монгол Улсыг төлөөлөн судалгаанд хамрагдсан иргэдээс авлигад хамгийн их автсан гэж хариулсан төрийн байгууллага, албан хаагчдийг харуулав.

*Авлигад хамгийн их автсан төрийн байгууллага, хувиар*

№	Төрийн байгууллага, албан хаагч	Хувь
1	Цагдаа	27
2	Төрийн албан хаагч	30
3	Орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч	29
4	Парламентын гишүүн	56
5	Шүүгч	42

Монгол Улсыг төлөөлөн судалгаанд хамрагдсан иргэд “Авлигын түвшин сүүлийн 1 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэх асуултад хариулсан байдлыг харуулав.

*Авлигын түвшин, хувиар*

№	Хариулт	Хувь
1	Өссөн	35
2	Буурсан	31
3	Өөрчлөлтгүй	34
4	Мэдэхгүй	0

Бүс нутгийн түвшинд Монгол Улсын авлигын нөхцөл байдлыг харуулав.

*Авлигын нөхцөл байдал, хувиар, эрэмбэ*

№	Хариулт	Хувь	Бүс нутагт эзэлсэн байр
1	Засгийн газрын авлига нь томоохон асуудал болсон	69	6
2	Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авахдаа хахууль өгсөн	22	11
3	Авлигын түвшин өссөн	35	5
4	Авлигын түвшин буурсан	31	8

2020 оны судалгаанд хамрагдсан иргэдийн 22 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн гэж хариулсан нь 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 9 хувиар нэмэгджээ. Мөн 2017 онд цагдаа, төрийн албан хаагч, парламентын гишүүнийг хамгийн их авлигад автсан гэж судалгаанд оролцогчид хариулж байсан бол 2020 онд энэ жагсаалтад орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид нэмэгдсэн байна.

**TRACE интернэшнл байгууллагын Авлигын эрсдэлийн матриц судалгаа**

TRACE интернэшнл байгууллага 2014 оноос эхлэн жил бүр Авлигын эрсдэлийн матриц судалгааг боловсруулж нийтэд зарлаж байна. Энэхүү судалгааг дэлхийн 190 орчим улс орныг хамруулан зохион байгуулдаг ба бизнес эрхлэгчдэд тулгарч болох эрсдэлийн талаарх найдвартай мэдээлэл өгөх зорилготой юм. Авлигын эрсдэлийн матриц судалгааг Нэгдсэн үндэстний байгууллага, Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг байгууллагаас цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн боловсруулдаг. Тус судалгаа нь тухайн улс орон, бүс нутагт бизнес эрхлэгчдэд тулгарч болзошгүй авлигын эрсдэлийн үнэлгээг боловсруулж, хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлдэг юм.

Авлигын эрсдэлийн матриц судалгааг 2020 онд 194 улс орныг хамруулан 0-100 онооны хооронд тодорхойлсон бөгөөд 0 оноо нь авлигын эрсдэлгүй, 100 оноо нь авлигын өндөр эрсдэлтэй болно. Монгол Улсын хувьд Авлигын эрсдэлийн матриц судалгаанд 49 оноо авч 96 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Монгол Улс 2019 онд 55 оноо авч 200 улсаас 109 дүгээр байр эзэлж байв.

Монгол Улсын Авлигын эрсдэлийн матриц судалгааг нийт 4 нөхцөл байдалд тус бүрт нь үнэлгээ өгч боловсруулдаг байна.<sup>5</sup> Үүнд:

*Хүснэгт 6. Монгол Улсын үнэлгээ*

Д/д	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	20 – 21 Өөрчлөлт
1	Хүрээ 1: Бизнесийн хүрээ төртэй харилцах харилцаа	61	65	72	63	9↓
2	Хүрээ 2: Хээл хахуулийн эсрэг хяналт, хууль сахиулах байдал	37	42	42	50	8↑
3	Хүрээ 3: Төрийн алба, төрийн үйлчилгээний ил тод байдал	57	56	54	44	10↓
4	Хүрээ 4: Хяналт тавих иргэний нийгмийн чадавх	36	33	35	27	8↓
<b>Дундаж оноо</b>		<b>52</b>	<b>52</b>	<b>55</b>	<b>49</b>	<b>6↓</b>

**110 ТУСГАЙ ДУГААРТ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ**

Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсаар 2020 онд хүлээн авсан дуудлагын талаарх мэдээлэл

Д/д	Агуулга	I улирал	II улирал	III улирал	IV улирал	Нийт	
						Тоо	Дүнд эзлэх хувь
1	Зөвлөгөө авсан	1,003	1,117	907	855	3,882	45.8
2	Утсаар тоглосон	237	336	315	492	1,380	16.3
3	Санал хэлсэн	17	6	3	2	28	0.3
4	Дугаар андуурсан	569	547	478	708	2,302	27.2
5	Өмнө нь өгсөн гомдол мэдээллийн талаар тодруулсан	87	117	124	190	518	6.1
6	Төрийн байгууллагын хүнд сурталтай холбоотой мэдээлэл ирүүлсэн	-	2	47	-	49	0.6
7	Гомдол өгсөн	49	92	86	90	317	3.7
<b>8</b>	<b>Нийт</b>	<b>1,962</b>	<b>2,217</b>	<b>1,960</b>	<b>2,337</b>	<b>8,476</b>	<b>100.0</b>


<sup>5</sup> <https://www.traceinternational.org/trace-matrix?#matrix-results>

2020 онд 110 тусгай дугаарт нийт 17851 дуудлага ирсэн байна. Нийт дуудлагын 47.5 хувь нь зөвлөгөө авах, гомдол мэдээлэл өгөх, дуудлага андуурах, утсаар тоглох зэргээр холбогдож ярьсан бол 52.5 хувь нь дуудлага тасарсан, дуудлага холбогдсон ч яриагүй тасарсан байна. 2020 онд 110 тусгай дугаараар 317 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, бүртгэн шалгасан.

110 тусгай дугаарт хандан өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэдийн 145 буюу 45.7 хувь нь нэрээ нууцлахыг хүссэн бол 172 буюу 54.3 хувь нь нэр, хаягаа ил тодоор бүртгүүлсэн байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 56.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 32.5 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 4.1 хувь нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл, төрлөөр




110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны чиглэлийг харвал төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудлаар 64, хүний нөөцийн томилгоотой холбоотой 60, захиргааны шийдвэр гаргалттай холбоотой 29, тусгай зөвшөөрөлтэй холбоотой 28, тендер, худалдан авах ажиллагаатай холбоотой 27, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалттай холбоотой 27 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл, төрлөөр



110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны салбарыг харвал нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах салбарын асуудлаар 64, бага, дунд боловсролын салбартай холбоотой 26, эрүүл мэндийн салбартай холбоотой 25, зам, тээвэр, төмөр замын салбартай холбоотой 17, цагдаатай холбоотой 17 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсан байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл, төрлөөр



### ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Үзүүлэлт	МД	Тайлант он
<b>А</b>	<b>Б</b>	<b>1</b>
Өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, тайлант оны эхэнд	1	129
Тайлант онд шинээр хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл	2	2,282
Тайлант онд шалгасан өргөдөл, гомдол, мэдээлэл - бүгд	3	2,411
Гэмт хэргийн шинжтэй	4	1,377
Гэмт хэргийн шинжгүй	5	1,034
Тайлант онд шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээлэл - бүгд	6	2,218
Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	7	508
Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	8	506
Нэгтгэн шалгасан	9	4
Судалгаанд авсан	10	172
Өргөдөл, гомдол, мэдээллийг албан тушаалтан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх боломжтой	11	412
Өргөдөл, гомдол, мэдээллийг шууд шийдвэрлэх боломжгүй	12	10
Албан тушаалтан өргөдөл, гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэлээр хянан үзэхгүй байх	13	286
Албан тушаалтан өргөдөл, гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэлээр буцаасан	14	34
Харьяаллын дагуу шилжүүлсэн	15	286
Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хугацаагаар	16	2,218
Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн	17	2,218
Хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	18	-
Өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, тайлант оны эцэст	19	193
Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагч	20	2,411
Хувь хүн	21	1,649
Хуулийн этгээд	22	716
Нэр хаяггүй	23	46

## АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Энэхүү “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээг (цаашид судалгаа гэх) авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хууль, эрх зүйн орчин, байгууллагын чадвар, чадамж, практик дахь бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох, холбогдох санал зөвлөмж боловсруулах зорилгоор Авлигатай тэмцэх газар (АТГ), Улсын Ерөнхий прокурорын газар (УЕПГ), Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-өөс Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн Үнэлгээний баг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд асуумж судалгаа авах, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, мөрдөгч, прокурор, шүүхийн шийдвэр судлах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, холбогдох хууль тогтоомж судлах ажлыг гүйцэтгэв. Дүгнэлт зөвлөмжийг боловсруулахад Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Авлигын эсрэг конвенци болон зарим улс орнуудын сайн туршлагаас ашиглав. Судалгаанд оролцсон хуульч, албан хаагчид болон экспертүүдийн санал зөвлөмж, мөн ажлын хэсгийн гишүүдийн оролцоотойгоор хийгдсэн нийт 114 зөвлөмж тусгагдсан. Азийн сан судалгааны бүрэн хэмжээний тайланг 2021 оны 3 дугаар сард АТГ, УЕПГ, ШЕЗ болон АХБ-д албан ёсоор хүлээлгэн өгсөн. Энэхүү товч тайланд зарим гол үр дүнгүүд болон гол ач холбогдол бүхий 45 зөвлөмж багтсан болно.


## АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын Эрүүгийн хууль (ЭХ)-д 11 төрлийн авлигын гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих, шийдвэрлэх ажиллагааг АТГ-ын мөрдөгч, прокурор, шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-д заасан журмын дагуу явуулж байна (Дүрс 1.)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат дараалал



**Дүрс тайлбар:**




Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны тайланд дурдсанаар 2019 онд нийт 523 авлигын гэмт хэрэг бүртгэгдсэн. 2018-2019 оны статистикаас үзвэл АТГ хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн ойролцоогоор 53%-ийг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж шалгасан. Үүнээс 54%-д нь АТГ-ын

Мөрдөн шалгах хэлтэс хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгажээ. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасан нийт хэргийн 36%-д эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж шалгасан. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн 139 хэрэг буюу 40%-ийг шүүхэд шилжүүлсэн. Үүнээс 54% нь шүүхээр шийдвэрлэгдэн, үлдсэн хувийг нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаажээ.


Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны тайланд дурдсанаар 2019 онд нийт 523 авлигын гэмт хэрэг бүртгэгдсэн. 2018-2019 оны статистикаас үзвэл АТГ хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн ойролцоогоор 53%-ийг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж шалгасан. Үүнээс 54%-д нь АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгажээ. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасан нийт хэргийн 36%-д эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж шалгасан. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн 139 хэрэг буюу 40%-ийг шүүхэд шилжүүлсэн. Үүнээс 54% нь шүүхээр шийдвэрлэгдэн, үлдсэн хувийг нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаажээ.

#### Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн тойм зураглал (2018-2019)



Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан авлигын хэргийн дийлэнх хэсгийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, мөн хахуулийн гэмт хэрэг эзэлж байна. Харин үндэслэлгүй хөрөнгөжих, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах зэрэг бусад төрлийн авлигын гэмт хэрэг харьцангуй цөөн шалгагдсан байна (Хүснэгт 1). Эдгээр үзүүлэлтээс харахад 22.1, 22.8, 22.9, 22.10 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаарх мэдээлэл авах, илрүүлэх, мөн шалгах үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

#### Авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, хэрэг шийдвэрлэлт (2013-2019)



*Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан, шүүхэд шилжүүлсэн авлигын гэмт хэрэг 2017-2019*

№	Зүйл анги	ХБМБ явуулсан нийт хэрэг	МБ-ын хэрэг	Шүүхэд шилжүүлсэн
1	22.1 Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	915	268	51
2	22.4 Хахууль авах	242	161	64
3	22.5 Хахууль өгөх	116	158	55
4	22.6 Гадаад улсын ТБ, ОУ-ын байгууллагын албан тушаалтныг хахуульдах	-	2	-
5	22.8 Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	36	28	3
6	22.9 Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	11	0	1
7	22.10 Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	41	26	3
8	22.11 Дураараа аашлах	8	0	-
9	22.12 Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	21	7	1
<b>Нийт (2017–2019)</b>		<b>1390</b>	<b>649</b>	<b>178</b>

## СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих, шийдвэрлэх тогтолцоонд хамаарах үндсэн 5 асуудлыг судалгаагаар тодорхойлсон бөгөөд эдгээрийн хүрээнд үр дүн болон зөвлөмжүүд гарсан. Үүнд: (1) Эрх зүйн орчин; (2) Стратеги, арга тактик; (3) Мэдлэг, ур чадвар; (4) Байгууллагын чадамж, хамтын ажиллагаа; (5) Хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх.


### 1. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль боловсронгуй бус байгаа нь авлигын хэргийг мөрдөн шалгахад сөргөөр нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл болж байна (Дүрс 4). Тодруулбал, Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргийн тодорхойлолт, томъёоллыг мөрдөгч, прокурор, шүүгч эргэлзээгүй ойлгож, хэрэглэхэд бэрхшээлтэй, хуулийн зүйл хэсгүүд тайлбар шаардах, ижил төстэй хэргүүдэд өөр өөрөөр хэрэглэгдэхэд хүргэж байна. Түүнчлэн, хянан шийдвэрлэх ажиллагааны зарим зохицуулалт нь мөрдөгч, прокурор хэргийг шуурхай шийдвэрлэхэд саад учруулж байна.

**Авлигын гэмт хэргийн тодорхойлолт, томъёолол:** Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйл, хэсгүүдэд заасан гэмт хэргийн шинжийн томъёолол, тэдгээрийн уялдаа, хүндрэх нөхцлийн логик дараалал тус бүр өөр, холбогдох тайлбарууд нь логикын хувьд ойлгоход төвөгтэй, бүх заалтад адил ашиглах боломжгүй, эргэлзээ үүсгэхүйц байна. Өөрөөр хэлбэл, хулгайлах, дээрэмдэх, хөрөнгө завших гэх мэт бусад гэмт хэргийн хэсгүүд нь үндсэн шинж болон нэмэлт шинжээр задарч, хүндрэх дараалалтай байхад 22.1, 22.4-т заасан гэмт хэрэгт өөрөөр буюу шинжүүдийг нэг хэсэгт багтаах байдлаар томъёолсон байна.




Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад сэргөөр нөлөөлж буй хүчин зүйлс (Өөрийн үнэлгээний асуумжийн дүнгээс)




Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдлуудад гэмт хэргийн шинжгүй үндэслэл дийлэнх хэсгийг эзэлж байна (Дүрс 5). Эрүүгийн хуулийн зохицуулалт боловсронгуй бус байгаа нь гэмт хэрэг тус бүрийн онцлог шинж, ялгааг мөрдөгч, прокурор, шүүгчид ялгаатай ойлгож, тайлбарлах, улмаар гэмт хэргийн шинжийг анхнаас нь зөв тодорхойлоход саад учруулахаар байна. Түүнчлэн авлигын гэмт хэргийн тодорхойлолт нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид заасан агуулга, томъёололтой бүрэн нийцэхгүй байна. Жишээлбэл, Конвенцийн 15 дугаар зүйлийн (б) хэсэгт “давуу байдал олж авахаар шууд ба шууд бусаар шаардсан эсвэл авсан” үйлдэл нь суурь гэмт үйлдэл байхаар тусгасан байхад Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд “тохиролцсон байх” шинжийг орхигдуулсан байна.

Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон үндэслэл



**Хөөн хэлэлцэх хугацаа:** 2017 оны 7 сарын 1-нээс 2019 оны эцэс хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлтийн шатанд 44, мөрдөн байцаалтын шатанд 21, шүүхийн шатанд 5, нийт 70 авлигын хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болжээ. Энэ нь 3 жилд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт авлигын хэргийн 42%-тай тэнцэх тоо юм. Судлагдсан хэрэг бүртгэлтийн хэргийн 12.6%-д нь (хэрэг бүртгэлтийн хэрэг нээх үед) хэрэг үйлдэгдсэнээс хойш 5 буюу түүнээс дээш жил өнгөрсөн буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан байв (Дүрс 6). Түүнчлэн хэрэг бүртгэлтийн дундаж хугацаа хагас жил орчим байгаа бөгөөд зарим хэргийн хувьд 1 жил буюу түүнээс ч удаан үргэлжилж байгаа нь хөөн хэлэлцэх хугацаа хэрэг бүртгэлтийн шатанд дуусах нөхцөл болж байна (Дүрс 7).


Гэмт хэрэг үйлдэгдсэн гэх хугацаанаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээх хүртэл өнгөрсөн хугацаа



Авлигын гэмт хэрэг нууц далд, зохион байгуулалттай үйлдэгддэг нь цөөнгүй тохиолдолд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл удаан хугацааны дараа АТГ-т ирэх шалтгаан болж байна. Тухайлбал, дээр дурдсан 12.6%-ийг эзэлж буй гэмт хэргийн талаарх мэдээлэл 6-10 жилийн дараа ирж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн байна. Тиймээс авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 8-аас доошгүй жил болгож нэмэгдүүлэх шаардлагатай байна.


ЭХ-ийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолно гэж заасан нь хэргийн ээдрээ төвөгтэй байдал болон бусад шалтгаанаар хэрэг бүртгэлт удааширах, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дуусах дөхсөн хэрэг хэрэгсэхгүй болох нэг шалтгаан болж болзошгүй байна. Тодруулбал, судлагдсан хэрэг бүртгэлтийн хэргүүдийн ойролцоогоор 14% нь тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас 1-2 жилийн өмнө хэрэг бүртгэлтэд ирсэн байна. Нөгөө талаасаа хэрэг бүртгэлтийн хэргийн 16%-д хэрэг бүртгэлт 1 жилээс дээш, 2 жил хүртэл хугацаанд үргэлжилсэн байна.

Авлигын хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа



Тодруулбал, 150-600 сая хүртэлх төгрөгийн хахуулийн хэрэгт оногдуулсан хорих ялын дундаж хэмжээ нь 5-10 саяын хахуулийн гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын дундажтай ижил буюу 3.6 жил байна. Үүнтэй адилаар 150-160 сая хүртэл төгрөгийн хахуулийн гэмт хэрэг болон 1 сая хүртэлх төгрөгийн хахууль авсан хэрэгт оногдуулсан торгох ялын дундаж нь ижил буюу 6.1 сая төгрөг байна (Дүрс 9). Үүнтэй адилаар эрх мэдэл, албан тушаалаа урвуулсан гэмт хэрэгт оногдуулсан торгох ялын хэмжээ нь учруулсан хохирлын хэмжээг харгалзахгүй байна. Энэ нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 30.1 дэх хэсэгт “тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл оногдуулна”, мөн ЭХ-ийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр, хэмжээ, гэм буруугийн хэлбэрт нь тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

### Авлигын хэрэгт оногдуулсан ял шийтгэлийн дундаж хэмжээ




## 2. СТРАТЕГИ, АРГА ТАКТИК

Мөрдөн шалгах ажиллагаа мэдүүлэгт хэт тулгуурлах, гомдлын хүрээнд хязгаарлах, улмаар хэрэг нотлогдохгүй байх тохиолдлууд байгаа нь мөрдөн шалгах ажиллагааны шинэлэг арга аргачлал, стратегийг нэвтрүүлэх, ажлын ачааллыг бууруулах шаардлагатайг харуулж байна.

Өөрийн үнэлгээний судалгаанаас үзэхэд мөрдөгчдийн 94% нь мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлэг авах, 78% нь данс гүйлгээ шалгах ажиллагааг тогтмол ашигладаг гэж хариулсан. Харин 10% орчим нь ажиглалт явуулах, харилцаа холбоог хянах, компьютерийн шинжилгээ хийх зэрэг аргыг ихэнх тохиолдолд ашигладаг гэжээ (Дүрс 10). Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагаа үндсэндээ уламжлалт арга ажиллагаанд тулгуурлаж байгаа нь удаан хугацааны дараа илэрдэг, зохион байгуулалттай үйлдэгддэг авлигын гэмт хэргийг илрүүлэхэд үр дүн багатай байна.

Өөрөөр хэлбэл шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг цаг тухайд нь бүрэн гүйцэд хийгээгүйгээс цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдаж мэдүүлэг, бусад шууд бус эх сурвалжид үндэслэн хэргийг хаах, хэрэгсэхгүй болгох нөхцөл болж байна.

### Мөрдөн шалгах ажиллагааны арга техник (Өөрийн үнэлгээний асуумжийн дүнгээс)



### 3. МЭДЛЭГ, УР ЧАДВАР


Сургах, мэргэшүүлэх замаар авлигын хэрэг дээр ажиллаж буй мөрдөгч, прокурор, шүүгчдийн чадвар, чадамжийг дээшлүүлэхэд тогтмол хөрөнгө оруулалт хийх, ажлын ачааллыг бууруулах шаардлагатай байна.

**Мөрдөгч, прокурор, шүүгчийн ажлын ачаалал:** Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлийг ажлын ачаалал гэж үзэж байна (Дүрс 11). Ажлын ачаалал их байгаа нь АТГ-ын хүлээн авч шалгаж буй гомдол мэдээлэл, хэргийн тоо их, авлигын гэмт хэргийн онцлог, түүний ээдрээ төвөгтэй байдалтай холбоотой байна. Тухайлбал, хэрэгт холбогдох мэдээлэл, нотлох баримт цуглуулах, судлах, шаардлагатай дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл авах, хууль тогтоомж, гэрээ хэлцэл зэрэг өргөн цар хүрээ бүхий баримт материал судлах, хянан үзэх нь ихээхэн цаг хугацаа, ажиллагаа шаардаж байна. Энэ нь хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хугацаа болон чанарт нөлөөлж болзошгүй байна.

АТГ-ын нэг мөрдөгчид оногдох ачаалал өндөр байна. Хонг-Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо жилд 2500 орчим авлигын гэмт хэргийн талаарх гомдол хүлээн авдаг бөгөөд нэг мөрдөгчид 2.5 гомдол, мэдээлэл ногдож байна. Сингапурын Авлигатай тэмцэх алба жилд дунджаар 400 гэмт хэргийн шинжтэй гомдол хүлээн авдаг ба нэг мөрдөгчид 4 гомдол ногдож байна. Харин Монгол Улсын Авлигатай тэмцэх газар жилд 800 орчим гэмт хэргийн шинжтэй гомдол хүлээн авдаг бөгөөд нэг мөрдөгчид жилдээ дунджаар 17 гомдол, мэдээлэл шалгаж байна.

Мөрдөгч, прокурорын ажлын ачааллыг харгалзан, мөн олон улсын жишигт нийцүүлэн мөрдөн шалгах, түүнд хяналт тавих хүний нөөцийг тус тус нэмэгдүүлэх нь зүйтэй. Жишээлбэл, Хонг-Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны нийт албан хаагчдын 72%, мөн Сингапурын Авлигатай тэмцэх албаны нийт алба хаагчдын 60%-нь мөрдөгчид байна. Гэтэл Монгол Улсын АТГ-ын авлигын мөрдөгчид нийт албан хаагчийн ойролцоогоор 21%-ийг эзэлж байгаа нь дээр дурдсан улсуудын жишгээс хэт доогуур байна. Нөгөө талаасаа мөрдөн шалгах хүчин чадал ба тухайн улсын авлигын индекс хооронд хамаарал байгаа нь судалгаанаас харагдаж байна (Дүрс 12, Хүснэгт 2).

*Мөрдөгчийн тоо ба авлигын төсөөллийн индексийн харилцан хамаарал*



## Авлигатай тэмцэх байгууллагуудын мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хүний нөөцийн харьцуулалт

№	Улсын нэр	Байгууллагын нэр	Нийт ажилтны тоо	Мөрдөгчийн тоо/ ажилтны тоонд эзлэх хувь	Нэг мөрдөгчид ногдох хүн амын тоо	СРІ <sup>3</sup> байр/ оноо
1	Австри	Холбооны Авлигатай тэмцэх товчоо	115	55 (47.8%)	163,636	12/77
2	Бутан	Авлигын эсрэг хороо	68	28 (41.2%)	27,000	25/68
3	Хонг-Конг	Авлигын эсрэг бие даасан хороо	1400	1000 (72%)	7,500	16/76
4	Индонези	Авлигын эсрэг хороо	629	267 (42.4)	1,029,213	85/40
5	Литва	Тусгай мөрдөн шалгах алба	231	135 (58.4)	20,440	35/60
6	Монгол	Авлигатай тэмцэх газар	153	47 (21%)	70,000	106/35
7	Сингапур	Авлигыг мөрдөн шалгах товчоо	160	100 (62.5%)	58,000	4/85

**Прокурор, шүүгчийг мэргэшүүлэх:**

Прокурор, ялангуяа шүүгчийг авлигын хэрэгт хяналт тавих, шалгаж шийдвэрлүүлэхээр мэргэшүүлэн ажиллуулах нь авлигын гэмт хэргийг илүү үр дүнтэй шийдвэрлэхэд ач холбогдолтой болох нь судалгаанаас харагдаж байна. Авлигын хэргийг харьяаллын дагуу эрүүгийн хэргийн анхан шатны аль ч шүүхийн шүүгч хуваарилалтын дагуу шийдэх боломжтой. Энэ зохицуулалтын дагуу 2017-2019 оны хугацаанд нийт 69 шүүгч авлигын хэрэг шийдсэн бөгөөд үүнээс 72.4% нь зөвхөн 1 хэрэг шийдсэн бол үлдсэн 30% нь 2-3 хэрэг шийдсэн байна. Шүүгч ердийн харьяаллаар авлигын гэмт хэрэг шийдвэрлэж байгаа нь энэ төрлийн хэрэгт туршлагажих боломжийг олгохгүй байна. Ийнхүү мэргэшихгүй байх нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн авлигын гэмт хэргийн холбогдох зүйл заалтыг ялгаатай ойлгож, хэрэглэх, эрүүгийн хариуцлагыг ижил төстэй хэрэгт хүнд, хөнгөн янз бүр оногдуулахад хүргэж байна. Өөрөөр хэлбэл авлигын хэрэг цөөн шийдэж байгаа шүүгч илүү хүнд ял оногдуулах, харин олон шийддэг шүүгч илүү хөнгөн шийдэх хандлага ажиглагдсан.

**Мөрдөгч, прокурор, шүүгчийг сургах, чадавхжуулах:** Өөрийн үнэлгээний асуумж судалгаанаас харахад мөрдөгч, прокурор, шүүгчийн хувьд харилцан бие биений мэдлэг ур чадварт сэтгэл дундуур буюу шүүмжлэлтэй хандаж байна. Энэ нь нэг талдаа зохих мэдлэг, туршлага бүхий хүнийг мөрдөгч, шүүгч, прокуророор

томилох, нөгөө талдаа томилогдсон ажилтнуудыг ажлын байрны шаардлагад нийцүүлэн сургах асуудал хангалтгүй байгааг харуулж байна. Судалгаанаас үзэхэд авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих чиглэлээр тогтмол ашигладаг практик гарын авлага, сургалтын материал байхгүй гэж үзэхээр байна. Ялангуяа авлигын гэмт хэрэг тус бүрийн шинжийн талаар албан ёсны дэлгэрэнгүй тайлбар, стандартчилсан мэдээлэл байхгүй байгаа нь мөрдөгч, прокурор, шүүгчид хэргийн нөхцөл байдал, нотлох баримтыг өөр өөрөөр ойлгох, тайлбарлах нөхцлийг бүрдүүлж байна.

**4. БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих, шийдвэрлэх чиг үүрэг бүхий алба нэгжийн хүний нөөцийн чадамж, санхүүжилтийг нэмэгдүүлэх, холбогдох журам, зөвлөмж, сургалтын материалыг АТГ, УЕПГ, ШЕЗ хамтран боловсруулж, нэг мөр мөрдүүлэх, энэ чиглэлээрх байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Мөрдөгч, прокурор, шүүгч нарын дунд ойлголт, хандлага, арга ажиллагааны хувьд ялгаатай зүйлүүд байгаа нь судалгаанаас харагдсан. Тиймээс харилцан бие биенээс суралцах, мэдлэг, мэдээлэл хуваалцах, хууль тогтоомж, холбогдох журам, арга ажиллагааны талаар ижил ойлголт,


нэгдмэл хандлага бий болгох шаардлагатай байна. Нэгдмэл ойлголт, хандлага хангалтгүй байгаа нөхцөлд мөрдөн шалгах ажиллагааны шинэ санаачлага, арга аргачлал нь бодитой хэрэгжиж, үр дүнгээ өгөх боломжгүй юм.

Судалгаанаас үзэхэд авлигын хэрэгт гаргаж буй мөрдөгч, прокурор, шүүхийн шийдвэрийн үндэслэл нь хангалтгүй, тусгах практик алдаатай, бүрэн бус тохиолдлууд байгаа нь хэрэг буцах, шийдвэрлэлт удаашрах нэг шалтгаан болж байна. Тодруулбал, шийдвэрт хүрч буй оюун дүгнэлт, шалтгаант холбоог хангалттай, тодорхой бичээгүй, шийдвэрт хүрсэн үндэслэл болон түүнийг нотлох баримт, мэдээллийг зааж өгөөгүй, тайлбарлаагүй байна. Шийдвэр ойлгомж муутай, анализ, дүгнэлт, шийдвэрийн логик гаргалгаа хангалтгүй байгаа нь дараа дараагийн шатанд тухайн шийдвэрийг хянахад ойлгомжгүй, эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэх, улмаар хэрэг буцах, хэрэгсэхгүй болох нэг шалтгаан болж байна. Эдгээр асуудал нь ажлын ачаалал, мэдлэг ур чадвараас хамааралтай хэдий ч байгууллага хооронд бодлого, зохицуулалтыг сайжруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

## 5. ХӨНДЛӨНГИЙН НӨЛӨӨЛЛӨӨС АНГИД БАЙХ

Хэргийг хууль ёсны дагуу, шударга, хараат бусаар шийдвэрлэхэд хөндлөнгийн нөлөөлөл байгаа нь асуумж судалгааны үр дүн болон ганцаарчилсан ярилцлагуудаас харагдаж байна (Дүрс 14). Ялангуяа хэрэгт шууд ба шууд бусаар ашиг сонирхол бүхий иргэн, албан тушаалтан хэргийн талаар ярих, асууж тодруулах, уулзах тохиолдол цөөнгүй гарч байна. Хараат бус байж, хэргийг шударгаар шийдэж байгаагаа мөрдөгч, прокурор, шүүгч нар хэлж байгаа хэдий ч аливаа хэлбэрийн хөндлөнгийн нөлөө, оролцоо ийнхүү ямар нэг хяналтгүй байгаа нь шийдвэрт нөлөөлөх эрсдлийг нэмэгдүүлж байна. Тиймээс мөрдөгч, прокурор, шүүгчийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалахад онцгойлон анхаарах, хараат бус ажиллах нөхцлийг хангах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан боловсронгуй болгох нь чухал байна.

*Авлигын гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд зүй бус нөлөөллийн үзүүлэх сөрөг үр дагавар  
(Өөрийн үнэлгээний асуумжийн дүнгээс)*



**Авлигын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх явцын хяналтыг нэмэгдүүлэх, хэргийн нууцлалыг хангах, мөрдөгч, прокурор, шүүгч, бусад этгээд хоорондын албан бус харилцааг хязгаарлах:** Авлигын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх явцын хяналтыг нэмэгдүүлэх нь нөлөөллөөс ангид байх, хэрэг шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах ач холбогдолтой юм. Тухайлбал, Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг хараат бус, эрх бүхий этгээд давхар хянан үзэх, ажиллагааны явцад тодорхой асуудлыг шалгах, анхаарал татсан хэргийг тусгай журмаар шалгах зэрэг арга хэмжээ авах боломжтой.

Өөрийн үнэлгээний асуумж судалгаанд оролцсон мөрдөгчдийн 22%, прокуроруудын 30%, шүүгчдийн 44% нь зүй бус нөлөөлөл, дарамт шахалт авлигын хэргийг шалгаж, шийдвэрлэхэд их, маш их сөрөг нөлөөтэй байна гэж үзэж байна. Тодруулбал, танил тал, хамт ажиллаж байсан, удирдах албан тушаалтнууд мөрдөгч, прокурор, шүүгчтэй утсаар ярьж хэрэгтэй холбоотой зүйл асуудаг, лавладаг, гуйлт хүсэлт тавьдаг талаар хэлж байв. Олон нийтийн анхааралд өртсөн авлигын хэрэг, эсхүл тухайн хэрэгт холбогдох мэдээлэл, нотлох баримтыг ил болгох, мөн уг хэргийг аль шүүхийн, ямар шүүгч шийдвэрлэх гэж буй талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх нь шүүгч хэргийг ямар нэг хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр

шийдэхэд ихээхэн саад учруулж байгааг шүүгчид хэлж байна. Тиймээс хэргийн оролцогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчтэй харилцах харилцааг нарийвчлан зохицуулах, хязгаарлалт хийх замаар мөрдөгч, прокурор, шүүгчийг болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Тухайлбал, хэргийн оролцогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчтэй харилцах харилцааг нарийвчлан зохицуулах, утсан харилцаа холбоо, биечлэн уулзалтыг албажуулж, бүртгэлжүүлэх, албан бус харилцааг хориглох замаар мөрдөгч, прокурор, шүүгчийг болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

## ЗӨВЛӨМЖ

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих, шийдвэрлэх тогтолцоонд хамаарах үндсэн 5 салбар асуудлыг судалгаагаар тодорхойлсон бөгөөд эдгээрийн хүрээнд өөрчлөн сайжруулах зөвлөмжүүд гарсан. Хоорондоо харилцан хамаарал бүхий эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд хууль тогтоомж, журамд өөрчлөлт оруулах, төсөв санхүүжилтийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны арга хэлбэр, стратегийг сайжруулах цогц арга хэмжээ авах шаардлагатай. Энэ хүрээнд АТГ, УЕПГ, ШЕЗ тус бүртээ арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс гадна төрөөс нэгдмэл бодлого, цогц үйл ажиллагаа хэрэгжүүлж байж өөрчлөлт бүрэн биелэлээ олох боломжтой юм. Судалгааны дагуу нийт 114 зөвлөмж өгч байгаа бөгөөд дараахь хүснэгтүүдэд хамгийн гол ач холбогдол бүхий 45 зөвлөмжийг багтаав.

ЭРХ ЗҮЙН ОРЧИН		
ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ	Д/д	ДЭЛГЭРЭНГҮЙ ЗӨВЛӨМЖ
<b>ЭХХШТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах</b>	1	АТГ-т өргөдөл, гомдол хүлээн авах, татгалзах үйл ажиллагааг багаар шийдвэрлэдэг болох. Өргөдөл, гомдол, гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж болох зохицуулалтыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон ЭХХШТХ-д оруулах;
	2	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгохын өмнө бие даасан, хараат бус хороо шийдвэрийг хянадаг тогтолцоог хуулийн байгууллагын бүтцэд бүрдүүлэх. Энэ боломжийг бүрдүүлэх өөрчлөлтийг Авлигын эсрэг хууль, ЭХХШТХ-д оруулах;
	3	Авлигын хэргийг давж заалдах шатны шүүх, анхан шатны журмаар шийддэг байхаар хуульд өөрчлөлт оруулах;
	4	Нөлөө бүхий албан тушаалтан үйлдсэн, ээдрээ төвөгтэй, олон холбогдогчтой авлигын хэргийг бүрэлдэхүүнтэй шийддэг байх зохицуулалтыг ЭХХШТХ-д оруулах;
	5	Мөрдөгч, прокурорын шийдвэрийг дээд шатанд хянахдаа уг шийдвэрийг гаргахад зөвлөлддөг буюу шууд хяналт тавих прокуророос өөр буюу дээд шатны прокурорын газрын прокурор хянаж шийдвэрлэдэг байхаар хуульчлах;
	6	Хохирогч, нэхэмжлэгч тогтоогдоогүй, мөн нэргүй гомдол, мэдээлэлд хамаарах хохирогчийн эрхийг хөндлөнгийн, хараат бус этгээдэд шилжүүлж болох заалтыг хуульд оруулах;

<b>ЭХ-д нэмэлт өөрчлөлт оруулах</b>	7	Хорих эсхүл торгох ял шийтгэлийг сонгох үндэслэл, нөхцлийг тухайн гэмт хэргийн шинж, хүнд хөнгөний байдлаас хамаарч шатлалтайгаар тогтоодог зохицуулалтыг бий болгох;
	8	Авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх өөрчлөлтийг ЭХ-д оруулах эсхүл;
	9	Тэнсэх арга хэмжээг хэрэглэх үндэслэл, нөхцөлийг тухайн гэмт хэргийн онцлог, хэргийн хүнд хөнгөн байдалд уялдуулан ялгамжтай хэрэглэх нарийвчилсан зохицуулалтыг ЭХ-д оруулах;
	10	Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг гэмт хэргийн хүнд, ноцтой байдал, түүний улмаас учирсан хохирлын хэмжээ, албан тушаалын байдалтай нь уялдуулан тогтоох зохицуулалтыг ЭХ-д оруулах. Тухайлбал, гүйцэтгэх, удирдах албан тушаалтан үйлдсэн бол ялын доод хэмжээ нь тус тус өөр байхаар тогтоох;
	11	Эрүүгийн хуульд хөрөнгө хураах ялыг оруулах;
	12	ЭХ-ийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн томъёолол, харилцан хамаарал, логик дарааллыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийг томъёолж буй аргачлалалаар, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэн шинэчлэн найруулах;
	13	Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт үйлдэл, эс үйлдлийг өөр төрлийн буюу бие даасан гэмт хэрэг болгох;
	14	Хахууль авах гэмт хэргийг үйлдсэн этгээдэд авсан хахуулийн хэмжээг харгалзан ял шийтгэл оногдуулах зохицуулалт, шатлалыг ЭХ-д оруулах;
	15	Нийтийн албан тушаалтанд давуу байдал бий болгосон, мөн хууль бусаар давуу байдал олж авсан нийтийн албан тушаалтан биш этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгох;
	16	Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Авлигын эсрэг конвенцид нийцүүлэн эрүүгийн хуулийн тусгай ангид засан бусад бүлгийн гэмт хэргээс аль болох уртаар буюу 8-аас доошгүй жилээр тогтоох;
<b>Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах</b>	18	Хөөн хэлэлцэх хугацаа хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээр зогсдог байх өөрчлөлтийг ЭХ-д оруулах;
	18	Нэр хаяггүй мэдээллийг шалгах журам, мөн мэдээлэгчийн ойлголт болон мэдээлэгч нэр хаягаа өгөхгүй байж болох зохицуулалтыг ЭХ-д нарийвчлан тусгах;
	19	Авлигын эсрэг хуулийн 4.1-т заасан нийтийн албан тушаалтны жагсаалтыг Авлигын эсрэг конвенцид нийцүүлэн өргөжүүлэх. Тухайлбал Авлигын эсрэг хуулийн 4.1.2-т “мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадлагаа гаргах, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий төрийн үйлчилгээний албаны ажилтан” “хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий аливаа хороо, комиссын гишүүн, дарга” гэж тус тус нэмэх;





# ГУРАВДУГААР БҮЛЭГ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР,  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 2020



## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 2020 ОН

**Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд нийт 10 үйл ажиллагаа, 26 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.1.1-Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох /АТГ, ТАЗ, 2017-2022/

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу Авлигатай тэмцэх газар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлдэг.

Авлигатай тэмцэх газраас 2017 онд 11143, 2018 онд 10461, 2019 онд 8682, 2020 онд 13030 хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хүлээн авч, хянан шийдвэрлэсэн бөгөөд нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсч болзошгүй, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал тогтоогдсон эсэх талаар долоо хоног тутам иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлээд байна.

2020 онд хянан шалгасан мэдүүлгээс 848 нэр дэвшигчийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан, шаардлага хангаагүй үндэслэлээр 489 мэдүүлгийг буцааж, 8 нэр дэвшигч тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдож байгаа талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн болно.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг Сонгуулийн ерөнхий, Хүний эрхийн үндэсний комисс, Санхүүгийн зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Үндэсний хөгжлийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Иргэний нийсэхийн ерөнхий газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Сэлэнгэ, Сүхбаатар, Өвөрхангай, Дундговь, Увс, Баян-Өлгий, Орхон, Хэнтий аймгууд холбогдох цахим хуудсандаа байршуулж хэвшүүлжээ.

Төрийн албаны зөвлөл холбогдох дүгнэлтийг өөрийн цахим хуудас дахь “Төрийн албаны зөвлөлийн хуралдааны тойм” хэсгээр дамжуулан ил тод болгож байгаа боловч Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх ажлыг цогц байдлаар зохион байгуулах ажилд төдийлөн ахиц гараагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга(цаашид “Төрийн албаны тухай хууль” гэх)-ын 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх, шалгалтын үйл явцыг иргэд олон нийт хөндлөнгөөс ажиглах боломжийг бүрдүүлсэн.

Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн захиалгын дагуу яам, Засгийн газрын агентлагийн удирдах албан тушаал, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн

бичгийн дарга зэрэг төрийн жинхэнэ албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс түшмэлийн ангилалд хамаарах 450 удирдах албан тушаалын шалгалт / Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн шалгалтад орсон/-ыг зохион байгуулахад хамгийн өндөр оноо авсан 350 албан хаагч, гүйцэтгэх албан тушаалын 1581 сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлахад хамгийн өндөр оноо авсан 578 албан хаагч, иргэнийг тус тус албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөл, түүний Салбар зөвлөлүүд нэр дэвшүүлж сул орон тоог нөхсөн байна.

Төрийн албаны зөвлөл, түүний Салбар зөвлөлүүд 2020 онд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 450 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан нь өмнөх оныхоос 15.2 дахин нэмэгдсэн бол төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 1581 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар өмнөх онтой харьцуулбал 28.3 дахин, 578 сул орон тоог нөхсөн нь өмнөх оныхоос 44.5 дахин тус тус нэмэгдсэн байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2020 онд төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулахдаа бүртгэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг бүрэн цахимжуулснаар уг үйл ажиллагаанд хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөл орохоос урьдчилан сэргийлж, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй зарчмыг ханган, шалгалтад оролцогчид мэдлэгээ бодитоор сорих боломжийг бүрдүүлж, хэвшүүлээ.

Мэдээлэл технологийн дэвшлийг ашиглаж олон улсад түгээмэл ашиглагддаг ном, сэтгүүлийг цахим платформоор дамжуулан шалгалтын сорилтой уншиж танилцах, онлайн тест боловсруулан өдөр тутам шинэчлэн түгээснээр виртуал орчинд иргэд өөрсдийн мэдлэг чадвараа урьдчилан сорих боломжийг бүрдүүлэн цахим зөвлөмж, цахим ном, шалгалтад хамтдаа бэлтгэх онлайн булан ажиллуулж байна. Төрийн албаны ерөнхий шалгалтад нийт 16218 иргэн бүртгүүлснээс 12286 иргэн буюу 75.7 хувь нь шалгалтад орж, нийт оролцогчдын 5017 буюу 40.8 хувь нь ерөнхий мэдлэгийн шалгалтад, 4070 буюу 33.1 хувь нь монгол хэл бичгийн шалгалтад, 3823 буюу 31.1 хувь нь дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэн цаашид төрийн жинхэнэ албаны сул ороны тооны тусгай шалгалтад орох эрхтэй болсон байна.

Ерөнхий шалгалтын үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн салбар комисс болон нийт 516 албан хаагч дэмжлэг үзүүлж ажилласны зэрэгцээ шалгалт авах 30 анги танхимд нийт

2010 компьютер, шалгалтын явцыг олон нийтэд нээлттэй, ил тод харуулах, хөндлөнгийн хяналтыг тогтоох зорилгоор шалгалт зохион байгуулж буй анги танхимд 39 хяналтын камер, анги танхимын гадна талд 22 дэлгэц байршуулан сонирхсон иргэдэд шалгалтын үйл явцыг нээлттэй байлгаж боломжийг бүрдүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.1.1-2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх / АТГ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын “Б” хэсэгт заасны дагуу “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” БАТАЛГААНЫ МАЯГТ-ыг ашиглан мэдүүлэг гаргах ажлыг зохион байгуулж байна. ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2017 онд эхлүүлэн системийн хөгжүүлэлтийг 2018 онд дуусгаж, 2019 оноос ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой болсон. 2019 онд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-тай цахим системээр холбогдон хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлүүлж улмаар Сангийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, “Улаанбаатар төмөр зам” ХНН, Увс, Завхан, Өвөрхангай, Төв, Баян-Өлгий, Баянхонгор зэрэг нийт яам, агентлаг, аймаг, орон нутгийн төрийн захиргааны болон төрийн өмчит компаниуд зэрэг 41 байгууллага цахим системд бүрэн холбогдоод байсан бол 2020 онд төрийн болон нутгийн захиргааны 884 нэгжийг цахим системд холбосон нь нийт холбовол зохих нэгжийн 80 орчим хувийг эзэлж байна. Авлигатай тэмцэх газраас 2020 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн 13030 мэдүүлгийг хүлээн авч, хянан шийдвэрлэсэн. Хянасан мэдүүлгээс 2033-ыг нь цахим системээр хүлээн авсан нь нийт урьдчилсан мэдүүлгийн 35.7 хувийг эзэлж байна.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагааг цахимжуулах

ажлын явц 90 орчим хувьтай байна. Системд ХАСУМ-ийг бүртгэх эрхийг нийт байгууллагуудын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд үүсгэсэн бөгөөд ингэснээр тухайн байгууллагад томилогдохоор нэр дэвшигч нь ХАСУМ-ийг цахим системд мэдүүлдэг болсон. ХАСУМ-ийн хяналт шалгалтын явц, үр дүнг системээс үзэх боломжтой болсон бөгөөд 2020 онд 81 байгууллага, түүний харьяа 1495 байгууллага ХАСУМ-ийг цахимаар хянуулсан байна.(Биелэлт 70 хувь)

4.1.1.1-3. ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах /АТГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12-т Төрийн албаны зөвлөл Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт (тухайн албан тушаалын) өгөх болзол, журам, Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмуудыг батлахаар заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор холбогдох журмуудыг батлан мөрдүүлж байна. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.6-д “Нэр дэвшигчийг томилохоос өмнө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д заасан мэдүүлгийг авсан байна.” гэж тусган хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.1-4. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /АТГ, ТАЗ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас яам, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийслэл, дүүрэг, 21 аймаг, зарим сумдад ажиллаж хуулийн хэрэгжилт болон төрийн албан дахь хүний нөөцийн томилгоонд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг тухайн албан тушаалд томилсны дараа хянуулахаар ирүүлсэн тоо 2017 онд 844 байсан бол 2018 онд 211, 2019 онд орон нутгийн төрийн байгууллагуудад 40 болж буурсан үзүүлэлттэй гарсан. Энэ хүрээнд албан тушаалын томилгоотой холбоотой асуудлыг нарийвчлан судалж, нөхцөл байдлыг тогтоон Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянуулалгүйгээр томилгоо

хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу ХАСУМ хянуулалгүйгээртомилгоохийсэналбантушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зорилтыг хэрэгжүүлж байхад Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд стратегитэй уялдахгүй агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Өөрөөр хэлбэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг өөрчлөн, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, хариу хүргүүлсэн байхад тухайн байгууллагын удирдлага нь нэр дэвшүүлсэн этгээдийг дур мэдэн томилох, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх эрсдлийг бий болгож байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үр дагаврын талаар УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

Гэвч дээрх хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн бол Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх, энэхүү зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах буюу сахилгын шийтгэл ногдуулах хуулийн зохицуулалт хэвээр үйлчилж байгаа нь хуулийг шударга ёсны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид хэрэгжүүлэх боломж байгааг илтгэж байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2018 онд төв, орон нутгийн төрийн байгууллагын удирдах ажилтны томилгоонд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хууль зөрчиж томилсон, мөн сонгон шалгаруулалтад тэнцээгүй удирдах албан тушаалтныг чөлөөлж, түр орлон гүйцэтгэгчдийг хуульд нийцүүлэн томилсон шийдвэр гаргажээ.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасны дагуу төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагад Хувийн ашиг сонирхлын

болон хөрөнгө, орлогын мэдүүлэг(ХАСХОМ) гаргадаг албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан арга хэмжээг авахаар хуульчилсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.1-5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан ба хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ыг баталсан. Уг журамд төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сантай байх, уг сан нь төрийн албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн мэдээлэл, төрийн албан тушаал эрхэлж байсан иргэний мэдээлэл, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах ажилтны нөөцөд байгаа иргэний мэдээлэл, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн төрийн албан хаагч, иргэний тухай мэдээллээс бүрдэхээр тусгажээ. Мөн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэхдээ төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг ашиглахаар тусгасан ба төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системийг боловсронгуй болгох ажлыг хийж байна. Уг системд төрийн тусгай албан хаагч буюу цэрэг, цагдаа, прокурор, шүүх, тагнуулын байгууллагуудын албан хаагчдын мэдээллийг нэгтгэхээр холбогдох хууль тогтоомжийг судалж байна. Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд бүртгэгдсэн албан хаагчдын мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин бодогдохоос гадна төрийн албан хаагчдын нарийвчилсан статистик мэдээ гарч, төрийн жинхэнэ албан тушаалд шатлан дэвшүүлэх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх бодитой нөхцөл бүрдэх давхар ач холбогдолтой юм. Цахим системийн мэдээллийн сан үнэн зөв, бүрэн мэдээлэлтэй байх зарчмыг баримтлан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо

бүртгэлд төрийн байгууллагуудыг давхардалгүй, бүрэн хамруулахаар ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн хугацаанд Засгийн газрын бүтцэд орсон өөрчлөлтөөр татан буугдаж хасагдсан болон шинээр нэмж байгуулагдсан байгууллагуудын хөдөлгөөнийг нэгдсэн бүртгэлд бүрэн тусгаж эцэслэн баталгаажуулах шаардлага тавигдсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолд “Тоо бүртгэлийг хөтлөх, тайлан гаргахад хамрагдах байгууллагуудын жагсаалтыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар болон холбогдох эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийг үндэслэн Төрийн албаны зөвлөл батална” гэж заасны дагуу бүртгэлд хамрагдвал зохих байгууллагуудын жагсаалт гаргаж эхэлсэн.

Жагсаалтад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл болон хамгийн олон байгууллага бүхий Боловсрол шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Соёлын яам зэрэг нийт 11 байгууллагын эрхлэх асуудлын хүрээний болон харьяа 3206 байгууллагын жагсаалт гаргаад байна. 2020 оны байдлаар Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системд 46 байгууллагыг шинээр бүртгэж, 65 байгууллагын мэдээллийг шинэчлэн зассан бөгөөд шинээр үүссэн 47 байгууллагад цэцэрлэг 21, ерөнхий боловсролын сургууль 9, эмнэлэг 2, Эрүүл мэндийн төв 3, Хүүхдийн хөгжлийн төв 3, Спорт сургалтын төв 3 болон Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Жендерийн үндэсний хороо, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Усны газар, Үндэсний геологийн алба, Соёлын яам гэсэн байгууллагууд бүртгэгдсэн байна. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын 11.4-т “Шалгалтад тэнцсэн иргэнийг зөвхөн тухайн аймаг, нийслэлийн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэж, бүртгэлийн жагсаалтыг Зөвлөлийн цахим хуудсанд байршуулна.” гэж заасны дагуу 2019, 2020 онд төрийн албаны ерөнхий шалгалт өгч төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас /<http://csc.gov.mn/s/35/805/>-д нээлттэй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор 2020 онд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны

ерөнхий шалгалтад тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн 3823 иргэн байгаа ба тэдгээр иргэдийн мэдээллийг цахим хуудсанд нээлттэй байршуулсан байна.(Биелэлт 70 хувь)

4.1.1.2-1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд тотмилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2022/

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 23 дугаар зүйлд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг тус тус хуульчилсан. Тухайлбал, төрийн төрийн захиргааны албан тушаалын тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох иргэний хувьд төрийн албанд ажилласан жил, тухайн ангилалд ажилласан жилийг зааж, мэргэшүүлэх багц цагийн сургалтад хамрагдаж, төгссөн байхаар тусгасан нь туршлага, ур чадварыг үндэслэн шатлан дэвшүүлэх нөхцөлийг бүрдүүлж, мөн хуулийн 26 дугаар зүйлд төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгуурыг тодорхойлон хуульчилсан. Төрийн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны ажлын үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж байх, тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага болон албан тушаалтын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг тус тус хориглосон зохицуулалтыг хийсэн болно.

Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”, мөн оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, мөн оны 16 дугаар тогтоолоор “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд уг албан тушаалыг үндэслэн сонгон шалгаруулалт зарлаж, сул орон тоог нөхөх арга хэмжээ авч байна.

Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, сайжруулах, өөрчлөх арга хэмжээг авч байна. Тухайлбал, Төрийн албаны

зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор “Төрийн албанд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ыг баталлаа. Ингэснээр Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн төрийн жинхэнэ албанд анх орох иргэнд туршилтын хугацааг хэрэглэх нийтлэг болзол, шаардлагыг шинэчлэн тогтоох, туршилтын хугацаанд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалах, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг зохицуулалтыг тусгав.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 244 дүгээр тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-д өөрчлөлт орууллаа. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалтын үнэлгээний босго оноонд өөрчлөлт оруулж, тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэгийг сорилоор шалгаж 20 хүртэл оноогоор үнэлэх, дүн шинжилгээ хийх чадвар, асуудал шийдвэрлэх чадварыг сорил болон бодлогоор шалгаж тус бүр 10 хүртэл оноогоор тус тус үнэлж, нийт оноо нь 60 ба түүнээс дээш оноо авснаар тэнцэх зохицуулалт оруулсан байна.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэг, салбарын эрдэмтэн, судлаачдын тусламжтайгаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудын төрийн албаны томилгоо, хөдөлмөрийн харилцаатай холбоотой зохицуулалтад судалгаа, дүн шинжилгээ хийж, хийдэл, давхардлыг арилгах, Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлал, хэм хэмжээтэй уялдуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлсээр байна.(Биелэлт 100 хувь)

4.1.1.2-2.Мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуульд иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан ба төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар тусгасан.

Тус хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан

тушаалд тавигдах тусгай шаардлага”, мөн оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, мөн оны 5 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”, мөн оны 14 дүгээр тогтоолоор “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам”, мөн оны 15 дугаар тогтоолоор “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, мөн оны 16 дугаар тогтоолоор “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, мөн оны 17 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”, мөн оны 25 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам” зэргийг батлав. Ийнхүү холбогдох дүрэм, журмуудыг батлан мөрдүүлснээр төрийн албаны томилгоо мерит буюу чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бүрдлээ.

Мерит зарчмыг тогтоох, хамгаалах бэхжүүлэх, байгууллагын хөгжлийн түвшинг хэмжих чиг хандлагыг тодорхойлох, байгууллагын хүний нөөцийн чадавхын түвшинг үнэлэх, хөгжүүлэх талаар зөвлөн туслах зорилгоор төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Төрийн албанд мэдлэг, чадвар, хандлагаар хамгийн сайн үнэлэгдсэн хүнийг сонгож томилох, албан хаагчийн сурч хөгжих, албан тушаал ахиж дэвших төлөвлөх, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг үнэн зөв шударгаар үнэлэх, ажлын гүйцэтгэл үр дүнд үндэслэсэн шагнал, урамшуулал олгоход мерит буюу чадахуйн зарчмын мөн чанар оршино. Энэ нь төрийн албан хаагч улс төрийн болон аливаа нөлөөллөөс ангид байх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан УИХ, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр уг хуульд батлахаар эрх олгосон нийт 46 журмыг батлан хэрэгжүүлж байна. Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах талаар төрийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч, 2020 онд төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх нийт 3447 албан тушаалын тодорхойлолтыг хянаж, “Батлах зөвшөөрөл” олголоо. 2019-2020 онд нийт зөвшөөрөл олгох

албан тушаалын тодорхойлолтын 98 орчим хувьд “Батлах зөвшөөрөл” олгосон байна. Албан тушаалын зорилго, зорилт чиг үүргийг байгууллагын бүтцийн нэгжийн зорилго, зорилт, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй нягт уялдуулснаар албан хаагчийн ажлын чиг үүргийн давхардлыг арилгах, байгууллагын болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг зохистой түвшинд хүргэж батлах, гүйцэтгэлийг бодитоор үнэлэх замаар хүний нөөцийн удирдлагын үр нөлөө дээшилж байгууллагын үйл ажиллагааны үр ашиг дээшлэх боломж бүрдэх юм. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.2-3. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг олон улсын стандартад нийцүүлэх /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлүүд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний сонгон шалгаруулах шалгалтын сорилын буюу тестийн шалгалтыг цахим хэлбэрээр авч хэвшүүлсэн бөгөөд төрийн албаны тусгай буюу албан тушаалын шалгалтыг онлайн, цахим хэлбэрт шилжүүлэх зорилт тавин бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг чадавхижуулах шаардлагатай байгаа болно.

2019 онд төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг анх удаа онлайнээр зохион байгуулж, шалгалтыг цахимаар авсан нь ахиц дэвшил гарсан, шинэлэг ажил болсон юм.

Төрийн албаны зөвлөл, түүний Салбар зөвлөлүүд төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчдаас чадахуйн зарчим, шатлан дэвшүүлэх тогтолцоонд суурилсан сонгон шалгаруулалтаар, боломжгүй тохиолдолд нөөцөд бүртгэлтэй иргэдээс сонгон шалгаруулалтаар нөхөж, хамгийн өндөр оноо авсан нэг иргэнийг Төрийн албаны зөвлөл, түүний Салбар зөвлөлийн тогтоолоор тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

Бүртгэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг бүрэн цахимжуулснаар энэ үйл явцад хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөл орохоос сэргийлж, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй зарчмыг ханган, шалгалтад оролцогчид мэдлэгээ бодитоор сорих боломжийг бүрдүүлэн хэвшүүлээ.

Мэдээлэл технологийн дэвшлийг ашиглаж олон улсад түгээмэл ашиглагддаг ном, сэтгүүлийн цахим платформоор дамжуулан шалгалтын сорилтой уншиж танилцах, онлайн тест боловсруулан өдөр тутам шинэчлэн түгээснээр виртуал орчинд иргэд өөрсдийн мэдлэг чадвараа урьдчилан сорих боломжийг бүрдүүлээ.

Цахим зөвлөмж, цахим ном, шалгалтад хамтдаа бэлтгэх онлайн булан ажиллуулсны дээр иргэдээс ирүүлсэн саналыг харгалзан шалгалтын сорил, хариултыг товхимол болгон хэвлэж, хэвлэлтийн бодит өртгөөр хэрэглэгчдийн гар дээр хүргэлээ. Шалгалтын сорилын мэдээллийн эх сурвалж, боловсруулан бэлтгэхэд ашигласан гарын авлагыг тодорхой байлгасан онцлогтой. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.2-4.Шалгалтын тестийн агуулгыг сайжруулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох хүрээнд төрийн албаны шалгалтын агуулгын шинэчилж байна. Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д төрийн жинхэнэ албаны шалгалтын агуулгыг удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, монгол хэлний ярианы болон бичгийн, багаар ажиллах (бусад) зэрэг чадварыг шалгахаар зохицуулсан. Өмнө нь төрийн албаны шалгалтын агуулгад хууль, эрх зүйн мэдлэг зонхилсон, монгол хэл, мэдээллийн технологийн мэдлэг багтдаг байсан бол 2019 оноос Монгол Улсын түүх, нийгэм, эдийн засаг, соёлын мэдлэгийн зэрэгцээ Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д заасан дээр дурдсан чадвартай холбогдох сорил, даалгавар нэмэгдэж, агуулгын хүрээ өргөжсөн.

2019 онд өмнө нь хэвлэгдэн гарч байсан гарын авлагаас хүчингүй болсон, нэмэлт, өөрчлөлт орсон хуулиудын сорилыг хасч, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, хүний эрхтэй холбоотой хууль тогтоомж, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийг зорилт”-ыг багтаасан нийт 1552 сорилыг шинээр боловсруулж, “Төрийн албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад бэлтгэх гарын авлага”-ыг баяжуулан хэвлэж, нийтийн хэрэглээнд гаргасан.

Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн

төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд мэргэжлийн байгууллага болон эрдэмтэн судлаачидтай хамтран төрийн албаны шалгалтын агуулгыг шинэчилсэн.Тухайлбал, Монгол Улсын түүх соёл, нийгэм эдийн засгийн шалгалтын сорил даалгаврыг магадлан шалгах 663, Хууль эрх зүйн мэдлэг шалгах сорилын санд байгаа тестийг магадлан шалгаж, хүчингүй болсон, нэмэлт, өөрчлөлт орсон хуулийн тестийг хасч, засварлан, шинээр 2939, Монгол хэлний ур чадварыг шалгах сорилын санд байгаа тестийг магадлан шалгаж, шинээр 700, дүн шинжилгээ хийх ур чадварыг шалгах сорилын санд байгаа тестийг магадлан шалгаж, шинээр 1000 сорилыг тус тус боловсруулсан. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.2-5.Төрийн захиргааны албан хаагчийн сэлгэн ажиллуулах журмыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батлахаар хуульчилсан бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 34/31 дүгээр хамтарсан тушаалаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг батлан мөрдүүлж байна.

Журам батлагдсанаар төрийн байгууллагын ажлын ачааллыг зохицуулах, төрийн албанд ажиллаж туршлага хуримтлуулсан албан хаачийн мэдлэг, ур чадварыг үр өгөөжтэй ашиглах, дадлага, туршлагыг нь бусдад эзэмшүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.2-6.Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална.” гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, “Албан тушаалын тодорхойлолтын маягт”, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулгын хуудас”, “Хяналтын хуудас”-



ыг тус тус баталсан. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг дээрх журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал бүрээр батлах, тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдол албан тушаалын тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байхаар хуульчилсан. Энэ дагуу төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр батлан мөрдүүлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.3-1.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээний холбогдох зохицуулалтыг бий болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж, дүгнэх талаар тусгасан ба “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журам”-ыг Засгийн газар батлахаар хуульчилсны дагуу Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, мөн оны 38 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус батлан хэрэгжүүлж байсан бол 2020 онд “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг тус тус шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2020 оны 217, 218 тогтоолоор баталлаа.

Мөн журмын хэрэгжилтийг хангахаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар стратеги болон байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус батлан хэрэгжүүлж, уг асуудлаар бүх шатны төрийн байгууллагад цахим орчинд /cabinet.gov.mn, igovernment.mn/ чиглэл өгч, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.1.4-1.Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн нөлөөллөөс ангид томилох, чөлөөлөх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших /мерит/ зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс томилохоор тус тус зохицуулсан. Мэдлэг, үр чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус төрийн албыг бэхжүүлэхтэй холбогдсон зарчмын нэг бол Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийн сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албаны тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.” гэж заасан явдал юм. Энэ тохиолдол буюу хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д заасныг зөрчсөн тохиолдолд улс төрийн албан тушаалтныг огцруулах үндэслэл болохоор хуульчилсан.

Мөн төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульчилж, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн баталж, хэн нэгэн хүнд тохируулан дураар өөрчлөх боломжгүй болсон нь төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх ажлыг хүний хүчин зүйлийн нөлөөллөөс ангид явуулах нөхцөлийг бүрдүүлсэн болно.

Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам,

эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших /мерит/ зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс томилохоор тус тус тогтоосон бөгөөд иргэнийг төрийн албанд томилох, чөлөөлөхдөө хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан. Мөн хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгохоор заасан.

Төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульчилж, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн батлах, хэн нэгэн хүнд тохируулан дураараа өөрчлөх боломжгүй болсон зэрэг зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтийг тусгаж өгсөн.

Төрийн албаны зөвлөлөөс 2020 онд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүнгээр нутгийн өөрөө удирдах байгууллагын байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг сонгох, нэр дэвшүүлэх, томилох үйл ажиллагаатай холбогдуулан 03 дугаар зөвлөмжийг гарган бүх шатны Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт хүргүүлэв.

Уг зөвлөмжид сонгуулийн дүнгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, төрийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч өөрчлөгдөх нь төрийн албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй гэж заасан Төрийн албаны тухай хуулийн хэм хэмжээг чанд хэрэгжүүлж ажиллах, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн байгууллагын хүний нөөцийн томилгоонд шууд болон шууд бус аливаа хэлбэрээр оролцох, нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглосон Төрийн албаны тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй баримтлахыг

улс төрийн бүх албан тушаалтнуудад зөвлөв. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.5-1. Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, таслан зогсоох, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн а/185 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/40 тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна(Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалын холбоос: [https://iaac.mn/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/atg\\_argachlal\\_2019.pdf](https://iaac.mn/files/d8faf0f3-92d8-470f-bb01-c1b0b25490be/atg_argachlal_2019.pdf)). Аргачлалын дагуу 2018 онд 6 төрийн бус байгууллагаар 24 яам, агентлагт, 2019 онд 5 төрийн бус байгууллагаар 15 байгууллагад авлигын эрсдэлийн үнэлгээг хийлгүүлэн, үр дүн, үнэлгээний тайланг яам, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулсан бол 2020 онд Шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагддаггүй, эсхүл хамрагдаж байгаа ч нарийвчлан үнэлгээ хийх шаардлагатай агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газар, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, сумын ЗДТГ зэрэг нийт 9 байгууллагын<sup>1</sup> үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй, үүсгэж болзошгүй шалтгаан нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээний ажлыг зохион байгуулж, үр дүнг тухайн байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлж ажилласан. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын бүтэц, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт, төсөв санхүү, шийдвэр гаргах үйл явц, ил тод байдал, мэдээллийн хүртээмж, ёс зүйн шударга байдлын түвшин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, авлигын эсрэг бодлого, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт тодорхой эрсдэл байна гэж дүгнэсэн. Тухайлбал:

<sup>1</sup> Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Төв аймгийн Батсүмбэр сумын ЗДТГ, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Жижиг, дунд үйлдвэрийн газар.

- Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой байгууллагын ажилчдын хөдөлмөрлөх эрхэд халдсан шийдвэр гаргах, төрийн албан хаагчийг орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам тодорхой бус, төрийн байгууллагад “орон сууцны зориулалтаар” газар эзэмшүүлсэн, газар эзэмших эрхийг холбогдох хууль тогтоомж зөрчин иргэн, хуулийн этгээдэд шилжүүлсэн, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагаас болон улс төрийн зүй бус нөлөөлөл их байдаг, хууль бус шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хуулиас давсан журам үйлчилж буй байдал;
- Төсөв санхүү, худалдан авалттай холбоотой худалдан авах ажиллагааг хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан тушаалтныг олон давтамжтай ажиллуулах мөн үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалах харилцаанд хувийн ашиг сонирхол үүссэн;
- Тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэцтэй холбоотой эрх зүйн байдлын хувьд хууль зүйн зөрчилтэй нөхцөл байдал үүсэх;
- Авлигын эсрэг бодлого болон удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлтэй холбоотой авлигын эсрэг бодлого, төлөвлөгөөг батлаагүй, үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл дутмаг, хангалтгүй;
- Ил тод байдалтай холбоотой байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт хангалтгүй, шалгуур үзүүлэлтэд нийцээгүй;
- Ёс зүй, шударга байдлын түвшинтэй холбоотой ёс зүй хяналт хариуцлагын тогтолцоо сул, тогтворгүй байгаа нь авлигын эрсдэлийг бий болгож байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, АТГ-аас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор АТГ-ын ажлын баг 2017 онд 21 аймагт 3 удаа, давхардсан тоогоор 144 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулсан. Тухайлбал, 2018 онд цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулан 21 аймаг, 50 суманд, 2019 онд 21 аймгийн төвийн

21 сумдад ажилласан нь хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна дүгнэлтэд хүрсэн болно. Иймд авлигын түвшинг бууруулах, авлигын эрсдэл үүсгэж буй хүчин зүйл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон нийслэл, аймаг, орон нутгийн удирдлагад, албан хаагчдад илэрсэн нөхцөл байдлын талаар танилцуулж, Засгийн газарт “Зөвлөмж” хүргүүлсэн. Мөн Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдал талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зарим зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

2018 онд яам, агентлагт ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр Засгийн газрын гишүүд, сайд нарт 2018 онд 159, 21 аймагт 10-15 асуудал бүхий, “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс 13 асуудал бүхий, 2019 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 5 асуудал бүхий, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаад Эрүүл мэндийн яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус 3-5 асуудал бүхий, 2020 онд зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр ажиллаад Засгийн газарт 10 асуудал бүхий, 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт 7 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар дүгнэн үзэхэд гүйцэтгэл 81 хувьтай байв.

Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн, хуулиар тусгай эрх олгоогүй

байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй гэж үзсэн Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”, Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаал, Эрчим хөгжлийн төвийн захирлын Б/36 дугаар тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”, Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2009 оны 28/01 дүгээр тэмдэглэл, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/18 дугаар тушаал зэрэг 50 гаруй дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгуулах арга хэмжээ авав.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт 91 журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээг авлаа. Тухайлбал, энэ ажлын хүрээнд Баянхонгор аймгийн 5, Говь-Алтай аймгийн 3, Завхан аймгийн 2, Өвөрхангай аймгийн 11, Өмнөговь аймгийн 3, Дундговь аймгийн 7, Увс аймгийн 5, Баян-Өлгий аймгийн 13, Хэнтий аймгийн 6, Дорнод аймгийн 9, Сүхбаатар аймгийн 4, Булган аймгийн 7, Орхон аймгийн 5, Дархан-Уул аймгийн 8, Ховд аймгийн 10 шийдвэрийг тус тус хянан үзсэн байна.

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүргийн хүрээнд 2020 онд төрийн байгууллага, албан тушаалтны батлан гаргасан нийт 18 дүрэм журамд авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал үүсгэх эрсдэл байгаа эсэхийг судлан үзэж, зарим шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгуулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллалаа. Энэ хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 316 дугаар тушаалаар баталсан “Монголбанкнаас банк, банкны ажилтнуудын үйл ажиллагаатай холбогдсон эрүү, иргэний хэрэгт магадлан шинжилгээ хийх журам”-ыг хүчингүй болгуулах арга хэмжээ авав.

Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны яамнаас боловсруулсан “Суралцагчийн сургалтын

төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөний үйлдвэрийн яамнаас боловсруулсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Сонгон шалгаруулах журам”-ын төсөлд тус тус санал хүргүүлж ажилласан байна.

Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2017 онд 22, 2018 онд 8, 2019 онд 42, 2020 онд 83 байгууллагад хүргүүлсэн АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр газар дээр нь ажиллахад мэдэгдлийн хариуг хуулийн хугацаанд ирүүлээгүй, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй хэлбэрийн төдий байгаа зэрэг нийтлэг дутагдал илэрсэн бөгөөд төрийн байгууллагууд Авлигын эсрэг хуулийн 6.1.12-т заасан “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах” нийтлэг үүргийн хэрэгжилт хангалтгүй байв.

Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгт албан хаагчид нь түлхүү холбогдож буй салбарт буюу Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төв, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудад ажиллав. Тухайлбал, нийслэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх буюу төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлтийг Нийслэлийн боловсролын газар 100 хувь цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт заасны дагуу цахим бүртгэл болон элсэлт, элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, урьдчилан сэргийлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах талаар тусгайлсан ЗӨВЛӨМЖ боловсруулан хүргүүлж, 2018 оны 9 дүгээр сард Нийслэлийн төвийн дүүргүүдийн сургуулиуд 45, 1, 84, 23, 24, 2019 онд 1,2, 5, 6, 9, 12, 13, 17 38,14, 33, 84, 18, 52, 75 сургуулиудын нэгдүгээр ангийн элсэлтийн, 20 цэцэрлэгийн бүртгэлийн явц байдалтай газар дээр нь танилцаж, хөндөгдсөн асуудлаар олон нийтэд мэдээлэв. Авлигатай тэмцэх газраас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож

буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газраас 2020 онд Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Бүртгэл хяналтын төв, Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Налайх, Багануур дүүрэг, Төв аймгийн Заамар суманд хүрч ажиллан, Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн биелэлттэй танилцах, шалган туслах, зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх, түүний хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг гүйцэтгэв. Тухайлбал, Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төвийн удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулсан “Авто тээврийн улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй авлигын эрсдэл” сэдэвт уулзалтыг зохион байгуулж, зөвлөмж өгөв. Зөвлөмжийн хүрээнд импортоор орж ирж буй авто тээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгийн төлбөрийг давхардуулан тогтоосноор жилд дунджаар 30 орчим тэрбум төгрөг иргэд, аж ахуйн нэгж төлөх байсныг илрүүлэн таслан зогсоож, Автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөр авто машинд шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж байна. Сонгинохайрхан дүүрэг дэх Газрын албаны үйл ажиллагаан дахь авлига, ашиг сонирхлын зөрчил гарах шалтгаан, нөхцөл, үйлчилгээний хүнд суртлыг тогтоох чиглэлээр Дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба болон Газрын алба, дүүргийн Мэргэжлийн Хяналтын хэлтэс, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газарт тус тус ажиллан, газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох чиглэлээр холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэв. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ажиллаж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг хууль тогтоомжоор төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээсэн нийтлэг үүргийн биелэлттэй танилцаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал, тус яамнаас олгодог зарим төрлийн

тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын 19 төрлийн эрхийн гэрчилгээ олгоход баримталдаг хууль тогтоомж, дүрэм журам, Засгийн газрын тусгай сан болох Байгаль орчин, уур амьсгалын сангийн үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгийн захиран зарцуулалтын байдал, тус яамны харьяа “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ, “Монгол Ус” ТӨҮГ, “Монгол кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮҮГ-уудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний биелэлтийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.

Эрүүл мэндийн салбарын авлигын эрсдэлийг тогтоож, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, дүн шинжилгээ хийн, түүнд тулгуурласан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн судалгааг эхлүүлж, нийт 21 хуулийг хянан үзэж, батлан хэрэгжүүлж буй дүрэм, журам, зааврын жагсаалтыг гарган, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн эсэхийг шүүн нягтлав. Тус салбарт 2018-2020 оны хооронд гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн, тус салбарт хийгдсэн аудитын байгууллагын дүгнэлттэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж байна. Эрүүл мэндийн салбарын авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал чирэгдлийг таслан зогсоох зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтний давхар ажил эрхлэлтийн байдлыг судлан тогтоохоор Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг гуравдугаар шатлалын хоёр эмнэлэгт давхар ажил эрхэлж буй эмч нарын судалгааг гаргуулан авч, дүн шинжилгээ хийлээ. Судалгаанд 2501 эмнэлгийн ажилтныг хамруулснаас 28 эмч, ажилтан давхар ажил эрхэлдэг нь тогтоогдсон. Аймгуудын нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 5 сая төгрөгнөөс дээш бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан мэдээллээ [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад байршуулсан байдал, тус байгууллагууд цахим хуудастай эсэх, цахим хуудсандаа шилэн дансны мэдээллээ байршуулсан эсэх эрүүл мэндийн салбарт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх тоон мэдээлэл, судалгаа зэрэгт дүн шинжилгээ хийсэн.

Биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ

байгуулж, ашигт малтмалын олборлолт явуулж байгааг таслан зогсоох чиглэлээр Төв аймгийн Заамар суманд ажлын хэсэг ажиллаж, илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулав. Авлигатай тэмцэх газраас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон нэр бүхий аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй танилцаж, авлигын эрсдэл, нөхцөл байдлыг тодорхойлон илэрсэн зөрчил, дутагдлыг газардээр нь арилгуулах арга хэмжээ авсан. “Хүнд суртлын мэдээлэл”-ийн мөрөөр Нийслэлийн захирагчийн ажлын албаны харьяа Хог хаягдал, удирдлагын хэлтэст ажиллаж, хог, хаягдал, золбин нохой, муур устгал, сэг зэмийг зайлуулах ажилд зориулсан төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны процесс, хяналт тавьж буй байдалтай танилцаж, холбогдох мэдээллийг гаргуулан авч, дүн шинжилгээ хийж байна. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Газрын алба, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, Ашигт малтмал, газрын тосны газраас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үйл ажиллагааны зохион байгуулалтад тандалт, ажиглалт хийж, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй фокус ярилцлага өрнүүлэн, нөхцөл байдлыг тогтоон, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулж ажилласан.

Төрөөс хэрэгжүүлж байгаа цаг үеийн шинжтэй асуудал, хорио цээрийн дэглэм, онцгой нөхцөл байдлын үед авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эрсдэлээс сэргийлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын онцгой комисс, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Халдварт өвчин судлалын үндэсний төвд зөвлөмж хүргүүлэв. Зөвлөмжөөр Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд “Ковид-19” вирусийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд зориулж Эрүүл мэндийн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудад сайн дурын үндсэн дээр бэлэн мөнгө болон эд материал хандивлах, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх зэрэг хэлбэрээр дэмжиж байгаатай холбогдуулан хандивын бүртгэл, ил тод байдлыг хангуулах, Нийтийн албанд өгсөн сайн дурын хандивыг хүлээн авах, захиран зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөх, орлого,

зарцуулалтын талаар иргэд, олон нийт нээлттэй мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийн тайлан гаргах, хууль тогтоомж зөрчиж авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллахыг анхааруулсан.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас байгалийн аюулт үзэгдэл, осол, гоц халдварт өвчин зэрэг гамшгийн нөхцөл байдлын үед хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс хандив, тусламж хүлээн авахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг чанд мөрдөх, хандив, тусламж, түүний зарцуулалтыг ил тод, нээлттэй мэдээлэх чиглэлээр харьяа байгууллагуудын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Нийслэлийн засаг дарга нарт мэдэгдлээ.

Төрийн байгууллагуудад хяналт шалгалтаар ажиллах явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааг нээлттэй болгох ажлыг эрчимжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхий сайд болон 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нар, Сонгуулийн ерөнхий хороо, улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчид, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Орон сууц, нийтийн аж ахуйн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг 20 байгууллагад 111 асуудал бүхий Зөвлөмж боловсруулан хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газарт авлигын эрсдэл үүсэж болох нөхцөл байдлыг судлан үзэж, эрсдэлийг таслан зогсоох чиглэлээр холбогдох зөвлөмжийг хүргүүлэв. Авлигатай тэмцэх газрын иргэд, олон нийтээс гомдол мэдээлэл хүлээн авах “110” тусгай дугаарын утсаар иргэдэд үйлчилгээ үзүүлж буй улсын бүртгэгчид иргэдтэй зүй бус харьцдаг, ёс зүйн зөрчил гаргаж байгаа талаар мэдээлэл удаа дараа ирсэн ба энэхүү ёс зүйн зөрчил үүсэх боломжийг бүрдүүлсэн гол шалтгаан нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас ийм төрлийн зөрчилд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, салбарын хэмжээнд ёс зүйн зөрчилд холбогдох арга хэмжээг тухай бүрд нь авдаггүй, хяналт шалгалтын холбогдох нэгжийг ажиллуулдаггүй ба энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах талаар зөвлөн

тусалж ажиллав. Сонгинохайрхан дүүргийн зарим хороодод хүнд суртлын мэдээллийн мөрөөр ажиллаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт 5 асуудал бүхий, Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг автомашины улсын дугаар олголт, бүртгэлийн үйл ажиллагаатай танилцаж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг тогтоож, хяналт шалгалтын мөрөөр гарсан зөрчил дутагдлыг арилгуулахаар Зам, тээврийн хөгжлийн сайдад 5 асуудал бүхий, Авлигатай тэмцэх газрын иргэд, байгууллагаас гомдол, мэдээлэл хүлээн авах “110” тусгай дугаарын утсанд ирүүлсэн гомдлын мөрөөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт, мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт (8 асуудал бүхий), Налайх дүүргийн цагдаагийн хэлтэст(-3 асуудал бүхий), Чингэлтэй дүүргийн цагдаагийн газарт(6 асуудал бүхий), Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт(5 асуудал бүхий), Төв аймгийн Сэргэлэн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт (7 асуудал бүхий), Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1 болон 3 дугаар хэлтэст(5 асуудал бүхий) зөвлөмжийг тус тус хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг тооцох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр арга зүйн туслалцаа үзүүлэх, албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, чадавхжуулах, цахимжуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав. (Биелэлт 100 хувь)

4.1.1.6-1. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг судлах, дүн шинжилгээ хийх, төрийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлуулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баталж, байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд 2019 оны 122 дугаар тогтоолоор зарим нэмэлт, өөрчлөлт оруулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.6-2. Үлгэрчилсэн дүрмийн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг салбар бүрээр батлуулах /ТАЗ, ЗГХЭГ, УИХТГ 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Энэ хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.”<sup>2</sup>, мөн зүйлийн 40.2-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”<sup>3</sup> Гэж тус тус заасан. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2-т “төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж болно” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Төрийн албан тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр төрийн албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн дүрэм бус төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм мөрдөгдөж эхэлсэн ба төрийн бусад байгууллага өөрийн онцлогт тохируулан ёс зүйн дүрэм батлах нь нээлттэй байгаа болно. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолд байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасан.

Татварын ерөнхий хууль, Төрийн аудитын тухай, Боловсролын тухай зэрэг хуулиудад албан хаагчдын мэргэжлийн болон салбарын ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх талаар тусгасан ба эдгээр албан хаагчдын ёс зүйн дүрмүүд бүгд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг батлахаас өмнө батлагдсан байна.

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д зааснаар төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд УИХ-аас ирүүлсэн Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн Эмнэлгийн ажилтны ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн Мэргэжлийн

2 Төрийн улс төрийн болон төрийн тусгай албан тушаал

3 Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаал

хяналтын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас ирүүлсэн тус сангийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, нийслэлийн Газрын албанаас ирүүлсэн албан хаагчийн ёс зүйн дотоод дүрмийн төслүүдэд тус тус санал өгөв. Түүнчлэн 2019 онд Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсан байна. 2020 онд Татварын албан хаагчийн ёс зүйн дүрэм, “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ, “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан” зэрэг байгууллагын ажилтан, албан хаагчдын дагаж мөрдөх ёс зүйн дүрмийн төслүүдэд тус тус санал боловсруулан хүргүүлэв.

Төрийн улс төрийн албан тушаалтны хувьд зөвхөн УИХ-ын 2009 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж байгаа бол бусад төрийн улс төрийн албан тушаалтан болох Засгийн газрын гишүүд, зөвлөх, туслах, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Засаг дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалтнуудын хувьд үйлчлэх ёс зүйн дүрэм батлагдаагүй байна.

Төрийн тусгай албан тушаалтны хувьд ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтоохоор хуульчилсан ба өнөөдрийг хүртэлх хугацаанд хуулиар буюу Улсын Их Хурлын тогтоолоор баталсан төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн дүрэм байхгүй, төрийн тусгай чиг үүргийг гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаандаа баримталдаг салбарын хуулиудад нь ёс зүрмийг батлахыг тодорхой субъектэд эрх олгох байдлаар зохицуулсан байна.

Засгийн газраас 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн 6.1-д “Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэд ажиллана” гэсний дагуу нийт 64 төрийн байгууллага Ёс зүйн зөвлөл, бүрэлдэхүүнээ байгуулаад байна. Монгол Улсын Их Хурал, Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канад Улсын Элчин сайдын яам хамтран “Итгэл даах төрийн албаны төлөө” уриатай зөвлөгөөнийг 2020 онд зохион байгуулж, уг зөвлөгөөнд Монгол Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагууд, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон

төрийн үйлчилгээний байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд зэрэг 330 оролцогч танхимаар, 4000 гаруй оролцогч онлайнаар хамрагдсан байна. Зөвлөгөөнөөр “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулахад ёс зүйн зөвлөлийн гишүүдийн санал, хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан ба журмыг төслийг батлах эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.6-3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах /ТАЗ, 2017-2022/

2018 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар АНУ-ын Азийн сантай хамтран нийслэлийн хэмжээн дэх төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээлэл, зөрчлийн агуулга, түүнийг шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлд Төрийн албаны зөвлөлөөс УИХ-д хүргүүлэх тайланд “төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаархи дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал”-ыг тусгахаар заасан.

Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.1.2-т заасан хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд буюу 3.1.2.г-д зааснаар “төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих”, 3.1.5-д заасан мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх хүрээнд буюу 3.1.5.в-д зааснаар “ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах” чиг үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сахилга, хариуцлагыг сайжруулах, ажлын байрны дарамтгүй орчин бүрдүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 02 дугаар зөвлөмжийг төрийн байгууллагын удирдах албан тушаалтан болон нийт төрийн албан хаагчдад хүргүүлж ажиллалаа. Зөвлөмжид төрийн албаны үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг баримтлах, иргэдийн өргөдөл



гомдол, санал хүсэлтийг үндэслэлтэй шийдвэрлэх, төрийн үйлчилгээг аливаа хэлбэрийн ялгаварлал гадуурхалгүй адил тэгш хүргэх, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан нь хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавих, төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг сайжруулах гэсэн агуулга туссан байна.

Мөн Төрийн албаны зөвлөлийн “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн тайлан, ёс зүйн зөрчлийн мэдээг ирүүлэх тухай” 04/1209 дүгээр албан бичгийг төрийн 67 байгууллагад хүргүүлснээс Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог 12 байгууллага, 12 яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч 11 агентлаг, аймаг, нийслэлийн 20 Засаг даргын Тамгын газраас харьяа нэгж, газрын Ёс зүйн зөвлөлийн судалгаа болон ёс зүйн зөрчлийн тайлан мэдээг ирүүлсэн байна. Ирүүлсэн тайлан, судалгааг судалж үзэхэд төрийн захиргааны болон нутгийн захиргааны 558 байгууллага, төрийн тусгай 213 байгууллага, төрийн үйлчилгээний 417 байгууллага, 6 төрийн өмчит үйлдвэрийн газарт нийт 1193 төрийн байгууллагад Ёс зүйн зөвлөл /хороо/-ийн байгуулагдан ажиллаж байна. Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд нийт 4626 албан хаагч Ёс зүйн зөвлөл, хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүний үүргийг хэрэгжүүлж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 1422 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан бөгөөд үүнээс төрийн тусгай 809 албан хаагч, төрийн захиргааны 353 албан хаагч, төрийн үйлчилгээний 260 албан хаагч тус тус хамаарч байгаа бөгөөд 2019 оны ёс зүйн зөрчилтэй харьцуулахад 24 нэгж буюу 4.8 хувиар буурсан байна.

Төрийн тусгай албан хаагчаас бусад албан хаагчдын ёс зүйн зөрчлийг шалгасан үндэслэлийг авч үзвэл, байгууллагын дотоод хяналтаар 328, иргэдийн гомдлоор 209, мэдээллээр 50, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн 26 мэдээллээр тус тус ёс зүйн зөрчлийг шалгасан байна.

Ёс зүйн зөрчилд ногдуулсан хариуцлагын хүрээнд сануулах 465, уучлал гуйхыг үүрэг болгосон 131, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэсэн 17 тохиолдол байна.

Ёс зүйн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл, ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн болон ажлын хариуцлага алдсан зөрчил 196, албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын байранд архидан согтуурсан зөрчил 37, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй зөрчил 48, ажлын цаг ашиглалтын зөрчил 46, харилцаа, хандлагын

зөрчил 163, хууль, дүрэм, журам зөрчсөн зөрчил 108, бусад буюу нууц задруулах, захирах захирагдах ёсыг зөрчих, албаны нэр барих, байгууллагын эд хөрөнгийг хувийн зорилгоор ашиглах зэрэг зөрчил 15 байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.7-1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх /АТГ, ТАЗ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газар (АТГ)-аас албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас факс, www.iaas.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, утсаар болон байгууллагын байранд биечлэн ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд өгөх боломжийг бүрдүүлсэн. АТГ нь дээрх мэдээллийг 2007 оноос 1969, 2014-2019 онд 1800-1969 хүлээн авч байсан бол 2019 оноос 110 тусгай дугаарын утсыг ажиллуулж байна. АТГ гомдол, мэдээлэл хүлээн авах цээжлэхэд амар, тогтооход хялбар, ярианы төлбөргүй “110” тусгай дугаарын утсыг ажилд оруулснаар иргэд авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, хүнд сурталтай үйлчилгээ, албан тушаалтны ёс зүй, зүй бус шаардлагын талаарх мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжтой боллоо. Энэхүү системийн тусламжтайгаар мэдээллийн сан үүсгэж, түүн дээр суурилан авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх сургалтыг үе шаттайгаар, илүү үр дүнтэй, давхардал, хийдэлгүй зохион байгуулах нөхцөл бүрдэж байна. Утасны дуудлагыг хүлээн авах ажилтны тоог нэмэгдүүлж, дуудлагын бичлэгийг хадгалах, хүлээн авсан гомдол, мэдээллийг бүртгэх, шийдвэрлэлтийг хянах програм хангамжийг боловсруулж, нэвтрүүлсэн. Гомдол мэдээлэл хүлээн авах “110” дугаарын утсыг олон нийтэд таниулах зорилгоор видео контент, шторк, зурагт хуудас гаргах зэрэг хэлбэрээр сурталчилгаа явуулж, зурагт хуудас, баннерийг гудамж, талбай дахь самбар, дэлгэц болон цахим хуудсуудад байршуулав. Мөн “Скайтел”, “Мобиком”, “Жи Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны оператор компанийн маркетингийн албатай хамтран холбогдох сурталчилгааг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулав. Ингэснээр гомдол, мэдээлэл хүлээн авах утасны програмд 2017 оны сүүлийн хагас жилд

нийт 125, 2018 онд 249 дуудлага ирж байсан бол 2019 онд 110 тусгай дугаарын утсаар зөвхөн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд 4464 удаагийн дуудлага бүртгэгдсэн байна. Тус газраас бусад орны сайн туршлагыг судалж, авлигын талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг иргэдэд ойртуулах зорилгоор Иргэний хяналтын төвүүдийг нээн ажиллуулсан бөгөөд 2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн төвүүдийн үйл ажиллагааг АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөл зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх газрын 110 тусгай дугаарын утсанд 2020 оны байдлаар нийт 17851 дуудлага ирсэн байна. Нийт дуудлагын 47.5 хувь нь зөвлөгөө авах, гомдол мэдээлэл өгөх, дуудлага андуурах, утсаар тоглох зэргээр холбогдож ярьсан бол 52.5 хувь нь дуудлага тасарсан, дуудлага холбогдсон ч яриагүй тасарсан байна. 2020 онд 110 тусгай дугаарын утсаар нийт 317 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэн шалгасан байна. Мөн дугаарын утсанд хандан өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж байгаа иргэдийн 145 буюу 45.7 хувь нь нэрээ нууцлан гомдол гаргахыг хүссэн бол 172 буюу 54.3 хувь нь нэр, хаягаа ил тодоор мэдээлэн гомдол гаргажээ. 110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 56.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 32.5 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 4.1 хувь нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна. Уг тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны чиглэлийг дурдвал төсвийн хөрөнгийн зарцуулалт(64), хүний нөөцийн томилгоо(60), захиргааны шийдвэр гаргалт(29), тусгай зөвшөөрөл(28), тендер худалдан авах ажиллагаа(27), хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт(27)-тай холбоотой байна. Мөн хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны салбараар нь үзвэл нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах салбар(64), бага, дунд боловсролын салбар(26), эрүүл мэндийн салбар(25), зам тээвэр, төмөр замын салбар(17), цагдаагийн байгууллага(17)-д хамаарч байна.

АТГ-ын гомдол, мэдээллийн програмыг шинэчлэх ажлыг зохион байгуулж програмын болон гэрээний маягтуудыг Үндэсний статистикийн хорооны хурлаар батлуулан

туршиж дууссан. Энэхүү програм ашиглалтад орсноор иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн шалгах хугацаа, явц байдал, шийдвэрлэлтэд нэгжийн дарга тухай бүр хяналт тавих, байгууллагын дотоод хяналтыг давхар хэрэгжүүлэх боломж бүрдсэн болно.

АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэх арга хэмжээний журам"-ыг шинэчлэн АТГ-ын даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Уг журам нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 4036 дугаарт бүртгэгдэн 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байна. Энэхүү журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд "Сахилгын шийтгэл" цэсийг шинээр нээн байршуулж, иргэд олон нийтийг мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэв. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 2019 онд 14 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байх ба үүнээс "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын хүрээнд 4 албан тушаалтны мэдээллийг журамд заасан хугацаанд, 8 албан тушаалтны сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг журамд заасан хугацаа өнгөрөөж тус тус нийтэд мэдээлсэн байна. Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд дахь "Сахилгын шийтгэл" цэсэнд болон "АТГ-Олон нийтийн төв" пэйж хуудсанд 2020 оны байдлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн нийт 25 албан тушаалтны талаарх мэдээллийг байршуулж, олон нийтэд мэдээлэв.

Төрийн албаны зөвлөлд 2020 онд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдээс нийт 43 гомдол, мэдээлэл ирүүлснийг Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх тул уг гомдол, мэдээллийг холбогдох байгууллагад шилжүүлсэн байна. Тухайлбал,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга болон албан хаагчид албан бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл ашигласан, ажлын цагаар архидан согтуурсан үйлдэл нь төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг зөрчиж байгаа талаар иргэнээс ирүүлсэн гомдлыг Хөдөлмөр, ниймгийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.

2020 онд 1245 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргаснаас 889 нь төрийн тусгай албан хаагч, 163 нь төрийн захиргааны, 183 нь төрийн үйлчилгээний албан хаагчид хамаарч байна.

Төрийн албаны зөвлөлд ирүүлж байгаа өргөдөл, гомдлын агуулгад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчдын ёс зүй, тэр дундаа ажлын байрны дарамт шахалтын талаар гаргасан өргөдөл, гомдлын тоо нэмэгдэж байна. Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хариуцлага тооцуулсан этгээдийн талаарх мэдээллийг цахимаар нийтэд түгээхийн зэрэгцээ хариуцлага тооцуулсан мэдээлэл болон авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан “танилцуулга” тогтмол хэвлэж түгээх ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэв. Ингэснээр мэдээлэл цахимаар хүлээн авах боломжгүй иргэд, олон нийтэд мэдээллийг хүргэх төдийгүй “иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийн мөрөөр Авлигатай тэмцэх газраас ажиллаж, зөрчил дутагдлыг тогтоож, хариуцлага тооцуулж ажиллаж байна” гэдгийг нийтэд сурталчлах, төрийн албан тушаалтан авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил болсон. Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчиж, хариуцлага тооцуулсан албан тушаалтны сахилгын шийтгэл хүлээсэн мэдээллээр танилцуулга, брошюрыг хэвлүүлж, иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болгов. (Биелэлт 100 хувь

4.1.1.8-1. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ. ШЕЗ, УЕПГ, 2018-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд сөрөг нөлөөлөл бүхий болон хууль бус захиргааны акт гэж эрх зүйн зөрчилтэй актыг хэрхэн ойлгох, 47 дугаар зүйлийн 1-д захиргааны акт хууль бус болох тохиолдол, 48 дугаар зүйлд сөрөг нөлөөлөл бүхий болон хууль бус захиргааны актыг хүчингүй болгох, 55 дугаар зүйлд захиргааны гэрээ хууль бус болох тохиолдол, 98 дугаар зүйлд захиргааны актыг хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх, бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох, өөрчлөх, мөн хуулийн аравдугаар бүлэг(100-104 дүгээр зүйл)-т

хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс өөрт учирсан хохирол арилгахыг шаардах эрх, хохирол барагдуулах этгээд, хохиролтой холбоотой маргаан шийдвэрлэх, хохирол барагдуулах, нөхөн олговор, түүний хэмжээг тогтоох, арван нэгдүгээр бүлэг (105-107 дугаар зүйл)-т хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг зохицуулж, төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгохоор заасан. Мөн хуулийн 76 дугаар зүйлийн 76.4-т “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.”, 76 дугаар зүйлийн 76.5-т “Энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.” гэж зохицуулсан.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн зохицуулалтыг тус тус тусгасан байна.

Прокурорын тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр ....төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэсэн заалтын дагуу төрийг төлөөлж прокуророор оролцсон тохиолдолд ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасны дагуу оролцуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлд заасны дагуу иргэд

мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас өөрт учирсан эдийн болон эдийн бус гэм хорын хохирлоо төрөөс (Засгийн газар) нэхэмжилж байна.

Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар хамтран Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, “Онч шийдэл” ТББ, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн албан хаагчид, холбогдох яам агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагуудыг оролцуулан “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, асуудлыг тоо баримт, мэдээлэлд тулгуурлан ярилцаж, учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, төрийн байгууллагын хамтын ажиллагаа зэрэг сэдвийг хэлэлцэж зөвлөмж гаргасан. (Биелэлт 100 хувь)

4.1.1.8-2. Хууль бус шийдвэр гаргаж, улсад хохирол учруулсныг шүүх тогтоосон тохиолдолд албан тушаалтныг нийтийн албанд дахин томилохгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлэх /ЗГХЭГ, ХЗДХЯ. ТАЗ, АТГ, ШЕЗ, УЕПГ, ҮАГ, 2018-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулахаар тусгасан. Мөн хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т зааснаар тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол “нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.” зэрэг шийтгэл оногдуулахаар заасан.

Мөн эрх зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд дээрх хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т заасан шийтгэл оногдуулаагүй, эсхүл тохирсон шийтгэлийг ногдуулаагүй тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилсан ба “нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж

орох эрхгүйгээр халах.” шийтгэл ногдуулсан тохиолдолд энэ хуулиас бусад хуулиас тогтоосон нөхцөл журам хэрэглэгдэхгүй болно.

Төрийн албаны тухай хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг “төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах” эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөний улмаас ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсаас нөхөн төлүүлдэг байдал арилах юм.

Төрийн албаны тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4-т “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.”, мөн зүйлийн 76.5-т “Энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.” гэж тус тус заасан.

Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглохыг эрх хасах ял гэнэ.” гэж тусган, шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно, мөн энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулахаар хуульчилсан. Хуульд

зааснаар шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолж байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2020 онд төрд бодит хохирол учруулсан илтэд хууль бус тушаалыг илрүүлж, уг тушаалыг гаргасан албан тушаалтантай тусгайлан уулзалт хийж, учир холбогдлыг ойлгуулан 4.5 орчим сая төгрөгийг хууль бус шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлж, 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдөр төрийн сангийн дансанд шилжүүлсэн байна. Төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгохтой холбогдуулан тусгайлсан журмын төслийг боловсруулж байгаа бөгөөд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үүднээс Үндэсний аудитын газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх бүхий ажилтан, албан хаагчидтай хэлэлцүүлэг хийж, санал солилцож, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлсон болно. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.9-1.Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /ЗГХЭГ, ХХМТГ, 2017-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас дижитал шилжилтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодорхой зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд энэ хүрээнд “Төрийн байгууллага хооронд албан бичиг солилцох суурь систем ([www.docx.gov.mn](http://www.docx.gov.mn))”-ийг хөгжүүлж “Үндэсний дата төв” УТҮГ-т хүлээлгэн өглөө. Энэхүү систем нь төрийн байгууллагууд ямар систем ашиглаж байгаагаас үл хамааран албан бичгийг цахимаар солилцох, цахим албан бичгийн нэгдсэн мэдээллийн сан үүсэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх өргөн боломжийг олгож байна.

Төрийн байгууллага хооронд албан бичиг цахимаар солилцох энэхүү боломж нь тодорхой нэг системийг ашиглаж байгаа байгууллага хооронд л хийгддэг байсан нь албан бичиг солилцохын тулд зөвхөн нэг систем ашиглах, өөр сонголт хийх боломжийг хязгаарлах сөрөг талтай байсан. Тус

системийг хөгжүүлж, “Үндэсний дата төв” УТҮГ-т хүлээлгэн өгснөөр “ХУР” үйлчилгээний тоог нэгээр нэмэгдүүлж, төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн системүүдийг нэг үйлчилгээгээр холбох боломж бүрдсэн болно.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тоон хэлбэрт хөтлөн бүртгэлжүүлэх, баримт боловсруулах, хянах, батлах (тоон гарын үсгээр батлах), байгууллага хооронд солилцох, баталгаажсан баримтыг цахим болон тоон хэлбэрээр архивлах боломжтой албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг нэвтрүүлсэн онлайн <https://edoc.ulaanbaatar.mn> системийг нийслэлийн харьяа 918 байгууллагын 12,898 албан хаагчид ашиглаж байна.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас эрхлэн “Төрийн байгууллагын дотоод удирдлагын систем”-ийг хөгжүүлэн 2020 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан. Уг системийг 21 аймгийн төв, 330 суманд суурилуулсан “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн системээр дамжуулан төрийн бүх шатны байгууллага ашиглах боломжийг бүрдүүлсэн. Уг систем нь албан хэрэг хөтлөлтийн модулыг багтааж байгаа ба төрийн байгууллагын хооронд албан бичгийг цахим хэлбэрээр төлөвлөх, солилцох, бүртгэх, архивт шилжүүлэх боломжтой болсон.

Захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлт болон солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2019 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлт, солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх туршилтын ажлыг эхлүүлж байсан бол 2020 онд “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем(ERP)”-ийг Соёлын яам, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ, Нислэгийн цаг уурын төв, “Монгол шуудан” ХК, Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Туул голын сав газрын захиргаа, Харилцаа холбооны зохицуулах хороо, Барилгын политехник коллеж, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал, Нийслэлийн төр захиргааны байгууллагууд, 21 аймгын Засаг даргын Тамгын

газар, 330 сумын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагуудад нэвтрүүлээд байна.

Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журмын хэрэгжилтэд хийсэн дүгнэлт болон улсын хэмжээнд төрийн байгууллагууд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамжийн талаарх судалгаа хийж, цахим хэлбэрээр архив албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах программ хангамжийн нийтлэг шаардлагыг боловсруулж, Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ыг баталсан.

Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоол болон Засгийн газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай” 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Архивын ерөнхий газрын даргын 2020 оны 04 сарын 24-ний өдрийн А/52/А-47 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, төрийн байгууллагад нийтлэг ашиглаж байгаа цахим албан хэрэг хөтлөлтийн систем, түүний үйл ажиллагааг шалган туршлаа. Үүний үр дүнд цахим баримт бичиг солилцооны дундын системийн бүтцийн зураглалыг гаргаж, систем хоорондын харилцан холболтын гарын авлагын төслийг боловсруулсан. Мөн “Цахим хэлбэрээр баримт бичиг солилцох программ хангамжийн холболтын техникийн шаардлага батлах тухай” тушаалын төслийг системийн бүтэц болон программ хангамжийн холболтын техникийн шаардлагын хамтаар боловсруулж, 2 байгууллагын даргын хамтарсан тушаалаар баталгаажуулахаар ажиллаж байна. Цахим баримт бичиг солилцооны дундын системийг “Үндэсний дата төв” УТҮГ-т байршуулахаар зохих гэрээ байгуулж, зохиомол серверт шилжүүлэн байршуулсан. Төрийн байгууллагын цахим хэлбэрээр баримт бичиг солилцох дундын системийг төрийн захиргааны болон төрийн өмчийн 43 байгууллага, Нийслэлийн нутгийн захиргааны 1148 байгууллага, 21 аймгийн нутгийн удирдлагын 542 байгууллага нийтдээ 1733 байгууллагын 24973 албан хаагч өдөр тутмын албан хэрэг хөтлөлтөд ашиглаж байна. (Биелэлт 70)

4.1.1.9-2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Төрийн байгууллага болон аж ахуйн

нэгжүүдийг төрийн мэдээлэл солилцооны системд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон төрийн үйлчилгээний платформоор дамжин хүрэх “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг хөгжүүлж байна.

“ХУР” системийн дэд бүтцийг өргөтгөх төслийг боловсруулан Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Ухаалаг засаг” төслийн Удирдах хороо болон төслийн ерөнхий зохицуулагчид танилцуулж зөвшөөрөл авлаа. Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэгчийн сонгох шалгаруулалтыг зохион байгуулж, төслийн гүйцэтгэгчээр шалгарсан “Вертексмон” ХХК-тай Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019.07.03-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсан бөгөөд нөөц өрөөний засварын ажлыг хийсэн.

Энэ хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газар 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн ХХМТГ/4/2020, УБЕГ/2020/29 тоот дугаар бүхий “Төрийн мэдээлэл солилцооны систем /ХУР/-ээр дамжуулан мэдээлэл ашиглах тухай гэрээ” байгуулж, төрийн байгууллагуудыг “ХУР” системд холбож, цахим хэлбэрээр мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлсэн. Улмаар Төрийн мэдээлэл солилцооны “ХУР системд төрийн 61, хувийн хэвшлийн 121 буюу нийт 182 байгууллага холбогдож нийт 308 веб сервисийг хөгжүүлсэн ба 215 сая удаа мэдээлэл солилцох хүсэлтийг амжилттай боловсруулж, хариу илгээн ажиллаж байна. (Биелэлт 70)

4.1.1.10-1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-т Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллахаар заасан. Үүний дагуу Засгийн газрын 2018 оны “Удирдлагын академийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 366 дугаар тогтоолыг батлан, Удирдлагын академид 2019 оноос өмнө төрийн захиргаа, төрийн удирдлага болон бизнесийн удирдлагын

чиглэлээр элсэн хувийн зардлаар суралцаж байгаа суралцагчдын сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн дуусгавар болгох арга хэмжээ авч, Засгийн газрын захиалгат сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлж байхаар шийдвэрлэсэн. Мөн тогтоолоор Удирдлагын академийн дүрмийг шинэчлэн баталсан ба тус байгууллага нь төрийн албан хаагчдын мэргэшүүлж бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, төрийн албаны хүний нөөцийн менежментийн асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага юм.

Засгийн газрын захиалгаар гүйцэтгэх сургалтын агуулга, хөтөлбөрийг Төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран баталж байна. Удирдлагын академи нь 2020 онд улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрт “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтын хөтөлбөр, хичээлийн дэлгэрэнгүй хөтөлбөр, зохион байгуулах төлөвлөгөө, семинар, дасгалын удирдамж болон сургалтад ашиглах жишээ, кэйс, онол, арга зүйн гарын авлага, судалгааны материалын агуулгын дагуу тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаал, төрийн албанд анх томилогдох албан хаагчдад дээрх чиглэлээр сургалтыг зохион байгуулаад байна. Тухайлбал, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад “Ёс зүйн менежмент, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” сэдвээр 159 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” сэдвээр 315 албан хаагч, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 473 албан хаагч, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх богино хугацааны сургалтад “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага” сэдвээр 424 албан хаагч, нийт 1371 албан хаагчийг тус сургалтад хамрууллаа. Мөн магистр, докторын сургалтад “Захиргааны процесс”, “Төрийн хяналт” хичээлийн хяналт шалгалт явуулах үйл явцад ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх гэсэн агуулгаар хичээл зааж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-т заасны дагуу төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтын хөтөлбөрт «Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл» сэдвийг тусгаж, 2020 оны хичээлийн жилээс эхлэн тогтмол зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэ хүрээнд 2020 онд анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх богино сургалтад аймаг, нийслэл, сум, дүүргийн нийт 575 хүн, яам агентлагийн 58 албан хаагч хамрагдаж, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл” сэдэвт хичээлийг зайн хэлбэрээр судалж, сургалтыг дүүргэн сертификат авсан болно. Мөн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга мэргэжилтнүүд болох нийт 44 албан хаагч, байгууллагын захиалгат богино хугацааны сургалтад оролцсон 122 хүнд “Төрийн албан хаагчийн ёс зүй, “Төрийн албан хаагчийн манлайлал, ур чадвар” сэдвээр тус тус сургалт хийв. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.10-2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах /АТГ, ТАЗ, УА, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасныг үндэслэн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын хэрэгцээг тодорхойлж, төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулан Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар, Төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар тус тус баталсан.

Үүнд төрийн албан тушаалын ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох иргэнийг мэргэшүүлэх

багц сургалтын болон төрийн албанд шинээр томилогдсон буюу туслах, дэс түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж байгаа иргэнийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын хөтөлбөр багтаж байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл, Удирдлагын академи хамтран үе шаттай сургалт зохион байгуулав.

Тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх багц сургалтад Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын болон Удирдлагын академийн удирдах ажилтнууд, яамдын төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга зэрэг нийт 131 удирдах албан тушаалтан, эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх багц сургалтад УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллага, яам, агентлагийн хэлтсийн дарга, аймаг, нийслэлийн ИТХ-н нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга зэрэг нийт 575 удирдах албан тушаалтан, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх сургалтад 455 албан хаагч, нийт 1161 албан хаагчийг хамрууллаа.

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт буюу тэргүүн, эрхэлсэн, ахлах албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад 2019 онд нийт 1198 албан хаагчдыг хамруулсан 13 удаагийн багц сургалтын хөтөлбөрт “Ёс зүйт манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Ёс зүйн менежмент, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” хичээлийг тус тус зохион байгуулсан болно.

Энэ хүрээнд ЗГХЭГ, яам, агентлаг, чөлөөт бүс, нийслэлийн ИТХ-ын ажлын алба, нийслэлийн ЗДТГ-ын дарга нарт зориулсан “Манлайллын симпозиум: Өөрчлөлт хийх чадварыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад 142, Төрийн байгууллагын хүний нөөцийн ажилтан нарт зориулсан “Төрийн албан хаагчдын сургалтын бодлого, тогтолцоо” сэдэвт сургалтад 61, нийт 203 албан хаагч богино хугацааны сургалтад хамрагдсан. Эдгээр сургалтыг Удирдлагын академийн Төрийн албаны сургуультай хамтран зохион байгуулав.

681 төрийн байгууллагаас Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн дагуу Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зорилтод

арга зүйн сургалт зохион байгуулж, 6500 төрийн албан хаагчийг хамруулав.

АТГ авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулав. АТГ-аас 2019 онд нийт 40 сэдвээр, Удирдлагын Академи, Монгол Улсын Их Сургууль, Монголын Улсын Боловсролын Их Сургуулиудтай хамтран нийт 20 сэдвээр тус тус сургалтын модуль боловсруулан нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Удирдлагын академитай хамтран нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын 6 модуль, гарын авлагыг боловсруулж, туршилт сургалтыг зохион байгуулан уг модулиар төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах ажлыг хэвшүүлээд байна. Түүнчлэн “Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-аас иргэдэд зориулсан авлигын эсрэг сургалтын модуль, “Жаргалант хангай” ТББ ерөнхий боловсролын сурагч, хүүхэд залууст зориулсан шударга ёсны хичээлийн сургалтын модуль, “Глоб интернешнл төв” ТББ сэтгүүлчид зориулсан сургалтын модуль, хөтөлбөрийг боловсруулж сургалтыг үе шаттай зохион байгуулсан.

Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр 2019 онд “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг боловсруулсан бол 2020 онд Засгийн газар, аймаг, нийслэл, яам агентлаг зэрэг байгууллага албан тушаалтны үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой тохиолдол (кейс)-ын дүн шинжилгээнд суурилсан төрийн байгууллагын худалдан авах, санхүү, хууль эрх зүй, дотоод хяналт шалгалт, аудитын болон удирдах албан тушаалтанд зориулсан 5 төрлийн сургалтын 20 модуль, сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

АТГ-аас авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд



чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулав. Уг хөтөлбөр нь 3 өдөрт багтаан хэрэгжүүлэх 9 цагийн лекц, 9 цагийн дасгал, 3 цагийн хэлэлцүүлгээс бүрдсэн бөгөөд хичээл тус бүрийн агуулгын боловсруулалтыг хийснээрээ онцлог юм. Иргэдийг авлигын эсрэг мэдлэг мэдээллээр хангаж, хандлага, нийгмийн оролцоог сайжруулахтай холбоотой арга хэмжээг авах зорилгоор сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр “Шударга ёс-Иргэний хяналт” сургалтын хөтөлбөрийг боловсруулсан юм.

Хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчдэд зориулсан интерактив модуль бүхий гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр ажиллах аппликэйшн бэлтгэж боловсруулах хүрээнд холбогдох судалгааг хийж, сургалтын модуль боловсруулав. Авлигаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг дээшлүүлэх, авлигыг мэдээлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр “Шударга ёс, хөгжил дэвшилд-Хувийн хэвшлийн оролцоо” сэдвээр сургалтын хөтөлбөр, гарын авлага, шинэчлэн боловсруулж, хувийн хэвшлийн байгууллагуудад иж бүрэн сургалт зохион байгуулах боломжтой болов. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 2018 онд эрхлэн хэвлүүлсэн “Шударга байдлын боловсрол” гарын авлагыг орчуулж, хэвлүүлэв. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.10-3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөр”-т “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” болон “Харилцааны соёл, ур чадвар” зэрэг чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт явуулахаар тусган хэрэгжүүлж байна.

Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институт улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх

сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу танхимын 14, зайн 4, ажлын байран дахь 5, нийт 23 удаагийн сургалтад нийт 1287 төрийн албан хаагч хамруулсан байна. Танхимын 6 чиглэлийн 14 удаагийн сургалтад 572 төрийн албан хаагч, “Албан хэрэг хөтлөлт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт”, “Төрийн албан хаагчийн манлайлал” сэдвээр зохион байгуулсан зайн сургалтад нийслэл, 21 аймаг болон яам, агентлагийн 298 төрийн албан хаагч, 12 аймаг нийт 417 төрийн албан хаагч ажлын байран дахь сургалтад хамрагдсан. Үүнд: Дорноговь, Говьсүмбэр, Төв аймагт “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдвээр Дархан-уул, Сэлэнгэ аймагт “Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээ”, Хөвсгөл, Булган, Орхон аймагт “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ”, Архангай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймагт “Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй” зэрэг сэдвээр сургалтыг тус тус зохион байгуулсан.

Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институт улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалтууд, төрийн байгууллагатай хамтарсан болон захиалгат сургалтуудад “Төрийн албаны ёс зүй”, “Төсвийн ил тод байдал” гэх мэт авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой сэдвээр тогтмол сургалт зохион байгуулж байна. Тухайлбал, төрийн албаны ёс зүй, манлайлал, харилцааны ур чадварын танхимын болон зайн, ажлын байран дахь сургалт, байгууллагуудын захиалгат богино сургалтад төрийн болон орон нутгийн нийт 1515 албан хаагчид хамрагдсан байна. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд байгууллагын захиалгат сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, удирдах ажилтны ёс зүй, төрийн үйлчилгээний соёл, захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь нийтлэг алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, төсөв санхүүгийн хяналт, худалдан авах ажиллагаан дахь нийтлэг зөрчил, түүнээс сэргийлэх арга зам зэрэг сэдвийн хүрээнд 510 хүн хамрагдсан.

Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг төрийн зарим байгууллагууд онцлог байдлаар зохион байгуулсан байна. Тухайлбал, нийслэлийн ЗДТГ Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын сургалтын хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийн агуулга” боловсруулан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн

иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, хөтөлбөрт тусгагдсан модуль сургалтуудыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Сургалтын төв”-ийг түшиглэн зохион байгуулав. Нийслэлийн төвийн 6 дүүрэг, хэрэгжүүлэгч 14 агентлагийн хүний нөөц хариуцсан ажилтнуудад зориулсан “Хувь хүнийг хөгжүүлэх нь” сэдэвт олон улсын сертификаттай сургалт; Герман-Монголын хамтарсан Афа академитэй хамтран “Төрийн албан хаагчийн хувь хүний хөгжил ба ёс зүй” сэдэвт сургалт; Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд зориулсан сургалтыг; “Төрийн албаны тухай хуулийн зохицуулалт, төрийн албаны соёл, стандарт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээ” сэдэвт сургалт; Дүүргийн хороодод шинээр томилогдсон хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хорооны зохион байгуулагч нарт зориулсан суурь сургалт, төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигчдэд зориулсан сургалт; Төрийн жинхэнэ албан тушаалд анх удаа орж байгаа албан тушаалтнуудад ажлын байранд тавигдах үндсэн шаардлага, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах сургалтыг тус тус зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулсан авлигын эсрэг сургалтад 2017 онд 11345, 2018 онд 14783, 2019 онд 25007, 2020 онд 13820 нийт 64955 этгээдийг хамруулжээ. Тэдгээрээс 2018 онд 8497, 2019 онд 4947 буюу нийт 13444 албан хаагчийг Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд сургасан бол 2019 онд тухайн байгууллага дээр болон аймаг орон нутагт зохион байгуулсан сургалтад 5238 албан хаагч, 3580 оюутан, сурагч, 7627 иргэд, 354 төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл тус тус хамрагдсан байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг сургалтад оролцогчдыг салбар, байгууллагаар нь авч үзвэл Ерөнхийлөгчийн Тамгын газар түүний харьяа байгууллагаас 32, Улсын Их Хурал түүний харьяа байгууллагаас 572, шүүхийн 3 байгууллагаас 121, прокурорын 11 байгууллагаас 254, Засгийн газар болон Ерөнхий сайд, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 17 байгууллагаас 582, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллагаас 31, Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагаас 429, гадаад харилцааны яамнаас 67, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 байгууллагаас 128, Зам тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагаас 216, Уул уурхай, хүнд

үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллагаас 16, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллагаас 132, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 байгууллагаас 1971, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 7 байгууллагаас 108, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллагаас 724, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллагаас 185, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас 51, нийслэлийн төр захиргааны 30 байгууллагаас 345 болон орон нутагт 7 аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий 1576 албан тушаалтан хамрагджээ.

АТГ-ын Олон нийтийн төвд нийтийн албан тушаалтнууд, зорилтот бүлэгт зориулсан авлигын эсрэг сургалтаас гадна иргэдэд мэдээлэл хүргэх, гомдол мэдээлэл хүлээн авах, гарын авлага, материал түгээх, дотоодын болон гадаадын хурал, зөвлөгөөн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж байсан бол цар тахлын улмаас авлигын эсрэг сургалт хэлэлцүүлгийг цахим хэлбэрт шилжүүлсэн 2020 онд нийт 13820 хүнийг сургалтад хамруулж, Авлигын эсрэг сургалтыг 2020 онд 93 удаа зохион байгуулж, цахим сургалтыг 20 удаа хийжээ. 2190 хүнд олон нийтийн сүлжээгээр live сургалт хийж, нийслэлийн 9 дүүргийн 143 хорооны 1631 албан хаагчийг цахим сургалтад хамрууллаа. Сургалтыг салбар, мэргэжил тус бүрээр төрөлжүүлэн зохион байгуулсан нь шинэлэг байв. Мөн иргэд, оюутан залуус, хувийн хэвшил зэрэг нийгмийн зорилтот бүлэг рүү чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Үзэл санааны удирдагчдаар оюутнуудад лекц уншуулах”, “Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь”, “Сайн туршлага: Иргэдийн бүлэг”, “Төрийн үйлчилгээ ба иргэний хяналт” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж нийт 68 байгууллагын 6381 иргэдийг хамруулаад байна.

Авлигын эсрэг сургалтын оролцооны байдлаас дүгнэхэд төрийн байгууллагуудын удирдлагын зүгээс уг сургалтад албан хаагчийг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын нэгдсэн төлөвлөлт, бодлогогүйн улмаас мэдээлэл авсан сэдвээр нэг албан хаагчийг удаа дараа оролцуулах, сургалтын ирц, гүйцэтгэл хангалтгүй байх, оролцогчдын давхардал, хийдэл гарах асуудлууд гарч байв. Авлигын эсрэг сургалтыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх, төрийн албанд анх удаа томилогдсон албан хаагчийг энэхүү

сургалтад заавал сургадаг байх, давтан сургалтад оролцогчдын эрэлт хэрэгцээг тодорхойлох ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн байгууллагуудад саналаа хүргүүлэв. Нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтад оролцогчдыг цахим системд бүртгэж хэвшсэн бөгөөд ингэснээр давтан сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, оролцоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон АТГ газраас 21 аймгийн удирдлагуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад орон нутгийн зүгээс анхаарах асуудлын талаар аймгийн удирдах ажилтнуудад мэдээлэл хийж, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан. Уг зөвлөгөөнд аймгийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, түүний дэргэдэх агентлагуудын удирдах ажилтнууд, мөн сумдын ИТХ болон ЗДТГ-ын удирдах албан тушаалтнууд 120 гаруй хүн оролцсон болно.

Төрийн байгууллагууд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор холбогдох сургалтуудыг зохион байгуулж ажилладаг. Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын хувьд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын захиргааны удирдлагын болон төлөвлөлт зохион байгуулалтын газар, хэлтэс, тасгийн дарга нарын сургалт, зөвлөгөөнд (60 орчим хүн хамрагдсан) “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний явц байдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр, ЦЕГ-ын орон нутгийн 50 орчим салбар ЭБАТ-уудын цугларалтад мөн сэдвээр сургалт хийж, арга зүйн удирдлагаар хангасан байна. Сангийн яам “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг сурталчлах нэг сарын аян”-ыг өрнүүлж, “Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв”, “Албаны соёл, ажил хэрэгч байдал”, “Төрийн албаны үнэт зүйл, байгууллагын соёл”, “Хүний нөөцийн хөгжил, хөдөлмөрийн ёс суртахуун”, “Харилцааны чадвар” зэрэг сургалт зохион байгуулан, яамны албан хаагчдын 75 хувийг хамруулсан. Улсын бүртгэлийн ерөнхий газар 69 удаагийн сургалт зохион байгуулж 3525 /давхардсан тоогоор/ гаруй албан хаагчийг, Засгийн газрын болон байгууллагын зардлаар, бусад төрийн байгууллагын зохион байгуулж буй сургалтад 193 гаруй албан хаагчийг хамруулсан. Мөн төрийн болон төрийн бус байгууллагын

захиалгаар иргэдэд зориулсан эрх зүйн сургалт зохион байгуулах зорилтын хүрээнд 15 удаагийн сургалтаар 481912 иргэнд мэдлэг олгож, үйл ажиллагаагаа сурталчилсан. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.1.10-4 Бүс нутгийн хэмжээнд авлигын эсрэг сургалт, семинарыг зохион байгуулах / АТГ, ЗГХЭГ, 2020-2022/

Ази, Номхон далайн бүс нутагт эрүүгийн хэргийн асуудлаар байгууллага хооронд мэдээлэл шуурхай солилцох, гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг царцаах, буцаах чиг үүрэгтэй “АРИН-АП” хэмээх сүлжээг анх БНСУ-ын Прокурорын дээд газрын санаачилгаар 2013 онд бий болгожээ.. Монгол Улсын хувьд Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээний 2019 оны даргалагч улсаар ажилласан бөгөөд Монгол Улсын Авлигатай тэмцэх газар Даргалагч улсын эрх, үүргийг хэрэгжүүлж Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний 6 дугаар бүгд хурлыг удирдан зохион байгуулсан. Энэхүү бүгд хуралд 22 улс, олон улсын 5 байгууллага, дотоодын төрийн 7 байгууллагын нийт 110 орчим төлөөлөгч оролцов. Бүгд хурлын дараа АРИН-АП сүлжээний гишүүн улс орнуудын төлөөлөгчид харилцан туршлага нээлттэй хуваалцах, албан болон албан бус шугамаар мэдээлэл солилцох зөв зохистой арга замыг тогтоож, хууль бус хөрөнгийг буцаах чиглэлээр урт хугацаанд, үр дүнтэй, найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Нуугдмал хөрөнгө илрүүлэх: Гэмт хэрэг үйлдэх замаар олсон хөрөнгөөс ашиг хүртэх эцсийн өмчлөгчийг олж тогтоох нь” сэдэвт сургалтыг 2019 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо мөн зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас гадаад хамтын ажиллагааг эхлүүлэх, өргөтгөх, харилцан туршлага солилцох, албан хаагчдыг сургах чиглэлээр БНХАУ-ын Үндэсний хяналтын хорооны Сургалтын төв, Гадаад хамтын ажиллагааны газарт санал хүргүүлээд байна. 2020 оны 9 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулах орос хэл өргөн хэрэглэдэг орнуудад зориулсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад албан хаагчдаа хамрууллаа. 2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол Улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах

ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монгол банкны холбогдох 29 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга StAR /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад шинээр албан тушаалд томилогдсон 30 мөрдөгчийг хамруулан, ахисан түвшний 3 удаагийн цахим сургалтыг 4, 5 дугаар сард зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газрын хүсэлтийн дагуу НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн банкны хамтарсан түншлэл болох “Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR)”-аас “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах” сэдэвт цахим сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Сургалтанд тус газрын Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэс, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн нийт 55 алба хаагч хамрагдаж АНУ, Их Британи, Франц, Сингапур, Швейцарь, Малайз зэрэг улсуудын улсын бүртгэлийн системээс аж ахуйн нэгж болон хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн эзэмшигчийн талаарх мэдээллийг олж авч болох боломжийн талаарх мэдлэгээ дээшлүүлсэн болно. (Биелэлт 70 хувь)

**Хоёр. Төрийн үйлчилгээний нээлтэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дахь зорилтын хүрээнд нийт 7 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.2.1-1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ХХМТГ, Бүх шатны төрийн байгууллагууд. 2017-2018/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолоор баталсан төрийн үйлчилгээний цахим систем /[ezasag.mn](http://ezasag.mn)/-д холбох төрийн 167 үйлчилгээний жагсаалтын дагуу 2017 онд 18 үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээг цахим машин ашиглан иргэдэд хүргэхэд мөрдөх “Төрийн үйлчилгээний цахим машины ашиглалт үйлчилгээний журам”-ыг шинэчлэн батлуулсан.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) цахим хуудсыг ашиглан Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн жолооны үнэмлэх солиулах үйлчилгээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 6 төрлийн үйлчилгээний холболтыг турших, Автотээврийн үндэсний төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 3 төрлийн үйлчилгээг ТҮЦ машины үйлчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсны дараа 2018 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 30 дугаар тушаалаар “Төрийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, төрийн үйлчилгээг иргэн төвтэй болгож, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан санал, дүгнэлт боловсруулж Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 259 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталж, 2015 оны 254 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-д 176 үйлчилгээг төрийн цахим мэдээлэл солилцох системд холбохоор холбогдох яам, үйлчилгээний нэрээр нь баталсан бол “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний жагсаалт”-д 38 байгууллагын 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр нэрээр нь тусгасан байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тоног төхөөрөмж авч, хөгжүүлэх ажлыг зохион байгуулсан. 2020 онд дээрх тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж 17 байгууллагын 117 сервисийг шинээр хөгжүүлсэн. 2020 оны жилийн эцсийн байдлаар төрийн үйлчилгээний нэгдсэн /[E-Mongolia.mn](http://E-Mongolia.mn)/ систем болон мобайл аппликейшнээр дамжуулан 181 үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэн ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэн, аж ахуйн нэгжид үзүүлдэг 30 багц нийт 118 үйлчилгээг 2021 оны 06 дугаар сард багтаан бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн систем хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

“Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ийг хөгжүүлэн 2018 оноос ашиглалтад оруулж системд төрийн 47, хувийн 118 байгууллагыг холбосон

бол 2019 онд ХУР системд 97 байгууллагын веб сервис холбогдож 19.246.680 мэдээлэл солилцох хүсэлтийг авч мэдээлэл илгээсэн байна. 2019 онд "Танилт, баталгаажуулалтын ДАН" системээр 18 байгууллага холбогдож 31.852 хэрэглэгч бүртгүүлж ашигласан, төрийн үйлчилгээний цахим машинаар 28 нэр төрлийн үйлчилгээг 1.426.491 иргэнд үзүүлсэн дүнтэй байв. 2020 оны байдлаар Төрийн цахим мэдээлэл солилцох "Хур" системд төрийн 61, хувийн хэвшлийн 121 буюу нийт 182 байгууллага холбогдож нийт 308 веб сервисийг хөгжүүлсэн ба 215 сая удаа мэдээлэл солилцох хүсэлтийг амжилттай боловсруулж, хариу илгээн ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санаачлан "Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 149 дүгээр тогтоолыг батлуулсан. Уг тогтоол батлагдснаар Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "Нэг цонхны үйлчилгээ", "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийг операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг "Үйлчилгээний нэгдсэн төв" болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад "Үйлчилгээний нэгдсэн төв" байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн мэдээллийн системийг хөгжүүлэн төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд холбох, иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд хандан авах замаар шийдвэрлэхээр тогтож, "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн мэдээллийн системийг хөгжүүлэхэд шаардлагатай 2.5 тэрбум төгрөгийн зардлыг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын II.1.3.1-д тусгагдсан "Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх "Хур" систем төслийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ыг баталсан бөгөөд түүний хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэхтэй холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Улсын бүртгэлийн ерөнхий газартай 2020 оны 05 дугаар

сарын 25-ны өдөр "Төрийн мэдээлэл солилцооны систем /ХУР/-ээр дамжуулан мэдээлэл ашиглах тухай гэрээ"-г байгуулсан. Тус гэрээний дагуу төрийн цахим мэдээлэл солилцох ХУР системд холбогдох хүсэлт гаргасан төрийн байгууллагуудыг холбож, үйлчилгээний гэрээг байгуулан ажиллах чиглэлийг Үндэсний дата төв УТҮГ-т өгч, хамтран ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.1-2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) цахим хуудсыг ашиглан иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн цахим үйлчилгээг сайжруулахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, "Интерактив" ХХК, "Интерактив Би Ай" ХХК хамтран холбогдох арга хэмжээг авч Санхүүгийн зохицуулах хороо Үндэсний дата төвтэй хамтран "ХУР" системд Санхүүгийн зохицуулах хорооны "Зөвшөөрлийн цахим систем"-ийг 2020 оны хагас жилд багтаан бүрэн холбов.

Цахим үйлчилгээний нэгдсэн [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn) порталаар дамжуулан цахим хэлбэрээр төлбөр төлөх, үйлчилгээний хүсэлтийн шийдвэрлэлтийг харах, хувь хүний өгөгдөлд хандсан тухай мэдээллийг иргэнд мэдээлэх, Чат бот ашиглан харилцах, өргөдөл гомдол гаргах, үндэсний цахим шуудангийн системтэй холболт хийж, нэвтрэхдээ арилжааны банкны эрх, бүртгэлтэй гар утасны дугаар болон тоон гарын үсгээр нэвтрэх боломжийг бүрдүүлэв. Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын хүрээнд 2020 оны байдлаар 23 байгууллагын 181 үйлчилгээг нэгтгээд байна. 2020 оны байдлаар үйлчилгээ авах хүсэлт 511,557 ирсэн ба 398,167 удаа үйлчилгээ авсан байна. Мөн гар утасны аппликешнийг 173,128 гаруй удаа татан авчээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний хураамж, мэдээллийн систем ашигласны төлбөрийн хэмжээг судлан тогтоохыг Сангийн сайдад даалгаж, Төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий нэгж байгуулан ажиллуулах, "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн ажилтнуудыг шаардлагатай сургалт, дадлагад хамруулахаар тогтсон. "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн үйл ажиллагааны журмыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 84 дүгээр

тушаалаар баталсан.

Иргэд төрийн үйлчилгээ авахдаа олон цонх дамжиж байгаа шатлалыг арилгах, давхардсан бүтэц үүсгэхгүй байх зорилгоор төрийн дижитал шилжилтийг хийж нэг цонхны үйлчилгээ болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг өөрчлөн зохион байгуулах, сумдад төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэгдсэн төв шинээр байгуулах, тэдгээрийг операторын горимд шилжүүлэх (олон цонх дамждаг шатлалыг арилгаж, тухайн нэг цонхноос бүх үйлчилгээг авах бололцоог бүрдүүлэх), үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргах эрх бүхий албан хаагчид цахим хэлбэрээр дамжуулах, шийдвэрлэлтийн явцыг иргэнд мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шийдвэрлэлтийн явцын талаар нэгдсэн хяналт хийх боломж бүхий “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн мэдээллийн системийг хөгжүүлж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбох асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор 2019 онд Засгийн газраас “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 149 дүгээр тогтоолыг батлан мөрдөж байна.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хүрээнд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Дүнжингарав, Мишээл, Драгон болон Оргил төв (4 цэг)-д болон 21 аймагт ажиллаж байсан Төрийн үйлчилгээний төвийн зохион байгуулалтыг Үйлчилгээний төв болгон өөрчлөн зохион байгуулж, Төрийн үйлчилгээний операторын [www.operator.e-mongolia.mn](http://www.operator.e-mongolia.mn) системийг хөгжүүлж, 21 аймгийн төв болон 330 сум суурин газрын ЗДТГ-т нэвтрүүлж 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн операторын горимоор төрийн үйлчилгээг үзүүлж байна. Үйлчилгээний нэгдсэн төвийн тоо 351, Үндэсний дата төвийн нөөц өрөөг, бүрэн тохижуулж төрийн мэдээлэл солилцооны системийн тоног төхөөрөмжийг Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр өргөтгөж 2020 оны 02 дугаар сард ашиглалтад оруулан, үйлчилгээний нэгдсэн төв болгон зохион байгуулав. Эдгээр төвүүдэд төрийн 28 байгууллагын 225 албан хаагч 325 нэр төрлийн төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг дороос үзүүлж байна. Жил тутам үйлчилгээний хандалт эрс нэмэгдэж байгаа бөгөөд хандалтыг оноор авч үзвэл, 2016 онд 1.000.049, 2017 онд 1.520.954, 2018 онд 1.917.929, 2019 онд 1.970.999, 2020 онд цар тахал гарсантай холбогдуулан үйлчлүүлэгчдийн тоо буурч 1.175.999 үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд тус тус үйлчилгээ үзүүлжээ. Үйлчилгээний хандалт жил тутам нэмэгдэж байгаа нь төрийн үйлчилгээг

авах иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэгдсэн төвүүдийг шинээр зохион байгуулж, үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өргөжүүлсэн, түүнчлэн иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж хэвшсэнтэй холбоотой. “Нэг цонхны үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолын дагуу нийслэл, орон нутагт нэг цонхны үйлчилгээний нийт 45 төв (213 цонх бүхий) үйлчилгээ үзүүлж байгаагаас 150 цонх нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа нэг цонх жилд дунджаар 3150 удаа, өдөрт 13 удаа үйлчилгээ үзүүлдэг ба төрийн байгууллагуудын үйлчилгээнээс шалтгаалан цонхны ачаалал харилцан адилгүй байдаг. Эдгээр төвүүдэд байгууллага тус бүрээс төлөөлөл сууж ажилладаг, үйлчилгээний ачаалал харилцан адилгүй, үйлчилгээ авах хүсэлтийг шийдвэрлэх явц иргэнд тодорхойгүй байдгаас хүлээлт үүсэх, дахин лавлаж ачаалал үүсгэх зэрэг асуудал тулгардаг байна.

Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем талаар танилцуулахад 2020 оны жилийн эцсийн байдлаар онд төрийн 61, хувийн хэвшлийн 121 буюу нийт 182 байгууллага холбогдож нийт 308 веб сервисийг хөгжүүлсэн ба 215 сая удаа мэдээлэл солилцох хүсэлтийг амжилттай боловсруулж, хариу илгээн ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг хүргэдэг төрийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг тэдгээрийн ашигладаг техник, програм хангамж, платформын ялгаатай байдлаас үл хамааран хоорондоо холбогдон, өгөгдөл мэдээлэл солилцох боломж бүхий “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” / [www.erp.gov.mn](http://www.erp.gov.mn) /-г бий болгон хөгжүүлэх замаар төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн урсгалын зохион байгуулалтыг сайжруулах, нэгдсэн удирдлагатай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод байдлаар хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Нийслэлийн цахим үйлчилгээний нэгдсэн портал [eservice.ulaanbaatar.mn](http://eservice.ulaanbaatar.mn) системийг 2018 онд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системээр нийслэлийн нутгийн захиргааны 113 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн. Нийслэлийн цахим үйлчилгээний <https://eservice.ulaanbaatar.mn/> систем Төрийн мэдээлэл солилцооны “Хур”, танилт нэвтрэлтийн “Дан” системийг ашиглан онлайн хэлбэрээр үйлчилгээ

үзүүлж төрийн байгууллагуудын үйлчилгээг нэг цонхоор үзүүлэх боломжийг хангасан систем бөгөөд тус системд тулгуурлан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Үндэсний цахим үйлчилгээний <https://e-mongolia.mn/> системийг нэвтрүүлсэн. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 салбарын 24 оператор нийслэлийн 9 байгууллагын 113 төрлийн үйлчилгээг операторын горимоор үзүүлж байна. Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон нийслэлийн нутгийн захиргааны 40 байгууллага, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар болон 171 хороо, нийслэлийн Дата төв, нэгдсэн сүлжээг гадны халдлагаас хамгаалж, мэдээллийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн ОӨУБЕГ, Цагдаагийн сүлжээ, Нийслэлийн нутгийн захиргааны 207 цахим хуудас, [ulaanbaatar.mn](http://ulaanbaatar.mn), [ub.gov.mn](http://ub.gov.mn), [smartcar.mn](http://smartcar.mn), [erp.ulaanbaatar.mn](http://erp.ulaanbaatar.mn) зэрэг 70 систем, ННЗБ-ын физик 33, виртуал 90 серверүүдийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж төрийн үйлчилгээг иргэд түргэн шуурхай авах нөхцлийг ханганажиллаж байна.

Сангийн яам хөрөнгийн үнэлгээний болон аудит, татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний хүрээнд тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд болон иргэдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн цахим хэлбэрт бүрэн шилжүүлэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс «Монгол Улсын шүүхийн цахим сан», «Эрэн сурвалжлах албадан ирүүлэх» бүртгэл тайлангийн систем, “Санал хүсэлт»-ийн систем, «Иргэний хэргийн хөдөлгөөний удирдлагын төв»-ийн систем, “Захиргааны хэргийн хөдөлгөөний удирдлагын төв»-ийн систем гэсэн 5 цахим үйлчилгээний системийг нэвтрүүлэв. Тухайлбал, Шүүхийн үүдэнд байрлах киоско төхөөрөмжөөр иргэдэд шүүхийн мэдээллийг хүргэх, иргэдээс шүүхтэй холбоотой санал хүсэлт болон судалгаа авах зорилготой “Санал хүсэлт” системийг ашиглаж байна. Түүнчлэн Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран шүүхэд шаардлагатай иргэн, хуулийн этгээдийн талаар лавлагаа, мэдээллийг цахимаар авах бололцоог бүрдүүлсэн.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүн таслах ажлын дүн мэдээг хагас, бүтэн жилээр жилд 2 удаа олон нийтэд мэдээлж, [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn) цахим хаягаас дээрх мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.1-3. Төрийн байгууллагуудын цахим засгийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагаар хангах бүтцийг бий болгох /ЗГХЭГ, ХХМТГ, 2020 он/

Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 73 дугаар тогтоолоор “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төрийн үйл ажиллагаан дахь мэдээллийн технологийн дэвшлийн хэрэглээ нэмэгдэж, байгууллага хооронд мэдээлэл солилцох дэд бүтэц сайжирч, цахим хэлбэрт шилжих төрийн үйлчилгээний төрөл, тоо өсч, хүнд суртал, авлига, хээл хахууль буурах, төсвийн болон иргэдийн зардал хэмнэх, төрийн үйлчилгээг хурдан шуурхай, цаг алдалгүй, орон зайнаас үл хамааран хүртэх давуу талууд бий болох юм.

Олон улсын сайн туршлагыг судалж хурдан нэвтрүүлэх, олон улсын жишигт нийцсэн, иргэн, хуулийн этгээдэд, хялбар, хүртээмжтэй, аюулгүй төрийн цахим үйлчилгээг бий болгож, нэг цонхонд төвлөрүүлэх, энэ салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 458 дугаар тогтоолоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан Цахим хөгжлийн үндэсний хороог байгуулж, дүрмийг батлан, үйл ажиллагаа явуулж байна. Цахим засаглалын хөгжлийг бүх салбарт ижил тэгш хөгжүүлэх, салбаруудад тулгамдсан асуудлуудад чиглэл, зөвлөмж өгөх зорилгоор УИХ-ын Цахим хөгжлийн үндэсний хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт Цахим хөгжлийн газрыг тус тус байгуулан ажиллуулж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.2-1. Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах /ЗГХЭГ, 2017-2018/

УИХ-аас 2001 онд баталсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд салбарын яамдаас олгох 18 чиглэлийн 103 ерөнхий төрөл, түүнд хамаарах 210 гаруй дэд төрлийн үйл ажиллагаа болон аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргаас олгох 7 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр заасан боловч бодит байдалд 54 байгууллага, 914 төрлийн зөвшөөрөл олгож ирсэн. Хууль хоорондын зөрчил, хийдлээс болж иргэдийн аж ахуй эрхлэх эрх зөрчигдөж, улмаар эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа дээрх зөрчилтэй нөхцөл байдлыг арилгах, мөн зөвшөөрөл, лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат,

дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг шинэчлэх, сайжруулах зорилгоор Засгийн газраас Зөвшөөрлийн тухай, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хуралд 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн барьсан бөгөөд төслийг холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлсэн. Энэхүү өргөн барьсан төслөөр зөвшөөрөл, түүний ангилал, бүртгэл, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох үндэслэл, журмыг тогтоосон бөгөөд Улсын Их Хурлаас уг хуулийг баталсны дараа Засгийн газраас холбогдох журам, зохицуулалтыг авч хэрэгжүүлэх арга хэмжээ авна. (Биелэлт 100 хувь)

**4.1.2.2-2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх /ЗГХЭГ, 2018-2022/**

Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаас хэлэлцэн баталсны дараа зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад олгох зохицуулалтыг авч хэрэгжүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны 10 сард Засгийн газрын шийдвэрээр төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, явцын мэдээллийг нэгтгэн үнэлгээ хийсэн. Уг судалгаанаас харахад 2020 оны байдлаар Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авалгүйгээр төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг 10 байгууллага байгаль орчин, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажил, үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр байгууллагыг дурдвал, Хустайн цогцолбор газар, Монголын барилгын үндэсний ассоциаци, Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага, Монголын ахмадын холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн зэрэг болно. Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар

гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийн төслийг шинэчлэн боловсруулах ажил хийж байна. Тухайлбал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/25 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам” баталсан. Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд: Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах, эрүүл зан зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа; эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагаанд оролцох, эмийг бүртгэх, баталгаажуулах, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд оролцож, санал өгөх, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, иргэний гомдол, саналын мөрөөр хяналт тавих, үнэлэх зэрэг үйл ажиллагаанд оролцож санал өгөхөөр тусгасан. Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шийдвэр гарган 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Барилгын салбарт өнөөдрийн байдлаар 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байгаа бөгөөд эдгээрт барилга байгууламжийн ажил гүйцэтгэх, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл багтаж байна. Барилга, байгуулалтын яамнаас “Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-д барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудлыг гэрээгээр гүйцэтгүүлэх эрхийг олгосон бол үлдэж буй гурван төрлийн тусгай зөвшөөрлийг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ тэргүүтэй найман байгууллагын түншлэлд олгосон байна. Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбарын хэмжээнд Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр-ийн хүрээнд хийгдэх ачаа, зорчигч тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг солилцох, тээвэрчдэд олгох, тооцоо хийх, хяналт тавих, Автотээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгох ажлыг “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж



байна. Тээврийн хэрэгслийг гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлэх таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (CPD карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт уг дэвтэрт тэмдэглэсэн асуудалтай холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг Монголын автомашин, мотоциклийн спортын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Мөн “Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2, 2.4, 2.6 болон 2.7 дахь заалтуудад заасан аж ахуйн нэгж, байгууллагуудаас тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авах авах, хүсэлтийг ажлын хэсгээр хэлэлцүүлж дүгнэлт гаргах зэрэг эрх үүргийг “Монголын авто замчдын холбоо ТББ”-д шилжүүлсэн бөгөөд тус ТББ-аас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийг олгож байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.2-3. Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; /ЗГХЭГ, ТББ, 2020-2021/

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх төрийн үйлчилгээний төрөл, хүрээ тодорхойгүйгээс төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байна. 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хууль нь энэ төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулаагүй тул Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны судалгаа тус тус хийгдсэн бөгөөд үүний дүнд Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж 2019 оны 12 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн боловч шинээр бүрэлдсэн Улсын Их Хурал төслийг хууль санаачлагчид буцаасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яам холбогдох төслийг шинэчлэн боловсруулаад байна.

Авлигатай тэмцэх газраас энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлыг гүйцэтгүүлэн

үнэлгээний тайланг төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. “Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөө” сэдэвт хэлэлцүүлэгт нийт 15 төрийн бус байгууллагын 42 төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлэгт оролцогчдоос 5 чиглэлээр гаргасан санал, дүгнэлтэд тулгуурлан Зөвлөмж боловсруулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний хүртээмж, түүнд тавих хяналтыг сайжруулах, цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, төрийн захиргааны байгууллагуудад чиглэл болгохоор ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.2.3-1. Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох /СХЗГ, 2018-2020/

Олон улсын стандарт хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /2018 оны 07-р сарын 01-нээс дагаж мөрдсөн/-ийн 14.2, 14.7 дахь заалтуудаар Олон улс бүс нутгийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэг баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй байхаар хуульчилсан хуулийн зохицуулалт бий болсон.

УИХ-аар 2019 онд баталсан Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалтын хүрээнд Хууль эрхийн хэмжил зүйн Олон улсын байгууллага /OIML/, зохих гэрээ хэлэлцээр байгуулсан гадаад орны хэмжил зүйн төв байгууллагаас загварыг баталж, гэрчилгээ олгосон тохиолдолд хэмжих хэрэгслийн загварын туршилтыг давтан хийхгүйгээр хүлээн зөвшөөрөх хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөж байна. Хэмжил зүйн Олон улсын байгууллага /OIML/-с загварыг баталсан хэмжих хэрэгсэлд давтан загварын туршилт хийлгүйгээр хүлээн зөвшөөрч зохих сертификат авсан хэмжих хэрэгслийн загварын тоо 2020 онд 4, 2021 эхний улирлын байдлаар 3 байх бөгөөд 2020 онд үйлдвэрлэгчийн анхдагч баталгааг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгжийг баталгаажуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.2.3-2. Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох; СХЗГ, ХЗДХЯ 2018-2020/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.1, 5.1, 5.2-д Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ гэсэн заалтыг шинээр оруулснаар хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөж бусад стандартыг сонгон хэрэглэх зохицуулалтыг тусгасан байна. Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох зорилтын хүрээнд 2020 онд 96 стандартыг хүчингүй болгож, 10 стандартад нэмэлт өөрчлөлт оруулан, 81 стандартыг шинэчлэн, нийт 261 стандартыг шинээр баталсан байна. Ингэснээр стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох зорилтын хүрээнд 2018-2020 онуудад нийт 137 стандартыг хүчингүй болгож, 97 стандартыг дахин хянаж шинэчлэн сайжруулав.(Биелэлт 100 хувь)

4.1.2.4-1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ЗГХЭГ, МХЕГ, ТЕГ 2018-2019/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүнзгийрүүлэн төлөвшүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийг сайжруулах зорилтын хүрээнд “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хяналтын хэлбэрүүдийг нарийвчлан тогтоож, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг шалгалттай хослуулан хэрэгжүүлэх замаар аюул, эрсдэлийг удирдах хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн шинэчлэн боловсруулж МХЕГ-ын даргын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг орчныг боловсронгуй болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч байна. Тухайлбал, “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хяналтын хэлбэрүүдийг нарийвчлан тогтоож, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн

туслах үйлчилгээг шалгалттай хослуулан хэрэгжүүлэх замаар аюул, эрсдэлийг удирдах хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн шинэчлэн баталж, 2021 оны хяналт шалгалтын төлөвлөлтийг хийж олон нийтэд зарласан. 2020 оны ээлжит эрсдэлийн үнэлгээг 79076 аж ахуйн нэгж, байгууллагын хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 137171 объектод 31 нэгжийн 1560 улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд бүртгэлээ. Эрсдэл ихтэй гэж үнэлэгдсэн объектын тоог 2019 оныхтой харьцуулж үзэхэд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл их үнэлэгдсэн объектын тоо 1469-өөр өсч, эрсдэл үүсэх магадлал багатай объектын тоо 3630-аар буураад байна. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлийн төлөв байдлын дүн шинжилгээ хийж аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан болон олон нийтэд хүргэсэн. Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 147 дугаар тушаалаар хяналт шалгалтын эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг баталж, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулсан. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг олон нийтэд 12 дугаар сарын 1-ний өдөр хуулийн хугацаанд [khyanalt.gov.mn](http://khyanalt.gov.mn), [shienkhyanalt.gov.mn](http://shienkhyanalt.gov.mn) цахим системээр, [inspection.gov.mn](http://inspection.gov.mn) цахим хуудсаар зарласан байна.

2020 онд хяналт шалгалтад ашиглах 12 хяналтын хуудас шинээр, 93 хяналтын хуудас шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, тус газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/32 тоот тушаалаар баталж, олон нийтэд <http://inspection.gov.mn/> цахим хуудсаар дамжуулан хүргэв. “Бизнес эрхлэгчдэд лабораторийн шинжилгээтэй холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох” тандалт судалгааг МХЕГ-ын даргын баталсан удирдамжаар Дундговь, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, ХАБҮЛЛ, НМХГ-ын НТЛ-ийн 202 бизнес эрхлэгч, лабораторийн ажилтныг хамруулан судалгааны мэдээллийг 2 жил цуглуулж, мэдээллийг SPSS программаар боловсруулан, эрсдэлийн дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулан, үр дүнг 21 аймаг, нийслэл, ХАБҮЛЛ-ийн лабораторийн эрхлэгч, шинжээч болон дээж авдаг улсын байцаагч нийт 230 ажилтанд онлайн сургалт зохион байгуулав. ХАБҮЛЛ-ийн Эрсдэлийн үнэлгээний төвтэй хамтран лабораторийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэл, эрсдэлийг тодорхойлох хяналтын хуудсыг боловсруулж үнэлгээ хийсэн бөгөөд цаашид аймаг, нийслэлийн

МХГ-ийн лабораториудыг олон улсын түвшинд хүргэх, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний бүтэц, найрлагыг нарийвчлан тогтоох, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, судалгаа шинжилгээ хийх чиглэлээр чадавхжуулах, олон улсад ашиглагдаж буй стандартуудтай жишсэн үндэсний шинжилгээний арга, аргачлалын стандартыг шинэчлэн боловсруулж, лабораторийн чадавх, чадамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. Түүнчлэн төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн найруулж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагуудыг судлан үзэж, энэ талаарх танилцуулгыг эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.

Татвар төлөгчийн эрсдэлийг тооцох, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд УИХ-аас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлд “Татварын албаны эрсдэлийн удирдлага”, 41-45 дугаар зүйлд татварын хяналт шалгалтын талаар зохицуулалт хийгдсэний дагуу холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн баталсан. Үүнд: Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 305 тоот тушаалаар “Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны ажиллах журам”, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/264 тоот тушаалаар “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”-ыг тус тус шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна. “Татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулах, санг бүрдүүлэх, ашиглах, сангийн нууцыг хамгаалах журам”-ын төслийг ОУВС-ын зөвлөмж болон Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “ТЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр»-тэй уялдуулан боловсруулж, ТЕГ-ын даргын А/113 дугаар тушаалаар батлуулсан. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасан мэдээлэл харилцан солилцох үүрэг бүхий байгууллагуудтай гэрээг байгуулах зорилгоор төслийг боловсруулж хүргүүлэн 2020 онд 16 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулаад байна. “Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-г 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр батлуулж, хамтран ажиллаж байна. Эрсдэлд суурилсан татварын

хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах ажлын хүрээнд татвар төлөгчдийн 2020 оны эрсдэлийн үнэлгээг тооцоходоо дараах эх сурвалжуудаас 2016-2019 оны мэдээлэл цуглуулан ажилласан. Үүнд: Татварын удирдлагын нэгдсэн систем /TAIS/, Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /TAXACT/, Цахим тайлангийн систем /ETAX/, Цахим төлбөрийн баримтын систем /E-BARIMT/, Цахим санхүүгийн тайлангийн систем /E-BALANCE/, Хөндлөнгийн мэдээллийн сан /TPI/, Гаалийн импорт, экспортын мэдээлэл, Нийгмийн даатгалын тайлангийн мэдээлэл, Төрийн сангийн зарлагын гүйлгээний мэдээлэл, Арилжааны банкны холбогдох мэдээлэл, Тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Хөрөнгийн мэдээлэл, Хяналт шалгалтын явцад байцаагчийн цуглуулсан мэдээлэл, Байнгын ашиглалтад оруулсан барилгын мэдээлэл, Газрын бүртгэлийн мэдээлэл, Татварын хяналт шалгалтын систем /FISHER/, Маргаан таслах зөвлөлийн мэдээлэл, Монгол Улсын далд эдийн засгийн судалгаа /Салбарын ангиллаар/, Эдийн засгийн салбарын ангиллын дундаж ашгийн судалгаа, Санхүү болон татварын хуурамч баримт бичиг бүрдүүлсэн татвар төлөгчдийн судалгаа, Татвар төлөгчийн бүртгэлийн харилцан хамаарлын судалгаа, Эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөөнд татвар төлөгчдийн сонголтыг дээрх мэдээлэлд хуурамч санхүүгийн тайлан илрүүлэх “FRAUD” загвар, Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дундаж үзүүлэлтээс хазайх стандарт хазайлтын түвшин, Логистик регресс буюу Шугаман бус магадлалын загвар, Корреляцын буюу хамаарлын шинжилгээ, VAR /Value at Risk/ буюу хамгийн их эрсдэлийн арга, Зөрүүгийн шинжилгээний арга ашиглан шинжилгээ хийж, сонгосон байна. Эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын тухайн оны төлөвлөгөөг боловсруулж, Татварын ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжүүлж хэвшсэн. 2020 онд Эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын үр дүнг үндэслэн ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газарт эрсдэлийн үнэлгээ тооцоход цаашид анхаарах асуудлуудын талаар холбогдох саналыг боловсруулан хүргүүлээ. Татвар төлөгчдийг Эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор, хяналт шалгалтын үр дүнд суурилсан, хяналт шалгалтаар нийтлэг гардаг зөрчлийг дахин гаргахгүй байх зорилгоор 2018-2019 оны зөрчлийн сангийн судалгаан дээр үндэслэн татвар төлөгчдөд зөвлөмж болгов. Татварын байцаагчдад зориулсан Барилга угсралтын үйл ажиллагаа, Уул уурхай хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа, Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын үйл

ажиллагаа, Бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээ, баар зоогийн газрын үйл ажиллагаа, Цахим худалдааны үйл ажиллагаа, Худалдаа, үйлчилгээний салбарын авто машин импортлогч, Авто тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчдөд татварын хяналт шалгалт хийх зэрэг 7 зөвлөмж гаргаж, Татварын удирдлагын нэгдсэн системийн хяналт шалгалтын модулийн тогтмол мэдээллийн санд байршуулж хэвшсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хуулийн зохицуулалтыг тодорхой

болгох чиглэлээр ажиллаж байна. 2020 онд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 15 этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийсэн бөгөөд 2019 онд хэрэгжүүлсэн 4 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайланг оролцуулан нийт 19 шалгалтын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн илэрсэн зөрчил, дутагдлын дүнг баталгаажуулсан байна. 2020 оны жилийн эцсийн дүнгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 19 хуулийн этгээдэд хийсэн баримтын шалгалтын дүнгээр нийт 21.29 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн байна /Хавсралт дахь 1 дүгээр хүснэгтээр харуулав/.

1 дүгээр хүснэгт


Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хийсэн баримтын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн

№	Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн нэр	Тогтоолын		Илэрсэн зөрчил, дутагдлын дүн /төгрөгөөр/
		огноо	дугаар	
1	“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Засгийн газрын хуралдаан		-
2	“Монголросцветмет” ТӨҮГ	-		
3	“МИАТ” ТӨХК	-		
4	“Монгол-Ус” ТӨҮГ	5/5/2020	238	57,783,276.91
5	“Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ	5/5/2020	239	368,870,000.00
6	“Техник спортын төв” ТӨҮГ	5/5/2020	237	1,283,239,100.00
7	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ	7/6/2020	326	798,200,000.00
8	“Цагаан шонхор” ТӨҮГ	7/6/2020	327	47,508,100.00
9	“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ	7/6/2020	325	417,699,826.00
10	“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК	10/20/2020	500	132,587,500.00
11	“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК	10/20/2020	501	1,923,429,870.00
12	“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ	12/8/2020	601	161,400,000.00
13	“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК	11/3/2020	535	623,939,360.00
14	“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ	11/3/2020	536	293,404,400.00
15	“Геологийн төв лаборатори” ТӨҮГ	Шалгалтын тайлан боловсруулж байгаа.		
16	“Монголын цахилгаан холбоо” ХХК	5/5/2020	235	3,573,800,000.00
17	“Харгуй” ТӨХК	7/6/2020	324	78,100,000.00
18	“Монголын төмөр зам” ТӨХК	5/5/2020	270	11,077,380,000.00
19	“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК	5/5/2020	236	453,410,000.00
Нийт дүн				<b>21,290,751,432.91</b>

2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан 19 хуулийн этгээдэд хийгдсэн төлөвлөгөөт баримтын хяналт шалгалтын дүнгээр 21,290.74 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд нийт зөрчлийн 4,804.64 сая төгрөг буюу 22.57 хувийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 10,464.75 сая төгрөг буюу 49.15 хувийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 4,093.01 сая төгрөг буюу 19.22 хувийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 1,928.34 сая төгрөг буюу 9.06 хувийг Засгийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийг зөрчсөн зөрчил, дутагдал тус тус эзэлж байна /Мэдээллийг хавсралт дахь 1 болон 2 дугаар зургаар харуулав/.


1 дүгээр зураг

Баримтын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил /сая.төгрөг/



2 дугаар зураг

Баримтын хяналт шалгалтаар илэрсэн хууль тогтоомжийн зөрчлийн дүн /сая.төгрөг/



Төлөвлөгөөт бус баримтын шалгалтыг төрийн өмчит 7 хуулийн этгээдэд хийж, тайлан, дүгнэлтийг тухайн ажлын хэсгийн нарийн бичигт нэгтгүүлэх, газрын удирдлагын бүрэлдэхүүн, холбогдох байгууллагад танилцуулах арга хэмжээ авч ажиллав /Төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг хавсралт дахь 2 дугаар хүснэгтээр харуулав/.

2 дугаар хүснэгт

Төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт


№	Хуулийн этгээдийн нэр	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх болсон тушаал шийдвэр
1	"Геологийн төв лаборатори" ТӨҮГ	ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/3522 албан бичиг, ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/01 дүгээр тушаал
2	"Төрийн орон сууцны корпорац" ТӨХК	ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/23 дугаар тушаал
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/24 дүгээр тушаал
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	ТӨБЗГ-ын даргын 2020 оны өдрийн А/30 дугаар тушаал
5	"Эрдэнэс Таван Толгой" ХК	Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн удирдамж
6	"Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨҮГ	ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/60 дугаар тушаал
7	"Төрийн орон сууцны корпорац" ТӨХК	ЗГХЭГ-ын даргын 2020 оны 63 дугаар тушаал

Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2020 онд төсөвт 7 байгууллагын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд системийн хяналт шалгалт хийснээс 6 нь төрийн өмчийн эмнэлэг, 1 их сургууль байна. Эдгээр 7 байгууллагад нийт дүнгээр 370.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн дүнтэй байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дийлэнхийг төсвийн хөрөнгөөр бий болж байгаа эд хөрөнгөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авдаггүй, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажилладаггүй зэрэг нөхцөл байдал тогтоогдсон /Хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчийн эмнэлэг, сургуулийн жагсаалтыг 3 дугаар хүснэгтээр, зөрчлийн мэдээллийг 3 дугаар зургаар харуулав/.

3 дугаар зураг

Төсөвт байгууллагад хийсэн системийн шалгалтаар илэрсэн зөрчил

Системийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил /сая.төгрөг/



#### 4.1.2.4-2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ 2018-2020/

Стандарт, хэмжил зүйн газраас Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх (2018-2020) ажлын хүрээнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 8.1.3-т стандартчиллын баримт бичигт “олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, түүнд нийцүүлэн гаргасан гадаад улсын стандарт” хамаарахаар, 12.1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ” гэсний дагуу Менежментийн стандартчиллын Техникийн Хорооны ажлын төлөвлөгөөний хүрээнд ISO 9001:2015 олон улсын стандартыг орчуулан үндэсний стандартаар батлан мөрдүүлж байна. Мөн гадаад улс орнуудын ижил төстэй стандарт, техникийн баримт бичгийг судлан, шүүлт хийж ISO/PAS 45005:2021 Covid-19 “Цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа” стандартыг үндэсний стандартаар батлав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Хөтөлбөрийн энэхүү заалтын хэрэгжилтийг хангуулах үүднээс байгууллага дундын ажлын хэсгийг томилж, хэрэгжилтийг хэрхэн хангуулах чиглэлээр нэгдсэн шийдэлд хүрэх саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, хувийг Стандарт, хэмжил зүйн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлээд байна. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг төлөвшүүлэх чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг батлан мөрдөж байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 23 хуульд “дотоод хяналт”-ыг хэрэгжүүлэх талаар туссан боловч хууль бүрт өөр өөр байдлаар хуульчилсан байна. Тухайлбал, “дотоод хяналтын журам, хөтөлбөр”-тэй байхаар 9 заалт, “дотоод хяналт хариуцсан нэгж, алба, ажилтан”-тай байхаар 6 заалт, “дотоод хяналтын тайлантай, түүнийгээ тайлагнадаг” байхаар 4 заалт, “дотоод хяналтыг хэрэгжүүлнэ”, “дотоод хяналтыг зохион байгуулна” гэсэн 8 заалт, “дотоод хяналтын тогтолцоотой байх” талаар 2 заалтад

тусгагдсан. Тухайлбал, “Дотоод хяналт”-ыг Дотоод хяналт, шалгалт, дотоод аудит, ISO, НАССР, зохистой дадал нэвтрүүлж дотоод хяналт тавих гэх мэт арга хэлбэрээр хэрэгжүүлэхээр томъёолсон. Салбарын холбогдох хууль, дүрэм, журамд “Дотоод хяналтын алба, Хөдөлмөрийн аюулгүй байдлын алба, Эрүүл ахуй халдвар хамгааллын алба, Чанарын алба” гэх мэтээр бүтцийг олон янз байхаар тусгасан байна. Хэдийгээр хууль, дүрэм, журамд “дотоод хяналт”-ын талаар заалтууд туссан байгаа ч хуульд янз бүрээр томъёологдсон, хэрхэн хэрэгжүүлэх, эрх үүрэг нь тодорхой бус байгаагаас бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байна. Тус байгууллагын 2019 онд хяналт шалгалтад хамрагдсан 11888 ААНБ-д “дотоод хяналт шалгалтын журам боловсруулж мөрддөг байх” заалтын хэрэгжилт 4081 объект 35%, дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх заалтын хэрэгжилт 3420 объект 50%-тай байгаа нь хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Иймд “дотоод хяналт”-ын нэгж/ажилтантай байх, түүний хэрэгжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхой болгон Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэгдсэн байдлаар томъёолж тусгуулах, мөн тус хуулийн заалттай уялдуулж “Зөрчлийн тухай” хуульд байгаа заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, дотоод хяналтын үйл ажиллагааг стандартчилах бодит шаардлагатай гэж үзжээ. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг төлөвшүүлэх чиглэлээр төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах талаарх энэхүү санал, судалгааны дүнг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Ажлын хэсэгт хүлээлгэн өгөөд байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар олгосон чиг үүргийн дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү эдийн засгийн үйл ажиллагаа, төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт, эзэмшил, ашиглалтын байдалд хийсэн хяналт шалгалт, түүний мөрөөр авах арга хэмжээний хүрээнд гаргасан тогтоол, зөвлөмж, чиглэлд тухайн байгууллагад дотоод хяналтыг сайжруулах асуудлыг тусган төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хүргүүлээд байна. Энэ хүрээнд 2020 онд хяналт шалгалтад хамрагдсан төрийн өмчит 43 (2019 онд хийсэн шалгалтад хамрагдсан 4 байгууллага орсон) хуулийн этгээдэд нийт дүнгээр 117 арга хэмжээг хяналт шалгалтын

тайланд тусган, 140 арга хэмжээ байна. Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын биелэлт, шалгалтын тайлангаар өгсөн үүрэг даалгавар, цаашид авах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2020 онд төрийн өмчит 10 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, хяналт тавьж байна. Шалгалтын үр дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч байгаа байдал, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн ногдол ашиг болон түрээсийн орлогыг төвлөрүүлсэн зэрэг эерэг үр дүн гарсан. (Биелэлт 70 хувь)

4.1.2.4-3.Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ 2018-2022/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны А/95 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын төлөвлөлт, тайлагналт, үнэлгээг боловсронгуй болгох санал боловсруулах” дэд ажлын хэсэг байгуулж, 2020 оны төлөвлөгөө, тайлан, үнэлгээнд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулаад байна. Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийг үндэслэн Улсын байцаагчийн хөдөлмөрийн жишиг норм нормативт урьдчилан сэргийлэх зорилгоор хийх хяналтын хувийг нэмэгдүүлэн, нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж, тус Газрын даргын 2020 оны А/121 дүгээр тушаалаар батлуулав. Энэхүү тушаалаар нэг хяналтын чиглэлийн улсын байцаагчийн жилийн ажлын жишиг нормативыг тогтоож, улсын байцаагч шалгалтыг жилийн ажлын хүн өдрийн 30%, бусад хүн/өдрүүдэд эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, сургалтууд зохион байгуулах болон бодлого боловсруулах ажил үйлчилгээнд зарцуулахаар тогтоосон. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2021 онд төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөлт хийх аргачлалыг мөн А/125 дугаар тушаалаар баталж, төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагуудад хүргүүлэн, төлөвлөлт хийх чиглэл өгөөд байна. Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны хяналт шалгалтын төлөвлөлтийг хяналтын чиглэл бүрээр нэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх

зорилт дэвшүүлэн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх 25 зорилтын хүрээнд 185 арга хэмжээг хяналтын 7 хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөн МХЕГ-ын даргын 2020 оны А/131 тоот тушаалаар батлуулж, байгууллагын цахим хуудаст олон нийтэд нээлттэй байршуулж, мэдээлсэн. Мөн Урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн хяналт шалгалтаас гадна аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналт, хамтын хяналтын хэлбэрийг нэвтрүүлж эхэлсэн. Мэргэжлийн хяналтын байгууллага эрсдэлийн удирдлагын стратегитай болсноор зөвхөн улсын байцаагч бизнес эрхлэгч дээр очиж эрсдэл, аюулыг бууруулах биш аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгосон. Хэрэглэгч, үйлчлүүлэгч өдөр тутам бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа байнгын хяналт тавьж, шаардлага хангасан эсэхийг хянах хэрэглэгчийн хяналтын хуудсыг шинэчлэн МХЕГ-ын даргын 2020 оны А/143 дугаар тушаалаар баталлаа. Ингэснээр хэрэглэгч бараа, бүтээгдэхүүн аюулгүй бөгөөд чанартай эсэхийг хянах мэдлэг, чадвартай болж байна. Хяналтын 12 чиглэлээр хяналт шалгалтын үр дүнг тооцох аргачлал боловсруулж нэгжүүдэд танилцуулга гаргахад зөвлөмж өгсөн. 2021 оны хяналт шалгалтын төлөвлөлтийн арга хэмжээ бүрийн гүйцэтгэл, үр дүнг тооцохдоо эрсдэлийн түвшинг шалгалт, ЗТҮ үзүүлсэн объект бүрд бууруулсан байх, илэрсэн зөрчлийг 100% арилгуулсан байх, торгууль, нөхөн төлбөрийг 100% барагдуулсан байхаар хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтийг боловсруулж МХЕГ-ын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан.

Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/142 дугаар тушаалаар баталсан эрсдэлд суурилсан төлөвлөгөөт хяналт шалгалтад 1351, татвар төлөгчийг хамруулахаас Covid-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор татвар төлөгчид хөл хорионд орсоны улмаас хяналт шалгалтад хамрагдах боломжгүй нөхцөл байдал үүссэнийг харгалзан эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөнд ТЕГ-ын даргын 2020 оны А/203 тушаалаар дахин тодотгол хийж 1278 татвар төлөгчийг шалгахад төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан байна. Үүнээс 1098 татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулсан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 85,9 хувьтай байна. 2020 онд хяналт шалгалтад хамруулах татвар төлөгчийн тоог өмнөх оноос 1420 татвар төлөгчөөр буюу 47.3 хувиар бууруулжээ. (Биелэлт 70 хувь)



4.1.2.5-1. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь “Шударга байдлын үнэлгээ” судалгаа юм. Төрийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ” судалгааг 2016, 2018, 2019 онд зохион байгуулсан бөгөөд үр дүнг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

Шударга байдлын үнэлгээгээр төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулдаг бөгөөд шударга байдлын үнэлгээний дэд үзүүлэлт болох ил тод, хариуцлагатай байдлын индексийн оноо 2016 онд 57.5, 2018 онд 56.5, 2019 онд 61.6, 2020 онд 74.1 гарсан нь 2018 оныхоос 5.4 пунктээр нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.

Шударга байдлын үнэлгээний үр дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.7-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.” гэж заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах шалгуур үзүүлэлт болгон ашиглаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөлөл”-ийг тодруулах судалгааг зохион байгуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн судалгааны үр дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлснээр судалгааны үр дүнг үндэслэн

уулзалт зохион байгуулсан.

“Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээ” хийх ажлыг Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрыг хамруулан зохион байгуулж, үнэлгээний үр дүнг тухайн байгууллагуудад танилцуулав. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сангийн авлигын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэв.

“Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа” болон “Хүүхдийн шударга байдал-2020” оны судалгаа (5469 сурагч, 601 эцэг, эхийг хамруулан)-зохион байгуулж байна. Бангладеш Улсын эцэг эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12 дугаар сургуулийн сурагчид, эцэг, эхчүүдийн шударга байдлыг үнэлэх судалгаа хийж байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг 4800 нийтийн албан тушаалтнаас хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн үйл ажиллагаа, мэдүүлгийн маягт, авлигыг мэдээлэх асуудал, эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаа, гомдол мэдээлэл хүлээн авах, шалгахад мэдээлэгчийн нууцлалыг хангах зэрэг асуудлаар судалгаа авч, тайланг боловсруулав. Мөн 2018, 2019 онд авлигын эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн 39 байгууллагатай холбогдуулан иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэлд, улс орнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн судалгаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэгжлэг хийх талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар тус тус судалгааг хийсэн ба хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох, Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаанд судалгаа хийхээр бэлтгэж байна.


Нийгмийн сүлжээ ашиглан олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлж байгаа байдал, авлигатай тэмцэх газрын нөхцөл байдалд, Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт авлигатай тэмцэх чиглэлээр тусгагдсан зорилтуудад дүн шинжилгээ хийв.

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын ил тод байдлын үнэлгээг 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар гүйцэтгэв. Үнэлгээг Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад үндэслэн боловсруулан 13 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд судалгаа хийсэн.


Хуулиар хүлээсэн үүрэг буюу мэдээлэл зохих мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэхийг үнэлэхдээ тухайн байгууллагын онцлог,

чиг үүргээс хамаарч яамдад 41, аймагт 38 шалгуур үзүүлэлт боловсруулан хэрхэн хангасан эсэхийг хянан шинжлэв. Шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулсан эсэхийг харгалзан 0-3 оноо, нийт 0-100 оноо өгөх замаар үнэлгээ хийв. Үнэлгээнд хамрагдсан 34 байгууллагын 21 нь буюу 61,7 хувь нь 60-аас доош оноотой үнэлэгдсэн нь Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Яамдын цахим хуудсанд дахь мэдээлэлтэй танилцахад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, хүний нөөцийн сул орон тооны зар, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгааныг байршуулаагүй байв.

### Яамдын цахим хуудасны үнэлгээ



### Аймгийн цахим хуудасны үнэлгээ



Аймгуудын цахим хуудсан дахь мэдээлэлтэй танилцахад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, хүсэлтийг хүлээн авах болон иргэд аж ахуйн нэгжээс өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, эрх бүхий байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалт, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл, журмын хамт байршуулаагүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлээгүй зэрэг зөрчил, дутагдал түгээмэл байна. Цаашид Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол үнэлж, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлнэ. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.2.6-1. Монгол Улсын иргэн бүрт цахим гарын үсэг олгох /ХХМТГ, 2017-2022/

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журмуудад заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох хувийн түлхүүрийг олгосон.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/36 дугаар тушаалаар байгуулсан “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах бодлогын чиглэл, холбогдох журмын хэрэгжилтэд санал, дүгнэлт гаргах” ажлын хэсгээс төрийн байгууллагуудад тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэхээр дүгнэлт гаргасны дагуу төрийн байгууллагуудад Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагатай бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг ашиглахтай холбогдуулан тоон гарын үсгийн тэмдэглэгээний хэлбэржилтийг боловсруулж, Нийслэлийн мэдээллийн технологийн газар, “Монпасс СА” ХХК, Нийслэлийн архивын газарт тус тус хүргүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв. Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоол, Төрөөс баримтлах бодлогын чиглэлийн дагуу “Үндэсний

дата төв” ҮТҮГ-ийг төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллагаар ажиллуулж, 2018 онд төрийн 765 албан хаагчдад тоон гарын үсэг олгож, нийслэлийн хэмжээнд 545 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж, 2019 онд төрийн 43 байгууллагын 940 ажилтанд тоон гарын үсэг олгож, нийслэлийн 8 байгууллагын 85 ажилтанд тоон гарын үсэг олгосон байна. Тухайлбал: Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Хот Төлөвлөлт хөгжлийн газар, Нийслэлийн Татварын Газар, Нийслэлийн Газрын Алба, Нийслэлийн Нийгмийн Халамжийн Газар, Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн Газар, Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар, Нийслэлийн Орон Сууцны Корпораци ХК зэрэгт олгосон.

Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн байгууллага бүр дээр тоон гарын үсгийн талаар ойлголт өгөх, хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр танилцуулга сургалтыг тогтмол явуулж байна. Тоон гарын үсэг ашигладаг төрийн захиргааны албан хаагчдын тоо 60 хувиар өссөн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 40 удирдах ажилтанд тоон гарын үсгийн төхөөрөмж авч, удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулах, тайлангийн модулийг сайжруулах ажлыг хийж байна. 2018 оны 3 дугаар сард Мэргэжлийн хяналтын системийн нийт ажилтнуудад Интерактив ХХК-тай хамтран онлайн сургалтыг зохион байгуулж, цахим системийн хяналт шалгалтын сайжруулсан модулийг ашиглалтад оруулснаас гадна шалгалтын удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг болсон.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэний үнэмлэхэд тоон гарын үсгийг бичих ажлын хүрээнд Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт иргэний цахим үнэмлэхэд 2048 битийн тоон гарын үсгийн гэрчилгээ суулгах туршилтын ажлыг зохион байгуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон “Үндэсний дата төв” ҮТҮГ-тай хамтран тоон гарын үсгийн гэрчилгээний дундын санг бий болгосон ба гэрчилгээ олгогч байгууллагууд гэрчилгээний мэдээллээ тухай бүр оруулсны дүнд 2019 оны байдлаар тус санд 18596 ширхэг тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээлэл байна.

Тоон гарын үсэг ашиглах нэгдсэн хэрэглэгчийн програм хангамж /Esign client/-ийг хөгжүүлж, гэрчилгээ олгогч байгууллагуудын ашиглаж байгаа e-Токен төхөөрөмжүүдийн драйверуудыг нэгтгэж,

ашиглаж эхлээд байгаа бөгөөд төхөөрөмжийн үнэ 30-50 хувиар буураад байна.

Төрийн албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа ба одоогийн байдлаар 1960 албан хаагч тоон гарын үсэг ашиглаж байгааг ирэх онд 3300 болгох зорилтой ажиллаж байна. Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч тусгай зөвшөөрөл эзэмшигч “МонПасс Са” ХХК, “Нью компас” ХХК, “Тридум э-Секьюрити” ХХК, “Ви Эс Эм” ХХК-ууд ажиллаж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон “Үндэсний дата төв” ҮТҮГ-тай хамтран тоон гарын үсгийн гэрчилгээний дундын санг бий болгосон ба гэрчилгээ олгогч байгууллагууд гэрчилгээний мэдээллээ тухай бүр оруулсны дүнд 2020 оны байдлаар тус санд 34317 тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээлэл байна. “Мобиком Корпораци” ХХК нь “Тридум э-Секьюрити” ХХК-тай хамтран Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дэмжлэгтэйгээр сим картанд суурилсан “Тоон гарын үсэг” үйлчилгээг нэвтрүүлсэн. Тоон гарын үсэг ашиглах нэгдсэн хэрэглэгчийн програм хангамж /Esign client/-ийг хөгжүүлж, гэрчилгээ олгогч байгууллагуудын ашиглаж байгаа “е-Токен” төхөөрөмжүүдийн драйверуудыг нэгтгэн, ашиглаж эхлээд байгаа бөгөөд төхөөрөмжийн үнэ 30-50 хувиар буураад байна. Төрийн албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажилласан ба 2019 онд 1960 албан хаагч тоон гарын үсэг ашиглаж байсан бол 2020 онд 6621 болж өссөн. (Биелэлт 70 хувь)

4.1.2.6-2. Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг боловсруулж мөрдүүлэх /ХХМТГ, ЗГХЭГ, ХЗДХЯ, 2018 он/

Дэлхийн банкныхонгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр Иргэд олон нийттэй харилцах төвийн санал хүсэлтийг хүлээн авах төвийн системийг шинээр хөгжүүлэн, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж 2020 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан ба тус систем дээр ажиллах Бизнес аналитикийн “Tableau” системийг ашиглахаар лицензийг худалдан авсан бөгөөд ашиглах албан хаагчдад сургалтын үр дүнг харгалзан төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмын төслийг боловсруулж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.6-3. Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааг шинэ хэлбэрт шилжүүлэх /АТГ, ЗГХЭГ 2018 он/

АТГ-аас өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас факс, www.iaac.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, 18001969 тусгай дугаарын утсаар болон байгууллагын байранд биеэр ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд биечлэн өгөх хэлбэрээр хүлээн авч байсан.

Авлигын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай 110 дугаарын утсыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. Энэ дугаар нь ярианы төлбөр үнэ төлбөргүй, иргэд тус 3 оронтой дугаарыг цээжлэхэд амар хялбар гэдгээрээ онцлог юм. 110 дугаарын утсыг хэвлэл мэдээлийн хэрэгслээр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Дүнжингарав” дахь салбар болон “Бөмбөгөр” худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэдэд сурталчлан, үүрэн телефоны операториудын харилцагч нарт мессеж хэлбэрээр хүргэх, Улаанбаатар хотын 6 дүүргийн 40 байршилд байрлах самбаруудад 110 дугаарын утасны сурталчилгааг үнэ төлбөргүй байршуулж ажиллав. Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарын утсыг цахим орчинд сурталчлах, мөн тус газраас зохион байгуулж буй аян, арга хэмжээг сошиал медиа сувгаар түгээх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулав.

2020 оны байдлаар 110 тусгай дугаарын утсанд нийт 17851 дуудлага ирсэн байна. Нийт дуудлагын 47.5 хувь нь зөвлөгөө авах, гомдол мэдээлэл өгөх, дуудлага андуурах, утсаар тоглох зэргээр холбогдож ярьсан бол 52.5 хувь нь дуудлага тасарсан, дуудлага холбогдсон ч яриагүй тасарсан байна.

110 тусгай дугаарын утсанд хандан өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж байгаа иргэдийн 145 буюу 45.7 хувь нь нэрээ нууцлан гомдол гаргахыг хүссэн бол 172 буюу 54.3 хувь нь нэр, хаягаа ил тодоор гомдол гаргасан байна. 110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 56.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 32.5 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 4.1 хувь нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны чиглэлээр нь харвал төсвийн хөрөнгийн зарцуулалттай

холбоотой асуудлаар 64, хүний нөөцийн томилгоотой холбоотой 60, захиргааны шийдвэр гаргалттай холбоотой 29, тусгай зөвшөөрөлтэй холбоотой 28, тендер худалдан авах ажиллагаатай холбоотой 27, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалттай холбоотой 27 гомдол, мэдээлэл ирүүлсэн бол хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 салбар нь нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах 64, бага, дунд боловсролын салбар 26, эрүүл мэндийн салбар 25, зам тээвэр, төмөр замын салбар 17, цагдаагийн албан хаагчидтай холбоотой 17 ӨГМ-ийг хүлээн авсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.7-1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх ./ЗГХЭГ, 2017-2022/

Төрийн албаны тухай хуульд Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ. Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батлахаар тусгасан болно.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 9.6-д “Захиргааны байгууллага нь хэрэглэгчийн үнэлгээг Хэрэг эрхлэх газрын баталсан ерөнхий удирдамжийн дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ” гэж заасны дагуу Хэрэг эрхлэх газрын 2017 оны 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг баталж, салбар чиг үүргийн үнэлгээний 63 үзүүлэлт, үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээний 19 үзүүлэлт, 16 асуудлаас бүрдсэн санал асуулгын хуудсаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Нийт 265 сум, дүүргийг төлөөлүүлэн 30068 насанд хүрсэн иргэнээс судалгаа авах ажлыг төрийн захиргааны холбогдох байгууллагууд хийсэн. Судалгааны дүнгээр ерөнхий сэтгэл ханамж 58.7 хувьтай, салбарын дундаж үнэлгээ 55.3 хувьтай, чанар хүртээмжийн дундаж үнэлгээ 67.8 хувьтай гарсан байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх чиглэлээр Батлан хамгаалах яам нь 2018 онд “Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг

бэхжүүлэх удирдлага, зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээ авна” гэсэн зорилгыг дэвшүүлэн 6 зорилтын хүрээнд 199 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах дүрмийн зорилт бүхий төрийн бус байгууллагуудаас сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийх, сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчдоод эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх, сонгуулийн хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий “Төрийн бус байгууллагаас сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах тухай журам”-ыг тус Хорооны 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү журамд заасны дагуу сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, мониторинг хийхээр “Нээлттэй нийгэм форум”, “Глоб интернэйшнл төв”, “Филантропи хөгжлийн төлөө төв”, “Мидас”, “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд”, Бодлогод залуусын хяналт” зэрэг 6 ТББ нэгдсэн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-нд тус Хорооны 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 53 дугаар тогтоолоор сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх зөвшөөрөл олгож, хамтран ажиллав. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв”, “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний төв” ТББ-ын Ус аймаг дахь салбар сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, мониторинг хийх, сонгогчдоод аргачилсан туслалцаа үзүүлэхээр зөвшөөрөл олгосон байна.

Сонгуулийн тухай хуулийн 5.5-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, ажиглалт хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх,

сургалт зохион байгуулах эрхтэй.” гэж зааснаар Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагын мэргэжлийн төлөөлөл шууд оролцож хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Иргэдийн сэтгэл ханамжийг тандан судалж, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг төрийн үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, түргэн шуурхай байгаа эсэх талаар иргэдийн санаа бодлыг тандан судалж судалгааны дүгнэлт, зөвлөмжийг төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бодлого шийдвэрийг боловсруулах, үнэлэх явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар үнэлэх юм. Засгийн газраас 2019 оны 12 дугаар сард «Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа»-г улс орон даяар зохион байгуулав. Судалгаанд Улаанбаатар хотоос гадна 21 аймгийн 291 сум, 545 багийг хамруулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын гуравны нэг хувийг хөдөө, орон нутгийн багт амьдардаг иргэд эзэлж байна. Төрийн үйлчилгээний салбар, чиг үүргийг нийт 13 салбарт хуваан иргэдээр үнэлүүлсэн. Салбарууд дунджаар 3.1 гэсэн үнэлгээтэй байгаа бол 7 салбар дунджаас дээгүүр үнэлэгдэж бусад нь дунджаас доогуур үр дүнг харуулж байна. Төрийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой бүлэг асуултаас мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдалтай холбоотой асуултауд илүү өндөр үнэлгээтэй байна. Харин үйлчилгээний ачааллын хэвийн байдлыг хамгийн тааруу үнэлжээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр Иргэд олон нийттэй харилцах төвийн санал хүсэлтийг хүлээн авах төвийн системийг шинээр хөгжүүлэн, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж 2020 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр илэрхийлэх боломжтой цахим үйлчилгээний нэгдсэн [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn) систем болон 11-11.mn системийг харилцан мэдээлэл солилцох боломжтой байдлаар холбосон. (Биелэлт 70 хувь)

4.1.2.7-2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018-2019 он/

Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам”-ыг баталсан. Уг журам нь төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө (цаашид “төлөвлөгөө” гэх) боловсруулах, баталгаажуулах, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд төрийн албан хаагчийн зан үйлийн үнэлгээ, ажлын цаг ашиглалтын байдал, албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан идэвх чармайлт, шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг нэгжийн дарга, багаар ажиллах чадвар үйлчилгээ үзүүлэх хандлагыг албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтын онцлогоос хамааруулан тухайн албан хаагчийн харьяалах нэгжийн хамт олон дүгнэхээр зохицуулж өгсөнөөрөө ач холбогдолтой юм. Албан хаагчийн үйлчилгээ үзүүлэх хандлагыг үйлчлүүлэгчээр үнэлүүлж, албан хаагчийн хандлага, зан үйлийг нэгжийн хамт олноор үнэлүүлэх ажлыг байгууллагын үнэлгээний баг зохион байгуулах бөгөөд үнэлгээг албан хаагчдаас нууцаар авч, санал тоолох ажиллагааг илээр явуулахаар тусган хэрэгжүүлсэн.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар “Ухаалаг засаг” төслийн санхүүжилтээр иргэдэд үйлчлэх лавлах төвийн үйл ажиллагааг дэмжих техникийн зөвлөх үйлчилгээ төсөл болон иргэдийн санал хүсэлт хүлээн авах лавлах төвийн системийг шинэчлэн хөгжүүлэх, нэвтрүүлэх төсөл, мөн иргэдийн санал хүсэлтийн мэдээлэлд бизнес анализ хийх дотоодын зөвлөх болон бизнес аналитикийн систем нэвтрүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, холбогдох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай загвар, аргачлалыг баталсан бөгөөд нэгжийн дарга албан хаагчийг хагас бүтэн жилээр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхээр зохицуулсан. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулж цаг тухайд нь үнэлснээр үнэлгээ илүү бодитой, албан хаагчдыг цаг тухайд нь урамшуулах, хариуцлага тооцох боломжтой эрх зүйн орчин бүрдэж байна. Төрийн жинхэнэ

албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгжийн даргаас гадна байгууллага бүрт үнэлгээний баг албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг байгууллагын бүхий л түвшинд жигд, бодитой, шударга хийгдэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ажилтнуудын үнэлгээг давхар хянаж эцсийн үнэлгээ өгөх зохицуулалтыг тусгасан. (Биелэлт 30 хувь)

4.1.2.7-3. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор төрийн байгууллага бүрт ажил дүгнэх үзүүлэлт бий болгож мөрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018 он/

ЗГХЭГ болон Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин /31 үзүүлэлтээр/ болон төрийн байгууллагын ажлыг үнэлэх /70 үзүүлэлтээр/ ажлыг улсын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн хооронд явуулсан. Энэ үнэлгээний хүрээнд төрийн албан хаагчийн сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдалтай газар дээр танилцаж, албан хаагчдаас ярилцлага авах ажлыг зохион байгуулсан.

“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай загвар, аргачлалыг баталсан бөгөөд нэгжийн дарга албан хаагчийг улирал тутам, нэгжийн даргыг төсвийн шууд захирагч хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхээр зохицуулсан. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулж цаг тухайд нь үнэлснээр үнэлгээ илүү бодитой, албан хаагчдыг цаг тухайд нь урамшуулах, хариуцлага тооцох боломжтой эрх зүйн орчин бүрдэв. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгжийн даргаас гадна байгууллага бүрт үнэлгээний баг албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг байгууллагын бүхий л түвшинд жигд, бодитой, шударга хийгдэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ажилтнуудын үнэлгээг давхар хянаж эцсийн үнэлгээ өгөх зохицуулалтыг хийсэн болно.

Сангийн яам Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор яамны цахим хяналт-шинжилгээ үнэлгээний “Лидер мониторинг” (LM) програмыг ашиглалтад оруулсан. Цахим хяналт-

шинжилгээ, үнэлгээний “Лидер мониторинг” програм нь

- Бодлогын баримт бичгүүдэд туссан Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ;
- Дээд байгууллагын тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгавар;
- Үндэсний аудитын газар, ТАЗ болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж;
- Сангийн яамны дотоод аудитын хорооноос өгсөн зөвлөмж гэх мэт байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнах шаардлагатай баримт бичиг, заавар, зөвлөмжийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэснээр ажилтнууд холбогдох мэдээллийг цаг алдалгүй тайлагнах, нэг ажлыг олон дахин тайлагнаж тэр бүрт газар хэлтсүүд хоорондоо бичиг бичих зэрэг ажлын давхардлыг арилган үйл ажиллагааг хөнгөвчилж байна. Сангийн яамны дотоод бүтцийн нэгжүүдийн долоо хоног, сар, жилийн төлөвлөгөө, тайланг тус програмаар нэгтгэн, ажилтан нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг оруулж өгснөөр “Үр дүнгийн гэрээ”-г програмыг ашиглан боловсруулж, дүгнүүлдэг болсноор илүү шударга, үнэн зөв дүгнэгдэх, нөгөө талаас гэрээ байгуулах, дүгнэх ажлыг хөнгөвчлөн цаг хугацаа хэмнэсэн, ажлын давхардал зохих хэмжээнд арилсан байна.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-д төрийн үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн нэг үзүүлэлт болох үйлчилгээ үзүүлэх хандлагыг хэрэглэгч буюу үйлчлүүлэгчээр үнэлүүлэхээр тусгасны дагуу иргэд төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх эрх зүйн орчин бүрдсэн. (Биелэлт 100 хувь)

**Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дахь зорилтын хүрээнд нийт 10 үйл ажиллагаа, 35 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.3.1-1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгох /СЯ, 2017-2022/

Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын нөхцөлд тухай бүр дүгнэлт хийж, үүнд тулгуурлан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/210, 2020 оны А/37 тоот тушаалаар тус тус байгуулан ажиллуулсан. Уг ажлын хэсэг шилэн дансны нэгдсэн системийн мэдээлэл оруулах хэрэглэгчийн ажлыг хөнгөвчлөх, мөн үнэн зөв ойлгомжтой мэдээллийг олон нийтэд хүргэхээр систем хоорондын мэдээлэл дамжуулах хэсгийг ажиллуулахаар судалгаа хийж, эхний ээлжид Е-Хуулга системээс дараах мэдээллүүдийг шууд татан шилэн дансны системд оруулах боломжийг бүрдүүлээд байна. Үүнд:

- Орлого, Зарлагын мөнгөн гүйлгээний мэдээлэл
- Дансны хуулганы мэдээлэл
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл
- Төрийн сангийн дансны жагсаалт зэрэг багтана.

Шилэн дансны системд оруулж буй мэдээлэлд олон нийт хяналт тавих боломжоор хангах зорилгоор [Shilendans.gov.mn/reportorgs](http://Shilendans.gov.mn/reportorgs) тайлан авах хэсгийг ажиллагаанд орууллаа. Мөн шилэн дансны нэгдсэн системд бүртгүүлэх үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэхээр судалгаа хийж байгаа бөгөөд үйл явцыг цахим болгосноор албан байгууллагууд заавал албан бичгээр хандах, биечлэн очих, хүлээлт үүсэх, байгууллагын мэдээлэл буруу ташаа орох зэрэг асуудлыг нэг мөр шийдвэрлэхээс гадна цаг хугацаа хэмнэх давуу талыг бий болгох юм.

2. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд иргэд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас өвчин, эмгэгийн төрлөөс үл хамааран шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, шуурхай авдаг болох зорилгоор эрүүл мэндийн салбарт хуваарилах санхүүжилтийг нэг худалдан авагчийн зарчмаар буюу эрүүл мэндийн даатгалын байгууллага улсын төсвөөс олгож байгаа санхүүжилтийг хуваарилдаг байхаар тооцож Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хууль

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулав. Улсын төсвийн одоогийн санхүүжилтийг өвчин, эмгэгийн нэр төрөл, тусламж, үйлчилгээний өртөг, тоо хэмжээнд үндэслэн тооцож эрүүл мэндийн даатгалын санд жил бүр шилжүүлснээр иргэн эрүүл мэндийн даатгалаараа эмнэлгийн бүх төрлийн тусламж, үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй авах, бүх шатлалын эмнэлгийн эмчийн бичсэн жороор эмийн үнийн хөнгөлөлт авах боломж бүрдсэн болно.

3. Төрийн байгууллагын хурал, семинар, сургалтыг цаашид цахимаар явуулж холбогдох зардлыг бууруулав. Төрийн байгууллагад иргэдээс тавьсан өргөдөл, гомдол шийдвэрлэх процессыг цахимжуулахаар ажиллаж байна.

4. Төсвийн байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг хэмнэх чиглэлээр төсвийн зардлын 2020 оны үлдэх хугацааны санхүүжилтийг ач холбогдлоор нь эрэмбэлж олгосон. Түүнчлэн төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсөвт байгууллагын тэвчиж болох зардлыг хэмнэв.

5. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ /ЖГҮ/-г 2020 оны 8 дугаар сард хийсэн ба үнэлгээний үр дүнг 21 аймаг дахь төслийн орон нутгийн ажилтнууд, 124 сумын хариуцсан ажилтан, албан хаагчдад үнэлгээний үзүүлэлт тус бүрээр танилцуулж, бага үнэлэгдсэн шалтгаан, алдаа, сургамжийн талаар харилцан зөвлөлдөв. 2020 оны үнэлгээгээр нийт сумдын дундаж 60.13% болсон нь төслийн зорилтот түвшин болох 60 хувьд хүрсэн бөгөөд 2019 оныхоос 1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний эхний үр дүн 2016 онд улсын хэмжээнд дунджаар 31.7 хувь байсан бол 2017 онд улсын дундаж үзүүлэлт 37.2 хувь, 2018 онд 50.3 хувь болж, 2019 онд 59.5 хувь болж, 2020 онд 60.1 хувьд хүрч өссөн. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд 2019 онд 222 сум буюу нийт сумдын 67 хувь урамшуулал авч байсан бол 2020 онд 248 сум буюу нийт сумдын 75 хувь нь урамшуулал авсан байна.

2020 онд нийт 330 суманд “ерөнхий дэмжлэг” 3.5 тэрбум төгрөг, болзол хангасан 248 сумдад “урамшуулал” 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд 2021 онд 330 суманд 2.5



тэрбум төгрөгийн “ерөнхий дэмжлэг”, 2020 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авах үнэлгээний болзол хангасан 225 сумдад 6.5 тэрбум төгрөгийн “урамшуулал” олгох саналыг 2021 оны Улсын төсөвт оруулан батлуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх /ТӨБЗГ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад төрийн хяналт шалгалт хийж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байна.

2020 онд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээдэд хяналт шалгалтын ажлыг хийсэн ба баримтын шалгалтад 15, системийн шалгалтад 7, гүйцэтгэлийн шалгалтад 10 хуулийн этгээд тус тус хамрагдсан болно. Баримтын шалгалтаар 21.2 тэрбум, системийн шалгалтаар 370,4 сая төгрөгийн зөрчил тус тус илрүүлжээ. Түүнчлэн, төлөвлөгөөт бус баримтын шалгалтыг төрийн өмчит 7 хуулийн этгээдэд гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дахин гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авахын зэрэгцээ хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэл болон зардлыг бууруулах талаар дүгнэлт гарган, шалгалтын тайланд тусгаж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоол, шийдвэрт тусган цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагад үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажиллав. Үүнд:

1. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь хот, орон нутаг хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний орлогоос 8 хувийг авч байна. Дээрх ажил үйлчилгээг гүйцэтгэхэд үйлдвэрийн газраас гарч байгаа зардал нь орлогоос давж байгаа тул автобус тээврийн компаниудтай байгуулсан гэрээг судлан үзэж дээрх үйлчилгээнээс авч байгаа орлогыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч эргэн танилцуулах;
2. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ-ын борлуулалт, үйлчилгээний орлого,

зарлагын байдалд дүн шинжилгээ хийж, орлогод тулгуурлан зардлыг төлөвлөх, үйл ажиллагааны чиглэлийг нэмэгдүүлэх талаар бодлогын яамтай хамтарч санал дүгнэлт боловсруулан танилцуулах;

3. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааг өргөтгөх, орлого үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг чиг үүрэгтэй нь уялдуулан судалж, дүн шинжилгээ хийж, үр дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг үүрэг, чиглэл болгосон;
4. “Монгол-Ус” ТӨҮГ-ын хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт орж, цаашид байгууллагын үр ашигт нөлөөлөх эрсдэл үүссэнтэй холбогдуулан чиг үүргийн шинжилгээ хийж, санал зөвлөмж өгч гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлэв.

Төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих, эзэмшилт, ашиглалтыг сайжруулах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны биелэлтийг цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан цахим хэлбэрээр дүгнэв. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнэхдээ холбогдох журмын дагуу 5 үндсэн үзүүлэлтээр байгууллага тус бүрийг дүгнэсэн бөгөөд улсын дундаж үнэлгээ “хангалттай” буюу 94.1 хувьтай, өнгөрсөн оны дүнгээс 2.1 хувиар өссөн дүнтэй байв. 2020 онд төрийн өмчит 961 хуулийн этгээд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүгнүүлснээс 182 хуулийн этгээд “сайн”, 779 хуулийн этгээд “хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2019 оны хэрэгжилтийг дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 597 дугаар тогтоол гаргасан бөгөөд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авах талаар зөвлөмж боловсруулан төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэв. Түүнчлэн төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, эзэмших, ашиглах газрыг баталгаажуулах, үнэлэх ажлыг бүрэн хийж дуусгах, тэг үлдэгдэлтэй буюу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнэлгээ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох зэрэг ажлын хэрэгжилт

хангалтгүй байгаа зөрчил, дутагдал гарч байгааг 2021 онд зохион байгуулагдах төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын бэлтгэл хангах ажлын хүрээнд шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, улмаар Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол гарч, уг тогтоолын хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан удирдамжийн дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-уудын 2019 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, шалгалтын дүнг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулав.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу “МИАТ” ТӨХК-ын 2017, 2018, 2019 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн 40.4 тэрбум төгрөгийн төлбөр, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 63, 65 дугаар тушаалын дагуу “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК, “Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨХХК-ийн үүсгэн байгуулагдсанаас хойшхи санхүүгийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалтыг хийж, урьдчилсан дүнг гаргаад байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 43 дугаар захирамжаар «Төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, эрх зүйн байдал, зааг ялгаа, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд цогц байдлаар дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах» ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.1-3. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх /СЯ, ХХМТГ, 2017-2020/

Төрийн аудитын байгууллагаас 2015-2020 оны хугацаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийт 8 удаа нийцлийн аудит хийж, нэгдсэн тайланг Улсын Их Хурал болон холбогдох байгууллагуудад хүргүүлж, цахим хуудсанд ил тод байршуулж ажилласан.

2020 онд гүйцэтгэсэн аудитаар улсын төсвийн 32 төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрт хамаарах 266 байгууллага, аймаг нийслэлийн 22 төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрт хамаарах 4087 байгууллага буюу нийт 4352 байгууллагыг түүвэрлэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг төсөв, санхүүгийн холбогдох баримт, нотлох зүйлстэй тулган шалгах горимыг хэрэгжүүлж, бусад 1458 байгууллага болон хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагын хувьд төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн дотоод хяналтын дүн мэдээ болон шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл зэрэгт үндэслэн уг хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлээ.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг уялдуулан, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсөв зарцуулах, шийдвэр үйл ажиллагааны ил тод байдлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох агуулга бүхий зөвлөмж/11/-ийг Засгийн газарт, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хөгжүүлэлтийг сайжруулах чиглэлээрх зөвлөмж/5/-ийг Сангийн яаманд өгсөн байна.

Зөрчлийн нөхцөл байдлаас шалтгаалан залруулах боломжтой зөрчлийг тухай бүр арилгуулж ажилласнаас гадна нийт 458 байгууллага, 332 албан тушаалтанд холбогдох зөвлөмж өгч, 131 байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан.

Сангийн яамнаас “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий “Дэд ажлын хэсэг” томилон ажиллуулж, хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг гүйцэтгэж байна. 2020 төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн талаарх мэдээллийг сар болгон төсвийн ерөнхийлөн захирагчаар гаргаж яамны [www.il.tod.mn](http://www.il.tod.mn) болон <https://>

[publicinvestment.gov.mn/](http://publicinvestment.gov.mn/) сайтад байршуулж олон нийтэд тухай бүр мэдээлж ажилласан. 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах, олон нийтэд нээлттэй ил тод болгох чиглэлээр томоохон шинэчлэлийн ажлуудыг хэрэгжүүлснээр Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа олон улсын түвшинд үнэлэгдэж, хөгжиж буй орнуудаас нэг алхам урагшилсан. Тухайлбал, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн болгож, <https://publicinvestment.gov.mn/> веб хуудас болон гар утасны “төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшныг ашиглалтад оруулсан.

2020 онд цахим хуудас болон гар утасны “төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшны хөгжүүлэлтийг үргэлжлүүлэн хийсэн. Уг системийг нэвтрүүлснээр санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн байдлаар түргэн шуурхай бэлтгэх, төсөл бүрээр нарийн мэдээлэл авах, орон нутаг болон салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээтэй танилцах, хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүй, тоон мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг авах боломж бүрдсэн. Ийнхүү санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлсэн нь төрийн үйлчилгээг түргэн шуурхай хэрэгжүүлэх, ил тод олон нийтийн оролцоог хангах зэргээр санхүүжилтийн үйл ажиллагааг илүү хариуцлагатай болгох том алхам хийгдэж төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах нөхцөл бий болсон.

Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг анх удаа тусгайлсан аргачлалын дагуу цахим системээр 2774 төсөл хүлээн авч, төслүүдэд үнэлгээ өгч, холбогдох материал тус бүрийг цахим системд оруулж төсвийн төслийг боловсруулсан.

Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг батлуулсан. Уг журмын дагуу төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтыг <https://publicinvestment.gov.mn/> веб хуудас болон гар утасны “төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшныг ашиглан гүйцэтгэж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн Зээлийн хэлэлцээр байгуулсан. Төслийн хүрээнд хөрөнгө оруулалтын <https://publicinvestment.gov.mn/> систем дээр үндэслэн худалдан авах ажиллагаа, гадаадын зээл тусламж, төрийн өмчийн бүртгэл зэрэг

системүүдийг нэгтгэн нэгдмэл дата программ хангамж, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох юм. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-4. Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах /СЯ, 2017-2022/

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг хяналт-шалгалт, үнэлгээний цахим систем /[odamis.mof.gov.mn/](http://odamis.mof.gov.mn/)-д тухай бүр байршуулж, үйл ажиллагааны явц, санхүүжилтийг олон нийтэд нээлттэй мэдээлж байна. Тус системийн хэрэглээ, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, өгөгдлийн төрлийг нэмэгдүүлж, өргөтгөн сайжруулах зорилгоор 2019 онд Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд үндсэн модулиудыг нэмэгдүүлэх, санхүүжилтийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрийн явцыг харуулах, гааль, нэмүү өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бүртгэх, инфографик, тайланг олон нийтэд шууд харуулах боломжит хэлбэрээр хөгжүүлж байна. Системд санхүүжилтийн цахим үйлчилгээг оруулснаар үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах, төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, олон нийт хяналт тавих, гүйцэтгэгч аж ахуйн нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах, иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломж бүрдэж байна.

Монгол Улсын Засгийн газартай байгуулсан гэрээ хэлцлийн хүрээнд олон улсын 2 банк, санхүүгийн байгууллага болон 11 орны гадаадын зээл, тусламжийн 103 төсөл, арга хэмжээг 1,242.3 тэрбум, ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөрийн санхүүжилтээр 3 хөтөлбөрийг 578.5 тэрбум, нийт 1,820.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Үндэсний аудитын газраас нийт 134 /Сангийн ямаар дамжин хэрэгжих 115, ТЕЗ-д хамаарах 19/ төсөл хөтөлбөрөөс Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” А/60 дугаар тушаалын дагуу нийт 67 төсөл, хөтөлбөрийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэж дүгнэлт гаргасан /“Зөрчилгүй” 59, “Хязгаарлалттай” 8/, түүвэрт 61,

ашиглалт гараагүй 4, хэрэгжиж дууссан 2 төсөлд аудит хийгээгүй байна.

Аудитаар нийт 227.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 132.5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.01 тэрбум төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 0.2 тэрбум төгрөгийн 10 албан шаардлага, 94.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 63 зөвлөмж хүргүүлээ.

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 134 төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайланг хамруулахаар төлөвлөж “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалын дагуу нийт 67 төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдүүд гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн ба аудитын тайланг [audit.mn](http://audit.mn) цахим сайтад байршуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт аймаг, сум бүрд хүрч, бүтээн байгуулалт хийгдэн ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Үүнтэй зэрэгцэн тус сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг бий болгох зорилгоор Сангийн яам орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлага мэдээллийн систем 2020 оны 12 дугаар сард бүх модулийн хөгжүүлэлтийг дуусган ашиглалтад оруулсан. Тус системд хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлан, хяналт, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, санал хүсэлт, гомдол, олон нийт хандах сайт болон веб гарын авлага гэсэн цэсүүдийг багтаасан. Удирдлага мэдээллийн системийг ашиглалтад оруулснаар иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө, тайлан зэрэг мэдээллийг бүрэн авах боломж бүрдэж байна.

Мөн 21 аймгийн Тогтвортой амьжиргаа – 3 / ТА-3/ төслийн ажилтнуудад онлайн системийн сургалтыг зааж, анхан шатны онлайн болон цаасан гарын авлагуудаар хангасан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн мэргэжилтнүүдтэй хамтран системд 2018-2020 оны мэдээллийг нөхөж оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Удирдлага мэдээллийн системд <http://onhs.mof.gov.mn/> вэбсайт болон <http://tusuv-oronnutag.mof.gov.mn/> вэбсайтын үндсэн цэс дунд байрлах «МЭДЭЭЛЛИЙН САН» гэсэн холбоосоор дамжин хандах боломжтой боллоо.

Төрийн аудитын байгууллагын батлагдсан төлөвлөгөөний дагуу орон нутгийн хөгжлийн

сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлд нийцлийн аудит хийж, Сангийн яамны /[mof.gov.mn](http://mof.gov.mn)/ цахим хуудсанд байршуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн сангаас хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын талаарх албан ёсны эх сурвалжид үндэслэн хяналтыг хэрэгжүүлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийн талаар аудит хийж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, хөтөлбөрийг бодитой төлөвлөх, сум, аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулах талаар зөвлөмж өгөхөөр ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.1-5. Олон улсын төсвийн түншлэлээс хийгддэг “Нээлттэй төсвийн индекс”-ийн үнэлгээг ахиулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх /СЯ, УАГ, 2018-2022/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг ил тод нээлттэй болгоход чухал хувь нэмэр оруулсан. Дэлхийн банкнаас төсвийн хөрөнгө оруулалтыг ил тод болгох ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд тус яам нь тодорхой хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглэсэн. Open budget partnership олон улсын байгууллагын 2019 оны судалгааны дүнгээр Монгол Улсын төсвийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ<sup>4</sup> 2017 оноос 10 оноогоор сайжирч, 56 оноотой болж 2017 онтой харьцуулбал 15 орноор урагшилж 41-р байранд орсон. Хоёр жил тутам хийгддэг энэхүү үнэлгээгээр 2015 онд 51 оноо авч байсан болно.

Сангийн яамнаас боловсруулан гаргадаг төсвийн талаарх баримт бичгийн агуулга, бүрдлийг өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал, иргэдийг санхүү төсвийн мэдээллээр хангах зорилгоор 2018, 2019, 2020, 2021 оны Иргэдийн төсөв эмхэтгэл, товхимол, 2021 оны төсвийн номыг хэвлүүлж, иргэдэд тараах, Сангийн яамны цахим хуудасны Иргэдийн төсөв цэсэнд байршуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна. Мөн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн улирлын эмхэтгэл, 2021 оны төсвийн төслийн эмхэтгэлийг цахим хэлбэрээр бэлтгэн Сангийн яамны цахим хуудасны Иргэдийн төсөв цэсэд байршуулав. Мөн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг сайжруулах, иргэдийг бодлого төлөвлөлтөд илүү идэвхтэй оролцоо боломжоор хангах зорилгоор [www.iltod.mn](http://www.iltod.mn)

<sup>4</sup> Уг индексийг хоёр жил тутамд гардаг ба улс орнуудын төв засгийн газрын төсвийн хариуцлагын түвшинг Ил тод байдал, Төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, Төсвийн хяналт гэсэн үндсэн 3 үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлдэг байна.

gov.mn цахим хуудсыг шинэчлэн:

- Нэгдсэн төсвийн мэдээллийг иргэдэд энгийн ойлгомжтой инфографик хэлбэрээр;
- Дэлхийн банкны BOOST санаачилгын хүрээнд 2013-2019 оны төсвийн түүхэн мэдээллийн санг боловсруулж, уг мэдээллийг ашиглан дэлгэрэнгүй хайлт хийх боломжтой нээлттэй төсвийн мэдээлэл хэлбэрээр түгээж байна:

Түүнчлэн төсвийн байгууллагуудад бараа, ажил, үйлчилгээ үзүүлж буй Бэлтгэн нийлүүлэгчдийн мэдээллийг үйлчилгээ хүлээн авсан Төсвийн байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч, Эдийн засгийн ангилал, гүйлгээний утга, мөнгөн дүнгээр хайх боломжтой хайлтын цэсийг хөгжүүлэв. (Биелэлт 30 хувь)

4.1.3.1-6. Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2018-2022/

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн байгууллагууд хандив, тусламжийн санхүүжилтийн зарцуулалтын мэдээллийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад байршуулж ажиллах үүрэгтэй.

Хувь хүн, хуулийн этгээдээс улсын төсөвт 2017 онд 153,0 сая төгрөгийн мөнгөн хандив төрийн сангийн дансанд төвлөрсөн ба 2019 онд зарцуулалт хийгдээгүй тул 2019.12.31-ний байдлаар 153,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. 2020 оны 04 сарын 02-ны өдөр хандив өгсөн 2 иргэн буцааж авах хүсэлтийн дагуу тус тус 10,0 сая төгрөг буцаан олгож, 133,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Ковид-19 цар тахалтай холбоотой хувь хүн, хуулийн этгээдээс Эрүүл мэнд, Онцгой байдлын байгууллагуудад өгсөн мөнгөн болон материал хандив тусламжийн орлого, түүний зарцуулалтын мэдээг сар бүр Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулж байхаар тус цахим хуудаст шинээр цэс үүсгэсэн.

Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахалтай холбоотой авч буй гадаадын зээл, тусламжийн дүн, зарцуулалтын талаар Сангийн сайд 2020 оны 11 дүгээр сард олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн. Олон Улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас төсвийн дэмжлэг, төслийн санхүүжилтэнд нийт 418.9 сая ам.долларын гэрээ хэлцэл байгуулсан. Үүнээс төсвийн дэмжлэг хэлбэрээр 199.5 сая ам.доллар, төслийн санхүүжилт хэлбэрээр 32.8 ам.долларыг тус тус аваад байна. Эдгээр зээл, тусламжийн хөрөнгийг Ковид-19 цар тахалтай тэмцэх эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлын хангах, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр

эрүүл мэндийн байгууллагуудыг хангах, иргэдийн орлогыг хамгаалах, эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Тухайлбал, Эрүүл мэндийн яам 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 106 байгууллага, аж ахуйн нэгжээс 775.061.068 төгрөгийн хандивыг авсан байх бөгөөд эдгээрээс бэлнээр 213.640.270 төгрөгийг, дансаар 561.420,798 төгрөгийг тус тус авсан талаар өөрийн албан ёсны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.2-1. Улсын болон орон нутгийн төсөвт хөндлөнгийн байгууллага, эрдэмтэн, судлаачаар санхүүгийн шинжилгээ хийлгэх боломжийг судлах, холбогдох арга хэмжээг авах /СЯ, 2017-2019/

ОУВС-ийн Төсвийн газраас боловсруулсан концессийн төслүүдийн санхүү, төсвийн эрсдэлийг үнэлэх загвараар 2 хоногийн сургалтыг зохион байгуулсан. Олон улсын Валютын сангийн Төсвийн газраас концессийн интитуцийн болон хууль эрх зүйн орчинд шинжилгээ хийх, концессийн төслүүдийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх, удирдах, тайлагнах, мониторинг хийх чиглэлээр техник туслалцааны ажлын хэсэг 2019 оны 6-7 дугаар сард ажиллаж, Төсвийн хөрөнгө оруулалтын газар болон холбогдох яамдын төлөөлөлтэй уулзаж нөхцөл байдлын шинжилгээ хийсэн. Ажиллах хугацаанд ОУВС-ийн Төсвийн газраас боловсруулсан концессийн төслүүдийн санхүү төсвийн эрсдэлийг үнэлэх загвараар 2 хоногийн сургалтыг яам, газруудын ажилтнуудад зохион байгуулсан. Ажлын хэсгээс тайлан, зөвлөмж боловсруулан тус яаманд ирүүлсэн болно.

Европын Холбооны санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд олон улсын зөвлөх 2019 оны 4 дүгээр ажиллаж, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-д зөвлөгөө өгч, улсын төсвийн хөрөнгө оруулалтын замын зураглал боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.

Сангийн яам “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) системээр дамжуулан 21 аймаг, нийслэл, агентлаг болон яамдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт болон тайлагналт хариуцсан 180 гаруй албан хаагчийг хамруулан 2020 оны 4 дүгээр сарын 8-9-ний өдрүүдэд улсын хэмжээнд цахимаар зохион байгуулж, улсын

төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны хэрэгжилт, үр дүн, 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт болон хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилт болон төлөвлөгөөг цахим системээр хэрхэн хэрэгжүүлж олон нийтэд ил тод, нээлттэй болгох, тулгамдаж байгаа, анхаарах асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв.

Монгол Улсын 2019, 2020 оны нэгдсэн төсвийн төслийг Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэхтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 оны төсвийн төсөлд 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 14 санал, зөвлөмж, 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 13 санал, зөвлөмж, 2020 оны төсвийн тодотголын төсөлд 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр 17 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн. Тус зөвлөлийн санал, зөвлөмжийг 2019, 2020 оны төсвийн тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх үед авч үзсэн болно.

Сангийн яам нь Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөлтэй хамтран орон нутгийн засаг захиргааны түвшинд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хэрхэн хангаж байгаа талаар болон орон нутгийн төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр засаг захиргааны үйл ажиллагаанд үнэлгээ хийх замаар зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. НҮБХХ-өөс 2020 онд Орон нутгийн чиг үүрэг, төсвийн орлого, зарлага, зарцуулалтын талаарх судалгааг бодлогын судлаачдаар гүйцэтгүүлж олон нийтэд танилцуулсан.

Европын Холбооны санхүүжилтийн хүрээнд Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд олон улсын зөвлөх “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-д зөвлөгөө өгч, улсын төсвийн хөрөнгө оруулалтын замын зураглал боловсруулах ажлыг гүйцэтгэсэн. Дээрх ажлыг үргэлжлүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах чиглэлээр гадаад болон дотоодын зөвлөхийг ажиллуулж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.2-2. Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх /СЯ, 2017-2022/

Сангийн яам нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих”, 12.1.16-д “төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын

үйл ажиллагааг хэрэгжүүлэх” чиг үүргийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтад хамрагдсан хугацаа, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн хэмжээ, түүнийг барагдуулах талаар зохиосон ажил зэргийг харгалзан налт шалгалтад хамрагдах байгууллагыг сонгон санхүүгийн хяналт шалгалт хийж байна.

2020 онд төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 11, нийт 16 санхүүгийн үйл ажиллагааны болон сэдэвчилсэн хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын дүнг Сангийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2 удаагийн хурлаар хэлэлцүүлэн нийт 38.2 сая төгрөгийн акт, 536.8 сая төгрөгийн албан шаардлага тогтоосныг баталгаажуулж, шалгалтад хамрагдсан байгууллагуудад 44 зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажилласан. Улсын /ахлах/ байцаагчид хяналт шалгалтаар тайлант онд нийт 575.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 38.2 сая төгрөгийн улсын байцаагчийн акт, 536.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 275.0 сая төгрөгийг барагдуулсан байна.

Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн шалгалтын материалыг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд хүргэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.2-3. Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, давхардлыг арилгах /СЯ, 2017-2019/

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д “Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төсөл”-ийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Энэ дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар хуулийн төслийг боловсруулах болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах, Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, дотоод аудит, хяналт шалгалтын чиг үүргийн давхардлыг арилгах үүднээс яамд, нийслэл, дүүрэг, аймгуудын жилийн төлөвлөгөөг нэгтгэн бодлого, удирдамжаар ханган ажилласан. Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр

сарын 8-ны өдрийн тушаалаар Улсын төсвөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний барилга, байгууламж, захиалагчийн техник, хяналтын байдалд дотоод аудит, хяналт шалгалтыг хийх удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу Барилга хот байгуулалтын яам, Хөвсгөл, Завхан, Төв, Дорноговь, Сүхбаатар аймгуудын дотоод аудитын нэгжтэй хамтран хийж гүйцэтгэсэн.

Улсын салбарын 86 байгууллага, 450 дотоод аудитор, санхүүгийн хяналт, шалгалтын байцаагч нар оролцсон зөвлөгөөнийг 2020 оны 10 сарын 30-ны өдөр танхим болон цахимаар зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх нэгжүүдтэй төлөвлөгөөг уялдуулах, нэг байгууллагад нэг цаг хугацаанд хяналт шалгалт хийж шалгалтад хамрагдаж буй байгууллагад хүндрэл учруулахгүй байх, ажлын уялдаа холбоог хангахыг зөвлөсөн. (Биелэлт 30 хувь)

#### 4.1.3.2-4. Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулан батлуулах / СЯ 2018-2019/

Сангийн яамнаас Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулаагүй байна. (Биелэлт 0 хувь)

#### 4.1.3.2-5. Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох / СЯ, УАГ 2018-2019/

Сангийн яамнаас санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7.3-т “санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан нь нотлогдсон” бол хариуцлага хүлээлгэхээр заасны дагуу санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, Зөрчлийн тухай хуулийн 11.1-д заасан хариуцлага ногдуулах арга хэмжээг авч байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй”, Аудитын тухай хуульд заасан хориглосон заалт болох хуулийн 20.4. “Аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхлэх, бусад аудитын

хуулийн этгээдэд гэрээгээр ажиллахыг хориглоно”, Аудитын тухай хуульд заасан аудитын хуулийн этгээдэд тавигдах шаардлага болох хуулийн 19.4. “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх эрхтэй аудитын хуулийн этгээд нь дөрвөөс доошгүй хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байна.” гэснийг зөрчсөн нэр бүхий нягтлан бодогч, аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 16,4 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн.

Мөн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрх авсан аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн нар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй” гэсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагын ерөнхий нягтлан бодогч нарт хариуцлага тооцож 130,2 сая төгрөгийн шийтгэл оногдуулан орон нутгийн төсөвт тус тус хуримтлуулаад байна.

Сангийн сайдын 2020 оны 93 дугаар тушаалаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх зорилгоор татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл бүхий 21 хуулийн этгээдэд хяналт шалгалтын ажил явуулж, Сангийн сайдын 2020 оны “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 153 дугаар тушаалаар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэн ажиллалаа.

2020 онд төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 11, нийт 16 санхүүгийн үйл ажиллагааны болон сэдэвчилсэн хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын дүнг Сангийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2 удаагийн хурлаар хэлэлцүүлэн нийт 38.2 сая төгрөгийн акт, 536.8 сая төгрөгийн албан шаардлага тогтоосныг баталгаажуулж, шалгалтад хамрагдсан байгууллагуудад 44 зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Улсын /ахлах/ байцаагчид хяналт шалгалтаар тайлант онд нийт 575.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 38.2 сая төгрөгийн улсын байцаагчийн акт, 536.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 275.0 сая төгрөгийг барагдуулсан байна. Мөн урьд онуудад хийгдсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд

тогтоогдсон төлбөрийн үлдэгдлээс нийт 78,915.1 сая төгрөг барагдуулснаас 17.0 сая төгрөг нь улсын байцаагчийн акт, 78,898.1 сая төгрөг нь албан шаардлага байна.

Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн шалгалтын материалыг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд хүргэж байна.

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тус хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, 42.2-т “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэж тус тус зааснаар хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бий болсон.

Төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд аудит хийх үйл ажиллагаа нь хуульд цаасан цагалбарт хугацаанд хийдэг онцлогтой.

Зарим тохиолдолд санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхэд хуульд заасан хугацаатай холбогдуулан боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 42.4-т зааснаар “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасны дагуу тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахад бусад хуульд заасан үндэслэл, журам үйлчлэхгүй.” байх зохицуулалттай болж, хариуцлага гарцаагүй байх зарчмыг баталгаажуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.3.3-1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах /СЯ, 2017-2019/

Засгийн газрын тусгай сан, бусад төсвийн хөрөнгөөр санхүүждэг сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, илтөд байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, хяналт, үр нөлөөг дээшлүүлэх саналыг боловсруулж, улмаар тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолыг баталсан. Тогтоолоор төсвийн хөрөнгөнөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдлийг Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан тогтмол мэдээлэх зэрэг нийт 14 арга хэмжээг авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан.

Тусгай сангуудын үйл ажиллагааг цэгцэлж, оновчтой зохион байгуулан, санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох, олон нийтийн оролцоог хангах замаар тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулсан. Тус хуулийн “Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт” бүлэгт тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж байхаар тусгасан.

Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэр гаргаж, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад байршуулж байгаа тул иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломж бүрдсэн. (Биелэлт 70 хувь)



4.1.3.3-2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх /СЯ, тусгай санг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан, 2017-2020 он/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 24 болон 25 дугаар зүйлд дараах заалтуудыг тусгаснаар тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Үүнд:

- Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.
- усгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19-д заасан тусгай сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.
- Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19, 5.3.20-д заасан тусгай сангаас зээл, буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.

“Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолд сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх чиглэлээр дараах заалтуудыг тусгасан. Тухайлбал, төсвийн хөрөнгөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа

байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдэл, шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулж мэдээлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, төсөл сонгон шалгаруулах, зээл олгох үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх арга хэмжээ авах зэргийг дурдаж болно.

*Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.* 2020 онд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажилд зуучлах үйлчилгээнд 52,160,000 төгрөг төсөвлөгдснөөс 45,673,541 төгрөг зарцуулсан. 2020 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд «Ажлын байрыг дэмжих хөтөлбөр»-ийн Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд нийт 304,097,000 төгрөг төсөвлөснөөс 301,292,607 төгрөг зарцуулсан, Ажил хайгч иргэн, оюутан суралцагчдыг цагийн ажилд зуучлах орлого нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 40,787,720 төгрөг төсөвлөснөөс 31,567,542 төгрөгийг тус тус зарцуулсан ба Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн салбар зөвлөлөөр батлагдсан хуваарийн дагуу зарцуулалт хийгдэж, үр ашигтай, өр, авлагагүй ажиллав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүр, санхүүгийн тайланг гарган [www.shilendans.mn](http://www.shilendans.mn) системд тогтоосон хугацаанд, байгууллагын албан ёсны [www.ubbirj.ub.gov.mn](http://www.ubbirj.ub.gov.mn) сайтын шилэн данс цэсэд тухай бүр оруулж, иргэдэд ил тод мэдээллэн ажиллалаа. Үүнд: 5 саяас дээш төгрөгийн 4 удаагийн гүйлгээгээр 439,000,000 төгрөгийн цалингийн зардлаас бусад санхүүжилтийн орлогын гүйлгээ, 56 удаагийн гүйлгээгээр 359,136,299 төгрөгийн ажил үйлчилгээ, бараа материалын худалдан авалт, ажлын гүйцэтгэлийн төлбөр зэрэгт тус тус зарцуулсныг олон нийтэд хүргэж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллав. 2020 оны газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системд байршуулан, төлөвлөгөөний дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд, ил

тод, хүнд сурталгүй, шуурхай хүргэх зорилгоор байгууллагын мэдээллийн самбарт 5 саяас дээш төгрөгийн цалингийн зардлаас бусад санхүүжилтийн орлого, зарлагын гүйлгээ болон бусад холбогдох мэдээллүүдийг байршуулан ажиллав.

Засгийн газрын нөөц сан, Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан. Сангийн яамнаас эдгээр тусгай сангийн мэдээллийг шилэн дансны системд байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан. Хууль зүй, дотоод хэргийн яам Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох тухай” журамд өөрчлөлт оруулах төсөлд санал авахаар Сангийн яаманд хүргүүлсэн байна.

*Эрүүл мэндийн даатгалын сан.* Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын мэдээг А-ЭМД-1 маягтын дагуу, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн мэдээг А-ЭМД-2 маягтын дагуу, эмийн үнийн хөнгөлөлтийн мэдээг 1 А-ЭМД-3 маягтын дагуу сар бүр гаргаж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн, тус хорооны www.1212.mn цахим хуудсанд тогтмол байршуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн сарын мэдээг Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Монгол банк, Үндэсний статистикийн газарт хуулийн хугацаанд тус тус илгээн ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг Сангийн сайдын 2003 оны 40 дүгээр тоот тушаалаар баталсан маягтын дагуу хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлж байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу хуулийн хугацаанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ цэсэд Эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий байгууллагад шилжүүлсэн орлого, зарлагын гүйлгээг цахим хуудсанд байршуулсан. Шилэн дансны хуудсанд тавигдах мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацааны дагуу байршуулан ажиллаж байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт

• Санхүүгийн тайлан /Хагас, бүтэн жилээр/  
Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан. Гадаад хэргийн яамнаас иргэдэд туслах сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсэнд байнга оруулж, олон нийтэд хүргэж байна. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 08 дугаар сарын 18-ны шийдвэрээр коронавируст цар тахлын улмаас гадаадад гацаж, санхүүгийн хүндрэлд орсон нутаг буцах боломжгүй иргэдэд зориулан УОК-т ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас цугларсан хандивын хөрөнгөөс 300,000,000 төгрөгийг Иргэдэд туслах санд төвлөрүүлсэн. Санд төвлөрүүлсэн нэмэлт 300 сая төгрөгнөөс 161 иргэний тусгаарлах байрны зардал болон бусад дэмжлэг үзүүлэхэд 136, 947, 100 төгрөг зарцуулсан бөгөөд үлдэгдэл 163,052,900 төгрөг байна. Иргэдэд туслах санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгийг дараах байдлаар зарцуулж байна. Үүнд: 2020 оны 10 дугаар сард Франкфурт, Сөүл, Токиод хийсэн тусгай үүргийн нислэгээр дээрх шаардлагыг хангасан 94 иргэний нислэгийн тийзийн төлбөрийг ОУШХБ, тусгаарлах байрны зардал болох 78,500,000 төгрөг, түүнчлэн АНУ-аас ирсэн 1 иргэний тийзийн зардал, Турк, Япон, Их Британи, БНСУ-аас ирсэн 11 иргэний тусгаарлах байрны зардал, ОХУ-д ял эдэлж шоронгоос суллагдсан 1 иргэний тусгаарлах байрны зардал, Туркээс ирсэн 1 иргэний тийзийн зардлын зөрүү, Туркт нас барсан 1 иргэний шарилыг Монголд авч ирэх, Америкийн Чикаго хотод нас барсан 1 иргэнийг чандарлуулах төлбөрт 25,802,500 төгрөг буюу нийт 104,302,500 төгрөгийн зардлыг, 2020 оны 12 дугаар сард Франкфурт, Сөүл, Токиод хийсэн тусгай үүргийн нислэгээр ОУШХБ-ын зардлаар БНСУ, Алжир, Швед, АНУ, Австрали, Япон, Турк, Арабын Нэгдсэн Эмират, Польш, Израил зэрэг улсаас ирсэн 42 иргэний тусгаарлах байрны зардалд 24,160,000 төгрөг, 2020 оны 11 дүгээр сарын тусгай үүргийн нислэгүүд цуцлагдсантай холбогдуулан хатуу нөхцөлөөр захиалсан тийз нь хүчингүй болсон, орон байрнаасаа гарсан, амьжиргааны зардалгүй болсон зэрэг 8 иргэний тусгаарлах байрны зардал, 1 иргэний онгоцны тийзийн зөрүү төлбөрт 6,921,400 төгрөг, ОХУ-д ял шийтгэл эдэлж шоронгоос суллагдсан 3 иргэнд байр хөлслөх, хүнсний зүйлээр дэмжлэг үзүүлэхэд зориулж 1,563,200 төгрөгийг тус тус зарцуулжээ.

Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан технологийн сан. Шилэн дансны тухай хуулийн

хэрэгжилтийг ханган Боловсрол, шинжлэх ухааны яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу [www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) байршуулан ажилласан.

Зэвсэгт хүчний хөгжлийн сан. Батлан хамгаалах яамнаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр мэдээлж байна. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод байдлыг хангах чиглэлээр орлого зарлагын төлөвлөлт батлах тухай Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/405 тушаалаар Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2020 оны орлого, зарлагын төлөвлөлтийг баталж, 2020 оны А/156, А/238 тушаалуудаар зарлагын гүйцэтгэлд өөрчлөлт оруулсныг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.3.3-3. Тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, дүнг олон нийтэд ил тод мэдээлэх /СЯ, 2017-2022/

Сангийн яамнаас 2017 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 2018 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Зарим төрлийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн санд шалгалт хийж Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн дүнг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд мэдээлсэн. Засгийн газрын зарим тусгай санд шалгалтын ажлыг явуулж, шалгалтын дүнг Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

2018, 2019 онд Засгийн газрын нийт 20 тусгай сангуудад санхүүгийн хяналт, шалгалт хийсэн. Үүнээс 3 тусгай санд хийсэн санхүүгийн хяналт, шалгалтын тайланг Засгийн газрын хуралдаанд, 15 тусгай санд хийсэн санхүүгийн хяналт, шалгалтын тайланг Сангийн сайдын дэргэдэх Аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн.

“Засгийн газрын тусгай сан”-д хийсэн хяналт, шалгалтын ажлын үр дүнд төсөв, санхүүгийн үйл ажиллагаа дахь алдаа, зөрчлүүдийг илрүүлж, цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний зөвлөмжийг өгч, акт, албан шаардлагыг хангуулахад анхаарч ажилласан нь төсвийг эрүүлжүүлэх, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Засгийн газрын 29 тусгай сангаас 20 тусгай сан үйл

ажиллагаагаа явуулахаар хуульчлагдсан бөгөөд чиг үүрэг нэгтэй, нэг салбарын 3 санг нэгтгэж, 7 санг татан буулгаж зохион байгуулалт хийн, 3 сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тусгайлсан үүрэг, даалгавар өгсөнд хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын тусгай сангийн хяналт, шалгалтын дүнгээр 2019 онд нийт 397.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 371.1 тэрбум төгрөгийн албан шаардлага, 26.5 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, ажил сайжруулах чиглэлээр 155 зөвлөмж хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Дээрх шалгалтын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж, дэлгэрэнгүй тайланг яамны [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) вэб сайтад <https://mof.gov.mn/article/entry/tailan-delgerengui> холбоосоор байршуулж, нийтэд ил тод мэдээлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.4-1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах /СЯ, 2017-2022/

Сангийн яам Орон нутгийн хөгжлийн сангийн “Удирдлагын мэдээллийн систем болон Олон нийтэд зориулсан портал сайтыг шинэчлэн боловсруулж, 2020 онд ашиглалтад оруулсан. Үүнтэй уялдуулан системийг хэрхэн ашиглах, мэдээллийг оруулах талаар холбогдох мэргэжилтнүүдэд онлайн сургалт зохион байгуулж, аймаг, сумдын ОНХС-ийн 2018-2020 оны шаардлагатай мэдээллийг системд оруулж олон нийтэд нээлттэй болгосон. Орон нутгийн хөгжлийн сангийн “Удирдлагын мэдээллийн систем” нь орон нутгийн хүрээнд санхүүжүүлэх болон цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаар мэдээллийн санг бүрдүүлэх зорилготой. Энэхүү систем ашиглалтад орсноор орон нутгийн засаг захиргааны энэ сангийн үйл ажиллагаатай холбогдох байгууллага, албан тушаалтан болон сангийн хариуцсан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтан хооронд мэдээлэл солилцож, аливаа төсөл хөтөлбөрийн хэрэгжиж буй эсэх асуудалд хяналт тавих боломж бий болж цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийхэд ашиглах юм.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг 2018 онд батлан мөрдүүлж эхэлснээс хойших хугацаанд журмын хэрэгжилтэд тулгарч буй асуудал, сайжруулах арга замын

талаарх хэлэлцүүлэг, санал асуулгын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтэд оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж тэдний санал, зөвлөмжийг сонсож хэлэлцсэн ба нийт 734 орон нутгийн албан хаагчдаас санал, асуулга авсан. Тус сангийн шинэчилсэн Удирдлагын мэдээллийн систем ашиглалтад орсон, Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-нд шинээр батлагдсантай холбоотойгоор олон нийтийн саналыг авч Орон нутгийн хөгжлийн сангийн ийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

ОНХС-ийн үйл ажиллагаа болон төслийн үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд тус сан болон төслийн үйл ажиллагаатай холбоотой нийт 2 шторк, 5 нэвтрүүлгийн зураг авалт, эвлүүлэг, хийц, цацалт, үндэсний болон орон нутгийн түвшинд 21 мэдээ бэлтгэл, цацалт хийж мөн 7 төрлийн мэдээлэл, сурталчилгааны материалыг нийт 233900 / үндэсний хэмжээнд/ ширхгийг хэвлэж, олон нийт болон сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад түгээв.

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1, 67 дугаар зүйлийн 67.3-т төсвийн төслийг боловсруулах явцдаа олон нийтэд танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг тусгана гэж заасан.

Орон нутгийн хөгжлийн сангийн систем (<http://onhs.mof.gov.mn/home/index/2020>)-д байршуулсан мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд 2020 оны төслийн төлөвлөлтөд 174,811 иргэнээс 19,761 санал гаргаснаас иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 3815 ажил хэрэгжиж байна.

Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах арга хэмжээний хүрээнд аймаг, нийслэлээс дараах байдлаар ажилласан байна.

*Нийслэл.* Улаанбаатар хотод Коронавируст (КОВИД-19) халдварт өвчин гарч, хөл хорио тогтоосонтой холбогдуулан Нийслэлийн 2021 оны төсвийн төслийг [ulaanbaatar.mn](http://ulaanbaatar.mn) цахим хуудсаар танилцуулан, 2020 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд цахим санал асуулгыг явуулахад нийслэлийн 9 дүүргийн нийт 157 иргэн хандан, 343 санал өгсөн.

*Архангай аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийгдэх ажлын талаар иргэдээс санал авах ажлыг бүх багуудын иргэдийн дунд хэлэлцүүлэг явуулах, цахим хуудсаар болон цаасаар санал авч, саналыг

үндэслэн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг эрэмбэлэсэн. Мөн орон нутгийн төсвийг хэлэлцэх явцад шууд утас ажиллуулан иргэдийн саналыг авах, төсвийн төлөвлөлтөд тусгах ажлыг зохион байгуулж байна.

*Баян-Өлгий аймаг.* Сумдын Засаг дарын Тамгын газраас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг авах ажлыг зохион байгуулж, хамгийн их санал авсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгтгэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан тусгасан.

*Баянхонгор аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтуудыг тухай бүр нь [tusuv-oron.nutag.mof.gov.mn](http://tusuv-oron.nutag.mof.gov.mn) цахим хуудсанд мэдээлэл оруулдаг. 2020 онд орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөд 9251 иргэнээс 1583 санал гаргаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 315 төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд сумдын хувьд иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авсан.

*Булган аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төслийг боловсруулахдаа аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр, харьяа хэлтэс, алба, агентлагуудаас ирсэн саналыг судлан, ач холбогдлоор нь эрэмбэлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газартай хамтран аймгийн 16 сум, 1 тосгоны иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 14,0 мянга гаруй иргэнээс санал авч, эрэмбэлэн хуулийн хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төслийг боловсруулахдаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын [www.bulgan.khural.mn](http://www.bulgan.khural.mn) цахим хуудас, аймгийн Засаг даргын Тамгын газрын [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) цахим хуудас болон facebook хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.

*Говь-Алтай аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд санал авах, өргөдөл, гомдлыг хүлээн авах үйл явц шийдвэрлэлтийг сайжруулах туршилтыг Шарга суманд зохион байгуулж, сурталчилгааны 2 самбарыг байршуулж, Дэлгэр сумд 323

иргэний гар утсанд мессеж илгээх замаар болон мэдээллийг Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар гэсэн албан ёсны фэйсбүүк хуудсаар постер бэлтгэж, бүүст /boost/ ашиглан 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс 14 хоногийн хугацаатайгаар сурталчилсны үр дүнд фэйсбүүк хуудас дагадаггүй 2000 гаруй иргэн, нийт 10800 иргэнд хүрсэн байна. Мөн тус сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд фэйсбүүк хуудсаар 36 иргэнээс 38 санал тус тус ирсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын санал авах ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 20-ны өдрүүдэд цахимаар болон бичгийн хэлбэрээр зохион байгуулж, нийт 1350 гаруй иргэн оролцсноос бичгээр 889, цахимаар 469 санал ирүүлснийг эрэмбэлэн 2021 оны төсвийн төсөлд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн баталсан.

*Говьсүмбэр аймаг.* Орон нутгийн хөгжлийн сан, Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг сум тус бүрт хуулийн хугацаанд иргэдээр хэлэлцүүлэх, санал авах, эрэмбэлүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд нийт 5330 өрхөөс санал авахаас 3521 өрх буюу 73.8 хувиас санал авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 36.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

*Дархан-Уул аймаг.* Орон нутгийн цахим сайт, телевиз, радиогоор Төрийн зарим чиг үүргийг "Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн оролцоотойгоор 60 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 400,0 сая төгрөг зарцуулсан. Сум, аймгийн ИТХ-ийн төлөөлөгчдөөс санал авах, иргэдээ сонсох 70371212 утас, [smartdarkhan.com](http://smartdarkhan.com) цахим хуудсаар санал авч, Багийн иргэдийн хурлаас гарсан саналыг тусгаж 2020 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төслийг боловсруулсан.

*Дорноговь аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөд 22,301 иргэд санал өгөх боломжтой байгаагаас 5,229 иргэнээс санал гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 691 ажил хийж гүйцэтгүүлэхээр баталснаас 322 ажлыг эрэмбэлж, 136 төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Сумдын хувьд иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авсан байна.

*Дорнод аймаг.* Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний саналыг сум, агентлагаас авч нэгтгэн гаргасан. Нэгтгэсэн жагсаалтыг зураг, төсөвтэй эсэх болон бодлогын баримт бичигтэй уялдуулан урьдчилсан жагсаалтыг нягтлан шалгаж иргэд олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг нээлттэй байдлаар зохион байгуулсан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах албаны албан ёсны цахим хуудсаар болон бусад цахим хаягаар олон нийт, иргэдэд мэдээлэн ажиллаж байна.

*Дундговь аймаг.* Сум, хэлтэс, агентлаг, байгууллагын дарга, эрхлэгч нарт 2020 оны 3 дугаар сарын 10-ны дотор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний санал ирүүлэх албан бичиг хүргүүлэн нийт 54 төсөл, арга хэмжээний санал ирсэн. 2021 оны ОНХС-аар хийгдэх ажлын саналыг 2020 оны 8 дугаар сарын 14-24-ний хооронд иргэдээс цахим хэлбэрээр авахад 819 иргэнээс 99 арга хэмжээний санал ирж нийт 153 арга хэмжээний саналын жагсаалтыг нэгтгэн Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцэж байгаагаар нь дахин жагсаалт үүсгэн, 2020 оны 10 дугаар сарын 27-29-ний өдөр иргэдээс 62 төсөл, арга хэмжээгээр цахимаар санал авсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч, төлөөлөгчдөөс ирсэн саналыг тусган төсөлд 2020 оны 11 дүгээр сарын 30-аас 12 дугаар сарын 1-ний хооронд дахин санал авч нэгтгэсэн. Цахим санал асуулгад нийт 3878 иргэн хамрагдсан. Аймгийн ИТХ-аас он дамжин хэрэгжих 16, шинээр 33 төсөл арга хэмжээ тус тус батлагдсан. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцын мэдээллийг [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn), [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад сар бүр байршуулан ил тод мэдээлэх ажлыг хэвшүүлсэн.

*Завхан аймаг.* Орон нутгийн төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах бүхий л үе шатанд төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор орон нутгийн телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж хэвшүүллээ. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж байгаа "Ард иргэдээ сонсох аян"-ыг жил бүр 3 удаа зохион байгуулж, иргэдээс гарсан саналуудыг нэгтгэн, хэлэлцүүлж иргэдийн 12000 гаруй саналыг эрэмбэлж, урт, дунд, богино,

хугацааны хөтөлбөр зорилтуудыг уялдуулан шийдвэрлэдэг болсон. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийн дэргэд “Ард иргэдээ сонсьё-70461212” утсыг ажиллуулан, иргэдийн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээг тоймлон 7 хоног бүр нэвтрүүлэг бэлтгэн хүргэж байна. Сар бүрийн ажлын тайланг өдрийн сониноор дамжуулан ард иргэдэд тайлагнах ажлыг хэвшүүлсэн. Мөн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж зайлшгүй шаардлагатай төслийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Орхон аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөлд санал авах ажлыг иргэдийн дунд хэлэлцүүлэг явуулах, цахим хуудсаар болон цаасаар санал авах хэлбэрээр нийт өрхийн 50 хувийг хамруулан санал авч, саналыг эрэмбэлж, төсөвт тусган аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулав. Мөн орон нутгийн “Номин” телевизтэй хамтран иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэн, санал хүсэлтийг шууд утсаар авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажилласан. Орон нутгийн төсвийн төслийг [shilendans.mn](http://shilendans.mn) сайтад хуулийн хугацаанд байршуулж, иргэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн ба батлагдсан төсвийн талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар танилцуулах зорилгоор “Иргэний төсөв” товхимолыг хэвлүүлэн түгээж, мөн “Иргэн танаа” сониноор иргэдэд мэдээлж байна.

*Өвөрхангай аймаг.* Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн хөгжлийн сан болон хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд иргэдийн саналыг авч эрэмбэлэн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэн батлуулж байна. Холбогдох материалыг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбар, веб хуудас, иргэдэд мэдээллээр үйлчлэх төвд хүргүүлэн ажилласан / <https://shilendans.gov.mn/org/43?group=0&year=2020Uvurkhangai.mn/>. Орон нутгийн төсвийн төсөлд олон нийтийн сонголт хийн, гарсан саналыг тусгаж байна.

*Өмнөговь аймаг.* 2020 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлыг эрэмбэлэх хүрээнд 15 сумын 13899 иргэнээс санал авах ажлыг зохион байгуулсан. 2020 онд орон нутгийн хөгжлийн сангийн 6,968,490.8 мянган төгрөгийн

санхүүжилттэй 158 ажлыг хийхээр төлөвлөж, төлөвлөсөн 158 ажилд 5,090,900.5 мянган төгрөгийн гүйцэтгэлийг олгож ажилласан байна.

*Сүхбаатар аймаг.* 2020-2024 онд хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 5 жилийн үндсэн чиглэлийн саналыг салбар бүрээр, бодлого боловсруулж буй мэргэжлийн байгууллагууд, иргэд олон нийтээс Сүхбаатар аймаг фэйбүүк хуудсаар дамжуулан саналыг авч нэгтгэн бодлогын баримт бичгүүдэд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах болон орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар багуудын иргэдийн Нийтийн Хурлаар дамжуулан мэдээллийг өгч ажилласан. Мөн [sukhbaatar.mn](http://sukhbaatar.mn) цахим хуудас, Сүхбаатар аймаг фэйбүүк хуудсаар холбогдох зар мэдээллүүдийг хүргэсэн.

*Сэлэнгэ аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлаар 2020 оны сумын болон аймгийн төсөвт тусгагдах хөрөнгө оруулалтын ажлуудын саналыг нэгтгэсэн. Жагсаалтад эрэмбэлэгдсэн хэрэгжүүлэх нэн шаардлагатай ажлуудыг зураг төсөв хийлгэж, төсөвт тусгуулж, 2021 оны төсвийн төслийн саналыг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд “Орон нутгийн төсөв таны төсөв” нэртэй иргэд олон нийтэд төсвийн төслийг энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

*Төв аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөд 45,292 иргэд санал өгөх боломжтой байгаагаас 9,395 иргэнээс санал гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 568 ажил хийж гүйцэтгүүлэхээр баталснаас 232 ажлыг эрэмбэлж, 201 төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Сумдын хувьд иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авсан байна.

*Увс аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөд 13,317 иргэд санал өгөх боломжтой байгаагаас 8,107 иргэнээс санал гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 629 ажил хийж гүйцэтгүүлэхээр баталснаас 375 ажлыг эрэмбэлж, 219 төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Сумдын хувьд иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авсан байна.

*Ховд аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөд 31,652 иргэд санал өгөх боломжтой байгаагаас 9,106 иргэнээс санал гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 632 ажил хийж гүйцэтгүүлэхээр баталснаас 339 ажлыг эрэмбэлж,

260 төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Сумдын хувьд иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авсан байна.

*Хөвсгөл аймаг.* Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөд 60,080 иргэд санал өгөх боломжтой байгаагаас 10,325 иргэнээс санал гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 877 ажил хийж гүйцэтгүүлэхээр баталснаас 349 ажлыг эрэмбэлж, 232 төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Сумдын хувьд иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авсан байна.

*Хэнтий аймаг.* Танхимаар болон цахим хэлбэрээр давхардсан тоогоор 1259 иргэний саналыг авч хэлэлцүүлж, 2021 онд шинэ хөрөнгө оруулалтаар 2,5 тэрбум төгрөгийн санхүүжилтэй 33 төсөл арга хэмжээ, 2020 оноос шилжиж орж ирсэн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 17 төсөл арга хэмжээ орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжин хэрэгжихээр байна. Нийт 50 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 6,3 тэрбум төгрөг байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.4-2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын [www.iltod.mn](http://www.iltod.mn), [www.shilendans.com](http://www.shilendans.com) цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх /СЯ, 2018-2022/

Сангийн яамны санаачилгаар төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн төсвийн тухай мэдлэг мэдээллийг тэлэхийг зорилго болгон 2018 оноос эхлэн иргэн бүрд ойлгомжтой байдлаар “Иргэдийн төсөв” товхимол болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хэлбэрээр бэлтгэн [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) цахим сайтад байршуулж байна. “Иргэдийн төсөв” 2021 эмхэтгэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн танилцуулга, тоо, баримт, графикийг боловсруулж нэгтгүүлсэн. Дэлхийн банктай хамтран улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдэд урьдчилсан үнэлгээ хийх /pre-screen/ аргачлалыг боловсруулсан. Дэлхийн банктай тохиролцсны дагуу урьдчилгаа үнэлгээний аргачлалыг 2020 онд туршилт байдлаар ашиглаж, 2021 онд эрх зүйн баримт бичиг болгон батлах бөгөөд энэ зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд урьдчилсан үнэлгээний загварыг оруулсан. Цахим системээр орон нутгаас Архангай аймаг, яамдаас БСШУЯ туршилтад хамрагдан урьдчилсан үнэлгээний загварыг ашиглаж болохоор байна гэсэн дүгнэлт ирүүлсэн.

2019 онд нийт Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт 13 удаа өөрчлөлт орж тухай бүрт нь Сангийн сайдын 2018 оны Төсвийн хуваарь батлах тухай” 309 дугаар “тушаалын холбогдох хавсралтад өөрчлөлтийг оруулж, Сангийн сайдын тушаалаар баталгаажуулан [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) цахим сайтад байршуулсан. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд болон холбогдох бусад материалын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг төсвийн ил тод байдлын [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) сайтад нийтэлсэн.

ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг 2018 онд батлан мөрдүүлж эхэлснээс хойших хугацаанд журмын хэрэгжилтэд тулгарч буй асуудал, сайжруулах арга замын талаарх хэлэлцүүлэг, санал асуулгын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтэд оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж тэдний санал, зөвлөмжийг сонсож хэлэлцсэн ба нийт 734 орон нутгийн албан хаагчдаас санал, асуулга авсан. ОНХС-ийн шинэчилсэн Удирдлагын мэдээллийн системийг ашиглалтад оруулж, Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-нд шинээр батлагдсантай холбоотойгоор олон нийтийн саналыг авч ОНХС-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа болон төслийн үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд тус сан болон төслийн үйл ажиллагаатай холбоотой нийт 2 шторк, 5 нэвтрүүлгийн зураг авалт, эвлүүлэг, хийц, цацалт, үндэсний болон орон нутгийн түвшинд 21 мэдээ бэлтгэл, цацалт хийж мөн 7 төрлийн мэдээлэл, сурталчилгааны материалыг нийт 233900 /үндэсний хэмжээнд/ ширхгийг хэвлэж, олон нийт болон сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад түгээв.. (Биелэлт 30 хувь)

4.1.3.5-1. Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг авах/Монголбанк, 2017-2020/

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А-155/134

дугаар хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан. Ковид-19 цар тахлын үед Монголбанк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, иргэд, аж ахуйн нэгжийн олгосон зээл, санхүүгийн ачаалал, дарамтыг багасгах үүднээс “Актив ангилал, активын эрсдэлийн эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаагаар өөрчлөлт оруулж, хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон активт тогтоох хугацааны ангиллын нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулах, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хоногийг активт хугацааны ангилал хийхдээ хасаж тооцох, зээлдэгч нь банкиндаа хандаж зээлийн эргэн төлөлтийн хуваарьтаа өөрчлөлт оруулах боломжоор хангах, ийм зээлийгжурмын дагуу бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй, эцсийн ангиллыг нь өөрчлөхгүй байх зэрэг арга хэмжээг түр хугацаанд буюу 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хэрэгжүүлнэ.

Ковид-19 цар тахлын тохиолдол дэлхий даяар болон Монгол Улсад илэрсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоож байгаагаас шалтгаалан аж ахуйн нэгж(ААН)-үүдийн үйл ажиллагаа хумигдаж, ажилтнууд болон өрхүүдийн орлого тасалдах, улмаар банк, санхүүгийн салбарт төлөх зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учрах нөхцөл байдал үүссэн. Улмаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А-122 дугаар, 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А-320 дугаар, 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А-423 дугаар тус тус тушаалын дагуу эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас 2020 оны 02 дугаар сараас эхлэн эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлүүдийн үлдэгдэл хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар, зээлийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр сунгахыг банкуудын гүйцэтгэх захирал нарт зөвшөөрсөн. Энэхүү арга хэмжээний үр дүнд банкууд 2020 оны эцсийн байдлаар нийт 115,659 зээлдэгчийн 1,268 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулсан байна. Энэ нь нийт хэрэглээний зээлийн багцын 30.1%-ийг бүрдүүлж байна. (Монголбанк - МБГ-МЗБХ)

Монголбанкнаас “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Өр, орлогын харьцааг тооцох аргачлал”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тус тус холбогдох өөрчлөлтүүдийг оруулж,

зээлийн хугацаа болон бүтцэд өөрчлөлт оруулах, хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнтэй холбоотой мэдээлэл, сургалт, тайлбарыг бэлтгэж хүргэснээс гадна арилжааны банкны харилцагчид зөвлөх ажилтнуудад заавар өгч иргэдэд тэгш мэдээлэл өгөх чиглэлийг өглөө.

Төв банк/Монголбанк/-ны тухай хууль болон Зээлийн мэдээллийн тухай хуульд тус тус заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авсан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь харилцагч, үйлчлүүлэгчийн зээлийн мэдээллийг хамгаалах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх харилцааг илүү нарийвчлан зохицуулах зорилготойгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А-231 дүгээр тушаалаар “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах журам”-ыг баталж, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч бүх этгээд нь үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүргийг өгч, хяналт тавин ажиллалаа.

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Зээлийн хүүг бууруулах стратеги” баримт бичгийг батлав. Монгол Улсын санхүүгийн салбар дахь санхүүжилтийн зардлыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал туссан. Энэхүү баримт бичгийн хүрээнд “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах” чиглэлд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 329/187 дугаар хамтарсан тушаалаар төрийн болон төрийн бус байгууллага, зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийн байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулахаар ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос нэр бүхий 10 Банк бус санхүүгийн байгууллагаас зээлийн гэрээг авч, судалгаа хийж, дор дурдсан дүгнэлтийг гаргаад байна. Үүнд:

1. Зээлдүүлэгчийн эрх ашигт илүү давуу байдал олгосон, зээлдэгчийн эрх үүргийг тодорхой сайн тусгаагүй, зээлдэгчийн эрхийг дутмаг тусгасан зэрэг зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүргийг тэгш биш тусгасан;
2. Зээлийн хүүг гэрээнд үндсэн хүүг зээлийн гэрээний эхний хуудсанд, хавсралтад



хөнгөлөлттэй хүүг тусгасан зэрэг 2 ялгаатай хүүг гэрээнд тусгасан. Зээлийн гэрээгээ сайн уншиж танилцсан зээлдэгчид хөнгөлөлттэй хүүгийн талаарх мэдээлэлтэй танилцаж үр шимийг нь хүртэж чадна. Харин зээлийн гэрээтэй сайн танилцаагүй зээлдэгчид энэхүү хөнгөлөлттэй хүүгийн талаар мэдэхгүй өнгөрөх зэрэг зээлдэгчийг төөрөгдүүлэх шинж чанартай;

3. Цахим зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй Банк бус санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний нөхцөл, зээлийн гэрээний эрх зүйг хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах шаардлагатай;
4. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн гэрээ нь хууль тогтоомжоор заасан гэрээний эрх зүйн ерөнхий заалтуудыг зарим нь хэт дэлгэрэнгүйгээр, зарим нь хэт товчхон, ойлгомжгүй, тодорхой бусаар заасан зэрэг хэт ялгаатай байдлаар зээлийн гэрээг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тиймээс зээлийн гэрээний ерөнхий жишиг загварыг нэгдсэн байдлаар гаргаж, зээлдэгчдэд хэт давуу байдал олгосон зээлийн гэрээ хийхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай;
5. Мөн Корона вирусийн халдвар дэлхий нийтийг хамарч байгаатай холбоотой халдварт өвчнөөс санхүүгийн зах зээлд нөлөөлж болзошгүй дам нөлөөг илрүүлэхээр “Шинэ корона вирусийн улмаас санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээ” судалгааг гүйцэтгэж, иргэд, аж ахуйн нэгжүүдийг ерийн дарамтад орох, санхүүгийн байгууллагуудын зээл чанаргүйдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр Банк бус санхүүгийн байгууллагууд болон хадгаламж зээлийн хоршоодын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд өөрчлөлт оруулах саналыг гаргасан.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Корона вирусийн халдвараас сэргийлэх “Зохицуулалтын байгууллагуудад хүргүүлэх зөвлөмж”-ийг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсаар дамжуулан хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.3.5-2. Банк зээл олгохдоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох /Монголбанк, 2017-2019/

Төв банкны зүгээс тухайн зээлийн бүтээгдэхүүний хүү, шимтгэлийг бодитой тогтоосон эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинэчлэн баталж, банкны салбараас санхүүгийн үйлчилгээ авах иргэд, аж ахуйн нэгжид бодит мэдээллийг хүргэх үүднээс банкуудын хадгаламж, зээлийн үйлчилгээний зарласан хүү, шимтгэл, бодит өртөгийн талаарх мэдээллийг сар бүр Монголбанкны цахим хуудас (Холбоос: <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=0>)-д байршуулдаг. Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам түүнтэй холбоотой зохицуулалтуудыг сурталчлах, мэдээлэл түгээх ажлуудыг 2020 оны 3 дугаар улиралд зохион байгууллаа. Үүнд: сэтгүүлчдэд эдийн засаг, санхүүгийн мэдлэг олгох сургалтын хүрээнд Татварын Ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар болон бусад төрийн болон хувийн байгууллагуудад зээл, зээлийн хүү, шимтгэл сэдвээр сургалт хийв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан “Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар”-ын дагуу банкны жилийн тайланд харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг, харилцагчийн эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлогын хэрэгжилт, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү шимтгэл, хураамжийн талаар банкны цахим хуудсанд мэдээлдэг ба Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан мэдээллийг банкны цахим хуудсанд тухай бүр, үнэн зөв тайлагнасан эсэхэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны сайтаар дамжуулан ББСБ-уудын санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг Монголын банкны холбоо, Монголбанкт хамтран зохион байгуулж байна. Энэ хүрээнд Дэлхийн банкны “Зээлийн хүүгийн тааз тогтоох” судалгааны ажлыг Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлж танилцуулга хийсэн ба АНУ, ХБНГУ, Австрали, Канад, Япон улсуудын хүүгийн тааз тогтоосон эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, түүний давуу ба сул талыг судалж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.5-3. Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх/Монголбанк, 2017-2020/

Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын банкны холбоо, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын ипотекийн корпораци, Азийн хөгжлийн банктай тус тус хамтран дараах гол ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

- Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль батлуулах,
- Санхүүгийн оновчтой шийдвэр гаргахад нь туслах, эрх тэгш харилцах чадамжийг бэхжүүлж, оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах,
- Санхүүгийн тэнцвэргүй байдлаас сэргийлэх зохицуулагч этгээдүүдийг эрх, үүргийн тодорхой болгох, энэ чиглэлд хяналт шалгалт хийдэг тусгай бүтэц бүрдүүлэх,
- Шимтгэл, хураамж болон санхүүгийн үйлчилгээний нэмэлт төлбөрийн талаарх ойлголтыг нийгэмд хүргэх,
- Орон сууцны ипотекийн зээл хүсэгчдэд чиглэсэн зөв, тодорхой ойлголтыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх,
- Зээлийн мэдээллийн сангийн ойлголт, мэдээлэл нийлүүлэгч талууд болон хэрэглэгч өөрийн мэдээллийг хэрхэн авч ашиглах, хяналт тавих талаар олон нийтэд хүргэх зэрэг арга хэмжээг авах.

Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн шинэлэг зохицуулалт орсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А-15 дугаар тушаалаар «Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай» хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан ба Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлагчид уламжлан улмаар хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-ын даргад өргөн мэдүүлсэн. 2020 онд байгуулагдсан шинэ парламентаас өмнөх парламентад өргөн барьсан хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасан.

Азийн хөгжлийн банк, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Азийн хөгжлийн банкнаас «Монгол Улсын санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх техник туслалцаа»-ны төслийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Уг төсөл хэрэгжихтэй зэрэгцээд Монгол Улсад тархсан КОВИД-19 цар тахлын улмаас төлөвлөгөөний дагуу хийх ажлууд удааширсан ч Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсэг нь хөл хорионы үеэр АХБ-ны техник туслалцааны зөвлөхүүдтэй хамтран Монгол Улс дахь санхүүгийн бүх салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах цогц хуулийн төсөл болох “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулж хууль санаачлагчид уламжилсан. Хуулийн төслийг Улсын Их Хуралд дахин өргөн барьж, чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.5-4. Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах /Монголбанк, 2017-2019/

Банкны салбар дахь банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах судалгааг Монгол Улс болон бусад улс орнуудын туршлагыг судлан боловсруулж, «Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр»-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 9 дүгээр сарын 14-ний А-366 тоот тушаалаар баталлаа. Энэхүү банкны шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох, банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлагыг төрөлжүүлэн харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох ажлуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд банкныг зөвхөн хувьцаат компани хэлбэртэй үүсгэн байгуулж, үйл ажиллагаа явуулах, банкны хувьцаа эзэмшлийн хувьд аливаа этгээд, түүний холбогдох этгээд банкны нийт саналын

эрхтэй хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтыг тусган, хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн чуулганаар хуулийн төслийг хэлэлцүүлэхийг дэмжсэн(УИХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганаар уг хуулийг баталсан).

Өнөөдрийн байдлаар банкны системд 12 банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанк энэ салбарт тэгш, шудрага өрсөлдөөн бий болгох үүднээс нэгдсэн зохицуулалтын орчин бүрдүүлэн ажилладаг. Тухайлбал, Төв банкнаас гаргасан бодлого, журам банкны онцлог, хэмжээ зэргээс үл хамааран ижил үйлчилдэг. Мөн банкнаас үзүүлэх үйлчилгээний урьдчилсан нөхцөл болгож тухайн банкны нэгдлийн оролцогч, өөрийн салбар, төлөөлөгчийн газар зэргээр үйлчлүүлэхийг харилцагчаас шаардахыг хориглосон Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүд буюу санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, зээлийн нөхцөлийн талаар тэгш, хүртээмжтэй мэдээллийг олгох ажлын хүрээнд Монголын Банкуудын Холбоотой хамтран банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргах зорилготойгоор вэб хуудсын дэд бүтцийг 2020 онд багтаан бэлтгэсэн ба үүний дагуу арилжааны банкуудаас мэдээллийг тухай бүр хүлээн авч, хамтран ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.5-5. Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах /Монголбанк, 2017-2022/

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг улам боловсронгуй болгохоор тусгасан. Энэ хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 4 дүгээр сард батлуулсан бөгөөд УИХ-ын сонгуулийн дараах шинэ засгийн газар үүссэнтэй холбоотойгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах хуулийн төслийн бичвэрүүдийг гүйцэтгэж бусад шаардлагатай хуулийн төслүүдийг боловсруулж, Засгийн газар болон УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаасны арилжааны горимд олон улсын стандартын дагуу Төлбөрийн-эсрэг-Нийлүүлэлт/ T+2 нэвтрүүлэх ажлын хүрээнд Сангийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 149 дүгээр тушаалаар “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд “DvP/T+2 горим” буюу “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” олон улсын зарчмыг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн зах зээлийн бусад дэд бүтцийн байгууллагууд болон Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлүүдийг оролцуулан зохион байгуулан ажиллаж холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах ажлуудыг гүйцэтгэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 29 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцоог DvP/T+2 горимд 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гэхэд шилжиж орохыг зах зээлийн оролцогчдод даалгаж тус өдрөөр DvP/T+2 горим зах зээлд амжилттай нэвтэрсэн. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээл олон улсын санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмыг амжилттай нэвтрүүлж, гадны хөрөнгө оруулагчид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх таатай орчин бүрдсэн бөгөөд үнэт цаасны арилжаанд ороход шаарддаг байсан 100 хувь мөнгөө байршуулах механизмыг халж, 30 хувийн дэнчин байршуулж арилжаанд оролцох, арилжааны шат дамжлага, зардал буурч, хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл байдлыг бий болгосон. Уг тогтоолд нэвтэрсэн болон хөрөнгийн зах зээлд хэрэгжүүлж буй бусад арга хэмжээний хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн шимтгэлийг 0.24 хувь байсныг үнэт цаасны төрөл тус бүрд тохирсон хувь хэмжээгээр буюу хувьцааг цэвэршүүлсэн үнийн дүнгээс (ЦҮД) 0.12 хувь (50 хувиар бууруулсан), Засгийн газрын бонд ЦҮД-ээс 0.00375 хувь, компанийн бонд ЦҮД-ээс 0.0075 хувь болгон тус тус бууруулсан. Ингэснээр зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардал буурч, зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцоход таатай нөхцөл бүрдэх зэрэг эерэг нөлөөтэй юм.

Гадаад улсын хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн биржийн хооронд олон улсын жишгийн дагуу шилжих буюу хөрвүүлэх чиглэлээр АНУ, Канад, Швейцар, Перу, Хонг Конг

зэрэг улсуудын зохицуулалтын орчинг “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай хамтран судалсан. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан Хорооны 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 758 дугаар тушаалаар батлуулсан. Ингэснээр гадаад улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй манай улсын томоохон компаниуд хувьцаагаа давхар арилжаалах, уг ажиллагаатай холбоотой бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх, дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах, бирж хоорондын хувьцааны хөрвүүлэлтийг хийх зэрэг томоохон зохицуулалтын өөрчлөлтийг бий болгох боломжийг бүрдүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”-ыг Захиргааны ерөнхий хууль болон олон улсын санхүүгийн зах зээлд ашиглагдаж буй хадгаламжийн бичиг гаргах үе шат, дараалал, стандартын дагуу шинэчлэн боловсруулж, Хорооны 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 757 дугаар тогтоолоор батлуулсан. Дээрх хоёр журам батлагдсанаар гадаадын болон дотоодын зах зээл хооронд үнэт цаас хөрвүүлж арилжаалах, хадгаламжийн бичгийг үнэт цаасанд хөрвүүлэх, бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаанд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон арилжаа эрхлэх байгууллагын үүрэг оролцоо, хариуцлага нэмэгдэж байна.

Мөн Засгийн газрын дотоод үнэт цаас/ЗГДҮЦ/-ыг иргэд болон аж ахуйн нэгжүүдэд хурдан шуурхай, хүртээмжтэй, чирэгдэл багатай гаргах зорилготойгоор блокчэйн технологи дээр суурилсан систем ашиглан арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Уг аппликэйшнийг ашиглан ЗГДҮЦ-ны дуудлага худалдааг өрсөлдөөнт, өрсөлдөөнт бус, хувь тэнцүүлсэн, хөнгөлөлттэй, хямдруулсан хувилбараар сонгох боломжтой бөгөөд төсвийн алдагдал нөхөх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, төсөл санхүүжүүлэх гэх зэрэг хуулиар зөвшөөрсөн зориулалттайгаар гаргахаар төлөвлөж байна.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2014 оны 85/А-106 дугаар тушаалаар “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын

10.1 дэх заалтад Кастодиан банк нь хадгаламж хэлбэрээр татсан үнэт цаасны үнийн дүнгээс Монголбанкны тогтоосон хувиар эрсдэлийн сан байгуулах бөгөөд тус эрсдэлийн сан байгуулах хувийг жил бүрийн эцэст Монголбанк шинэчлэн тогтоохоор заасан байдаг. Энэ хүрээнд цаашид хөрөнгийн зах зээлийг дэмжих, кастодианы үйл ажиллагааг өргөжүүлэх, цар тахалын үед банкуудын үйл ажиллагаанд хөнгөлөлт тусалцаа үзүүлэх үүднээс кастодиан үйл ажиллагааны эрсдэлийн сангийн хэмжээг 2020-2021 онд “0” хувь болголоо. (Биелэлт 70 хувь)

4.1.3.6-1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Энэ дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар хуулийн төслийг боловсруулах болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах, Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Хуулийн төсөлд санхүүгийн хяналтын улсын байцаагч, дотоод аудиторчуудын хараат бус байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх асудлыг тусгасан. Дотоод Аудиторчуудын Олон Улсын Институтээс 2017 оны 1 дүгээр сард дотоод аудитын баримт бичиг, стандартад өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2013 онд гаргаж байсан гарын авлагыг шинэчлэн боловсруулж Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлуулан мөрдүүлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, аудитын албадыг салбарын нэгдсэн бодлого, хууль эрх зүйн орчин, стандарт, улсын салбарын дотоод аудитын гарын авлагаар ханган дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлж ажилласан. Сангийн сайдаас Аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулж буй гэрээнд орон нутгийн санхүүгийн хяналт, аудитын албадын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тусгаж хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав.

Мөн улсын салбарын дотоод аудитын нэгжийн

албан хаагчдад дотоод аудитын талаар мэдлэг, мэдээллээр шуурхай хангах зорилгоор “Улсын салбарын дотоод аудит” пэйж хуудсыг нээн ажиллуулж байна. Сангийн яам, Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөлтэй хамтран улсын салбар дахь дотоод аудиторын үнэ цэнийг сурталчлан таниулах, дотоод аудиторуудын мэдлэг, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх зорилгоор “Улсын салбарын дотоод аудиторуудын зөвлөгөөн-2020”-ийг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан байна. Зөвлөгөөнд төрийн 88 байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын нэгжийн дарга, мэргэжилтэн, нийт 450 оролцогч хамрагджээ. (Биелэлт 70 хувь)

4.1.3.6-2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын одоогийн тогтолцоонд шинжилгээ хийх, эрх зүйн орчинг судлах, холбогдох арга хэмжээг авах/СЯ, 2017-2022/

Дотоод аудитын тогтолцооны шинжилгээ, эрх зүйн орчны судалгаанд үндэслэн Дотоод аудитын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулснаас гадна дотоод аудитын тайлан, дүгнэлтэд хяналт тавих чиглэлээр Чанарын баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх ажил хийгдэж байна. 2017 онд Дотоод аудитын Чанарын баталгаажуулалтын гарын авлага боловсруулж гаргасан бөгөөд Хөвсгөл аймаг, Нийслэл, Гадаад харилцааны яамд зэрэг байгууллагуудын Дотоод аудитын нэгжид туршилтаар Чанарын хяналт хийж, зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Мөн эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоо нэвтрүүлэх хүрээнд ажлын хэсэг байгуулагдан, журам, бодлогын баримт бичгийг шинэчлэх ажил хийгдэж байна. Дотоод аудитын ажлын үе шатыг цахимжуулах, нэгдсэн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр “Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем” програм хангамжийн техникийн даалгаврыг боловсруулаад байна.

Дотоод аудитын сургалтын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд Дотоод аудитын Олон улсын институт зэрэг гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалгааны ажил хийж байна. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албадыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах үүднээс 2019 онд Сангийн сайдын 268, 274 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, “Чанарын үнэлгээний аргачлал” болон “Дотоод аудитын

чанарын үнэлгээ хийх журам”-уудыг 2019 оны 12 дугаар сард 268, 274 дүгээр тушаалаар тус тус батлуулан, аргачлалуудыг хэвлэн, 2020 оны 10 дугаар сард улсын салбарын бүх байгууллагын дотоод аудитын нэгжид хүргүүлэв. Сангийн яамнаас “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-д заасан чанарын үнэлгээг Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын албанд 2 жил тутамд 1 удаа, харин тухайн ДАА нь өөрийн үнэлгээг жилд 1 удаа тус тус хийхээр зохицуулсан нь дотоод аудитын тогтолцоог сайжруулах, ажлын үр дүнг дээшлүүлэхэд хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.7-1. Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /СЯ, УАГ 2017-2019/

Төрийн аудитын бодлого, арга зүйг олон улсын жишиг, стандартад нийцүүлэн аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн олон зорилтод арга хэмжээг Төрийн аудитын байгууллагаас төлөвлөн хэрэгжүүлж байна. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн болох аудитын зөвлөмж, өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, боловсронгуй болгох зорилгоор “Хүлүгү санаачилга” Судалгаа шинжилгээний институттай 2019 оны 12 дугаар сараас 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хамтран ажилласан. Судалгааны баг 2018, 2019 оны төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжөөс түүвэрлэн авч, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн бөгөөд судалгааны дүнд үндэслэн санал дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон зөвлөмж, тайлан боловсруулж ирүүлсэн. Судалгаанд 2018-2019 оны 3,639 төлбөрийн акт, 5,758 албан шаардлага, 16,607 зөвлөмж буюу нийт 26004 шийдвэрээс түүврээр 1298-г бүрэн хамруулсан.

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) болон судалгааны ажлын тайлан, зөвлөмжид үндэслэн “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5034 дугаарт бүртгүүлсэн.

Сангийн сайдын “Төлөвлөгөө батлах тухай” 2020 оны 162 дугаар тушаалаар Үндэсний аудитын газраас Засгийн газрын 2019 оны

санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Шилэн дансны тухай хуулийн 2019 оны хэрэгжилт, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудлын төслийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан, мөрдөж ажиллаж байна.

Сангийн сайдад өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийн явцад 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд нийт 37 зөвлөмж, 6 албан шаардлага хамрагдсан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 85.9 хувь, албан шаардлагын биелэлт 60 хувьтай байна.

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн “Баянхонгор аймгийн Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл”-ийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан, Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайлан, Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар тус тус өгсөн зөвлөмжүүдийн биелэлт бүрэн хангагдсан болно. (Биелэлт 100 хувь)

4.1.3.7-2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллага өөрт учирсан хохирлыг барагдуулах талаар хуульчилсан зохицуулалтын хүрээнд хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж, хэрэв тийм нэгж байхгүй бол энэхүү үүргийг төрийн аудитын байгууллага хариуцахаар заасан. Хууль хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж буй аудитын явцад төрийн албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халснаас олгох нөхөн төлбөрт төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж олгосон зөрчилд

төлбөрийн акт тогтоож, төрийн албан хаагчийн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулж шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу хохирлыг барагдуулснаас төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар тухайн байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгжид албан шаардлага тус тус хүргүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Үндэсний аудитын газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 онд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргын хууль бус шийдвэрээр төрийн албанаас чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн, халагдсан 18 хүнд ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд нийт 135.4 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон зөрчил илэрснийг хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээ авахуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.

Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд Төрийн албаны зөвлөл төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаж байхаар хуульчилсан. Энэ дагуу Төрийн албаны зөвлөлөөс төрд бодит хохирол учруулсан, илтэд хууль бус тушаал гаргасныг илрүүлж, уг тушаалыг гаргасан албан тушаалтантай тусгайлан уулзалт хийж, учир холбогдлыг тайлбарлаж, төрд учруулсан 4.5 орчим сая төгрөгийн хохирлыг хууль бус шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлж, 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдөр төрийн сангийн дансанд шилжүүлсэн байна. Улмаар буруутай шийдвэр гаргасан төрийн албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх ажил үргэлжлэн хийгдэж бөгөөд уг шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаж байна. Түүнчлэн төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгохтой холбогдуулан тусгайлсан журмын төсөл боловсруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-д “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч хуулийн этгээдийн дансанд байгаа

төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын Төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөрийн зардалд 2016 онд 2.3 тэрбум төгрөг, 2017 онд 14.9 тэрбум төгрөг, 2018 онд 2.3 тэрбум төгрөг, 2019 онд 2.4 тэрбум төгрөг, 2020 онд 2.3 тэрбум төгрөг батлагдсан байна.

Төрийн албаны зөвлөлөөс төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхтэй холбогдуулан Үндэсний аудитын газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх бүхий ажилтан, албан хаагчидтай хэлэлцүүлэг хийж, санал солилцож, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойллоо. (Биелэлт 70 хувь)

4.1.3.7-3. Аудитын дүгнэлтийн мөрөөр хийсэн ажлын үр дүнг хянах, үнэлэх нэгдсэн журмыг батлан мөрдүүлэх /СЯ, 2018-2020/

Сангийн яамнаас Дотоод аудитыг тухай анхдагч хуулийг төслийг эцэслэн боловсруулсан. Дотоод аудитын дүрмийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэж заасны дагуу Нийслэлийн дотоод аудитын алба, Гадаад харилцааны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторудын аудитын дүгнэлт, ажлын материалд чанарын баталгаажуулалтын гарын авлагын дагуу баталгаажилт хийж, хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгсөн. Гарын авлагыг туршилтаар дээрх 3 байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж туршсан бөгөөд шинэчлэх, сайжруулах шаардлагын улмаас гарын авлагыг 2019 онд шинэчлэн боловсруулж батлав.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах үүднээс 2019 онд Сангийн сайдын 268, 274 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, “Чанарын үнэлгээний аргачлал” болон “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-уудыг тус

тус боловсруулан батлуулсан. Тус аргачлалуудыг 2020 оны 10 сард төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжүүдэд хүргүүлсэн. “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-д зааснаар Сангийн яам чанарын үнэлгээг төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын албанд 2 жил тутамд 1 удаа, харин тухайн дотоод аудитын алба нь өөрийн үнэлгээг жилд 1 удаа тус тус хийхээр зохицуулсан нь дотоод аудитыг ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх ач холбогдолтой байна.

Арга хэмжээний мөрөөр хийсэн ажлын үр дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу үнэлгээ хийж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.8-1. Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах /СЗХ, СЯ, 2017-2022/

Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтад холбогдох зохицуулалтыг тусгаж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-19.6, 19.4 дэх заалтад заасан нөхцөл шаардлагын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бүх аудитын компаниудад адил түвшний нөхцөл шаардлага тавигдаж байна. Хэрэв гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах бол Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтад заасан нэмэлт шаардлага тавьж ажиллах тэгш нөхцөлийг хангуулж байна. Сангийн яамны <https://mof.gov.mn/> цахим хуудасны ил тод цэсний тусгай зөвшөөрөл дэд цэсэд 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотод 120, орон нутагт 19 аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд бүртгэлтэй байна.

Даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ явуулах эрхтэй компаниудын мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны <http://frc.gov.mn/daatgal#> цэсний аудитын компани хэсэгт байршуулан ажиллаж байна. 2020 оны байдлаар нийт 45 даатгалын байгууллагад аудит хийх эрх олгогдсон ба 2020 онд шинээр 1 хуулийн этгээдэд тус эрхийг олгосон байна. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компаниудын холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн Хорооны цахим хуудасны тусгай зөвшөөрөл эзэмшигчид хэсэгт байршуулж байна. Тус мэдээлэлд компанийн оноосон нэр, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, хаяг байршил, удирдлагын мэдээлэл, улсын бүртгэлийн болон

регистрийн дугаар багтдаг ба олон нийтэд нээлттэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 2 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийг баталсан бөгөөд энэхүү дүрмийн 7 дугаар хавсралтаар “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудитор тавигдах нөхцөл шаардлагыг тогтоож өгсөн. Хорооны 2013 оны 451, 452, 453 дугаар тогтоолоор баталсан “Аудит, үнэлгээ, хуулийн компани”-дыг бүртгэх, бүртгэлээс хассан журмуудыг нэгтгэж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.8-2. Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад төрийн захиргааны байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах/СЯ, 2017-2018/

Сангийн сайдын 2019 оны 119 дүгээр тушаалаар Аудитын тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад Сангийн сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар баталсан “Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам”-ыг дагуу хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын нэгдсэн дүнгийн шийдвэрийг Сангийн яамны “Ил тод” цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Мөн Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Сангийн яамны “Ил тод” цахим хуудсанд 2019 оны байдлаар нийт 5 удаа байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээлэх тухайд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно.” гэж заасны дагуу аж ахуйн нэгж байгууллага өөрөө мэдээлэх боломжтой.

Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасны дагуу Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд чанарын хяналтыг жил бүр хэрэгжүүлдэг бөгөөд чанарын хяналтын дүнг Сангийн яамны [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) сайтаар дүнг олон нийтэд нээлттэй болгон ажиллаж байна. Засгийн газрын тогтоолын дагуу тус яамнаас “Төсвийн ерөнхий захирагч нарын

шилэн дансны хөтлөлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн тайлагнаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.9-1. Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн аудитын тухай(шинэчилсэн найруулга) хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэж заасан нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт бий болсон.

Төрийн аудитын тухай хуульд нийцүүлэн “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлуулсан. Журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх зохицуулалтыг тусгасан.

Төрийн аудитын байгууллага нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд 32 төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, илтгэх хуудас бэлтгэж төсвийн ерөнхийлөн захирагчийн Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга нарт цахимаар хүргүүлж ажилласан.

Энэхүү аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнд өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг 2018-2020 онд нэгтгэн товхимол бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчдад гардуулдаг болсноор харьяа байгууллагуудад нийтлэг илэрдэг алдаа дутагдлыг дээд удирдлагын түвшинд олж харах, тус зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхааран ажиллах, төсөв санхүүгийн сахилга



хариуцлагыг төлөвшүүлэхэд илүү үр дүнтэй байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.9-2. Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангах, аудитын байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох /ҮАГ, 2017-2018/

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” хэмээн төрийн аудитын байгууллагын үндсэн чиг үүрэг, зарчмыг баталгаажуулсан.

УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тус тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.2.5-д “төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.” гэсэн үзэл баримтлалын чиглэл болгон тусгасан. Энэ хүрээнд “Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр батлуулан, 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байна. Хуульд төрийн аудитын байгууллагын хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн баталгааг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгахын зэрэгцээ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Энэ хуулийн 11.2-т заасан аудитыг гүйцэтгэхэд төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, аливаа дарамт, шахалт үзүүлсэн, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.”, 39.2-т “Нөлөөллийн мэдүүлэг хөтөлөх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.” гэж заасан байна. Үүний дагуу Үндэсний аудитын газраас журмын төслийг боловсруулж, төсөлд санал авах ажлыг зохион байгуулсан байна. (<https://audit.mn/?p=2949>) Түүнчлэн аудитын дээд байгууллагын хараат бус байдлыг санхүү төсөв, хүний нөөц, үйл ажиллагааны хувьд хараат бус байх гэсэн 3 түвшинд авч үздэг.

*Санхүү, төсвийн хараат бус байдал:* Төрийн

аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 40 дүгээр зүйл /Эдийн засгийн баталгаа/ ийн 40.1-д “Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжинэ. Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана”. 40.4.-т “Засгийн газар төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус заасан.

*Хүний нөөцийн хараат бус байдал:* Төрийн аудитын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1<sup>5</sup>, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3<sup>6</sup>-т зааснаар төрийн аудитын байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан тушаалын ангилалд хамаардаг. Төрийн аудитын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д зааснаар Төрийн аудитын байгууллагын албан хаагч тусгайлан тангараг өргөдөг.

*Үйл ажиллагааны хараат бус байдал:* Төрийн аудитын тухай хуульд заасан чиг үүргээ чанартай, дэлхийн бусад төрийн аудитын байгууллагын жишигт нийцсэн аудитыг гүйцэтгэхэд томоохон үүрэг гүйцэтгэх, үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахад үндэсний стандарттай байхыг шаарддаг. Энэ хүрээнд 2020 онд MNS 6817 : 2020 Төрийн аудитын 8 стандартыг батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.9-3. Удаа дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, дотоод хяналт хангалттай үнэлгээ авсан байгууллагын санхүүгийн тайланд жил бүр аудит хийдэггүй байх нөхцөл, шалгуурыг боловсронгуй болгох /ҮАГ, СЯ, 2017-2020/

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан холбогдох дүрэм, журам, бусад баримт бичгийг хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулж байна. Тухайн санхүүгийн жилийн зохих хугацаанд завсрын аудит хийгдсэн, тайлант хугацаанд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт ороогүй, олон нийтийн болон хууль тогтоох байгууллагын анхаарал татсан бусад асуудал хөндөгдөөгүй зэрэг үзүүлэлт шаардлагыг хангасан байгууллагуудыг түүвэрт хамруулан илэрсэн алдаа, зөрчлийг харьяалагдах дээд байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн дүнд нэгтгэн дүгнэлт өгч байна.

5 Төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогч, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч ажиллах бөгөөд тэдгээр нь төрийн тусгай албан хаагч байна.

6 ... Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал;

Санхүүгийн тайлангийн 2019 оны аудитад нийт 681 байгууллагын санхүүгийн тайланг хамруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 689 байгууллагыг хамруулж, 395 дүгнэлт гарган, 301 байгууллагыг түүвэрт хамруулж, “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэх баримтлах журам”-ын дагуу шалгуур хангасан 1 байгууллагад /Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар/ итгэл үзүүлсэн. Дээрх журмын дагуу өмнө жилд 3 байгууллагад итгэл үзүүлсэн. Төрийн аудитын байгууллагаас төсвийн байгууллагууд, төрийн өмчит төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагууд гадаадын болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа зээл тусламжийн санхүүгийн тайланг аль болох бүхэлд нь хамруулах зорилго тавьж түүврийн болон итгэл үзүүлэх байгууллагуудын тоог цөөн байлгахыг зорьж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.9-4. Төрийн аудитын байгууллага зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах/ҮАГ, 2018-2020 он/

Төрийн аудитын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн аудитын үйл ажиллагаанд оролцох шинжээчийн сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан зохион байгуулах зорилгоор “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/82 тоот тушаалаар баталгаажуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4906 дугаарт бүртгүүлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Журмын 3.4.1.1-д “шинжээч сонгон шалгаруулах тухай урилга (шинжээчид тавигдах шаардлага, ирүүлэх материал, хугацаа, төсөв бүхий)-ыг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.”, 3.4.2.1-д “ажлын хэсэг шинжээч сонгон шалгаруулах дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх тухай зар (шинжээчид тавигдах шаардлага, материал ирүүлэх хугацаа, төсөв бүхий)-ыг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ. Дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх хугацаа зар нийтэлснээс хойш 5 хоног байх бөгөөд хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/92 дугаар тушаалаар “Шинжээч (шинжээч/санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх хуулийн этгээд)-ийн ажлын даалгавар”-ын загвар, “Шинжээч сонгох саналын жишиг баримт бичиг”-ийг тус тус батлан мөрдүүлж байна. Эдгээд журмын хэрэгжилтийг ханган ажилласнаар Төрийн аудитын байгууллага нь зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах нарийвчилсан эрх зүйн зохицуулалт бий болж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.10-1. Төрийн аудитын хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд мэдээлэх/ҮАГ, 2017-2022/

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор баталгаажуулан тухай бүр байгууллагын албан ёсны цахим хуудас болох [audit.mn](http://audit.mn) сайтад ил тод байршуулж байна. Тухайлбал, төрийн аудитын байгууллага нь 2020 онд нийт 372 байгууллагын санхүүгийн аудитын, гүйцэтгэлийн 9 аудитын, нийцлийн аудитын 6 тайланг Үндэсний аудитын газрын албаны ёсны цахим хуудас [www.audit.mn/](http://www.audit.mn/)-т ил тод байршуулж нийт 18 хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлсэн.

Үндэсний аудитын газраас Дэлхийн банктай хамтран OPEN AUDIT үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж, баталгаажсан аудитын бүх тайланг тусгайлан цэс үүсгэн байршуулснаар иргэд, олон нийтэд мэдээллийг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдээд байна. (Биелэлт 100 хувь)

4.1.3.10-2. Аудит хийхдээ эрсдэлтэй сэдэв, чиглэлийн талаар олон нийтээс санал, судалгаа авах үйл ажиллагааг цахим технологи ашиглан нэвтрүүлэх/ҮАГ, 2017-2019/

Төрийн аудитын байгууллага нь аудитын сэдэв сонголт, чиглэлийн талаар олон нийтээс санал судалгаа авч тусгах, эрсдэлтэй сэдэв сонгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тухайлбал, аудитын иргэний танхимыг Нийслэл, Говь-Алтай, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэд ажиллуулж байгаа бөгөөд 2020 онд Хэнтий аймгийн иргэдээс “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалт”-д хийх аудитын сэдвээр 1135 иргэнээс санал асуулга, судалгааг авч, дүгнэсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Төрийн аудитын байгууллага үр дүнтэй, үр ашигтай аудитыг хийхийн тулд

шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.”, 11 дүгээр зүйлийн 11.3.3-т “иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх.” гэж тус тус заасан байна. Уг заалтын дагуу Орон нутаг дахь Төрийн аудитын газрууд (Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод аймгийн) 2021 онд гүйцэтгэх аудитын сэдэв сонгоход олон нийтийн оролцоог хангах зорилгоор иргэд, олон нийтийг саналыг фэйсбүүк, тухайн байгууллагын цахим хаяг, утас болон биечлэн цаасаар ирүүлэх талаар урилга нийтэлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги 2020-2023”-ыг баталсан. Стратегийн зорилтыг хангах хүрээнд 2020-2023 онд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Төрийн аудитын үйл ажиллагаа, үр дүнг түгээх арга зүйг хөгжүүлэх;
- Төрийн аудитын үе шатанд иргэдийн оролцоог хангах тогтолцоог бий болгох зэрэг болно.

Төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийг хэрэгжүүлэхдээ төрийн аудитын ил тод, нээлттэй байдлыг хангах зарчмыг удирдлага болгон аудитын тодорхой үе шатанд иргэдийн оролцоог хангах, харилцагч талуудаас мэдээлэл, санал, санаачилга, зөвлөмжийг хүлээн авч, аудитын үр нөлөөг сайжруулах бодлого баримталж байна.

Дээрх стратеги төлөвлөгөөний дагуу аудитын сэдвийн санал хүсэлтийг иргэд, иргэний нийгмийн байгууллагаас авах энэ хүрээнд аудитын сэдвийн саналыг холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэн цахимаар, судалгаа хийх болон харилцагч талуудтай оролцоот уулзалт зохион байгуулах замаар хүлээн авах нөхцөл бүрдэж, хэрэгжүүлэн ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.3.10-3. Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг болох /СЯ, 2017-2019/

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн

багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;” энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тогтмол мэдээлэх хуулийн зохицуулалт үйлчилж байна. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-дах заалт энэ хуулийн 3.1.1-д төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэхээр заасны дагуу ТЕЗ нарын дэргэдэх дотоод аудитын алба нэгжүүд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2020 онд хийсэн аудитаар холбогдох байгууллагууд байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлдэггүй хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нийтлэг илэрсэн. ТЕЗ-дад холбогдох мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасан хугацаанд иж бүрэн мэдээлдэг байх чиглэл зөвлөмж хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн.

Сангийн яам нь үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд хөтөлбөрийн энэ заалтын хүрээнд нийт төрийн байгууллагууд төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн данс болон цахим хуудсаараа мэдээлж буй байдалд Үндэсний аудитын газартай хамтран хяналт тавьж, хэрэгжилтэд нэгдсэн дүгнэлт хийж, үнэлгээ өгөх шаардлагатай байна. (Биелэлт 70 хувь)

**Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 15 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2019 онд 12 арга хэмжээг хэрэгжүүлж дуусган, 3 арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.4.1-1. Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг боловсронгуй болгох үйл ажиллагааг дуусгах /СЯ, 2017-2019/

Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” буюу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ийг 2017 онд бүрэн ашиглалтад оруулсан байна.

2018 онд 1433 захиалагчийн худалдан авах ажиллагааны 21417 төлөвлөгөө, 2019 онд 2035 захиалагчийн худалдан авах ажиллагааны 27010 (өссөн дүнгээр) төлөвлөгөөний талаарх мэдээлэл тус тус бүртгэгдэж байсан бол 2020 онд 2345 захиалагчийн худалдан авах ажиллагааны 29219 (өссөн дүнгээр) мэдээлэл бүртгэгдэж, олон нийтэд мэдээлсэн нь өмнөх оноос 210 захиалагч, 2909 төлөвлөгөөгөөр нэмэгдсэн дүнтэй байна.

Төрийн болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр УИХ-аас батлан, 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Хуулийн 5 дугаар зүйлд 5.1.25. “Худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, 15 хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог.”, “5.1.26. Цахим худалдан авах ажиллагаа гэж цахим худалдан авах ажиллагааны системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг.”, “5.1.27. “Цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг.” тус тус нэмж тусгасан.

Мөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинээр дараах 6 журмыг Засгийн газрын тогтоолоор болон Сангийн сайдын тушаалаар батлан мөрдөж байна:

1. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол);
2. “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол);
3. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан

мэдээлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар);

4. “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” (Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаал);
5. “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаал);
6. “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” (Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаал); 10

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн шаардлагатай хөгжүүлэлтийн ажлыг хийж, боловсронгуй болгож байгаагийн зэрэгцээ нэгдсэн системийн дэд системүүдийг үе шаттай нэвтрүүлэн ашиглаж байна. 2019 онд системийг боловсронгуй болгох, хууль журамтай холбоотой өөрчлөлтүүдийг хийж, 2020 онд үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүллээ. Үүнд:

- Нийлүүлэгч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг захиалагч болон Сангийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар цахим хэлбэрээр хүлээн авч хариуг хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн;
- Гомдлын процессыг бүрэн цахимжуулж, 2020 оны байдлаар 292 гомдлыг бүртгэсэн;
- Гэрээний гүйцэтгэлийн модулийг ашиглалтад оруулж, системд 19652 гэрээний мэдээлэл бүртгэсэн;
- Тендерийн материалыг тухайн тендерт оролцогчдод цахим системээр дамжуулан хүсэлт гаргаж тендерийн материалтай танилцах боломжийг бүрдүүлсэн;
- Цахим системд тендерт эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтыг байршуулсан;
- Тодруулгыг цахим хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг нэмж бүрдүүлсэн ба 2020 оны байдлаар уг системд 879 тодруулгыг бүртгэсэн;
- Түншлэлийг цахим хэлбэрээр гаргах нөхцөл бүрдүүлж, уг системд 1141 хүсэлт бүртгэгдэж, 769 түншлэлийн гэрээг байгуулсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.1-2. Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д 2018 онд 1433 захиалагчийн худалдан авах ажиллагааны 21417 төлөвлөгөө бүртгэгдэж байсан бол 2020 онд нийт 2345 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны

төлөвлөлтийн талаарх 29219 (өссөн дүнгээр) мэдээлэл бүртгэгдэн олон нийтэд мэдээлэгдсэн нь 912 захиалагч болон 9802 төлөвлөгөөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааны мэдээллийн нээлттэй байдлыг хангаж, өрсөлдөх боломжийг бий болгох, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим системийн ашиглалтад дэвшил гарч байгааг харуулж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) -д 2020 оны байдлаар нийт 22274 төсөл, арга хэмжээний тендерийн урилга зарлагдсанаас “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга 22043 байгаа нь нийт урилгын 99.0 хувийг эзэлж нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь мөн захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг илтгэж байна.

Тус системээр дамжин 2018 онд 10202, 2019 онд 17371, 2020 онд 21945 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 2474-өөр буюу 26.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн 2020 онд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн захиргааны бүх шатны байгууллагуудын албан хаагчдад зориулан байгууллага тус бүр дээр тоон гарын үсгийн талаар ойлголт өгөх, хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр танилцуулга, сургалтыг зохион байгуулсан. Худалдан авах ажиллагааны тендерийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглаж эхэлснээр тендерийн үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжих боломж бүрдэв. (Биелэлт 100 хувь)

4.1.4.2-1. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хянан шийдвэрлэх чиглэлээр журам боловсруулах /СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.7-д заасны дагуу Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 131 дүгээр тушаалаар «Тендер оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам»-ыг батлан мөрдөж байна. <https://www.legalinfo.mn/law/details/14468?lawid=14468>

Цар тахлын үеийн нөхцөл байдалтай уялдуулан Сангийн яам цахим системээр дамжуулан тендер оролцогчдын гомдлыг хүлээн авч, захиалагч байгууллагуудыг цахим системээр дамжуулан

гомдлыг хянахад шаардлагатай материал ирүүлэхийг мэдэгдэн, 2020 онд нийт 316 гомдлыг цахим системээр дамжуулан хүлээн авч хянан хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив, албан хэрэгхөтөлөлтийн тухай хуульд заасны дагуу цахимаар ирүүлсэн гомдлыг албан бичгээр баталгаажуулах шаардлагатай тул цахим системээр ирүүлсэн гомдлыг хуулийн хугацаанд хүлээн авсанд тооцож, гомдол гаргагчид гомдол хянан шийдвэрлэх хугацаанд албан бичгээр ирүүлэхийг мэдэгдэн ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.2-2. Иргэд тендерийн үйл ажиллагаа, явц байдлын талаар санал, бодлоо илэрхийлэх, харилцах, гомдол гаргах асуудлыг “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-д тусгах /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/

Иргэд, олон нийт тухайн тендертэй холбоотой тодруулгыг цахим хэлбэрээр гарган зохион байгуулагчид ирүүлэх, захиалагч тал цахим тодруулгыг хүлээн аваад хариуг нийт сонирхогч, оролцогчдод нээлттэйгээр системд байршуулан мэдээлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Нийлүүлэгч тал гомдол гаргахдаа цахим хэлбэрээр гаргах, түүнийг захиалагч болон Сангийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар цахим хэлбэрээр хүлээн авч, хариуг хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн. 2019 онд Сангийн яамнаас тендер оролцогчийн гомдлыг албан бичгээр (уламжлалт хэлбэрээр) хүлээн авсан бөгөөд тухайн гомдолтой холбоотой тендер оролцогчийн ирүүлсэн тендерийн материалыг цахим системээс татан авч, хянан шийдвэрлэсэн. 2020 онд нийт 292 гомдлыг цахим системээр дамжуулан хүлээн авч, хуулийн хугацаанд хянан шийдвэрлэжээ. Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд тендерийн материалтай тухайн тендер оролцогч цахим системээр дамжуулан танилцах боломжийг цахим системд бүрдүүлсэн.

Иргэд, олон нийт, тендер оролцогч, захиалагч байгууллагын төлөөлөлд худалдан авах ажиллагаатай холбоотой шуурхай үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр холбоо барих утас, албаны и-мэйл хаягаар ирүүлсэн санал хүсэлтэд шуурхай хариулахаас гадна төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д LiveHelpDesk-ийг ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлэв. Ингэснээр ажлын бус цагаар үйлчлүүлэх, цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөгөөг цаг алдалгүй шуурхай авах, иргэд, олон

нийт, тендерт оролцогч, захиалагч байгууллагын үлдээсэн цахим зурвас, захидал, асуултад цахим шуудангаар хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлэн зөвлөгөө, мэдээллийг өгч байна. Мөн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэгдсэн тендерийн урилгыг олон нийтийн сүлжээний нийтлэг хэрэгсэл болох твитер хуудсанд дамжуулан нийтлэх боломжийг бий болгон иргэд, олон нийтэд шуурхай мэдээлэл түгээх арга хэлбэрийг нэмэгдүүлсэн. (Биелэлт 100 хувь)

**4.1.4.2-3. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдол мэдээллийг хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “тендерт оролцогч нь захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авсан, эсхүл тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг Сангийн яаманд тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана” гэж заасан. Үүний дагуу Сангийн яам нь тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг цахим хуудсаараа дамжуулан сар бүр мэдээлж байна.

Сангийн яаманд 2017 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 813 гомдол

ирүүлснийг тендерт оролцогчдоор дамжуулан 453 хууль бус шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан бөгөөд Сангийн яам гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланд тусган, Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үнэлгээний хороонд тавих захиалагчийн хяналтыг сайжруулж ажиллахыг даалгасан.

2018 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 1446 гомдол холбогдох байгууллагуудад гаргасан бөгөөд үүнээс 198 гомдол буюу 13.7 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1187 буюу 82.1 хувь нь захиалагчийн шийдвэрт, 61 буюу 4.2 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсны дараа, эсхүл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

2019 онд нийт 1,352 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 219 гомдол буюу 16 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1,060 буюу 78 хувь нь захиалагчийн шийдвэрт, 74 буюу 6 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

2020 онд нийт 1,163 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 154 гомдол буюу 13 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 914 буюу 79 хувь нь захиалагчийн шийдвэрт, 95 буюу 8 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна (Зураг 1).

**Гомдол шийдвэрлэлт**




Тендер шалгаруулалттай холбоотой гомдлын тоо 2017-2018 онд өсөх хандлагатай байсан, харин сүүлийн 2 жил тасралтгүй буурсан. Энэ нь 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг улсын орлого болгох болсонтой холбоотой байж болох юм.

Захиалагчийн шийдвэрт буюу Сангийн яаманд тендерт оролцогч тендерийн баталгаагаа барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах шинэ зохицуулалт 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү зохицуулалтыг мөрдөж эхэлснээс хойш зарлагдсан тендер

шалгаруулалтад гаргасан үндэслэлгүй гомдлын хэмжээ 2019 оны сүүлийн хагас жилд 92 буюу 16.2 хувь болж буурсан. Төрийн сангийн “Тендерийн баталгааны орлого” дансанд 81,458,648 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгон төвлөрүүлсэн байна. Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 482 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 90 шийдвэрийг тус тус захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.

Сангийн яамнаас тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан иргэд, аж ахуйн нэгжээс 2014-2020 онуудад ирүүлсэн гомдлыг хянан үзсэн байдлыг зургаар үзүүлбэл:



2020 онд Сангийн яаманд 816 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 560 аж ахуйн тендер оролцогчдоос ирүүлсэн давхардсан тоогоор 1009 гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх” журам /цаашид “журам” гэх/-ын дагуу хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс захиалагчийн шийдвэр гараагүй бөгөөд гомдолд дурдсан асуудлыг хуулиар захиалагч хянан шийдвэрлэх гомдол, хуулийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан, Сангийн яамны эрхлэх асуудалд хамаарахгүй, тендерт оролцогч гаргасан гомдлыг эргүүлэн татсан, болон журамд заасан бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй тул буцаасан гомдол 285 буюу нийт гомдлын 22 хувийг эзэлж байсан. Хууль, журамд заасан шаардлага хангасан, Сангийн яамны эрхлэх асуудалд хамаарах 724 гомдлыг хянан шийдвэрлэснээс нийт гомдлын 134 буюу 12 хувь нь гомдол үндэслэлгүй буюу захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, захиалагчийн шийдвэр үндэслэлгүй буюу захиалагч хууль зөрчсөн тухай шийдвэр гаргаж, зөрчлийг шүүхийн өмнөх шатанд залруулсан (Хүснэгт 1).

Захиалагч хуульд заасан журам зөрчсөн тул тендер шалгаруулалтыг хүчингүй болгож хуульд нийцүүлэн дахин зохион байгуулахыг мэдэгдсэн 71, захиалагчийн шийдвэр үндэслэлгүй бөгөөд тендерийн үнэлгээг дахин хийхийг мэдэгдсэн 519 шийдвэр гаргасан буюу тендерт оролцогчдоос ирүүлсэн нийт гомдлын 58 хувь нь үндэслэлтэй байсан.

Хүснэгт 1.

2020 онд Сангийн яаманд тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэсэн байдал

Гомдол шийдвэрлэлтийн төрөл	Ирсэн гомдол	Хувь
Захиалагчийн шийдвэр гараагүй, гомдолд дурдсан асуудлыг хуулиар захиалагч хянан шийдвэрлэхийг мэдэгдсэн	8	0.6%
Хуулийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг гомдол гаргагчид буцаасан	10	1.7%
Тендерт оролцогч гаргасан гомдлыг эргүүлэн татсан	35	3.5%
Сангийн яамны эрхлэх асуудалд хамаарахгүй гомдлыг гомдол гаргагчид буцаасан	49	5.4%
Захиалагч хуульд заасан журам зөрчсөн тул тендер шалгаруулалтыг бүхэлд хүчингүй болгож хуульд нийцүүлэн дахин зохион байгуулахыг мэдэгдсэн	71	5.7%
Сангийн яамны гаргасан гомдлын бүрдүүлбэрийн шаардлага хангахгүй тул гомдол гаргагчид буцаасан	88	10.5%
Хуулийн 55 дугаар зүйлд хамаарахгүй тул гомдол хүлээн авах боломжгүй мэдэгдэж шүүхэд хандахыг мэдэгдсэн	95	8.5%
Гомдол үндэслэлгүй буюу захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байгааг мэдэгдсэн	134	12.0%
Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй тендерийн үнэлгээг дахин хийх шийдвэр гаргасан	519	51.9%
<b>Нийт</b>	<b>1009</b>	<b>100.0%</b>

Сүүлийн 3 жилийн хугацаанд гэрээ байгуулахын өмнөх шатанд захиалагчийн шийдвэрт тендерт оролцогчдоос гаргасан гомдлын тоо буурсан боловч захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрийн тоо төдийлэн өөрчлөгдөөгүй байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2020 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд 32 гомдол, нэхэмжлэл гарсан бөгөөд хянан шийдвэрлэгчээр ангилан харуулбал:

1. Сангийн яаманд 22 гомдол:

- Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй- 1 (4.5%),
- Дахин үнэлгээ хийж, гэрээ байгуулсан (Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй боловч холбогдох байгууллагаас нэмэлт лавлагаа, тодруулга авсны үндсэн дээр дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн)- 10 (45.5%),
- Тендер шалгаруулалтыг дахин зарлаж, гэрээ байгуулсан- 4 (18.2%),
- Гомдол гаргагч этгээд гомдлоо татсан- 3 (13.6%),
- Бусад (дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн боловч Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр санхүүжилт хасагдсан-2, гомдлыг хүчингүй болгосон-1, гомдол хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэсэн-1)- 4 (18.2%).

2.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 5 гомдол:

Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэх-5 (100%) байна.

3.Шүүхийн нэхэмжлэл 5:

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нийт 5 тендерт оролцогч компаниас нэхэмжлэл гаргаж, шүүх 1 нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, 2 нэхэмжлэлийн шаардлагаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Бусад нэхэмжлэлүүд шүүхэд хянан шийдвэрлэгдэж байна. Нийт хянан шийдвэрлэгдсэн гомдлын 47.5 хувь нь захиалагчийн гаргасан шийдвэр үндэслэлтэй гэж хянагдсан байгаа бөгөөд гомдол шийдвэрлэгдэх хуулийн хугацаанд тухайн тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй гэрээ байгуулах ажил хүлээгдэж, хугацаа алдах байдал үүссэн үр дагавар гарсан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан гомдол, түүний шийдвэрлэлтийн мэдээллийг байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээнд тусган холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлж байна. (Биелэлт 100 хувь)



4.1.4.3-1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг зохистой тогтоох, түүнд хяналт тавих, өөр хоорондоо зөрүүтэй авлига гарах нөхцөл бүрдүүлэх хуулийн заалтыг хянан үзэж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох /СЯ, 2017-2020/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 оны 03 дугаар сард оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиг үүргийг бие даасан агентлаг хэрэгжүүлж байна.

“Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” зэрэг журмыг баталсан. Тухайлбал, Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 132 дугаар тушаалаар «Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам»-ыг баталснаар тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих боломж бүрдсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, журам, заавар батлагдсанаар тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын материалыг ил болгож захиалагч тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт тавих, худалдан авах ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл буюу хар жагсаалтыг хөтөлж, чанаргүй, гэрээний үүргээ биелүүлдэггүй компанийг дахин тендерт оролцуулахгүй байх, чанар, стандартын шаардлага хангасан дотоодын бараа, бүтээгдэхүүнд давуу эрх олгох, дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барааны тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахгүй байх, урьдчилан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн.

2020 онд Сангийн яамнаас “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”,

“Харьцуулалтын аргаар худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг”, “Тендер үнэлэх, тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал, заавар”, “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн сангийн болон үнэлгээний хорооны ажиллах журам”-ын төслүүдийг боловсруулсан.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт оруулах саналыг боловсруулж, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-2. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах /СЯ, 2017-2020/

2017 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <http://pcsp.gov.mn> цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны <https://tender.gov.mn> системд тус тус байршуулж, олон нийтээс санал авч, төсөлд тусгасан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг аймгуудын Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд, яамдын холбогдох албан тушаалтнууд, төрийн бус байгууллагын төлөөлөл 80 гаруй хүнийг оролцуулан 2017 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. 2018 онд Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулж 21 аймгийн орон нутгийн өмчийн газар холбогдох 30 гаруй мэргэжилтэн, 830 иргэн, 180 аж ахуйн нэгжийн саналыг авч, төсөлд тусгасан. Түүнчлэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүх шатны төсөвт байгууллагын төлөөлөлд танилцуулж, санал авч хэлэлцүүлсэн. 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах

санал боловсруулахдаа олон нийтийн саналыг авч тусган, Сангийн яаманд хүргүүлсэн. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу боловсруулсан дараахь бодлогын баримт бичигт олон нийтээс санал авч шинээр батлуулсан. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм, Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам - Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоол;
2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам - Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаал;
3. Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам - Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаал;
4. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам - Сангийн сайдын 2019 оны 208 дугаар тушаал;
5. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 13 тендерийн жишиг баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулав. Сангийн сайдын 2019 оны 122, 123, 124, 125, 126, 127, 128 болон 129 дүгээр тушаал.

Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу дээрх дүрэм, журмын төсөлд бүх төсвийн ерөнхийлөн захирагчаас санал авч, мөн Сангийн яамны цахим хуудас ([www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn)), Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д байршуулж санал авч, төсөлд тусган батлуулсан.

Дээр дурдсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;" гэж захиалагчийн эрх, үүрэг заасан хэсгийг өөрчлөн найруулсан. Энэ нь цахим худалдан авах ажиллагаа"-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.4.3-3. "Цахим худалдан авах ажиллагаа"-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2020/

Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.7-д заасан засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд урилга, үр дүн, мэдээллээ бүрэн оруулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох заалт хүчингүй болсон. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулан дээрх хуулийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх харилцааг Зөрчлийн хуулиар зохицуулахаар тусгасан боловч Зөрчлийн хуульд холбогдох заалт ороогүй тул хариуцлага хүлээлгэх боломжгүй байдал үүсээд байна.

Одоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж заасны дагуу «Цахим худалдан авах ажиллагаа»-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулиар хариуцлага ногдуулах эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

Тендерт оролцогчийн зүгээс «Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам» болон Тендерийн жишиг баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу тендерийн материалаа цахим системээр дамжуулан илгээхдээ Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж ирүүлэх ба тэдгээрийг хуулийн дагуу ил болгохыг хориглосон зайлшгүй үндэслэлийг бичгээр тайлбарласан байхыг зохицуулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.4.3-4. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.14-т заасны дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-ээр дамжуулан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх

тогтолцоог бүрдүүлсэн байна. Сангийн яам өөрийн цахим хуудсандаа тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн мэдээллийг байршуулж байна. Уг жагсаалтад орсон аж ахуйн нэгж нь тухайн хугацаанд цахим системээр дамжуулан аливаа тендер шалгаруулалтад оролцох боломжгүй байхаар цахим системийн хөгжүүлэлтийг хийсэн.

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталсан.

Журам батлагдсан даруй 2019 онд төсвийн ерөнхийлөн захирагч нараас хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтад заасан нөхцөл үүссэн эсэх талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт авч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, нэр бүхий 20 компанийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэж, цахим системд олон нийтэд нээлттэй мэдээлж байсан бол 2020 онд Сангийн яамнаас дээрх журамд заасны дагуу холбогдох нотлох баримтыг авч хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, нэр бүхий 35 компанийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэй мэдээлсэн болно. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.4.4-1. Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аас баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3-т “Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах эрхтэй” гэж заасан байна. Сангийн яамнаас “Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх заавар”-ын төслийг боловсруулан холбогдох байгууллагаас санал авч байна. (Биелэлт 30 хувь)

#### 4.1.4.4-2. Концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгосон журам боловсруулах /ҮХГ, 2017-2018/

Үндэсний хөгжлийн газраас Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүний дагалдах журмуудыг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2019 онд 2 удаа зарласан боловч шаардлага хангасан санал ирээгүй тул тендер хүчингүй болсон. Үндэсний хөгжлийн газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах журмуудын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ авах талаар тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд орсон 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч улмаар концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг Төрийн худалдан авах ажиллагааны газарт Үндэсний хөгжлийн газраас шилжсэн. (Биелэлт 0 хувь)

#### 4.1.4.4-3. Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах /ҮХГ, 2017-2019/

Үндэсний хөгжлийн газар 2017 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан, 2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Мөн Азийн хөгжлийн банктай хамтран гадаадын болон дотоодын зөвлөх сонгон ажиллуулж, хуулийн төсөл, үзэл баримтлалын эхний хувилбарыг боловсруулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн үр дагаварт мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зайлшгүй шаардлагатай байсан бөгөөд төсөвт тус судалгааг хийлгэх зардал тусгагдаагүй байснаас ажлын гүйцэтгэл удааширсан.

Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг Үндэсний хөгжлийн газраас Төрийн худалдан авах ажиллагааны газарт Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч шилжих болсонтой холбогдуулан ажил хүлээлцэх ажлын хэсэг ажиллаж байна. (Биелэлт 0 хувь)

4.1.4.5-1. Гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аар баталсан нэмэлт, өөрчлөлтөөр “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм болон тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэж өөрчлөн найруулсан.

Үүний дагуу Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмын 3.1-д эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсан шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэхээр, 3.2-т төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгж нь эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг тухай бүр шинэчилж, худалдан авах ажиллагааны цахим систем / [www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/)-д олон нийтэд нээлттэй байршуулахаар заасан.

2019 онд гэрээний үүргээ биелүүлээгүй 20 этгээдийн мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт Худалдан авах ажиллагааны цахим систем болон Сангийн яамны <https://mof.gov.mn/article/tender/blacklist>, <https://www.tender.gov.mn/mn/bidder/blacklist> цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлж байсан бол 2020 онд тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд нийт 35 тендерт оролцогчдыг бүртгэж, олон нийтэд мэдээлэв. (Биелэлт 100 хувь)

4.1.4.5-2. Гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах албадлагын арга хэмжээ авах эрхийг төрийн байгууллагад олгох, хариуцлагыг чангатгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх /СЯ, 2017-2019/

Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д заасан гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх заалт хүчингүй болж, хууль зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр болсон. Гэвч Зөрчлийн тухай хуульд уг асуудал тусгагдаагүйгээс үүдэн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэхэд хүндрэл учирч байв.

Иймд Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг батлуулсан. Энэхүү журмын 2.5-д “Иргэн, хуулийн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах хугацаа нь энэ тухай төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 3 жил байна” гэж, 2.6-д “Захиалагч хуулийн 14.5-д заасны дагуу эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзана” гэж тус тус тусган баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.4.5-3. Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах /СЯ, 2017-2019/

“Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу Сангийн яам тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж байна.

Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах болон ямар албан тушаалтанд хариуцлага тооцуулах механизм бүрдээгүй байна. Захиалагч гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах үүрэг хүлээж, энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан, Зөрчлийн хуулийн заалтыг тодорхой болгох шаардлагатай байна. (Биелэлт 30 хувь)

**Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд нийт 17 үйл ажиллагаа, 34 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 2020 оны байдлаар тоймлон танилцуулбал:

4.1.5.1-1. Шүүгч, прокурорын сонгон шалгаруулалт, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан, дэвшүүлсэн, шагнаж урамшуулсан, чөлөөлсөн, хариуцлага тооцсон байдалд судалгаа хийж, дүнг олон нийтэд мэдээлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

2020 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 11 дүгээр тушаалаар 53, 123 дугаар тушаалаар 67 шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд, 2020 оны 32, 33, 34, 43, 47, 53, 57, 65, 130 дугаар тушаалаар анхан, давж заалдах болон хяналтын шатны 61, нийт 181 шүүгч, Ерөнхий шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлуулсан, МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар 58 шүүгчийн орон тоонд нөхөн бүрдүүлэлт хийгдсэн. Үүнээс 21 шүүгчийг адил шатны шүүхэд шилжүүлэн, 8 шүүгчийг дэвшүүлэн томилж, 16 шүүгчийг чөлөөлж, 1 шүүгчийг огцруулсан.

Шүүгчийг шагнаж урамшуулах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн зарлигаар Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 6, Алтан гадас одонгоор 21, Хөдөлмөрийн хүндэт медалиар 36 шүүгч, ажилтныг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 3877 дугаар тушаалаар “Хууль зүйн албан тэргүүний ажилтан” цол, тэмдэг, Жуух бичгээр 75, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 213 дугаар тогтоолоор “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр 2 шүүгч, ажилтныг тус тус шагнасан. Мөн 2020 оны Шүүхийн ерөнхий зөвлөлийн 79 дүгээр тогтоолоор 6 шүүгчийг “Шударга ёсны элч” тэмдгээр, даргын тушаалаар нийт 109 шүүгч, ажилтан, иргэнийг ШЕЗ-ийн “Хүндэт тэмдэг”, “Өргөмжлөл”-өөр шагнав.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүгчийг сонгон шалгаруулах, томилох процессийг дэлгэрэнгүй тодорхой болгож, шүүгчийг сонгон шалгаруулах процесс олон нийтэд нээлттэй, ил тод байхаар, мөн хуульчаас шүүгчийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн,

хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг нээлттэй сонгон шалгаруулж томилох процессийг тодорхой тусгаж өгсөн.

Энэхүү арга хэмжээний гол шалгуур үзүүлэлт нь шүүгч, прокурорыг томилох, сэлгэн ажиллгуулах, дэвшүүлэн томилох, огцруулах, шагнаж, урамшуулсанд байдалд дүн шинжилгээ хийсэн боловч олон нийтэд мэдээлэх талаар тодорхой ажил хийгдээгүй байна.

Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн тайланд дээрх арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой ямар арга хэмжээг хэрэгжүүлсэн нь тодорхойгүй, 2019 оны тайланд “Прокурорыг сонгон шалгаруулах журам”, “Прокурорыг албан тушаалд дэвшүүлэх, бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журам”, “Дээд шатны прокуророор ажиллах санал, хүсэлт гаргасан прокурорын мэдлэг, ур чадварыг үнэлж, дүгнэх журам”-ыг Прокурорын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна. (Биелэлт 70)

4.1.5.1-2. Шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах журам, шалгуурыг шинэчлэн боловсруулах, шүүгчийн хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр зарлигаар “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталж, энэхүү журмын дагуу шүүгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.

Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д шүүгчийн сонгон шалгаруулах журам, шалгуурыг өөрчлөн хуульчилсан бөгөөд энэхүү хуульд заасан шалгуурын хүрээнд дээрх “Шүүгчийн сонгон шалгаруулах журам”-ыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Прокурорын тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталсан ба хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Прокурорын мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг Улсын Ерөнхий прокурор батална.” гэж заасны дагуу журмын төслийг шинэчлэн

боловсруулж байна. (Биелэлт 70)

4.1.5.1-3. Шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг хуулиар тодорхой болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2019/

Монгол улсын Шүүхийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн төсөлд “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч хуульд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн нэр дэвшигчийг шүүгчээр томилохоос татгалзаж, энэ тухай Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ” гэж Ерөнхийлөгч шүүгчид нэр дэвшигчийг томилохоос татгалзах ганцхан үндэслэлийн тусгасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавиннэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно”, 15.2-т “Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийг судлан үзэж, түүнийг томилох буюу томилохоос татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 15.3-т “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно”, 15.4-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг гурван жилийн хугацаагаар томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно” зэрэг хуулийн зохицуулалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байна.

Шүүхийн тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүгчид нэр дэвшигч Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасан “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг

бусад шүүхийн шүүгчээр томилж болно.”, Шүүхийн тухай хуульд заасан “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй, шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлаагаатай байх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх, шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх” гэсэн шаардлагыг хангаагүй гэж үзвэл шүүгчээр томилох татгалзах эрхтэйг байхаар тусгасан.(Биелэлт 70)

4.1.5.1-4. Шүүгчид нөлөөлөх үйлдэл хийсэн, нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2021/

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцэж байна. Уг хуулийн төсөлд шүүгчийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах эрх зүйн орчныг баталгаажуулах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын Ерөнхий прокурор зэрэг албан тушаалтан нь шүүгчтэй албан ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд өгч байх, түүнчлэн Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор ийм шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Шүүхийн ерөнхий зөвлөл нэн даруй хуралдаж Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхээр уламжлуулан хүргүүлж, шийдвэрлүүлж байхаар хуульчлаад байна. Өөрөөр хэлбэл Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх процессийг тодорхой болгон тусгаад байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Журам, загвар шинэчлэн батлах тухай” тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ыг 1 дүгээр, “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”-ыг 2 дугаар,

“Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан загвар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлуулав.

2020 онд нийт 17 шүүгч, 2 шүүх бүрэлдэхүүнээс 9 нөлөөллийн мэдүүлэг, 1 шүүх бүрэлдэхүүнээс хэрэг хянан шийдвэрлэсэнтэй холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлд гомдол ирүүлсэн. Үүнээс:

- 4 нөлөөллийн мэдүүлгийн материалыг харьяалах Прокурорын газраас хянан үзэж, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн;
- 1 нөлөөллийн мэдүүлгийн материалыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс холбогдогч этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 1.000.000 /нэг сая төгрөг/-өөр торгох арга хэмжээг авсан;
- 2 нөлөөллийн мэдүүлгийн материалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн “нөлөөлсөн нөхцөл байдал тогтоогдоогүй” гэж шийдвэрлэсэн бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс холбогдох хариуг шүүгчид өгсөн;
- 3 нөлөөллийн мэдүүлэг болон нэг гомдлын материалыг холбогдох цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлсэн нөлөөллийн мэдүүлгийн материалыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх мэдээ мэдээллийг тухай бүр мэдүүлэг хөтлөгч нарт мэдэгдэн ажиллалаа.

2013-2020 оны байдлаар шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс нийт 52 нөлөөллийн мэдүүлгийг хөтөлж Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлсэн байна. (Биелэлт 70)

4.1.5.1-5. Шүүгч, прокурорын ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах, Ёс зүйн хорооны шийдвэр шүүхийн хяналтад байгааг өөрчлөх /ШЕЗ, УЕПГ, 2017-2020/

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүгчид хориглох зүйлийн нарийвчлан тусгасан байх ба энэхүү хориглолтууд нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ болж, зөрчсөн талаар гомдол, мэдээлэл ирвэл Сахилгын хороогоор шийдвэрлүүлэхээр заажээ. Энэхүү хуулийн төсөлд Шүүхийн сахилгын хороог байгуулах, сахилгын хэрэн хянан шийдвэрлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг нарийвчлан тогтоосон байх ба төсөлд Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны журам, Шүүгчид

холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл, “Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно” гэж тусгасан нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас шүүхэд давж заалдах эрхийг Шүүхийн сахилгын хороонд үлдээж, хяналтын гомдол гаргах эрхийг талуудад эдлүүлэхээр үлдээсэн зохицуулалт юм. Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүгчид хориглох зүйл, түүнийг зөрчсөн тохиолдолд Сахилгын хороогоор шийдвэрлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар зарлигаар “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус шинэчлэн баталж, прокурорын байгууллага үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын ерөнхий прокурорын 2019 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, Улсын ерөнхий прокуророос 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 07 дугаартай, Ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах тухай албан даалгаврыг гаргасан.

Прокурорын байгууллагаас 2020 онд дээрх дүрэм, журам, албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс суртахууны хэм хэмжээг танин мэдэх, хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “Монгол төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр цахим сургалт, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 07 дугаартай албан даалгаврын хүрээнд харьяа прокурорын газрууд дотооддоо нийт 19 удаа 24 цагийн сургалтад 138 прокурор, Дорноговь, Дундговь аймгийн прокурорын газрууд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 02 дугаартай зөвлөмжийн дагуу сургалт зохион байгуулсан.

Нийслэлийн прокурорын газраас иргэд болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос прокурорын ёс зүй, харилцааны талаар гаргасан гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг төвийн 6 дүүргийн прокурорын газарт шалгаж, Нийслэл, дүүргийн прокурорын газрын прокуроруудтай

хамтарсан Сахилга хариуцлагын зөвлөгөөнд дүнг танилцуулсан байна.

Баянзүрх дүүргийн прокурорын газар Хуульчдын өдрийн хүрээнд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан “Хуульчийн ёс зүй” сэдэвт нэвтрүүлэгт оролцож, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацсан.

2019 онд 11 прокурорын асуудлыг Прокурорын ёс зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 6 прокурорыг ёс зүй зөрчсөн гэж дүгнэж байсан бол 2020 онд Прокурорын ёс зүйн зөвлөл 2 удаа хуралдаж, 3 прокурорын ёс зүй зөрчсөн эсэх асуудлыг хэлэлцэн, гишүүдийн олонхийн саналаар хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэсэн дүгнэлтийг гаргасан. Улсын ерөнхий прокуророос Прокурорын ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн 1 прокурорт ажлаас халах сахилгын шийтгэл оногдуулжээ.

Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажлын алба 2020 онд иргэд, байгууллага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос гаргасан прокурорын ёс зүйтэй холбоотой 24 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 3 буюу 12.5 хувийг Прокурорын ёс зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн, 16 буюу 66.7 хувийг хүлээн авахаас татгалзсан, 5 буюу 20.8 хувийг прокурорын үндсэн хяналтын чиг үүрэгтэй холбоотой гэж үзэн харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна. Ажлын албаны хүлээн авч шалгасан прокурорын ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл өмнөх оноос 17 буюу 41.4 хувиар буурчээ.

Прокурорын ёс зүйтэй холбогдуулж гаргасан гомдлын 21 буюу 87.5 хувь нь прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад баримтлах ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаарх гомдол, 3 буюу 12.5 хувь нь хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн талаарх гомдлууд тус тус эзэлж байна. (Биелэлт 70)

4.1.5.1-6. Шүүх хуралдаанд нууцтай холбоотой асуудал хэлэлцэх хэсгийг хаалттайгаар бусад хэсгийг нээлттэй явуулахаар эрх зүйн орчинг бүрдүүлэх /ШЕЗ, ХЗДХЯ, 2018-2019/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 3.2 дугаар зүйл “Шүүх хуралдааныг нээлттэй явуулах”, 36.10 дугаар зүйл “Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох” зэрэг зохицуулалтыг тусгаснаар холбогдох эрх зүйн орчин бүрдсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 12

дугаар сарын 14-ний өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”-д 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, ажилтнууд урьдчилан хүсэлт гаргах шаардлагагүйгээр сурвалжилга бэлтгэх боломж бүрдсэн. Улмаар 2020 онд олон нийтийн анхаарал татсан, авлига албан тушаалын хэргийн шүүх хуралдааны явц, шүүхийн шийдвэрийг иргэд олон нийтэд цаг тухай бүрд нь шуухай мэдээлж ажилласан.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын шүүхийн төрийн болон албаны нууцыг хамгаалах журмаар шүүх хуралдааныг хаалттай явуулах асуудлыг нарийвчлан журамласан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.5.2-1. Ерөнхий шүүгчийг томилох шалгуур, журмыг шинэчлэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2017-2018/

“Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ын төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр зарлигаар батлуулан дагаж мөрдөж байна.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ерөнхий шүүгчийг томилох журмыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч 14 хоногийн дотор зургаан жилийн хугацаагаар, зөвхөн нэг удаа томилно.
- Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн зөвлөлөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар олонхийн саналаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.
- Олонхийн саналаар нууц санал хураалтаар сонгож чадаагүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг гурван жилийн хугацаагаар тухайн шүүхийн Зөвлөлөөс томилно.
- Ерөнхий шүүгчийг томилох шалгуурыг Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн зөвлөлөөс сонгохорор тусгасан. (Биелэлт 70 хувь)



4.1.5.3-1. Прокурор, шүүгчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг оруулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

Улсын ерөнхий прокуророос 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Улсын ерөнхий прокурорын газраас 2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө”-г батлан гхэрэгжүүлэв.

Прокурорын байгууллагын сургалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, прокурор, ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хувь хүнийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд зориулсан оновчтой, чанартай сургалтыг зохион байгуулах зорилгоор Улсын ерөнхий прокурорын 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар “Прокурорын байгууллагаас сургалтын талаар баримтлах үзэл баримтлал”-ыг шинээр, А/83 дугаар тушаалаар “Прокурорын байгууллагын сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн тус тус баталж, гаргалаа.

Сургалтын талаар баримтлах үзэл баримтлалд прокурор, прокурорын туслах ажилтнаар шинээр томилогдохын өмнөх заавал судлах, сонгон судлах сургалтын талаар тусгасан ба мөн прокурорын байгууллагын сургалтын төлөвлөгөөг хяналтын ажлын мэдээ, шалгалт судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, прокурор, ажилтны сургалтын эрэлт хэрэгцээ, ирүүлсэн санал зэрэгт үндэслэн жил бүр гарган, хэрэгжүүлж ажиллах талаар үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрт тус тус тусгасан.

Улсын ерөнхий прокурорын тушаалаар 2020 онд прокурорын байгууллагын хэмжээнд 38 прокурорын туслах ажилтан, 15 Тамгын хэлтсийн даргыг дэвшүүлж, холбогдох хуульд заасан шаардлага хангасан 16 иргэнийг, нийт 69 хүнийг шинээр прокуророор томилсон байна. (Биелэлт 100 хувь)

4.1.5.3-2. Шинээр томилогдсон шүүгч, прокурорт сургалтын хөтөлбөрийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр сургалтыг зохион байгуулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын тушаалаар Шинээр томилогдсон шүүгчдэд зориулсан сургалтыг Ашиг сонирхлын зөрчил,

анхаарах асуудал”, “Албан тушаалтны ХАСХОМ, анхаарах асуудал”, эрүүгийн хэргийн шүүгч нар “Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр 13 шүүгчийг хамруулан 2020 оны 05 дугаар сарын 26-29-ний өдөр танхимаар зохион байгуулав.

Улсын ерөнхий прокурорын тушаалаар 2020 онд прокурорын байгууллагын хэмжээнд 38 прокурорын туслах ажилтан, 15 Тамгын хэлтсийн даргыг дэвшүүлж, холбогдох хуульд заасан шаардлага хангасан 16 иргэнийг, нийт 69 хүнийг шинээр прокуророор томилсон байна. Шинээр томилогдсон прокуроруудад танхимаар болон цахим хэлбэрээр бусад байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж ажилласан. Тухайлбал, Монголын хуульчдын холбоотой хамтран 2020 оны 1 дүгээр улиралд “Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгах аргачлал”, Авлигатай тэмцэх газартай хамтран “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал” сэдвээр, мөн харьяа прокурорын газрууд дотооддоо шинээр томилогдсон прокуроруудыг сургаж, дадлагажуулах чиглэлээр сургалтыг тогтмол зохион байгуулсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.5.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах /АТГ, 2017-2021/

Авлига албан тушаалын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг судлан яамдын харьяа байгууллагууддаа тавих хяналт болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шат шатны удирдлагын хяналт сул, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, нийтээр дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг хангадаггүй, төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалт сул, хууль, журамд заасан шаардлагын хэмжээнд хяналт тавьдаггүй, мөн хүний нөөцийн томилгоо хууль, тогтоомжид нийцээгүй, сул орон тоог нээлттэй зарладаггүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилладаггүй, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага хангаагүй мэргэжлийн бус хүнийг ажлын байранд томилдог зэрэг нийтлэг зөрчлүүд тогтоогдсон тул гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 2020 онд эрх бүхий албан тушаалтанд мөрдөгчийн мэдэгдэл 103, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулахаар 43 албан бичгийг хүргүүлэн, 18

мэдэгдэл, албан бичгийн мөрөөр нөхцөл байдал арилсан эсэхийг шалгахгаар газар дээр нь ажиллав.

2020 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 114 эрүүгийн хэргийн 81 эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолын хуулбарыг шүүх, прокурорын байгууллагаас хуулбарлан авч сан бүрдүүлэн, дүн шинжилгээ хийж байна.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг саналыг Засгийн газарт хүргүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр мөрдөн шалгах ажлын шуурхай байдалд тодорхой ахиц гарсан. Тухайлбал мөрдөн шалгах албаны дарга гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл шалгах хугацааг 14 хүртэл хоногоор сунгах, мөрдөгч нар төрийн болон иргэний хувийн захидал харилцаа, эрүүл мэндийн нууцаас бусад мэдээллийг бие даан иргэд байгууллагаас авдаг болсон.

2011-2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл”-ийг хэвлүүлэн олон нийтэд түгээв. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой. (Биелэлт 70 хувь)

4.1.5.4-2. Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх /Real name financial Transaction act/ эрх зүйн орчинг бий болгох /СЗХ, 2017-2018/

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь санхүүгийн аливаа ажил үйлчилгээг жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх талаар заалт оруулсан. Ингэснээр эх үүсвэр нь тодорхойгүй мөнгийг санхүүгийн салбараар дамжуулах, мөнгө угаах эрсдэлээс хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болгоно.

УИХ-аас 2020 оны нэгдүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулснаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн

үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулсан бөгөөд зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Уг хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо гуравдугаар сарын 25-нд «Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг баталж, холбогдох ажлыг хэрэгжүүлж эхэлснээр одоогийн байдлаарул хөдлөх хөрөнгө зуучлалын тусгай зөвшөөрлийг 142 хуулийн этгээд, үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 19 хуулийн этгээд, 379 иргэнд олгоод байна.

Төсвийн байгууллага нь Төрийн сангаас өгсөн нэр, нууц үгийг ашиглан Сангийн яамны цахим хуудаснаас онлайн хуулга, тайланг авч өөрийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлтэй тулган өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна. Төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд хяналт тавих, зарлагын гүйлгээ хийх эрхийг хоёр гарын үсэгтэйгээр баталгаажуулах ба 1 дүгээр гарын үсгийг хууль болон төсвийн ерөнхийлөн захирагчийн тушаалаар эрх олгосон албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн хуульд заасны дагуу төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогч нар зурж төлбөрийн гүйлгээг тухай бүр хийж байна. Зарлагын гүйгээг хийхдээ Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу Төлбөрийн хүсэлтээр хийж баталгаажуулдаг.Төлбөрийн хүсэлтэд төлбөрийн хүсэлтийн дугаар, огноо, төсвийн байгууллагын бүртгэлийн дансны дугаар, албан ёсны нэр, улсын бүртгэлийн регистрийн дугаар, төлбөр хүлээн авагчийн улсын бүртгэлийн регистрийн дугаар,төлбөр хүлээн авагчийн нэр болон дансны дугаар, төлбөр хүлээн авагчийн банк, төлбөрийн нийт хэмжээ тоогоор болон үсгээр, төлбөрийн нийт дүн, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын нэр, код болон үнийн дүнгийн задаргаа, гүйлгээний утга, хяналтын хуудасыг бүрэн үнэн зөв бөглөж баталгаажуулсны дараа зарлагын гүйлгээг хийж тайлан бүртгэлд тусгадаг. Мөн гүйлгээ хийхэд үндэслэх баримтуудад урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, баталгаажуулсан цалингийн жагсаалт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны

шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримтыг бүрдүүлэн санхүүгийн гүйлгээг Төрийн сангаар хийлгэж тайлан бүртгэлд тусгаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.5-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, төрийн албан хаагчийн ёс зүй, хүнд сурталтай төрийн үйлчилгээтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах 110 тусгай дугаарыг /үнэ төлбөргүй/ 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс ажиллуулж эхэлснээс хойш нийт 17125 удаагийн дуудлага ирүүлснийг бүртгэн хяналт тавьж, байгууллагын хэмжээнд 2020 онд нийт 2282 гомдол мэдээлэл хүлээн авснаас 110 тусгай дугаарын утсаар нийт 317 гомдол, мэдээллийг хуулийн дагуу хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Тусгай дугаарын утсыг зорилтот бүлгүүдэд сурталчилсан видео контент, зурагт хуудас, сурталчилгааны материалыг тогтмол түгээн ажилласнаар иргэдийн АТГ-т хандах хандалт эрс нэмэгдэж, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шүгэл үлээх соёл нэмэгдэж байна.

110 тусгай дугаарас гадна Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, факс, шуудангаар, биечлэн уулзаж гомдол мэдээлэл хүлээн авахын зэрэгцээ АТГ-Олон нийтийн пэйж хуудсанд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг бүртгэж авч, хяналт тавьж ажиллаж байна.

Мөн Авлигатай тэмцэх газраас яам агентлагт авлигын эсрэг булан, мэдээллийн самбарыг байршуулан, санал хүсэлтийг хайрцагаар санал хүсэлт, мэдээлэл хүлээн авч байна.

Авлигын талаар гомдол, мэдээлэл өгч байгаа иргэний урамшуулах тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Мэдээлэгч (Шүгэл үлээгч)-ийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.5-2. Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2021/

Авлигатай тэмцэх газраас Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргад хүргүүлэв. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй холбогдуулан бий болсон орлого, буруутай этгээдээр төлүүлсэн хохирол, урьдчилан сэргийлсэн нөхцөл байдал, хууль зүйн үр дагаврыг харгалзан мөнгөн шагнал, урамшууллын мөнгийг хэрхэн тооцож олгох, эдгээрийн хоорондын ялгаа, баримтлах мөнгөний хэмжээг тодорхой тусгасан. Авлигатай тэмцэх газраас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвд захиалан хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг үнэлгээг хийлгүүлсэн болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгож, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батлахаар тусгасан ба Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэв. Журмын төсөлд төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, албан тушаалтны ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, энэхүү үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгохоор тусгаж, хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, зарчим, хамрах хүрээ, зохион байгуулалт, санхүүжилт, арга хэлбэрийг тодорхойллоо. Энэхүү журмын төслийг боловсруулахдаа байнгын үйл ажиллагаатай, орон тооны хяналтын чиг үүрэг бүхий бүтцийг бий болгохоос татгалзаж, төрийн байгууллага тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх олон нийтийн хяналтын чиглэлийг тодорхойлдог, сонгон шалгаруулалт зарлан уг ажлыг зохион байгуулдаг, үр дүнг ашиглан өөрийн байгууллага, албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй шалтгаан нөхцөлийг тодорхойлох, арилгахад чиглэсэн арга хэмжээ авдаг хэлбэрт шилжих нь зүйтэй гэсэн үзэл баримтлалыг баримтлав.

Журмын зорилго нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, албан тушаалтны ёс зүй, сахилга, хариуцлагыг

нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, энэхүү үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоход орших юм. Мөн хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, бүх шатны Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллага, төрийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг олон нийтийн хяналтад хамруулахаар журамлалаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна” гэсэн хуулийн заалтыг үндэслэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулах зорилгоор “Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан, холбогдох судалгааг хийж, төсөлд 22 салбар зөвлөлөөс санал авсан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.6-1. Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2019/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, УИХ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, даган гарах хуулиуд болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулж, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газраас санал авч, тусган Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн. Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2-т заасан бүрдүүлбэрт хамаарах Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ,

хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр гүйцэтгүүлэн тайланг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлэв. (Биелэлт 70 хувь)

4.1.5.6-2. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт нэг өдрийн сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Сургалтаар Монгол улс дахь хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, сэтгүүлчийн аюулгүй байдлын өнөөгийн түвшний тухай судалгаанд тулгуурласан мэдээллийг танилцуулж эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсэн ойлголт, ёс зүй, олон улсын чиг хандлага, хуурамч мэдээллийг таних арга, алхмууд, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр дүнгийн талаар мэдээлэл өгсөн. Сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газрын 57 гаруй албан хаагч хамрагдав.

Авлигын болон бусад төрлийн гэмт хэргийг эрэн сурвалжлах, хууль зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, сэтгүүлчидтэй нягт хамтран ажиллах арга замыг нээх зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Олон нийтийн төв”-д “Авлига ба эрэн сурвалжлах сэтгүүлчид” сэдэвт бүтэн өдрийн сургалтыг зохион байгуулж, сургалтад оролцогчдоос сургалтын үнэлгээний хуудсаар авсан саналын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. Хэвлэл мэдээлэл нь иргэний нийгмийн нэг хэсэг болохын хувьд хяналт тавих, мэдээлэх чиг үүргээрээ дамжуулан авлигыг эсэргүүцэх хүчтэй салбар юм. Ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь авлигын хэргийг илрүүлэх, уг хэргийг олон нийтийн анхаарлын төвд оруулахад голлох үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүлчдийг жил бүр авлига, ашиг сонирхлын талаар сургалтад хамруулан тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх нь онцгой ач холбогдолтой. (Биелэлт 100 хувь)

4.1.4.6-3. Сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар судалгаа, хяналт мониторинг хийх /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2020/

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2018 онд

эхлүүлсэн сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх цогц судалгааг Глоб интернэшнл төвтэй хамтран зохион байгуулж, судалгааны дүнг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр олон нийтэд мэдээлж, судалгааны тайланг нэгтгэн, судалгаанаас 3 зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон Улсын Их Хуралд хүргүүлсэн байна. /[http://resource4.sodonsolution.org/mediacouncil/File/2021/01/25/v02syozco4zucrvp/Setguulchdiin\\_ayulgui\\_baidliig-hangah\\_erh\\_zuin\\_zohitsuulalt-Tailan\\_2019-MNG.pdf/](http://resource4.sodonsolution.org/mediacouncil/File/2021/01/25/v02syozco4zucrvp/Setguulchdiin_ayulgui_baidliig-hangah_erh_zuin_zohitsuulalt-Tailan_2019-MNG.pdf/) (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.7-1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах/АТГ, 2017-2022/

Хүний нөөцийг чадавхижуулах, хандлага төлөвшүүлэх, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлын хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, мэргэшүүлэх давтан сургалтад 5, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3, нийт 12 албан хаагчийг, худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох буюу худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад нэр бүхий 16 албан хаагчийг, АНУ-д англи хэлний сургалтад 3 албан хаагчийг тус тус суралцуулав.

2020 оны 9 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулсан Орос хэл өргөн хэрэглэдэг орнуудад зориулсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад 4, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд “Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад 22 албан хаагчийг суралцуулав. Тус хорооноос 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Олон улсын авлигын эсрэг салбарын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт”-д Авлигатай тэмцэх газрын 6 албан хаагчийг хамруулав.

2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол Улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монгол банкны холбогдох алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Тус сургалтад нийт 29 албан хаагч хамрагдснаас тус байгууллагын МШХ, ГАХ-ийн 8 мөрдөгчийг,

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачмлга СтАР /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад шинээр албан тушаалд томилогдсон 30 мөрдөгч, ахисан түвшний сургалтад 4 дүгээр сард 2 удаа, 5 дугаар сард 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан бөгөөд 9 албан хаагчийг хамруулав.

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачлага СтАР /StAR/-аас МШХ, ГАХ-ийн нийт мөрдөгчдөд зориулан “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 9 дүгээр сарын 30-ны өдөр, 10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд зохион байгуулсан Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалтад АТГ, УЕПГ, ЦЕГ-ын 18 албан хаагчийг хамруулсан. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.5.7-2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох /АТГ, 2017-2019/

Авлигад нөлөөлж байгаа хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн албаны тогтвортой байдал, иргэдийн орлого, шүүхийн хараат бус байдал, сонгууль, улс төрийн намын санхүүжилтэд дүн шинжилгээ, авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн авлигын эсрэг дагнасан шүүх байгуулах, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, УИХ-ын гишүүдийн тангарагт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг тусгах, авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх, иргэд, олон нийтийн анхаарал татсан зарим хэргүүдийг тодорхой хэмжээгээр мэдээлдэг байх, мэдээлэгчийг хамгаалах, олон нийтийн зөвлөлийн гишүүдийн болон шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, Авлигатай тэмцэх газрын салбар, нэгжийг орон нутагт байгуулах, хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэв.

2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн санал тусгагдаж “Монгол Улсын Их Хурлын гишүүний тангарагт “...авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая...” гэсэн заалт, 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-иар мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дээрх агуулга бүхий 2, 3 дахь

өгүүлбэр нэмэлтээр орсон.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн тандан судалгаа, зардлын тооцоо, төслийн үзэл баримтлал, танилцуулга боловсруулах ажлыг хариуцан зохион байгуулж, хууль санаачлагчид уламжлаад байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн тандан судалгаа, зардлын тооцоо, төслийн үзэл баримтлал, танилцуулга боловсруулах ажлыг хариуцан зохион байгуулж, хуулийн төслийг дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамт хууль санаачлагчид уламжилсан.

Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/, төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ХАСХОМ гаргах албан тушаалтны хамрах хүрээг оновчтой тогтоох, ХАСХОМ-ийн маягыг боловсронгуй болгох зорилгоор УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.7-3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санг бий болгож, хөгжүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг олон арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэн, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэлээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдэх үе шат 2019 онд дууссантай

холбогдуулан хэрэгжүүлэгч байгууллагуудаас тайлан, мэдээг цахимаар авч, авч, нэгтгэн, үнэлгээ хийв. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг дэх үе шатанд 205 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 192 арга хэмжээ зохих хэмжээнд хэрэгжиж, гүйцэтгэл 58,8 хувьтай гэж дүгнэгдсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэг дэх үе шатны тайланг олон нийтэд түгээж, байгууллагын цахим хуудсанд байршууллаа. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдэх үе шатны хэрэгжилтэд “Иргэний нээлттэй боловсрол” ТББ-аар хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгүүлэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн нэгдсэн цахим сангийн програм хангамжийг хөгжүүлэх чиглэлээр “Ухаалаг Засаг” ТББ-тай хамтран ажиллаж, Авлигын эсрэг нэгдсэн сүлжээ болгон өргөжүүлэн, 4 дэд санг хөгжүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.8-1. Гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг ашиглах талаар сургалт явуулах /АТГ, 2017-2022/

2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улсад суугаа АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монгол банкны 29 алба хаагчдыг, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга СтАР /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад АТГ-т шинээр албан тушаалд томилогдсон 30 мөрдөгч, ахисан түвшний 3 удаагийн цахим сургалтад 9 албан хаагчийг, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилаа СтАР /StAR/-аас “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалтад АТГ, УЕПГ, ЦЕГ-ийн 18 албан хаагчийг тус тус хамруулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.9-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санг бий болгох /АТГ, ХЗДХЯ 2018-2019/

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 оны 05 дугаар сарын

15-ны өдрөөс эхлүүлсэн. Нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн олон нийтэд зориулсан “e-justice.mn” портал, цахим хуудсыг 2018 оны 6 сарын 15-ны өдөр албан ёсоор нээж, туршилтын журмаар ажиллуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/134 дүгээр тушаалын дагуу Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг Прокурорын байгууллага хариуцан ажиллаж байна.

Мөрдөн шалгах ажиллагаа болон прокурор, шүүхийн байгууллагуудын дунд “гэмт хэргийн цахим сан”-тай болсон бөгөөд энэхүү цахим мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох ажил тогтмол хийгдэж байна.

Улсын Ерөнхий Прокурорын Газраас авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл нэгдсэн санд бүрэн бүртгэгдэж, бүртгэсэн мэдээллийг хайлтаар шүүж үзэх боломжтой болсон. (Биелэлт 70 хувь)

4.1.5.9-2. Мэдээллийн санд олон нийттэй харилцах цэс үүсгэж, хамрах хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэх /АТГ, 2017-2020/

АТГ ирсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн тоон үзүүлэлтийг тус газрын цахим хуудсаар олон нийтэд тогтмол мэдээлж байна.

Прокурорын байгууллагын хариуцан ажиллаж байгаа шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд иргэний портал үүсгэх, олон нийтэд нээлттэй байлгах боломжийн талаар хамтран ажиллах байгууллагуудтай яриа хэлэлцээр хийсэн. Авлигатай тэмцэх газраас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн цахим мэдээллийн сан”-г хөгжүүлэлтийг хийж, олон мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.10-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэрийг сайжруулах /ШЕЗ, 2017-2022/

Монгол Улсын шүүхийн цахим сан буюу www.shuukh.mn сайтад төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг бүрэн

эхээр байршуулан, иргэд, олон нийтэд мэдээлдэг. Дээрх цахим хуудсыг 2011 оноос хойш технологийн шинэчлэл хийгдээгүй байсныг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр шинэчилснээр иргэд, олон нийт тухайн цахим хуудсаар шүүхийн шийдвэрт хайлт хийхэд хэргүүдийг Эрүүгийн хуулийн бүлэг тус бүрээр нь ангилсан нь хялбар болсон. Мөн эрүү, иргэн, захиргааны шүүхийн нэгдсэн системтэй холбогдсоноор шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг бууруулсан. 2020 онд авлигын 74 шүүхийн шийдвэрийг нэмж байршуулсан байна. 2020 оны байдлаар тус цахим санд эрүү, иргэн, захиргааны хэргийн 377,212 шийдвэр хадгалагдаж байгаа бөгөөд 2020 онд шүүхийн цахим санд 1656536 удаагийн хандалт хийсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/44 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-ыг баталж, журмаар иргэн, хуулийн этгээд интернэтийн сүлжээ ашиглан цахим сангаас шүүхийн шийдвэрийн мэдээлэл болон тогтоох хэсгийг үзэх, бүрэн эхээр нь татаж авах харилцааг зохицуулсан байна.

Шүүх, шүүхийн захиргааны онцлох үйл явдал, шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон олны анхаарал татсан хэргийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулдаг. Тус хэвлэлийн бага хурлаар олон нийтийн анхаарал татсан, авлига албан тушаалын хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн дүн мэдээг танилцуулж хэвшээд байна. “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг 2020 онд 8 удаа зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 255 хэвлэл мэдээллийн байгууллага, 293 сэтгүүлч сурвалжилж олон нийтэд хүргэлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”-д 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулснаар хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, ажилтнууд урьдчилан хүсэлт гаргах шаардлагагүйгээр сурвалжилга бэлтгэх боломж бүрдсэн. Улмаар 2020 онд олон нийтийн анхаарал татсан, авлига албан тушаалын хэргийн шүүх хуралдааны явц, шүүхийн шийдвэрийг иргэд олон нийтэд цаг тухай бүрд нь шуурхай хүргэж ажилласан. (Биелэлт 70 хувь)

4.1.5.10-2. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд мэдээлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

Шүүн таслах ажлын болон шүүхийн захиргааны мэдээ мэдээллийг “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч” сургалтад хамрагдсан сэтгүүлчдээр дамжуулан олон нийтэд үнэ төлбөргүй түгээж байгаа нь олон нийтэд үнэн бодит мэдээлэл хүрэх ач холбогдолтой хамтын ажиллагаа болж байна.

Хэвлэл мэдээллийн мониторингоос үзэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрч байгаа шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийн 96 хувь нь шүүхээс албан ёсны эх сурвалжтай байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүн таслах ажлын дүн мэдээг хагас, бүтэн жилээр жилд 2 удаа олон нийтэд мэдээлж хэвшсэн, мөн “www.judcouncil.mn” цахим хаягт байршуулсан. 2020 оны байдлаар авлигын хэргийг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээс харж болно. (Биелэлт 70 хувь)

4.1.5.11-1. Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг үүсгэн, сургалтад ашиглах /АТГ, ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

Авлигын гэмт хэргийг шүүхэд шийдвэрлэсэн байдал: Монгол Улсын хэмжээнд 2020 онд Эрүүгийн хууль /2002 он/-ийн Хорин наймдугаар бүлэг Албан тушаалын гэмт хэрэг, Эрүүгийн хууль /2015 он/-ийн шинэчилсэн найруулгын Хорин хоёр дугаар бүлэгт заасан 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж 236 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шилуүүлснээс 116 гэмт хэрэгт холбогдсон 234 хүнд ял шийтгэл ногдуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Авлигын гэмт хэргийг цагаатгасан тоон мэдээнд хуульд заасны дагуу цагаатгасан болон гэмт хэрэг нотлогдохгүй байх, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй зэрэг үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон мөн Өршөөлийн хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн зэрэг байдлаар ял шийтгэл оногдуулаагүй хүний тоог нийтэд нь хамааруулсан болно.

Улсын Ерөнхий Прокурорын Газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсээс 2020 онд Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэгдсэн хэргүүдэд хяналт шинжилгээ хийж, эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах,

хахууль авах гэмт хэрэгт Эрүүгийн хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэгжүүлэх талаар 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжийг, гэмт хэргийн тусгай субъектын нийтлэг шинж, тухайлбал Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21, 22, 23, 28 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн тусгай субъектын онцлог, хэн хамаарах, хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал, авлига өгөх гэмт хэргээ илчлэн ирэх гэмт хэрэгт Эрүүгийн хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэгжүүлэх талаар 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5/07 дугаартай зөвлөмжийг тус тус харьяа прокурорын газруудад хүргүүлсэн.

Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсээс Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирол төлөгдөөгүй шалтгаан нөхцөл, төлөгдөөгүй хохирлыг иргэний журмаар нэхэмжлэх боломжтой эсэхийг 2019 он, 2020 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн прокурорын газруудын хэрэгсэхгүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тогтоол, шүүхийн тогтоол, магадлалын хэмжээнд судалж, анхаарах асуудлаар 5/71 дугаартай мэдээлэл бичиж, харьяа прокурорын газруудад хүргүүлсэн байна. Судалгааны мөрөөр төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирол төлөгдөөгүй 14 хэрэгт нэхэмжлэл гаргуулах, түүнчлэн 18 хэрэгт авагдсан нотлох баримтуудад үндэслэн холбогдох ажиллагааг явуулж, прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой эсэх талаар дүгнэлт хийлгүүлэхээр харьяа прокурорын газарт албан бичгээр үүрэг өгч, гэмт хэргийн шинжтэй хэргийг тус прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст хянуулахаар тус тус шийдвэрлэсэн. Мөн төрийн байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах, шаардлагатай тохиолдолд төрд учирсан хохирлыг нэхэмжлэхэд өмгөөлөгчийн байр сууринаас, эрх зүйн туслалцаа үзүүлж хамтран оролцох талаар сурталчлан таниулах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн.

Судалгааны дүнгээс үзэхэд прокурор төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах боломжтой, өөрөөр хэлбэл гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон ч хэрэгт авагдсан баримтаар гэрээ хэлцэл, үүргийн гүйцэтгэл, тендер, сонгон шалгаруулалт зэрэг иргэний маргаанд Иргэний хуулийн тохирох зүйл заалтыг баримтлан нэхэмжлэл гаргах, эсхүл төрийн байгууллагаар нэхэмжлэл гаргуулах, хийж гүйцэтгэсэн ажил, худалдан авсан бараа бүтээгдэхүүний чанарт



дүгнэлт хийн, Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт зааснаар иргэн байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай нотлох баримт болон мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагаа явуулж, иргэний журмаар нэхэмжлэх эсэхийг тодорхойлж төрийн байгууллагуудтай хамтран ажиллах боломж байна гэж дүгнэсэн.

Улсын ерөнхий прокурорын газраас эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалт, судалгаа, хяналт шинжилгээний мөрөөр харьяа прокурорын газрын прокуроруудад зориулан гаргасан мэдээлэл, зөвлөмж, ажлын чиглэл зэрэг баримт бичгийг pdf файл болгон байгууллагын дотоод сүлжээнд байршуулан, прокурор, ажилтанд гарын авлага болгон ашиглуулж байна.

АТГ-аас “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл”-ийн 2011-2018 оны шүүхийн шийдвэрийн эмхтгэлийн бэлтгэн хэвлүүлэн олон нийтэд түгээв. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой.

АТГ 2020 онд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх онтой харьцуулбал 2.4 хувийн өсөлттэй байна.

2020 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 12,133,529,9 /арван хоёр их наяд, нэг зуун гучин гурван тэрбум таван зуун хорин есөн/ сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 35,640,6 /гучин таван тэрбум зургаан зуун дөчин/сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 10,112,736,4 /арван их наяд нэг зуун арван хоёр тэрбум долоон зуун гучин зургаан /сая төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор 16 төрлийн гарын авлага, эмхэтгэл хэвлүүлэн иргэд, багш, оюутан судлаачдын хүртээл болгоод байна. Мөн авлигын

гэмт хэргийн бодит жишээн дээр тулгуурласан цуврал видео контентуудыг бэлтгэн олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж байна.

Азийн хөгжлийн банкнаас Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх техникийн туслалцаа төслийн /2019-2021/ гүйцэтгэгч байгууллагаар Авлигатай тэмцэх газар, хэрэгжүүлэгч байгууллагаар Улсын Ерөнхий Прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл сонгодон уг төсөл 2018 оны 12 дугаар сараас хэрэжиж эхэлсэн. Уг төсөл нь авлигын гэмт хэрэг шийдвэрлэлтийн урсгалд дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх, албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх, гарын авлага боловсруулах, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн төсөл, авах арга хэмжээний зөвлөмж боловсруулж Монгол Улсын Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх зорилготой болно. (Биелэлт 70)

4.1.5.11-2. Олон улсын байгууллага, гадаад орноос багш, мэргэжилтэн урьж сургалт зохион байгуулах /АТГ, 2017-2019/

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга “СтАР” /StAR/-аас “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт сургалтад АТГ-т шинээр албан тушаалд томилогдсон 30 мөрдөгч, ахисан түвшний сургалтыг 4 дүгээр сарын 15-22, 23-30-ны өдрүүдэд, 5 дугаар сарын 7-14-ний өдрүүдэд 3 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж 9 албан хаагчийг мэргэшүүлэв.

Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга СтАР /StAR/-аас “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 9, 10 дугаар сард зохион байгуулсан Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний сургалтад АТГ, УЕПГ, ЦЕГ-ийн 18 албан хаагчийг хамруулсан.

2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран Монгол улсад “ФАТФ”-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг зохион байгуулж АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монголбанк зэрэг байгууллагын 29 албан хаагчдыг чадавхжуулсан. (Биелэлт 100 хувь)

4.1.5.12-1. Сургуулиудын давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгуулах /АТГ, ХЗДХЯ, 2017-2018/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний болон онцгой байдлын байгууллагын тасгийн дарга буюу түүнтэй адилтгах албан тушаалтны нөөцөд авагдсан албан хаагчдад “Албан тушаалын дамжаа”-г хичээллүүлж байна. Энэхүү “Албан тушаалын дамжаа”-ны хөтөлбөрт “Авлигатай тэмцэхэд төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлага” сэдэвт 4 цагийн сургалтыг оруулахаар хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан. “Албан тушаалын дамжаа”, Удирдах ажилтны давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар сургалтыг оруулж хэвшсэн.

Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын сургалтад “Авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “Албан тушаалын гэмт хэргийн криминологи шинж”, “Албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх арга зүй”, “Албан тушаалын гэмт хэргийн нотолгооны онол, арга зүй” гэсэн бүлэг сэдвүүдийг сургалтын хөтөлбөрт тусган мөрдөж байна.

Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2014 оны “Нийтлэг шаардлага батлах тухай” А/174 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий суурь “Нийгмийн ухаан” хичээлийн чиглэлд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах” арга хэмжээг Монголын Их, дээд сургуулийн консерциумын гишүүн сургуулиудын хэмжээнд тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхээр холбогдох төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

АТГ-аас зохион байгуулж их, дээд болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл хандлагыг хэрхэн тусгасан талаар судалгааны ажлыг хийлгүүлсэн. Эрх зүйч бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт авлигын гэмт хэргийн талаар хэрхэн тусгасан талаарх судалгаа хийж дүн шинжилгээ хийсэн.

“Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв туссан байдалд дүн шинжилгээ хийх” үйл ажиллагааг хэрэгжүүлж “Шүтэлцэт Оюу” ТББ-ын боловсролын салбарын шинжээч, судлаачидтай хамтран хичээл, сургалтын хөтөлбөрт дүн

шинжилгээ хийлгүүлэх ажлыг зохион байгуулж, шинжилгээний дүгнэлтийн дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан санал дүгнэлтийг нэтгэн Боловсрол, шинжлэх ухааны сайдад зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжөөр Боловсролын салбарт бүх түвшиний сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд нийтийн алба, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, мэдлэгийг түгээх, авлигаас ангид байх заан үйлийг дадал хэвшил болгох хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлэх, сургалтын байгууллагуудад тавигдах стандарт шаардлага, магадлан итгэмжлэлийн сонгон шалгаруулалт, тэдгээрийн хариуцлага, урамшуулалын үзүүлэлтэд авлигаас ангид байх, шударга ёсны зарчимд нийцсэн шалгуурыг тусгах талаар зөвлөлөө. (Биелэлт 70 хувь)

4.1.5.13. Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх

Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, гаргах үүрэг бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэх чиглэлээр холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр бэлтгэж байна. Мэдүүлэг гаргах албан тушаалтны хүрээг тодорхойлоход тухайн албан тушаалын авлигад өртөх эрсдлийг үндэслэл болгохоос гадна хуулиар тогтоосон хэрэгжүүлэх чиг үүрэг, албан тушаалын ангилал зэрэглэл зэргийг баримталж харгалздаг. *Тухайлбал*, 2020 онд АТГ-т ирүүлсэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мэдүүлэг гаргагчдын тоо 4469 буюу 51.4 хувиар өссөн, мөн хянаж хариу хүргүүлсэн тоо 4403 буюу 51 хувиар тус тус өссөн нь 2020 онд зохион байгуулагдсан Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуультай холбоотойгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж шилжилт, хөдөлгөөн хийгдсэнтэй холбоотой гэж дүгнэхээр байна.

Мөн 2020 онд Засгийн бүтцэд өөрчлөлт орж, Соёлын яам болон Жижиг, дунд үйлдвэрийн газар, Усны газар, Биеийн тамир спортын хороо, Үндэсний геологийн алба, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар зэрэг байгууллагууд шинэчлэн байгуулагдаж, зарим албан тушаалтнуудыг ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнийг төсөлд тусгасан бөгөөд цаашид ХАСХОМ гаргасан мэдүүлэг гаргагчдын тоон үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байх тул төрийн

үйлчилгээний болон төрийн тусгай албаны төсөв хөрөнгө захиран зарцуулах, ажилтныг томилох, чөлөөлөх, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, зөвшөөрөл олгох зэрэг талаарх судалгааг АТГ-тай шууд харилцдаг 118 байгууллага, түүний харьяа 1700 гаруй салбар нэгжийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудаас гаргуулж саналыг нэгтгэн боловсруулсан болно. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.14-1. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягыг боловсронгуй болгох /АТГ, 2017/

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам", "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт", "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт", "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт", "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт", "Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт"-ыг шинэчлэн боловсруулж, маягыг нөхөх зааврын төслийг боловсруулав. Төсөлд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудаас саналыг авч тусгаж, төслийг эцэслэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлахад бэлэн болгоод байна. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.14-2. Мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжих /АТГ, 2017-2022/.

Мэдүүлгийг цахим системд гаргуулах болон мэдүүлгийн хяналт шалгалтыг уг системийг ашиглан шуурхай үр дүнтэй явуулах нөхцлийг бүрдүүлсэн. Үүнд:

- Албан тушаалтны сүүлийн 5 жилийн ХАСХОМ-ийг хянахад ашигладаг мэдүүлгийн хяналт шалгалтын харьцуулалтын хүснэгтийг боловсруулж, улмаар сайжруулан үйл ажиллагаандаа ашиглаж хэвшүүлсэн нь гар ажиллагааг багасгаж, хяналт шалгалтын чанарыг дээшлүүлэх ач холбогдолтой болсон, Мэдүүлгийн хяналт шалгалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх үүднээс мэдүүлгийн цахим мэдээллийн сангаас орлого, хөрөнгийн өсөлтийн харьцаа алдагдсан, үнэн зөв мэдүүлээгүй байж болзошгүй мэдүүлгүүдийг хүний

оролцоогүйгээр сонгох техникийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Улсын бүртгэлийн эд хөрөнгийн, хуулийн этгээдийн, иргэний, гэр бүлийн, тээврийн хэрэгслийн, үнэт цаасны зэргээр нийт мэдээллийн 80 хувийг авч ашиглаж байгаа ба ингэснээр албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгах хугацаа богиносож, хяналт шалгалтын тоо, үр дүн дээшилсэн. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа, ХАСХОМ-ийн үнэн бодит байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Татварын болон Нийгмийн даатгалын байгууллага, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажилласнаар Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Татварын ерөнхий хуулийг зөрчсөн нийт 31.952.156.613 төгрөгийн зөрчил илэрч, 801.596.630 төгрөгийн нөхөн ногдуулалтын акт тавигдсан байна. Мөн давхар ажил эрхлэлтийн байдлыг хянах, хууль тогтоомж зөрчих асуудлыг судлан тогтоох үйл ажиллагааны хүрээнд 8 яамны 1151 албан тушаалтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгаж, Барилга, хот байгуулалтын яамны 4, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, Батлан хамгаалах яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх, энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэв.

- 2020 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 13151 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 13030 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэсэн байх ба хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан 848, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 489 мэдүүлгийг буцаан хүргүүлж, 8 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн байна. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бүртгэх, хянах үйл ажиллагааг цахимжуулж, улмаар нийт байгууллагын 90 гаруй хувь нь мэдүүлгээ цахимаар гаргаж байгаа нь шалгалтын үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах, мэдээллийг нэг дороос бүрэн авч хянахаас гадна мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл

ажиллагааг хөнгөвчлөх, цаг хугацаа хэмнэсэн үйл ажиллагаа болсон байна.

Түүнчлэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болох ажлын хүрээнд мэдүүлэг гаргагч болон тухайн байгууллагын ЭБАТ-д ХАСУМ-ийг хяналтын явцыг харуулах боломжийг системд бүрдүүлсэн. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.15-1. Хууль бус нөлөөллийн хэлбэрийг оновчтой тодорхойлох /АТГ, 2017-2019/

Хууль бус нөлөөллийн хэлбэрийг тодорхойлох, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг судлах, мэдүүлгийн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох үйл ажиллагааг оновчтой тодорхойлох зорилгоор эрх бүхий албан тушаалтнуудын дунд судалгаа зохион байгуулж, 737 эрх бүхий албан тушаалтан хамрагдсан байна.

Судалгааны дүнгээс харахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-т заасан “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ” гэсэн зохицуулалт, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан “мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй” гэсэн хуулийн зохицуулалтыг мөрдөхгүй байх, УИХ-ын ХЗБХ-ны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 заасан нэмэгдлийг олгохгүй байх, олгохоос татгалзах зэргээр ЭБАТ-ын үйл ажиллагаанд нөлөөлөх хэлбэрийг тодорхойлов. Цаашид хуулийн холбогдох зохицуулалтыг мөрдөхгүй байгаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд ногдуулах хариуцлагын асуудлыг тодорхой болгох талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Журам, загвар шинэчлэн батлах тухай” тогтоолоор “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ыг 1 дүгээр, “Нөлөөллийн мэдүүлгийн загвар”-ыг 2 дугаар, “Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан загвар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлуулсан. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.15-2. Хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох /ЗГХЭГ, 2017-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах эрх зүйн зохицуулалтыг тусгасан. (Биелэлт 70 хувь)

#### 4.1.5.16-1. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2019/

Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд заавал авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газар санал, зөвлөмж гаргах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны а/183 дугаар тушаалаар “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ыг батлан мөрдүүлсэн бөгөөд тус газраас 2020 онд дараах дүрэм, журмыг хянаж санал зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд: Монголбанкны ерөнхийлөгчийн “Монголбанкнаас банк, банкны ажилтнуудын үйл ажиллагаатай холбогдсон эрүү, иргэний хэрэгт магадлан шинжилгээ хийх журам”-ыг хянан хүчингүй болгуулахаар саналыг хүргүүлэв. Сангийн сайдын “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөв, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”, “Засгийн газрын

гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөв, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, Монгол Улсын Засгийн газрын “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-д авлига, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл боломж байгаа эсэхийг хянан үзэж, шаардлагатай саналыг хүргүүлэв.

“Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам”-ын төсөл, “Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс хураагдсан баялаг, эд зүйлийг шийдвэрлэх журам”, “Гаалийн тусгай бүсийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”, “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”, “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх 4 журам”, “Гаалийн хяналтын бүсийн журам”, “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”, “Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх заавар”, “Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох журам”, “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын төсөл зэргийг хянаж, холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлээ. (Биелэлт 30 хувь)

4.1.5.17-1. Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжид тусгаж нэр томъёог тодорхой болгох /АТГ, 2017-2018/

Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа хэргээ илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх талаар Эрүүгийн хуульд нэмэлт оруулах санал боловсруулан хүргүүлснээр Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн тайлбарт хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж

ялаас чөлөөлөхөөр Эрүүгийн хуульд тусгагдсан.

Эрүүгийн хуулийн дээрх тайлбарт өөрчлөлт оруулах саналаа хүргүүлж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн тайлбар/Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн өөрчлөн найруулж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулсан. (Биелэлт 100 хувь)

**Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 19 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.6.1-1. Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, Авлигын эсрэг түншлэл /PACI/-ийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Авлигын эсрэг түншлэлийн гол зарчмуудыг сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх /МҮХАҮТ, МАОЭНХ, МБЗ 2017-2019/

Авлигын эсрэг түншлэл /PACI/-ийн удирдах зөвлөлийн хугацаа дууссан бөгөөд шинээр зөвлөл байгуулаагүй тул арга хэмжээний биелэлтийг үнэлээгүй.

4.1.6.1-3. Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг гишүүн байгууллага болон төрийн байгууллагуудын нөөц боломжийг ашиглан сурталчлах /МҮХАҮТ, МБЗ 2017-2020/

Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагаа зогссон тул арга хэмжээний биелэлтийг үнэлээгүй.

4.1.6.2-1. Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах /АТГ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ, ОӨУБЕГ, 2017-2019/

2020 онд Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшлийн нийт 21 байгууллагын 320 хүнд “Бизнесийн ёс зүй ба авлига”, “Авлигын гэмт хэрэг, анхаарах асуудал”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулав. Үүнд: “Таван богд” групп, “Improve program” хөтөлбөр, “Шунхлай” групп, “MNAgency”, “Viral”, “Orgilmedia”, “Global Event”, “EMOZ agency”, “IDlabAgency”, “Boomerang Mongolia”, “iLAB Production”, “IMGroup”, “Shogun Art Studio” зэрэг компани, хувийн хэвшлийн менежер, ажилтнууд болон жолооны курсийн захирал, гарааны бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, МҮХАҮТ-ын “Бизнес академи”-ийн суралцагч нар багтаж байна. Сургалтад оролцогчдод Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшил, бизнес эрхлэгчдэд зориулан гаргасан “Авлигаас урьдчилан сэргийлэх 9 зөвлөмж”, Шударга ёс хөгжил дэвшилд: Хувийн хэвшлийн оролцоо” зэрэг гарын авлагыг сурталчлан түгээв.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас үл хөдлөх

хөрөнгө зуучлалын шинэ реалторуудын сургалтыг 3 удаа зохион байгуулж, 60 зуучлагчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр сургалт явуулсан.

Стандарт, хэмжил зүйн газраас хувийн хэвшлийн байгууллагуудад олон улсын стандарт, хэм хэмжээг үйл ажиллагаандаа тусгаж нэвтрүүлэх, чадавхжуулах 38 удаагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж компаниудын 1140 хүнийг хамруулжээ.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 155 аж ахуйн нэгжийн 2500 албан тушаалтныг хамруулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгууллаа.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас худалдаа, үйлчилгээний газруудын бараа, бүтээгдэхүүний хямдралтай худалдаанд шалгалт хийж, зөвлөмж хүргүүлсэн бол иргэд, хэрэглэгчид аж ахуйн нэгжүүдийн бараа буцаалттай холбоотой, бараа бүтээгдэхүүний баталгаат хугацаа, цахим худалдан авалт, урьдчилан сэргийлэх арга зам” зэрэг асуудлаар 3 заавар, 1 зөвлөмж боловсруулж, олон нийтэд хүргэж ажиллажээ. (Биелэлт 70 хувь)

4.1.6.2-2. Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх /ҮХГ, ЗГХЭГ, СЯ, АТГ 2018-2022/

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хуулийн зохих шалгуурыг бүрэн хангасан, 10-500 тэрбум төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдэд татварын хувь, хэмжээг “Тогтворжуулах гэрчилгээ”-г 5-18 жилийн хугацаатай олгох замаар дэмжлэг үзүүлдэг. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2020 оныг дуустал нийт 16 хуулийн этгээдэд “Тогтворжуулах гэрчилгээ” олгож, нийт хөрөнгө оруулалтын дүн 4 их наяд 98 тэрбум төгрөг болсон. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын гадаадын хөрөнгө оруулагч, түүний удирдах бүрэлдэхүүний 3 хүртэлх иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгох хүсэлтийг Үндэсний хөгжлийн газар шийдвэрлэх үйл ажиллагааг цаасан суурьтайгаар ажлын 3 хоногт шийдвэрлэдэг байсныг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, ажлын 8 цагт багтаан [www.invest-assist.gov.mn](http://www.invest-assist.gov.mn) хаягаар хүсэлтийг шийдвэрлэж,

хариуг хүргүүлдэг болов.

Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Сангийн сайдын тушаалаар олгодог байсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг Мэргэшсэн нягтлан бодогчийн институт ТББ-д, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгт, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн үйлчилгээг Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд, Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, сан бүрдүүлэх, ашиглах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2019 оны А/16, А/07 дугаар хамтарсан тушаалаар “Олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/22 дугаар тушаалаар “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлуулснаар Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.3-1. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх /ЗГХЭГ, ҮХГ, 2018-2022/

Бизнес, хөрөнгө оруулалтын орчинд тулгарч буй түгээмэл саад, бэрхшээлийг төр, хувийн хэвшлүүд хамтран шийдвэрлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулахад хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх хуулийн этгээдийн төлөөллөөр тухай асуудлыг хэлэлцүүлж, санал авч, зөвшилцөл хийх, мэдээллээр хангах үүрэг бүхий “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо”-г 2017 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар «Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл»-ийн дэргэд байгуулсан. 2017-2020 оны хугацаанд Зөвлөлдөх хорооны хурлыг нийт 10 удаа, техникийн ажлын хэсгийн хурлыг нийт 3 удаа зохион байгуулж, 3 зөвлөмж гаргаж, дараах асуудлыг авч хэлэлцсэн.

Тухайлбал,

1. Татварын багц хууль, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн талаар зөвлөмж;
2. Үндэсний хөгжлийн газар, Дэлхийн банкны группийн ОУСК-тай хамтран хийсэн “Хөрөнгө оруулалтын шинэчлэлийн зураглал”-ын үр дүнгийн тухай зөвлөмж;
3. Хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн биржийн шимтгэлтэй холбоотой асуудлын хүрээнд зөвлөмж;
4. Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;
5. Баялаг бүтээгчдийг дэмжих цогц хуулийн төсөл боловсруулах тухай;
6. Үндэсний үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих тухай багц хуулийн төслийн үзэл баримтлал;
7. “Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт татах стратеги төлөвлөгөө”-ний төсөлд хорооны гишүүдээс цахимаар санал авч, саналуудыг тусгав.

“Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл” нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх” үүрэгтэй. Мөн “Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем”-ийг 2020 онд ашиглалтад оруулсан. Уг систем нь хөрөнгө оруулагчийн өргөдөл, гомдлыг төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор шийдвэрлэх нөхцөлийг бий болголоо. Ингэснээр авлигын эрсдэлийг бууруулах эерэг нөлөөтэй юм. (Биелэлт 70 хувь)

4.1.6.3-2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах /ҮХГ, СЯ 2017-2018/

Сангийн яам 2018 онд Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй байгуулсан гэрээний 3.2-т авлигаас урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчлөөс ангид байх агуулгыг тусгаж ажилласан. 2020 онд нэмэлт

ажил хийгдээгүй. (Биелэлт 0)

4.1.6.3-3. Олон улсын болон дотоодын бизнесийн орчин дахь авлигатай тэмцэх сайн туршлага, эрсдэлийн менежментийн стратегийг судлах, нэвтрүүлэх санаачилга өрнүүлэх / МҮХАҮТ, Гишүүн байгууллага. АТГ 2018-2019/

2020 онд МҮХАҮТ-ын дэргэд “Комплаенсын үндэсний зөвлөл”-ийг байгуулж, COMPLAEN-ын анхдугаар чуулганыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан байсан боловч “Ковид-19” цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор түр хугацаагаар хойшлогдсон.

Авлигатай тэмцэх газраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төрөөс олгож байгаа санхүүжилтийн үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах нь” сэдэвт цахим хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулсан. Энэ хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан бизнесийн ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр танхимын болон видео сургалт, сурталчилгааны ажлыг хийв. (Биелэлт 30 хувь)

4.1.6.3-4. Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй бодлого, тогтолцоог санаачилж хэрэгжүүлсэн байгууллагыг урамшуулах механизм бий болгох/АТГ, МҮХАҮТ, ХЗДХЯ 2020-2022/

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна”, мөн зүйлийн 34.2-т “Иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл ногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно”, мөн 34.3-т “Энэ хуулийн 34.1, 34.2-т заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж тус тус заасан. Энэ хүрээнд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төслийг боловсруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулахдаа төвлөрлийг сааруулж, зөвлөл болон салбар зөвлөлөөс олгох, зохион байгуулсан ажил, арга хэмжээг тодорхой

шалгуурын дагуу бодитой үнэлэх, үр дүнг тооцож урамшуулахад чиглэсэн хэлбэрт шилжих нь зүйтэй гэж уг журмыг боловсруулсан ажлын хэсгээс үзсэн. Журмын төслийг <https://mojha.gov.mn/newmojha/> сайтад байрлуулж, олон нийтээр хэлэлцүүлж, холбогдох саналыг тусгасан байна. Төслийг батлуулахаар Сангийн яамд хүргүүлэхээр бэлтгэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Монгол Улсын Шадар сайдаар дамжуулан, УИХ-ын даргад өргөн барьсан. Энэхүү хуулийн төсөл нь УИХ-ын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон. (Биелэлт 70 хувь)

4.1.6.4-2. Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

2020 онд Улсын Их Хурлын дэргэд Инновац, цахим бодлогын байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, мөн Засгийн газрын бүтцэд Соёлын яам байгуулагдснаар 2018 онд боловсруулсан Өрсөлдөөний тухай хуулийн төсөлд дахин санал авах, хэлэлцүүлэх, инноваци, блокчэйн, биг дата, цахим орчны зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах нөхцөл байдал үүссэн тул хуулийн төслийг дахин боловсруулж байна. Энэ хүрээнд харилцаа, холбоо, мэдээллийн технологи, зам тээвэр, худалдаа, үйлчилгээний салбар, МУИС-ын Хууль зүйн сургууль, Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн багш, эрдэмтэн судлаачид, Монголын банкны холбоо, Эм хангамжийн болон эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэгч, Газрын тосны бүтээгдэхүүний салбарын аж ахуй эрхлэгч, БНСУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуй эрхлэгч, барилгын салбарын аж ахуй эрхлэгчид зэрэг 14 салбарын төлөөллийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж, санал авсан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-3. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Энэ хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн үнэлгээ, холбогдон гарах зардлын тооцоонд хийсэн үнэлгээний тайланг гаргаж, Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсэн. (Биелэлт



30 хувь)

4.1.6.4-4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх /ШӨХТГ 2018-2020/

“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, Монгол Улсын Шадар сайд, Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан хөтөлбөрийг дэмжих боломжгүй тухай хариу ирүүлсэн.

Патентын тухай хууль болон Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуульд шинэчилсэн найруулга, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулж, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах /ШӨХТГ 2017-2019/

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Өрсөлдөөний тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийг даган гарах “Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, түүнийг дэмжиж оролцсон тухайгаа сайн дураараа илчилсэн аж ахуй эрхлэгчид ногдуулах шийтгэлээс хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар оруулах бэлтгэл ажлыг хангав. Мөн тус газраас харилцаа холбооны салбар, санхүүгийн салбар, эрүүл мэндийн даатгалын салбарт төрийн захиргааны байгууллагаас гаргаж байгаа шийдвэр нь аж ахуй эрхлэгчийн өрсөлдөөнийг хязгаарласан эсэхэд хяналт шалгалт хийж зөвлөмж хүргүүлжээ. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт зөвлөмж хүргүүлсэн. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Зам, тээврийн хөгжлийн яам нь улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай гэрээ байгуулахдаа Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 заалтыг зөрчсөн тул зөрчлийн арилгуулах талаар албан бичиг; Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн А/24 дугаар тушаалаар баталсан “Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм” нь аж ахуй эрхлэгчийн өрсөлдөөнийг хязгаарласан эсэхэд хяналт шалгалт хийж, тус дүрэм нь

Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т “тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн” гэж, 13.2.7-д “аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн” гэж тус тус заасныг зөрчсөн тул Өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэн аж ахуй эрхлэгчдийн өрсөлдөх боломжийг бүрдүүлж ажиллах талаар Зам, тээврийн хөгжлийн яаманд албан бичиг хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.4-6. Өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах, шударга өрсөлдөөнийг дэмжсэн сургалтыг жил бүр зохион байгуулах /ШӨХТГ 2017-2019/

2020 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих хүрээнд Зар сурталчилгааны хууль, тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийслэл, орон нутгийн 173 хэвлэл мэдээллийн байгууллага, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт сургалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тендер захиалагч байгууллагуудын уулзалтыг зохион байгуулж, 20 гаруй захиалагчдад зөвлөмж хүргүүлсэн бөгөөд энэ чиглэлээр 21 аймгийн орон нутгийн өмчийн газрын албан хаагчдад цахим сургалт зохион байгуулсан.

Гудамж талбайд байршуулсан самбар, аж ахуйн нэгж, байгууллагуудын нэр зэрэг нь Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийж аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлэв.

Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах ажилд олон нийтийн оролцоог хангах, аж ахуй эрхлэгчдийн эрхийг дээдлэх, үйл ажиллагаа, үйлчилгээний чанарын сайжруулах зорилгоор нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга, мэргэжилтэн, харилцаа холбоо, банк, санхүү, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон байгууллагуудын хэрэглэгчийн төв хариуцсан захирал, менежерүүд зэрэг 34 байгууллагын төлөөлөлд цахим сургалт зохион байгуулав.

“Койка” олон улсын байгууллагатай хамтран “Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад төрийн байгууллага, аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах нь” цахим сургалтыг 50 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан зохион байгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /УУХҮЯ 2017-2019/

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох урьдчилсан тандалт судалгаа, үр нөлөө, зардлын тооцооны судалгааг хийн, тайлан боловсруулж, олон нийтэд танилцуулсан. Хуулийн үзэл баримтлалыг 2020 оны 08 дугаар сард шинэчлэн баталсан бөгөөд төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албаны цахим хуудсаар дамжуулан иргэдээс санал авч байна. Хуулийн төслийг олон улсын жишигт нийцүүлэн батлах зорилгоор Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр олон улсын болоод дотоодын зөвлөхүүдийг ажиллуулж, 2021 оны хаврын чуулганд хуулийн төслийг өргөн барихаар ажиллаж байна.

Монгол Улсын эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор Нээлттэй нийгэм Форум, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба хамтран эрдэс баялгийн салбарын гэрээний мэдээллийн цахим санг 2019 онд байгуулсан. 2020 оны байдлаар Эрдэс баялгийн салбарын 800 гаруй гэрээ, 162 гэрээний заалтын тайлбарыг [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn) цахим сайтад байршуулаад байна. Цаашид 300 гаруй гэрээг байршуулахаар холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас татан төвлөрүүллээ. (Биелэлт 30 хувь)

4.1.6.5-2. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах /УУХҮЯ 2017-2019/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нээлттэй нийгэм форум, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба хамтран «[www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn)» гэрээний ил тод байдлын цахим санг бий болгож, 2019 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулсан. 2020 оны байдлаар уг санд 796 гэрээ байршуулснаас Бүтээгдэхүүн хуваах гэрээ 26, Хөрөнгө оруулалтын гэрээ 4, Тогтвортой байдлын гэрээ 11, Орон нутагтай хамтран ажиллах 167 гэрээг байршуулаад байна. (Биелэлт 100 хувь)

4.1.6.5-3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох /ЗГХЭГ, УУХҮЯ 2020-2022/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/1327 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-12/”-ийг бүртгүүлэх талаар аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэж, зөвлөсний үр дүнд 2020 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын 2019 оны тайлангаа гаргасан компаниудаас 291 компани сайн дураараа ашиг хүртэгч (бенефициар) эздийнхээ мэдээллийг ил тод болгосон.

Одоогийн байдлаар эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл Улсын бүртгэлийн газарт хадгалагдаж байгаа бөгөөд энэхүү мэдээллийг ил тод болгох талаар эрх зүйн орчин бүрдээгүй тул аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр холбогдох мэдээллийг ил тод болгож байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд эрдэс баялгийн салбарын эцсийн эзэмшигчийг ил тод болгох талаар Засгийн газар журам батлах, мэдээллийн санг бүрдүүлж, нийтэд ил болгох талаар улсын бүртгэлийн болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт холбогдох заалтуудыг оруулж өгсөн. Мөн эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулагч аж ахуйн нэгж, байгууллагуудыг эцсийн эзэмшигч, хамаарал бүхий компанийг ил болгохоор хуулийн төсөлд тусгасан. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-4. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх /УУХҮЯ 2017-2020/

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөний дагуу газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-т талбайнуудад байгаль орчин менежментийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, хянан батлах журмын хүрээнд жил бүрийн 12 дугаар сард дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчин менежментийн төлөвлөгөөний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг Байгаль орчин менежментийн төлөвлөгөөг боловсруулах хянан батлах тайлагнах журмын дагуу гаргадаг. 2020 онд байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-т 19 болон 21 дүгээр

талбайд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-138 тушаал болон «эвдэрсэн газрыг ургамалжуулах», техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008 зэрэг стандарт, журмыг тус тус үндэслэн нийт 1400 ширхэг мод суулгах ажил хийгдсэн. Мөн 75 га газарт хөрс сийрэгжүүлэх ажил, замуудын дунд хаагдсан газарт байгаа эвдэрсэн замуудыг хаах ажил 50 хувьтай, нийт 200 цооногт 10 метрийн өргөнтэй галаас хамгаалах зурвас бүс барих ажил, усны мониторингийн төхөөрөмж суурилуулах зэрэг ажлууд хийгдсэн байна. Мөн дэлхийн улс орнуудад Ковид-19 цар тахлын дэгдэлт ихэссэнтэй холбогдуулан гэрээлэгч компани болох «Петрочайна дачин тамсаг» ХХК болон «Доншен газрын тос Монгол» ХХК-ууд гадаадад байгаа шаардлагатай инженер техникийн ажилтнуудаа 2020 оны 08 дугаар сар хүртэл Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайнууд дахь ажлын байрандаа авчирч чадаагүй. Үүний улмаас 2020 онд хийгдэхээр төлөвлөгдсөн байсан өрмийн шингэн хаягдлын санг саармагжуулах болон нөхөн сэргээх ажил, дүйцүүлэн хамгаалах зэрэг ажлууд хийгдээгүй бөгөөд 2021 онд хэрэгжүүлэхээр дахин төлөвлөгдсөн байна. (Биелэлт 70 хувь)

4.1.6.5-5. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах /УУХҮЯ 2017-2019/

Энэ хүрээнд бүтээгдэхүүн хуваах 27, газрын тосны эрлийн 16 гэрээг «[www.lltodgeree.mn](http://www.lltodgeree.mn)» сайтад байршуулсан.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуйн нэгж хамрагдсан боловч тайланд бүх аж ахуйн нэгжүүдийг хамруулдаггүй бөгөөд тайлан бичихээр шалгарсан компани тодорхой нөхцөлүүдийг харгалзаж, ямар аж ахуйн нэгжийг тайланд хамруулахыг шийдвэрлэдэг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2019 оны тайланд «Петроматад» ХХК, «Петрочайна Дачин Тамсаг» ХХК, «Доншен газрын тос Монгол» ХХК, «Мак» ХХК, «Макс-Ойл» ХХК, «Магнай Трэйд» ХХК, «Смарт ойл» ХХК, «Вүльф Петролиум» ХХК зэрэг 8 гэрээлэгчийн үйл ажиллагааг тусгуулсан.

2019 оны ил тод байдлын тайланг боловсруулах компаниар “Гранд Торнтон” ХХК шалгарч тайлан бичих явцын хэлэлцүүлэг хийгдэж байна. /Жич: 2020 оны тайланг бичих компанийг 2021 оны тендер шалгаруулалтаар сонгоно/. Цаашид энэ

үйл ажиллагаа тогтвортой явагдаж байгаа бөгөөд холбогдох хууль журмын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. (Биелэлт 100 хувь)

#### **Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд нийт 6 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ тусгагдсан.Зорилтын хүрээнд төлөвлсөн арга хэмжээг тоймлон танилцуулбал:

4.1.7.1-1. Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах /АТГ, яам, агентлаг, аймаг, нийслэл дэх ГХУСАЗСЗ 2017-2018/

АТГ-аас “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт цахим хэлэлцүүлгийг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцүүлэгт нийгмийн халамжийн үйлчилгээний салбарын мэргэжилтнүүд болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 аймгийн төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулав. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сайн байх нь ирээдүйд илүү үр дүнтэй нийгмийн халамжийн үйлчилгээ хэрэгжүүлэх боломжийг Засгийн газарт олгоно. Гэтэл энэ чиглэлийн ажлын үр дүнгийн үнэлгээ өмнө нь хийгдээгүй тул эцсийн үр дүн ямар байгааг, хэрхэн сайжруулж болох тал дээр ойлголт багатай байна. Авлигатай тэмцэх газраас хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлсэн үнэлгээний үр дүнг холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлснээрээ цаашдын бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлох ач холбогдолтой байв.

“Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлсэн бөгөөд тайланг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 15 байгууллагын 42 хүнийг оролцуулсан онлайн хэлэлцүүлэг зохион байгуулав. Төрөөс нийтийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх үйл явцыг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх харилцааг зохицуулсан эрх зүйн орчин, гадаадын зарим улсын эрх зүйн тогтолцоо, туршлагыг судлах,

үүний үндсэн дээр бодит байдлыг тодорхойлох зайлшгүй шаардлага бий болсон. Гэтэл энэ чиглэлийн ажлын үр дүнгийн үнэлгээ хийгдээгүй тул Засгийн газар эцсийн үр дүн ямар байгааг, хэрхэн сайжруулж болох тал дээр ойлголт багатай байна.

Авлигатай тэмцэх газраас захиалан хийлгэсэн үнэлгээний үр дүнг холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлснээр цаашдын бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой боллоо гэж хэлэлцүүлэгт оролцогчид онцлов. Хэлэлцүүлгийг “Олон нийтийн төв” фэйсбүүк пэйж хуудсаар лайв хэлбэрээр түгээж, олон нийт оролцох боломжийг хангаж ажиллав.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоо, үр ашигтай байдалд хөндлөнгийн үнэлгээ хийх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг “Хууль тогтоомж, бодлого судлалын төв” ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан тухайн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сангууд болон төрийн бус байгууллагаас төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар харилцан мэдээлэл солилцлоо.

Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээнд гарсан үр дүн, үр нөлөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлэх чиглэлээр Монголын хуульчдын холбоо, “Баасанжав Консалтанг” ХХК-тай хамтран ажиллав.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөлөл”-ийг тодруулах судалгааг зохион байгуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав.

АТГ-аас шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын чиглэлээр иргэд, төрийн бус байгууллагыг чадавхжуулах, олон улсын сайн туршлага бүхий авлигын эсрэг ном, гарын авлага орчуулж түгээх зорилгоор тэдгээрт зориулсан” гарын авлагыг англи хэлнээс орчуулан, тус гарын авлагын агуулгын хүрээнд иргэд, ТББ-д сургалт зохион байгуулав. Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хүнс, хөдөө аж ахуй,

хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сангууд дахь авлигын эрсдэлийн үнэлгээг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд эдгээр салбар байгууллагуудын шийдвэр гаргах түвшин дэх анхаарах асуудал, алдаа дутагдлыг хөндлөнгийн үнэлэлт, дүгнэлтээр гаргуулан түүний мөрөөр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Нээлттэй нийгэм форум” ТББ-тай хамтран “Хувьцаат компанийн комплайнс, мэдээллийн ил тод байдал” хэлэлцүүлгийг 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээр Хорооноос компанийн засаглалыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын шинэчлэл, хувьцаат компаниудын хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээсэн үүргийн нийцэл, хувьцаат компанийн мэдээлэл, тайлагналын ил тод байдал, цаг үеийн болон цаашид чухалчлан анхаарах асуудлаар хэлэлцсэн ба мэргэжлийн холбоод болон хувьцаат компаниудын ТУЗ-ийн гишүүдийн төлөөлөл, зах зээлийн судлаач, мэргэжилтнүүд зэрэг нийт 150 гаруй хүн оролцов. Монголын даатгалын холбоотой байгуулсан «хамтран ажиллах гэрээ», Монголын банкны холбоо, Монголын зуучлагчдын холбоо болон Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо нартай хамтран ажиллаж, даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх олгох сургалтыг мэргэжлийн холбоодууд зохион байгуулж, шалгалтыг Хороо авч байна. Даатгалын мэргэжлийн холбоодуудад мэргэжлийн эрх олгох сургалтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх чиглэл өгч, даатгалын зуучлагч, даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх эрх олгох сургалт, шалгалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулсан. Мөн СЗХ-ны 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ын дагуу Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбооноос байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмийг батлан ирүүлсэн бөгөөд тус дүрмийн дагуу өөрийн гишүүн байгууллагуудынхаа хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Ингэснээр салбарын салбарын холбоодыг бэхжүүлэх, ёс зүйтэй болох улмаар даатгуулагчийн эрх хамгаалагдах тогтолцоо бүрдсэн. Санхүүгийн зохицуулах хороо

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран ажиллах гэрээг 2019 оны 12 сарын 09-ний өдөр 2 жилийн хугацаатайгаар байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд ББСБ-уудын удирдах албан тушаалтнуудыг сертификатжуулах сургалт, Компаенс ба ёс зүй цахим сургалтуудыг СЗХ-ны Санхүүгийн боловсрол сургалтын алба, МББСБХ-той хамтран зохион байгуулж, 2020 онд ББСБ-уудын удирдах албан тушаалтнуудыг сертификатжуулах сургалтыг 2 удаа, Компаенс ба ёс зүй онлайн сургалтыг 8 удаа явуулсан. Санхүүгийн зохицуулах хороо салбарын мэргэжлийн холбоодтой /ХААГБТЭБНМБНХ, ММНБИ, ММУИ, МХХ, МБХ, ММНБИ, ММУИ, МДХ, МДЗХ, ҮМҮЧАЭҮХ/-хамтран ажиллах гэрээг байгуулж салбарын ажилтнуудад эрх олгох, мэргэшүүлэх зэрэг сургалтыг хамтран хэрэгжүүлэхээр тогтсон. Хорооны цахим хуудсанд Хууль, журмын төсөлд санал авах хэсэгт 30 хоногийн хугацаатай 2020 онд 22 журам байршсан бөгөөд үүний үр дүнд 91 төрийн бус байгууллагууд саналаа өгч оролцов. (Биелэлт 70 хувь)

4.1.7.1-2. Иргэдийн оролцоо, санал, санаачилгыг нэгтгэх, төрийн бодлого, шийдвэр гаргахад тусгах боломжийг бүрдүүлсэн бизнес анализийн систем хөгжүүлэх /ХХМТГ, Үндэсний дата төв УТҮГ 2020-2022/

Монгол Улс дэлхийд цахим засаг, иргэний цахим оролцооны хүрээнд өөрийн түвшинг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор төрийн дижитал шилжилтийг цогц байдлаар харж, төрийн дижитал шилжилтийн эко системийг технологийн түвшинд бий болгох чиглэлээр Үндэсний дата төвөөс [Eparticipation.gov.mn](http://Eparticipation.gov.mn) -Төрийн нэгдсэн санал асуулга хүлээн авах, шийдвэр гаргах систем ажиллуулж байна. Энэхүү Иргэдийн цахим оролцооны систем нь төрийн бүх байгууллагуудад тус системийг ашиглан өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэлийн хүрээнд холбогдох иргэдээ сонгож санал асуулга, хэлэлцүүлгийг үүсгэн явц, үр дүнг хянах боломж бүхий систем юм. Иргэд тухайн системд нэвтрэхдээ “E-Mongolia” Танилт нэвтрэлтийн нэгдсэн системийн тусламжтайгаар өөрийгөө баталгаажуулах ба баталгаажуулсны дараагаар төрийн бүх шатны байгууллагаас явуулж буй санал асуулга, хэлэлцүүлэгт оролцох, санал, гомдол хүсэлтээ илгээх боломжтой болно. Энэхүү систем нь мөн Иргэдээс ирүүлэх санал, хүсэлт, шүүмжлэл, гомдол талархлыг хүлээн авч холбогдох байгууллагуудад шилжүүлэн

шийдвэрлэх боломж бүхий “11-11” төвийн системтэй холбогдож ажилладаг бөгөөд санал гомдлыг иргэдийн цахим оролцооны системээрээ дамжуулан өгөх, хянах боломжийг бүрдүүлнэ. Монгол Улсын иргэд энэхүү системийг ашиглан төрийн бүх шатны байгууллагаас явуулж буй санал асуулга, хэлэлцүүлэгт оролцох, санал, гомдол, хүсэлтээ илгээх боломжтой байх бөгөөд өөрийгөө “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн системийг ашиглан цахим орчинд баталгаажуулсан байх шаардлагатай юм. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн өргөдөл гомдлын [www.11-11.mn](http://www.11-11.mn) систем дээр ажиллах Бизнес аналитикийн “Tableau” системийг ашиглахаар лицензийг худалдан авсан бөгөөд ашиглах албан хаагчдад сургалтыг хийхээр төлөвлөж байна.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, “Ухаалаг засаг” төсөл, “Соёмбо” хууль зүйн нөхөрлөлөөс зохион байгуулсан Нээлттэй өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Уг хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, хүртээмжтэй болгох, үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. (Биелэлт 30 хувь)

4.1.7.1-3. Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах зорилтын хүрээнд “Ил тод Улаанбаатар Академи”-тай хамтран ажиллах /АТГ, нийслэлийн ЗДТГ, ГХУСАЗСЗ 2017-2019/

Авлигатай тэмцэх газар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 117 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын санал санаачилгыг дэмжиж, 47 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт, төрийн албаны удирдах албан тушаалтан, худалдан авах алба, хуулийн хэлтэс, санхүү, дотоод

хяналт, аудитын албан тушаалтнуудад зориулсан 5 төрлийн 20 сургалтын модулийг боловсрууллаа. Мөн хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчдэд зориулсан гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах сургалтын интерактив модуль бүхий аппликэйшний зохиомжийн төслийг боловсруулах, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв хэрхэн туссан байдалд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлэв. Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, энэ дагуу тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгууллаа. Ухуулга сурталчилгааг видео контент, зурагт хуудас, брошюр нугалбар, подкаст, үзүүлэн таниулах, радио контент, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео цахим хичээл, орон нутаг дахь сурталчилгаа, нийтийн тээврийн сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэцийн сурталчилгаа, цахилгаан шатны сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл жанраар бэлтгэн, түгээж ажиллав.

Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллага, маркетинг, бүтээлч үйлдвэрлэлийн салбарын залуусыг татан оролцуулах, сургах, туршлага хуваалцах, хамтран ажиллахад зорилгоор сэтгүүлч, байгууллагын маркетинг, сошил медиа хөгжүүлэгч мэргэжилтнүүдийг хамруулан 2020 оны 9 дүгээр сард 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал” хакатон /тодорхой өгөгдсөн сэдвийн хүрээнд төрөл бүрийн мэргэжил, чадвартай хүмүүсээр үр дүнтэй багийг бүрдүүлэн, богино цаг хугацаанд шинэ санааг хөгжүүлж асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх нэг төрлийн уралдаант үйл ажиллагаа/-г зохион байгуулав.

Шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Үнэгүй фитнес” ТББ-тай хамтран “Эрүүл бие-Эрүүл

нийгэм Амьдралын хэв маягаа өөрчилъе» арга хэмжээг 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Үндэсний соёл амралтын хүрээлэнд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 260 гаруй иргэн хүрэлцэн ирж 100 хүний дунд 10 төрлийн авлигын эсрэг мэдлэг олгох өртөөлсөн тэмцээнийг амжилттай зохион байгуулав.

Тус газраас Нийслэлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран Нийслэлийн ГХУСАЗСЗ, нийслэлийн ИТХ-ийн 2020 оны 27 тоот тогтоолоор баталсан төсвийн хүрээнд олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, шударга ёсны зөв хандлага төлөвшүүлэх, авлигын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, түүний хор уршиг, үр дагаврыг ухуулан таниулах зорилгоор иргэдийн амьдралд, бүтээгдэхүүний үнэ, эдийн засаг, иргэдийн тэгш хүртээмжтэй үйлчилгээ авах боломжид авлигын үзүүлэх нөлөөллийг энгийн, ойлгомжтой хялбаршуулсан байдлаар харуулах б төрлийн сэдэвчилсэн видео контентууд, авлигын эсрэг сурталчилгааны чиглэлээр 10 төрлийн зурагт хуудсыг тус тус бүтээж олон нийтэд түгээв. (Биелэлт 30 хувь)

4.1.7.2-1. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, тогтвортой, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг нь баталгаажуулах зэрэг чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох /ХЗДХЯ 2017-2019/

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны судалгааг тус тус хийсэн. Үүний дүнд Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл гэсэн нэр, агуулгаар боловсруулж, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийн төслийг шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Барилга, хот байгуулалтын яамнаас салбарын хэмжээнд олгогддог тусгай зөвшөөрөл олгох ажлыг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шийдвэр гарч, уг ажил 2 дахь жилдээ амжилттай хэрэгжиж

байна. Барилгын салбарт өнөөдрийн байдлаар 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байгаа бөгөөд эдгээрт Барилга байгууламжийн ажил гүйцэтгэх, Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, Өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл багтаж байна. Тус яамнаас “Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-д барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудлыг гэрээгээр гүйцэтгүүлэх эрхийг олгосон бол бусад гурван төрлийн тусгай зөвшөөрлийг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ тэргүүтэй найман байгууллагын түншлэл гүйцэтгэж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбарын хэмжээнд Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд хийгдэх ачаа, зорчигч тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг солилцох, тээвэрчдэд олгох, тооцоо хийх, хяналт тавих, Автотээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгох ажлыг “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Тээврийн хэрэгслийг гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлэх таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (CPD карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт уг дэвтэрт тэмдэглэсэн асуудалтай холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг Монголын автомашин, мотоциклийн спортын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.7.2-2. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх механизмыг бүрдүүлэх /ОӨУБЕГ, ТББ 2019-2020/

Улсын бүртгэлийн багц хуулийг 2018 онд Улсын Их Хурлаас баталж, 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжснээр хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээллийг нээлттэй болгосон. 2019 оны 9 дүгээр сараас ашгийн төлөө бус төрийн бус байгууллагын анхны үүсгэн

байгуулагч, эцсийн өмчлөгч, удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж эхэлсэн. Тайлант хугацаанд 1675 төрийн бус байгууллагыг шинээр бүртгэсэн байна. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг тухайн байгууллагад ирүүлэхээр заасны дагуу 2020 онд 401 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч ажилласан. Төрийн бус байгууллагын судалгааг холбогдох байгууллагуудад гарган хүргүүлж байна. Тухайлбал, Сангийн сайдын 2020 оны 20 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг”-т улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй төрийн бус байгууллагын, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдаа эрхлэгчийн, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлалын үйл ажиллагаа эрхлэгчийн судалгаа, Зам, тээврийн хөгжлийн яаманд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлсэн 44 төрийн бус байгууллагын судалгаа, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлд улсын бүртгэлд бүртгэлтэй холбоо /НҮТББ/-ны судалгаа, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын судалгааг гарган, [cn\\_data@police.gov.mn](mailto:cn_data@police.gov.mn) цахим хаягаар тус тус хүргүүлээ. Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй төрийн бус байгууллагуудын судалгааг Сангийн яаманд цахим хаягаар хүргүүлж, санхүүгийн тайлан өгсөн эсэх талаар мэдээллийг гаргуулан авлаа. Уг мэдээллийг үндэслэн 2019 онд санхүүгийн тайлан өгсөн төрийн бус байгууллагын жагсаалтыг гарган, Улсын бүртгэлийн нэгдсэн архивт хадгалагдаж байгаа хувийн хэрэгтэй тулгалт хийсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын төрийн бус байгууллагын салбар дахь терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний ажлын хэсгийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.7.2-3. Төрийн бус байгууллагуудын мэдээллийн идэвхтэй солилцоог бий болгох, хоорондын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээ, түншлэлийг дэмжих /АТГ 2018-2020/

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх

чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохоор төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газар, ХХААХҮЯ, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төрөөс олгож байгаа санхүүжилтийн үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах нь” сэдэвт цахим сургалтыг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан болон 21 аймгийн хөдөө аж ахуйн газрын төсөл сонгон шалгаруулалтын хороо, дэд хорооны бүрэлдэхүүнийг хамруулан 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав. “Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрхзүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах” чиглэлийн хүрээнд 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвсэл, Сэтгүүлчид, Хэвлэл мэдээллийн байгууллага, Төрийн бус байгууллагын төлөөлөл, ХЗДХЯ-тай хамтран Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах салбарын анхны хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулав.

АТҮХ-ийн хэрэгжилт, авлигын индексийн судалгаа, шударга байдлын үнэлгээний дүн, шалтгаан нөхцөл болон авлигатай тэмцэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллага хэрхэн оролцох талаар мэдээлэл өгч, чадавхжуулав. 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан төрийн бус байгууллагад хөндлөнгийн байгууллагаас үнэлгээ хийсэн дүнг хэлэлцэх цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс дэвшүүлсэн саналуудыг зөвлөмж болгон нэгтгэв. (Биелэлт 30 хувь)

4.1.7.3-1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх /АТГ 2017-2019/

Олон улсын авлигын эсрэг өдрийг тохиолдуулан цаг үеийн онцлог, ээдрээтэй байдал, түүнтэй холбогдон үүсч байгаа авлигын эрсдэлийг хөндсөн “Ковид ба Авлига”: Иргэдийн чөлөөт индэр” цахим хэлэлцүүлгийг иргэний нийгэм, мэргэжлийн холбоод, судлаач нарын дунд зохион байгуулав. Цахим хэлэлцүүлгийн оролцогчид шинэ төрлийн “Ковид-19” вирусийн цар тахалтай тэмцэх

цаг үед авлигын гэмт хэрэг гарах эрсдэл, түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар мэдээлэл солилцож, санал дэвшүүлэв. Цахим хэлэлцүүлгийн үр дүнд авлигын гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байгууллагуудад тусгайлсан хугацаатай зөвлөмж өгөх, цар тахлын үед цугларсан хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад хамтран хяналт тавих, худалдан авах ажиллагаанд зориулан тусгайлсан заавар боловсруулж, төрийн байгууллагуудад түгээх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор мэдээлэл байршуулах заавар боловсруулах зэрэг саналуудыг оролцогчдоос дэвшүүлж, цаашид цар тахлын үед төрийн байгууллагуудын хүлээн авсан хандив, тусламж, зарцуулсан хөрөнгөнд үргэлжлүүлэн хяналт тавьж, хамтран ажиллахаар болов.

Нээлттэй нийгэм форум” ТББ нь “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалтын үнэлгээний тайлан”-г хийж гүйцэтгэн, үр дүнг танилцуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг тодорхойлох үзүүлэлтүүдийн дундаж дүн 64 хувьтай гарчээ. Энэ нь СЗХ-ны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-д зааснаар Монголын хөрөнгийн бирж дээрх ТОП-20 хувьцаат компанийн засаглалын түвшин “дунд” буюу удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй эрсдэлтэй гэж үзсэн байна. Хувьцаат компанийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байж, гүйцэтгэлээ үнэн зөв, хариуцлагатай тайлагнах нь урт хугацаанд тогтвортой, үнэ цэнэтэй, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлнэ гэж дүгнэсэн.

Эрчим хүчний салбарт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт, үндэсний стандарт, судалгаа шинжилгээ, ТЭЗҮ боловсруулах, баталгаажуулах үе шатанд тухайн төсөлд талуудын оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах, зөвшилцөх, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд салбарын үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эрчим хүчний ассоциаци, Эрчим хүчний инженерүүдийн холбоо зэрэг мэргэжлийн ТББ-тай нягт хамтран ажиллаж байна. Энэ чиглэлээр яамны ШУТЗ, нормчлолын удирдах зөвлөл болон бусад холбогдох ажлын хэсгүүдийн гишүүдийн 17-20 хувьд мэргэжлийн ТББ-ын төлөөллийг томилон ажиллуулснаар тухайн төрийн байгууллагын үйл ажиллагаанд ТББ хяналт тавих боломжийг бүрдүүлэв. Мөн <https://www.ipom.gov.mn/> цахим хуудсаар дамжуулан



байгууллагын үйл ажиллагаа, авлигын эсрэг үйл ажиллагаа, хүний нөөц, шилэн данс болон оюуны өмчийн газрын даргын тушаал, хууль эрх зүйн болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажилласан болно.

Авлигатай тэмцэх газраас жил бүр гаргадаг Шударга байдлын үнэлгээгээр яамд, агентлагийн дунджаас доогуур үнэлэгдсэн байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, тулгарч буй асуудал, бэрхшээлийг тэдний дэмжлэгтэйгээр шийдвэрлэх, тухайн салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг багасгах талаар тогтмол зөвлөмж хүргүүлснээр худалдан авах ажиллагааг үнэлэх Үнэлгээний хороог төрийн бус байгууллагын төлөөлөлгүй байгуулах зөрчил эрс буурсан. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явцад иргэн, иргэний нийгмийн байгууллага, сонирхогч этгээдээс хяналт тавих боломжийг олгох, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах зөвлөмжийг тухай бүр хүргүүлж байна. Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор төрийн байгууллагууд Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнаж, үр дүнг tender.gov.mn-д байршуулан ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.7.3-2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх /ЗГХЭГ, аймаг, нийслэлийн Засаг дарга 2018-2022/

Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох үүднээс ГХЯ-ын үйл ажиллагаанд 2016 оноос хойш хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж байгаа болно. ГХЯ-ны 2019 оны хэрэглэгчийн үнэлгээний дүн 83.48 хувь буюу 3.16 оноо авав. Төрийн зарим ажил үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлж, монгол иргэдэд консулын үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх, Виз мэдүүлэгчийн хувьд цаг хугацаа хэмнэх, визийн үйлчилгээ хялбар шуурхай болж, газар зүйн байршлаас үл хамааран виз авах нөхцөл бүрдүүлэх үүднээс БНСУ-ын Сөүл дэх "Автохолдинг ХХК"-иар визийн үйлчилгээг гүйцэтгүүлэх " Монгол улсын виз мэдүүлгийн төв"-ийг ажиллуулж байна. БНСУ-ын Пусан дахь "VFS Глобал" компаниар визийн үйлчилгээ гүйцэтгүүлэх "Монгол улсын виз мэдүүлгийн төв"-ийг мөн байгуулан ажиллаж байна. Ингэснээр БНСУ-д виз олголт дунджаар 13-17 хувиар өсч

байгаа бөгөөд нийт визийн 97 хувийг БНСУ-ын иргэдийн жуулчны виз эзэлж байна. Засгийн газрын 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалаар яамдад хийсэн чиг үүргийн шинжилгээ хийснээр ХХААХҮЯ Газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого үндсэн чиг үүргийн хүрээнд таримал ургамлын үр, үслэг, суулгацын хангамж, сортын бүртгэл, үржүүлэх, нөөц бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг, мал аж ахуйн хөгжлийн бодлого үндсэн чиг үүргийн хүрээнд мал сүргийг эзэмлэх, бүртгэлжүүлэх гэх мэт 13 эрх хэмжээг; Эрчим хүчний яам нормативын баримт бичгийг боловсронгуй болгох зэрэг чиг үүргийг тус тус Мэргэжлийн холбоод, ТББ-аар гүйцэтгүүлэхээр санал гаргасан бөгөөд холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар шийдэх юм.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Эрчим хүчний сайдын 2020 оны 286 дугаар тушаалаар эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох түр журмыг баталсан. Журмаар тухайн чиглэлийн тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг мэргэжлийн ТББ-д шилжүүлэх юм.

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хүрээнд 2020 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн 3 телевиз, МҮОНРТ-ын орон нутаг дахь сурвалжлагч, нэг богино долгионы радио, нэг сар тутмын сэтгүүл, 3 сар тутмын сонин, 2 вэб сайт, МҮОНР-ийн сурвалжлагч нийт 12 байгууллагатай 45 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний гүйтэтгэлээр 37.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Нэмэлт санхүүжилтийн дансны 210801 зардлын зүйл ангиар хөрөнгийг зарцуулж, шилэн дансанд болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлд оруулж [www.uvurkhangai.mn](http://www.uvurkhangai.mn) сайтын шилэн төсөв цэсний "Төсвийн гүйцэтгэл" цонхонд байршуулж олон нийтэд ил тод мэдээлж байна. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх чиглэлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор шинэчлэн, хэрэглэгчийн сэтгэл ханамж, хөндлөнгийн үнэлгээ зэрэг чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллав. Сэлэнгэ аймгийн Засаг даргаас 2020 онд аймагтаа идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Улаан загалмайн нийгэмлэг гэх зэрэг төрийн бус байгууллагатай тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээний дагуу нийт 20.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж үр дүнг улирлаар

тооцон ажилласан. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан нийт 10.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.7.3-3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээлэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах /ЗГХЭГ, ХЗДХЯ, холбогдох бусад яам, ТББ 2020-2022/

Энэ хүрээнд төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хөндлөнгийн шинжээчдээр гүйцэтгүүлэхээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан ба үнэлгээг “Жи Би Эм Сошиал ресерч консалтинг” ТББ гүйцэтгэж, тайланг 2020 оны 02 дугаар сард хүлээн авсан. Хөндлөнгийн үнэлгээний тайланг төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтээр 2020 оны I дүгээр улиралд хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгууллахаар туссан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдсоор 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөө” сэдвийн дор цахим хэлбэрээр зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, “Жи Би Эм Сошиал ресерч консалтинг” ТББ, Монголын хуульчдын холбоо, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, “Баасанжав Консалтинг” ХХК, “Монголын авто замчдын холбоо” ТББ, “Монголын авто тээвэрчдийн холбоо” ТББ, “Монголын барилгын үндэсний ассоциац” ТББ, “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Нээлттэй нийгэм форум” ТББ, “Хүний хөгжил судалгааны төв” ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл нийт 42 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийг Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төв фэйсбүүк пейж хуудсаар лайв хэлбэрээр түгээж олон нийт оролцох боломжийг хангаж ажиллав. Хэлэлцүүлэгт оролцогчид төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа асуудал нь маш чухал гэдгийг онцолсон бөгөөд олон улсын нийтлэг туршлагад үндэслэж явж байгаа тул эрх зүйн баталгааг бий болгох, үйл ажиллагааг сайжруулах нь зүйтэй

гэдэгт санал нэгдэж, ЗӨВЛӨМЖ гаргав.

Төрөөс нийтийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх үйл явцыг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх харилцааг зохицуулсан эрх зүйн орчин, гадаадын зарим улсын эрх зүйн тогтолцоо, туршлагыг судлах, үүний үндсэн дээр бодит байдлыг тодорхойлох зайлшгүй шаардлага бий болсон. Гэтэл энэ чиглэлийн ажлын үр дүнгийн үнэлгээ өнөөдрийг хүртэл хийгдээгүй тул Засгийн газар эцсийн үр дүн ямар байгааг, хэрхэн сайжруулж болох тал дээр ойлголт багатай байна. Авлигатай тэмцэх газраас захиалан хийлгэсэн үнэлгээний үр дүнг холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлснээр цаашдын бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой боллоо гэж хэлэлцүүлэгт оролцогчид онцлов. Хэлэлцүүлгийг “Олон нийтийн төв” фэйсбүүк пэйж хуудсаар лайв хэлбэрээр түгээж, олон нийт оролцох боломжийг хангасан. (Биелэлт 30 хувь)

4.1.7.4-1 Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах /АТГ, ХЗДХЯ 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулахаар тусгагдсаны дагуу орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах чиг үүрэг бүхий авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг 2017 онд байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 30 байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүн, 2019 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллуулж байсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/53, А/44 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Засгийн газрын яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий

Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журам” хүчингүй болсонтой холбоотойгоор уг зөвлөлийн үйл ажиллагаа зогссон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан “Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх /код-109/ журам”-д Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих орон тооны бус зөвлөл байгуулах А/190 тушаалаар орон тооны бус зөвлөлийг байгуулсан. 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хамтран ажиллах олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдтэй хууль тогтоомжоор олгосон эрх, чиг үүргийн хүрээнд авлигын гэмт хэрэг болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох, бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулж, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Олон нийтийн цагдаа нарыг ажиллуулж, мэргэжил арга зүй дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох” гэж заасан. Төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч, төсөлд тусган Засгийн газрын тогтоолын төслийг батлуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.7.4-2. Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдийг сургах, чадавхжуулах /АТГ 2017-2022/

Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон яам, агентлагийн дэргэд ажиллах Авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийн 152 гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 01, 05 дугаар саруудад зохион байгуулан энэ хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хяналт шалгалт, үр нөлөө”, “Нээлттэй мэдээллийг ашиглаж албан тушаалтанд хяналт тавих нь”, “Цахим худалдан авалтын үйл ажиллагаа: Хөндлөнгийн хяналт, арга зам”, “Төсвийн төлөвлөлт ба үр ашгийг хянах арга зүйд суралцах нь”, “Төсвийн үйл явцад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх арга зам, туршлага”, “Худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлээс

урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвээр сургалт хийж, иргэний хяналтыг орон нутагт бэхжүүлэх чиглэлээр ажиллах иргэдэд тусгайлсан мэдлэг, мэдээлэл, арга зүйд сургасан. Төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан журам Засгийн газрын тогтоолоор батлагдвал, энэхүү журмын дагуу байгуулагдах зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр арга хэмжээ авахаар төлөвлөж байна. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.7.4-3. Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журмыг батлуулж, мөрдөх /АТГ 2017/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар зарлигаар “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн ажиллах журамд заасны дагуу 2020 оны нэгдүгээр улиралд ОНЗ нь 2 удаагийн хуралдаан зохион байгуулж 2020 оны ажлын төлөвлөгөө, орон нутагт хүрч ажиллах тухай, ОНЗ-ийн дэд зөвлөлийг зохион байгуулах болон дотоод үйл ажиллагааны асуудлууд болон өргөдөл гомдлын явцын талаар хэлэлцсэн. АТГ-ын [www.iaac.mn](http://www.iaac.mn)-д Олон нийтийн ажиллах журам, нэмэлт өөрчлөлт, ОНЗ-ийн гишүүдийн мэдээлэл, ОНЗ-өөс зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг оруулж, олон нийт цахимд орж танилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

#### 4.1.7.5-1. Авлигын тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг боловсронгуй болгох /АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар зарлигаар “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын хоёрдугаар зүйлийн 2.1-д зөвлөл олон нийтийг төлөөлөх хэрэгжүүлэх асуудлаар авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, үнэлэх, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, нийтийн сонсгол зохион байгуулах, төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжид АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн явц, үрдүнтэй танилцах, авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд тайлбарлан таниулах сургалт, сурталчилгааны ажилд оролцох зэрэг нийт 23 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан

ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 186 дугаар зарлигаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэхүү зарлигаар Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлд “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн олон улсын болон үндэсний хөтөлбөр, төсөлд хамрагдах, оролцох” нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Мөн дээрх зарлигаар “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.3-т “Хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтрасан нийтийн сонголыг зохион байгуулах замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах” гэснийг “Хэлэлцүүлэг, зөвлөгөөн болон эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтарсан нийтийн сонголыг зохион байгуулах замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах, энэ хүрээнд Олон нийтийн дэд зөвлөлийг ажиллуулж болно” гэж өөрчлөн найруулжээ. (Биелэлт 100 хувь)

4.1.7.5-2. Олон нийтийн зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гишүүдийн урамшууллын асуудлыг шийдвэрлүүлэх /АТГ, ХЗДХЯ, АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018-2020/

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох” гэж заасны дагуу төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох журмын төсөлд хэрэгжүүлэх этгээдийн ажиллах нөхцөл боломж, урамшуулах асуудлыг тусгасан болно.

АТГ-ын Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмын 2.1.17-д АТГ-аас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж дуусган, хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргасан хэргийн үндэслэл материалтай танилцах, дүн шинжилгээ, судалгаа хийх заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах— чиглэлээр Нийслэлийн прокурорт санал хүргүүлсэн. Олон нийтийн зөвлөлийн гишүүд хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлигаас ангид байх хууль эрх зүйн зохицуулалт, иргэдийн оролцооны чиглэлээр мэдээлэл хийдэг. Олон нийтийн зөвлөлийн дарга 7 хоног бүрийн бямба гаригт Баасангийн цаг нэвтрүүлгийг хөтөлж, Монгол улсад тулгамдаж

байгаа асуудлуудыг иргэдтэй утсаар холбогдон мэдээлэл солилцож байна. МҮОНТ-ийн эрх зүйн цагаар ОНЗ-ийн дарга, гишүүд оролцон олон нийтэд авлигаас ангид байх, 110 үнэ төлбөргүй утсаар авлига, албан тушаалын гэмт үйлдэл, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил зэрэг мэдээллийг шуурхай авч байгаа талаар мэдээлэл түгээж, үндэслэлгүй хөрөнгөжихөөс ангид байхын тулд татварын тогтолцоог өөрчлөх талаар санал дэвшүүлсэн. ОНЗ нь Авлигатай тэмцэх газраас авлига албан тушаалын гэмт хэрэг мөн эсэх талаар мэдээлэл хүсч ирсэн иргэдийг хүлээн авч биечлэн уулзаж, хууль, зүйн туслалцаа үзүүлж /хуулийн зөвлөгөө/ өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг нотлох баримтын хамт хүлээн авч харьяалах байгууллагууд руу нь харьяаллын дагуу албан бичиг явуулах үйл ажиллагаанд нийт 67 иргэд хамрагдлаа. АТГ-ын дэргэдэх ОНЗ-ийн дарга, гишүүд Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр өдөр тутмын сонинд ярилцлага өгч, мөн “Өөр өнцөг” нэвтрүүлэгт оролцон, “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аянд нэгдсэн нь авлигатай тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагуудын нийгмийн хариуцлага, оролцооны томоохон илэрхийлэл болов ОНЗ-өөс санаачлан Монгол дархлаа нь авлигаас ангид байхаас эхлэлтэй гэсэн сэтгэхүйг олон нийтэд бий болгох зорилгоор цахимд уриалга гаргасан. ОНЗ-ийн гишүүд авлигаас ангид байхын тулд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон нийтийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх, шүгэл үлээгч нарыг хамгаалах зэрэг асуудлаар цахим мэдээлэл байнга солилцож, телеграмм хурлыг 7 хоног бүр тогтмол хуралдуулж хэвшсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.7.5-3. Олон улсын туршлагад тулгуурлан Олон нийтийн зөвлөлийн дэргэд Авлигын эсрэг иргэд, залуучуудын клубыг байгуулах /АТГ-ын дэргэдэх ОНЗ. АТГ 2018-2022/

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлөөс Их Британийн Засгийн газраас 2010 онд ашигласан сайн туршлага болох авлигыг мэдээлэхэд хэрэглэж буй Мэдээлж, Жигш аргад тулгуурлан “Авлигыг мэдээлж, Жигш(АМЖ)” клубыг үүсгэн байгуулсан. Авлигыг мэдээлж, жигш буюу “АМЖ клуб” нь <https://www.facebook.com/naming.shaming> сувгийг ашиглан мэдээлэл хүлээн авч, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг мэдээллийг олон нийтэд хүртээмжтэйгээр түгээх, ард иргэдийн санал бодлыг нийгмийн сүлжээгээр дамжуулан хүлээн авах, авлигаас

ангид байх, авлигыг мэдээлэх арга замыг түгээн ажиллаж байна.

“АМЖ клуб” нь Авлигын талаарх мэдээллийг хүлээн авах 110 дугаарын утсыг сурталчлах, холбогдох мэдээллийг иргэдэд хүргэх, хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажилласны зэрэгцээ иргэд, залуучуудын шударга ёсны ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх 3 модультай сургалтын бэлтгэл ажлын ханган, сургалтуудыг явуулав. Тус клуб нь олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO/MNS 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд тус стандартыг дагаж мөрдөх нь “Авлигыг мэдээлж, Жигш” клубын давуу тал байх болно. Дээрх олон улсын стандарт нь тухайн байгууллага, клубын үйл ажиллагааны чанарыг удирдах, хянах тогтолцоо ба олон улсын стандартын шаардлагад нийцсэн болохыг баталгаажуулдаг бөгөөд байгууллагын үйл ажиллагаа хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрэлт, шаардлагад нийцсэн байлгахад нь туслах зорилготой, дэлхийн 178 орны 1064000 байгууллагад хэрэгжсэн, дэлхийн хамгийн түгээмэл удирдлагын тогтолцооны стандарт юм. Цаашид авлигын эсрэг олон улсын стандарт, тэргүүн туршлагыг судалсан үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигагүй нийгэм, шударга ёсыг сурталчлах цахим хуудас тогтмол ажиллуулах, нийгэмд шударга ёс тогтоох олон талын ажлыг санаачилж, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.7.6-1. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан этгээдийг олон нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх /АТГ, ХЗДХЯ, ШЕЗ, ТББ 2018-2019/

Захиргааны ерөнхий хууль болон Төрийн албаны тухай хуульд хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн, мөн шүүхийн шийдвэрийн нээлттэй ил тод байх зарчим үйлчилж байгаа учраас дээрх асуудлаар мэдээлэх боломж бүрдсэн.

Шүүх, шүүхийн захиргааны онцлох үйл явдал, шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон олны анхаарал татсан авлига албан тушаалын хэргийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж байна. Мөн тухайн хэргүүдийн талаар иргэд олон нийтийг цаг алдалгүй мэдээллээр хангах зорилгоор олон нийтийн сүлжээг ашиглан “шүүхийн мэдээ” фейсбүүк пейж хуудсыг ажиллуулан шүүхийн шийдвэрүүдийн талаарх мэдээллийг хүргэж

байна.

Авлигатай тэмцэх газраас авлигын гэмт хэргийн улмаас төр, иргэн, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүргийн хүрээнд 2020 онд 35,6 тэрбум төгрөгийн, 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 72,4 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж төр, иргэн, нийтийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн бөгөөд энэ талаар байгууллагын цахим хуудас, iaас.mn мэдээллийн хуудас, “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлэг, твитер facebook пэйж хуудас, МҮОНР-ийн 110 мэдээллийн хөтөлбөр зэрэг хэвлэл мэдээллийн боломжит бүхий л хэлбэрээр иргэд олон нийтийн хүртээл болгосон. Тус газраас газраас авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан этгээдийг олон нийтэд ил тод мэдээлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон. (Биелэлт 70 хувь)

4.1.7.6.-2. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох, нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх /ХЗДХЯ, АТГ, ТББ 2020-2022/

Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох боломжгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцэж, 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан. Уг хуультай холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, мөн өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцохоор холбогдох өөрчлөлтийг оруулсан болно. Түүнчлэн тус яамнаас санаачлан боловсруулж 2017 онд батлуулсан Прокурорын тухай шинэчилсэн найруулгын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах”, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх,

эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авна” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж, мөн зүйлийн 20.2 дахь хэсэгт “Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх дээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй” байхаар, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тогтоол, даалгавар, зөвшөөрөл, шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, санал, эсэргүүцэл, хүсэлт, нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана гэж, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана” гэж тус тус хуульчилсан. (Биелэлт 30 хувь)

4.1.7.6-3. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын туслалцаа авах арга хэмжээг зохион байгуулах /АТГ, ЦЕГ, мэргэжлийн холбоод, ТББ 2020-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын туслалцаа авах арга хэмжээг чиглэлээр Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, тэдгээрийн гишүүн аж ахуйн нэгж, мэргэшсэн үнэлгээчид, аудиторууд болон хууль зүй, санхүүгийн чиглэлээр дагнасан орчуулга хийдэг мэргэжлийн орчуулагчдыг мөрдөн шалгах ажиллагааны явцад шинжээч, орчуулагчаар томилж дүгнэлт гаргуулж байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад 2020 онд 380.991.734 төгрөгөөр 48 санхүүгийн шинжилгээг, 77.796.600 төгрөгөөр 65 удаагийн үнэлгээг, 39.505.250 төгрөгөөр 21 удаагийн орчуулгыг тус тус мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн хамтран ажилласан. (Биелэлт 100 хувь)

**Найм. Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр нийт 5 үйл ажиллагааны хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2020 оны зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.8.1-1. Баримтад суурилсан сэтгүүл зүйг хөхиүлэн дэмжих, сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхийг нэмэгдүүлэх /АТГ, ХХМТГ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдэх үе шатанд сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газар Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб интернэшнл төв” ТББ байгууллагатай хамтран “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо”, “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад зохион байгуулсан ба Монголын сэтгүүлчдийн нэгдсэн холбооноос санаачлан орон нутгийн сэтгүүлчдийг чадавхжуулах зорилгоор «Орон нутгийн хэвлэл мэдээллийн II форум»-ыг 100 гаруй сэтгүүлч, уран бүтээлчдийн дунд, “Хуурамч мэдээлэл ба төөрөгдөл-Иргэдийн мэдэх эрхийг хамгаалах нь” сэдэвт анхдугаар чуулганыг 100 гаруй сэтгүүлчдийг хамруулан тус тус зохион байгуулсан.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Германы Фридрих Эбертийн сан, Дойче Велле Академи болон Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран «Хэвлэлийн эрх чөлөө ба Дижитал хувьсал» сэтгүүл зүйн ёс зүйн форум, Глоб Интернэшнл төвөөс Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хэвлэл мэдээлэл ардчиллын төлөө” төслийн хүрээнд хийсэн «Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт» судалгааны тайлан зорилтот бүлгүүдэд танилцуулж, санал, мэдээлэл солилцсон.

Мөн “Нийгмийн сүлжээ болон тоон контентын эрх зүйн орчин” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Иргэн, төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн сүлжээг зүй зохистой ашиглах мэдлэг ойлголт өгөх, цахим орчинд үйлдэгдэж байгаа аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нь зөвлөмж өгөх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын Хэвлэл мэдээллийн алба, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Гадаад харилцааны яам, Цагдаагийн Ерөнхий газар хамтран «Нийтлэхээсээ өмнө бодъё, тунгаая» санаачилгыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, бүх нийтэд түгээх зурагт хуудас, төрийн байгууллагуудад түгээх зурагт хуудас, Хэвлэл, мэдээллийн байгууллага болон мэдээллийн вэб сайтуудад түгээх зурагт хуудасны агуулга тус бүр 10 төрлийг бэлтгэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар, НҮБ-ын Хүүхдийн сан, “Fargo foundation Mongolia” төрийн бус байгууллагатай хамтран “Зөвийг түгээе” аяныг нэг сарын хугацаатай амжилттай зохион байгуулав.

Хэвлэлийн хүрээлэнгээс «Хуурамч мэдээлэлтэй хамтын хүчээр тэмцье» уриатай “TechCamp Mongolia-2019” Ази, Номхон далайн бүсийн цугларалтыг Монголд анх удаа АНУ-ын Элчин Сайдын яам, “Мидас” ТББ болон Хэвлэлийн Хүрээлэн хамтран зохион байгуулав. Оролцогч, зохион байгуулагчдаас бүрдсэн 100 гаруй хүн эдгээр өдрүүдэд цахим орчинд мэдээлэл эрж хайх, нягтлан шалгах бүтээлч санаачилгаа уралдуулан худал мэдээлэлтэй тэмцэх аргад суралцах интерактив хэлэлцүүлэг хийв. Энэхүү үйл ажиллагаанд Монгол, АНУ, Узбекистан, Казакстан, Киргиз, Вьетнам, Бутан, Непал, Мьянмар улсаас төлөөлөн ирсэн сэтгүүлч, нийгмийн сүлжээний идэвхтнүүд оролцсон бөгөөд сургагч багшаар гадаад, дотоодын 8 үндсэн багш нар болон Хэвлэлийн хүрээлэнгийн багш ажиллав. “Fact checking and verification”-ы сургалтын хөтөлбөр шинээр боловсруулж, сэтгүүлчдэд зориулсан нийгмийн сүлжээнд түгээж буй мэдээллийг ашиглах, бусдад түгээхээс өмнө нягтлан шалгах үндсэн алхам, баримтыг нягтлан шалгах, эх сурвалжийг баталгаажуулах зарим арга, нийгмийн мэдээллийн сүлжээ болон Интернэтийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хэрхэн ашиглах талаарх мэдлэг олгосон цуврал сургалт зохион байгуулав. (Биелэлт 70 хувь)

4.1.8.1-2. Эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд сургалт зохион байгуулсан байх /АТГ, МСНЭ, Хэвлэлийн хүрээлэн, 2018-2020/

Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилго бүхий “Investigative Journalism Dialogue” эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын хурлыг хоёр жил дараалан

зохион байгуулав. Олон улсын хуралд Германы Дойче Велле олон улсын мэдээллийн агентлагийн Судалгаа ба Хамтын ажиллагааны төсөл, Хонг Конгийн Их сургуулийн “Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл судлалын төв”, ЮНЕСКО-гийн Бээжин дэх салбарын Мэдээлэл, харилцааны салбар, Нээлттэй Нийгэм Сангийн Хараат бус сэтгүүл зүйн хөтөлбөр зэрэг байгууллагын төлөөлөл, зочид оролцож, Монголын сэтгүүлчид, сэтгүүлзүйн багш, судлаачид, иргэний нийгмийн төлөөлөлтэй харилцан туршлага солилцлоо.

ХБНГУ-ын Дойче Велле Академи, Фридрих Эбертийн Сангийн тэтгэлгээр Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гурван долоо хоногийн сургалтад төв орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын 17 сэтгүүлч хамрагдаж амжилттай төгсөв.

Хэвлэлийн хүрээлэнгээс тоон мэдээллийг ашиглаж эрэн сурвалжилсан бүтээл бэлтгэх чадавхийг дээшлүүлэх цогц хөтөлбөрийн хүрээнд цуврал 5 сургалт, 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд “Дата сэтгүүл зүйн удиртгал”, “Дата өгөгдлийг дүрсжүүлэх нь”, “Дата анализ” зэрэг сургалтыг Хэвлэлийн Хүрээлэнгийн багш нар, төслийн зөвлөлтэй хамтран зохион байгуулснаас гадна Үндэсний Статистикийн хороо болон МУИС-ийн багш нартай хамтран статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүйн нэмэлт сургалтуудыг тус тус зохион байгуулав. Төслийн сургалтуудад хамрагдсан 4 баг бүтээлийн тэтгэлэг авч, эрэн сурвалжилсан Дата сэтгүүл зүйн бүтээл бэлтгэж, төслийн төгсгөлийн шатанд олон нийтэд танилцуулсан.

Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн, Азийн сангаас зохион байгуулсан “Залуусын дуу хоолой” чуулга уулзалтын “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба залуусын оролцоо” сэдвийн хэлэлцүүлгийг Хэвлэлийн Хүрээлэнгийн багш нар удирдан зохион байгуулав.

Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэй хэрэгжсэн Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол төслийн хүрээнд Хэвлэл мэдээлэл ба иргэдийн оролцоо, мэдээлэл авах эрх, эрх чөлөө, нийгмийн сүлжээ ба дижитал боловсрол, хуурамч мэдээллийг илрүүлэх тухай сэдвээр сургалт зохион байгуулав.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс 2020.9.15-ны өдөр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамтай хамтран “Мэргэшсэн ажилтан бэлтгэх бодлогыг сурталчлах нь” сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулав. МСНЭ-ээс 2020.12.17-ны өдөр “Цар тахлын үед орон нутгийн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд

тулгамдаж буй сорилт, бэрхшээл” сэдэвт цахим уулзалтыг бүсээр хуваан Баруун бүс /Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан/ Зүүн бүс /Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Налайх, Багануур/ Төвийн бүс /Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хөтөл/ аймгууд дахь салбар зөвлөлийн тэргүүн болон гишүүн сэтгүүлчидтэй зохион байгуулав. (Биелэлт 70 хувь)

4.1.8.2-1. Сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тохиолдолд “Нөлөөллийн мэдүүлэг” гаргах, хууль бус нөлөөлөлд хариуцлага хүлээлгэх асуудлыг судлах, санал боловсруулах /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, АТГ, ХЗДХЯ. 2018-2019/

Хэвлэлийн хүрээлэнгээс ХБНГУ-ын Ханс Зайдель Сан, Эрх Зүйн Боловсролын Академийн дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээллийн эрх зүйн асуудлаар гурван удаагийн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд хэвлэн нийтлэх эрх чөлөө, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбартай холбоотой амин чухал хууль, эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал, “Гүтгэх үйлдлийн тухай ойлголт”, Төрийн ба албаны нууцын тухай хуулийн зохицуулалтыг хөндөв. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл болон 300 гаруй сэтгүүлч нэгдэж 2020.4.27-ны өдөр хуулийн байгууллагын алба хаагч сэтгүүлчийн биед халдсан асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад мэдээлэл хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, албан ёсны цахим хуудастаа 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байршуулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 13.14 “Худал мэдээлэл тараах” заалтыг өөрчилж, хэвлэлийн болон иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүхий л талаар хянан цагдах, хязгаарлан боомилохоор тусгасан талаар МСНЭ-ээс байр сууриа илэрхийлэн, мэдэгдэл гаргасан.

Хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулж буй эвлэл, холбоод 2020.12.18-ны өдөр нэгдэж, Хэвлэлийн эрх чөлөөний төлөө Үндэсний түр зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөл нь Хэвлэлийн эрх чөлөөг хангах, хамгаалах, баталгаажуулах үндсэн чиглэлээр ажиллах бөгөөд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг батлах хүртэл үндэсний хэмжээний зөвшилцлийн үйл ажиллагаа явуулж байхаар тогтсон байна. /Биелэлт 30 хувь/

4.1.8.2-2. НҮБ-ын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй орчинг бүрдүүлэх уриалга, ЮНЕСКО-гоос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнах /ГХЯ, 2017-2020/

НҮБ-аас гаргасан уриалга, ЮНЕСКО-гоос Монголын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн дагуу сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулснаас гадна гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс сурвалжлага, нэвтрүүлэг хийх гадаадын сурвалжлагчдын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, ГХЯ дээр бүртгэн, түр сурвалжлагчийн үнэмлэх олгож байна. Гадаад харилцааны яамнаас 2020 онд нийт 18 гадаадын хэвлэл мэдээллийн агентлагуудын төлөөлөгчдийг бүртгэж, сурвалжлагчийн үнэмлэх олгосон. Гадаад харилцааны чиглэлээр дагнан бичдэг, энэ сэдвийг сонирхон судалдаг сэтгүүлчдийн “Дипломат клуб”-ын үйл ажиллагааг сэргээн нээлтийн ажил болгож, 14 хоногийн сургалтыг Дипломат Академитай хамтран 30 хэвлэл мэдээллийн байгууллагын 32 сэтгүүлч, редакторыг хамруулан зохион байгуулав.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр хараат бус судлаачидтай хамтран “УИХ-ын сонгуулийн жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох хэргийн шийдвэрлэлт” судалгааг хийв. Энэхүү судалгааг 2020 оны 6 дугаар сарын 2-ноос 8 дугаар сарын 19-ний өдрүүдэд ЦЕГ, ТЕГ, ХХЗХ, УЕПГ-аас Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой гомдлуудын тоон мэдээлэл дээр үндэслэн хийж, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “Хэвлэл мэдээллийн бодлого” цуврал дугуй ширээний ярилцлагын 5 дахь цувралын үеэр танилцуулсан. Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллага, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол” төслийн хүрээнд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын үндэсний форумыг Монголд анх удаа Хэвлэлийн хүрээлэнгээс зохион байгуулав. Форумд төрийн болон болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн төлөөлөл, дунд сургуулийн багш, албан бус сургалтын байгууллагын төлөөлөгч нийт 100 гаруй хүн оролцож, Монголд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг хөгжүүлэхийн ач холбогдол, шаардлага хэрэгцээ, нөхцөл байдал,



тулгамдсан асуудлуудыг хэлэлцэв. (Биелэлт 70 хувь)

**4.1.8.3-1. Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ 2017-2019/**

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн салбарын эрх ашгийг илэрхийлэх саналыг тусгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хэлэлцүүлэг”-ийг 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Авлигатай тэмцэх газар, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл хамтран зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт сэтгүүлзүй, хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн төрийн бус байгууллага, редакц, сэтгүүлчдийн 150 орчим төлөөлөл оролцож, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас танилцуулсан хуулийн төслийг хэлэлцэж саналаа өгөв.

Тус хэлэлцүүлгийн үр дүнд салбарын саналыг авах Ажлын хэсгийг 20 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ба 3 дугаар сарын 3-ныг хүртэл нийт таван удаа хуралдаж, нэг удаагийн уулзалт хийсэн. Хэвлэл мэдээллийн салбарын саналыг авах, нэгтгэх зорилгоор байгуулсан хэлэлцүүлэг, Ажлын хэсгийн хуралдаан, уулзалтуудын үр дүнд боловсруулалтын шатанд 50 орчим хувьд нь өөрчлөлт орсон ба уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагын хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, редакцын талаарх мэдээлэл олон нийтэд ил тод байх зэрэг олон шаардлагууд тусгалаа олсон болно. (Биелэлт 30 хувь)

**4.1.8.3-2. Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч, хөрөнгө оруулагчийг олон нийтэд мэдээлж байх үүргийг хуульчлах, уг үүргийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /МСНЭ, ХМЗ 2020-2022/**

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг 2019 онд баталсан ба уг хуулийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэхүү хуулиар Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгах асуудлыг зохицуулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшигчийн овог,

эцэг /эх/-ийн нэр, нэр, компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалт, эзэмшиж байгаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нэр, төрөл, тоо, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад хуулийн этгээдэд эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ, хэрэв нөхөрлөл бол оруулсан эд хөрөнгийн хэмжээ зэргийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхээр заасан. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчлэн найруулгын төсөлд Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн ил тод байдлыг хангах талаар, ялангуяа хуулийн этгээдийн нэр, хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл санхүүгийн тайлан ил тод, нээлттэй байхаар тусгасан.

Олон улсын авлигатай тэмцэх XIX хуралд Хэвлэлийн Хүрээлэнгийн төлөөлөл оролцож хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хараат бус байдал, улс орны авлигын нөхцөл байдалтай хэрхэн холбогдож буй талаар санал бодлоо солилцлоо. Хэвлэлийн Хүрээлэнгээс тогтмол хэрэгжүүлж буй Media watch онлайн хэлэлцүүлгийн үеэр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, түүний хязгаар, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын мөн чанар, гүтгэлэг ба худал мэдээлэл, хэвлэл мэдээлэл ба нийгмийн мэдээллийн сүлжээ гэсэн үндсэн 4 сэдвийн хүрээнд анализ хийн, хэлэлцүүлэг өрнүүлэв. (Биелэлт 30 хувь)

**4.1.8.4-1. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой ажлаа ил тод мэдээлэх, гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018-2022/**

ХЗДХЯ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төлөөлөл орж, хамтран ажиллаж байна.

Хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан 2019, 2020 онд “Хэвлэл мэдээлэл ба тав дахь засаглал”, «Хэвлэлийн Эрх чөлөө - Иргэдийн Эрх чөлөө» сэдэвт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөг хадгалж, баталгаажуулах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудад тулгарч буй асуудал, өөрчлөлт,

хөгжлийн чиг хандлага, сэтгүүлчдийн итгэл үнэмшил, үүрэг, хариуцлага, эрх зүй зэрэг асуудлуудыг хэлэлцэв.

Конрад-Аденауэр-Сангийн санхүүжилттэйгээр “Хараат бус хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин” сэдэвт дугуй ширээний уулзалтыг хэвлэл мэдээллийн байгууллагын 25 төлөөлөгчтэй зохион байгуулж, Монгол дахь хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн орчин, эрүүгийн хууль, гүтгэх, доромжлох асуудлыг зохицуулалт, хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтыг хэлэлцэв. (Биелэлт 30 хувь)

4.1.8.4-2. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэвлэл мэдээллийн байгууллагаар хийлгэсэн сурталчилгаа нийтлэл нэвтрүүлэгт зарцуулсан хөрөнгө, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй хамтран ажиллах чиглэлээр байгуулсан гэрээг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх /ХЗДХЯ, МСНЭ 2019/

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/39 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг хийсэн. Хуулийн төсөлд мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой холбогдох заалтуудыг тусган оруулж, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан танилцуулсан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулинд аливаа мэдээ, мэдээлэл нь Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд нээлттэй байхаар холбогдох заалтууд тусгагдан орсон. Шилэн дансны тухай хуулийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д мэдээ, мэдээллийг байршуулан мэдээлдэг. (Биелэлт 30 хувь)

4.1.8.5-1. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг редакци, сэтгүүлчдэд мөрдүүлэх, таниулан сургах, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах /Хэвлэл мэдээллийн зөвлөл 2017-2019/

Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо, Радио телевизийн Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн

гомдлыг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан хэлэлцэж, дүгнэлтээ гаргаж байна. Тус зөвлөл нь 2020 онд Хэвлэл мэдээллийн зөвлөлд иргэн, байгууллагаас редакцийн сэтгүүл зүйн агуулга нь ёс зүйн зарчим зөрчсөн, худал мэдээлэл агуулсан гэсэн нийт 52 өргөдөл гомдол ирүүлснийг Ёс зүйн хороод 6 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, өргөдөл гомдлуудыг шийдвэрлэсэн талаар 6 удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтэд нээлттэйгээр байршуулан (<http://www.mediacouncil.mn/as/shiidver>) хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээв.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчим, сэтгүүлчийн аюулгүй байдлын сэдэвт уулзалт, сургалтуудыг хэвлэл мэдээллийн байгууллага/редакциудад 12 удаа, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гишүүд, ажлын албанд 4 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сэтгүүл зүйн чанарын тухай хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд зориулсан хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага 6, хэвлэлийн бага хурал 1, кейс судалгаа, мониторингийн ажлыг 2 удаа тус тус зохион байгуулж, нийт 1000 гаруй хүнд хүрч ажиллажээ. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд цахим болон хэвлэмэл танилцуулгыг түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн мэдээллийн сүлжээгээр идэвхтэй түгээв. Салбарын эвсэл, холбоод, редакторууд болон дотоод, гадаадын түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд улирал тутам цахим сэтгүүл гаргаж, олон нийтэд түгээж байна. 2020 онд нийт дөрвөн дугаар гаргаж дотоодын 700 гаруй, гадаадын 100 орчим хүнд илгээв. Мөн өөрийн нийгмийн сүлжээний хуудсуудаар дамжуулан ёс зүйн зарчмаа баримтлан ажиллах уриалга бүхий мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд Ёс зүйн асуудал яагаад чухал вэ? хэмээх сэдвээр видео контентууд, Цар тахлын онцгой нөхцөл байдалд сэтгүүлчид хэрхэн ажиллах тухай редакторуудын байр суурийг илтгэсэн постерууд тус тус бэлтгэн түгээв. Өдрийн сонинд “Улс орнууд худал мэдээллийг Эрүүгийн хуулиар зохицуулахын эсрэг байр суурьтай байгаа” сэдвээр ярилцлага өгөх, Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сонгуулийн сурталчилгаа болон цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөөний асуудлын талаар редакторууд, салбарын мэргэжилтнүүдийн үзэл бодол бүхий

эшлэл, “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” гарын авлагыг 15 хэсэг бүхий карт байдлаар гаргаж, хэвлэмэл (1000 хувь) болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээв. Гарын авлагын агуулгад Чөлөөт, хараат бус хэвлэл, Мэдэх эрх ба өөрийн зохицуулалт, Сэтгүүлчийн ёс зүй, Хүний эрх ба хэвлэл мэдээлэл, Зөрчигдсөн эрхээ сэргээх нь, Иргэний гомдлыг барагдуулах нь зэрэг сэдвүүдийг багтсан болно. Уг гарын авлагыг Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр бүтээсэн. Цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөөний асуудал, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчлэл, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн нэмэлт, өөрчлөлтийн санал, Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын талаар хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч, мэдээ нийтлэлд эх сурвалжаар оролцон хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлж, олон нийтийг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тухай мэдээ, мэдээллээр тогтмол хангаж байна.

Хэвлэлийн хүрээлэнгээс ХБНГУ-ын Дойче Велле Академи, Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран “Цахиур” эрэн сурвалжлах сэтгүүл зүйн шилдэг бүтээлийн уралдааныг гурван жил дараалан зохион байгуулав. ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сантай хамтран “Media and Me” нэг өдрийн сургалтыг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл,

**Ес. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9 дэх зорилтын хүрээнд нийт 8 үйл ажиллагаа, 17 арга хэмжээг тусгасан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.9.1-1. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланг ил тод мэдээлэх, мэдээлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх чиглэлээр хууль тогтоомжид байгаа зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх /СЕХ, 2018-2019/

Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах, энэ хүрээнд Төрийн аудитын байгууллагын эрх, үүргийг тодорхой болгон зохицуулсан байна.

*Тухайлбал,* Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэхээр тусгасан.

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуульд оролцсон нэр дэвшигч, нам эвслийн сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудасны “УИХ сонгууль” / “зардал” цэсэнд 2008, 2012, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг байршуулан, нээлттэй мэдээлж байна. Мөн цахим хуудсыг шинэчилж Улсын Их Хурлын сонгууль 2020 цэсэнд “сонгуулийн зардал” цэсэнд Сонгуульд оролцсон нам, эвслийн Улсын Их Хурлын сонгуулийн зардал, санхүүжилт, тайланг нээлттэй танилцах боломжийг бүрдүүлсэн.

Мөн тус зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд өмнө үйлчилж байсан Сонгуулийн тухай хууль (2019.12.20-ны өдрийн хуулиар хүчингүй болсон хууль)-ийн 60 дугаар зүйлийн 60.5-д “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж заасны дагуу УИХ-ын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд тайлангаа ирүүлээгүй намыг бүртгэхээс татгалзах шийдвэр (Сонгуулийн Ерөнхий Хорооны 2018 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 22 дугаар тогтоол)-ийг гаргаж хуулийн хэрэгжилтийг хангаж байсан. Гэвч уг зохицуулалт шинэ хуульд тусгагдаагүй байна. Нөгөө талаас, дээрх зохицуулалтууд нь улс төрийн намын сонгуулийн үеийн зардлын тайлангийн ил тод байдалтай холбогдох зохицуулалт бөгөөд 2019 оны 12 дугаар шинэчлэн батлагдсан тул хэрэгжилтийг тайланг үнэлэх хугацаа нөхцөл бүрдээгүй байна.

Улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаа, нэн ялангуяа сонгуулийн бус үеийн санхүүжилт, түүний ил тод байдлыг зохицуулсан хууль тогтоомж шинэчлэгдээгүй хэвээр байна. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт. Улс төрийн намын санхүүжилтийн талаар зохицуулалтыг хуульчилсан бөгөөд “20.3.Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.” гэж заасан нь уг бүлэгт 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс хойш нэмэлт, өөрчлөлт ороогүйн дээр, хэрэгжилт нь хангалтгүй, мөн зохицуулалт нь хэт ерөнхий, аудит, хяналт шалгалт хийх тогтолцоо нь тодорхойгүй, олон улсын стандартаас хол зөрүүтэй хэвээр байгааг олон улсын болон дотоодын судалгаануудад<sup>1</sup> дурдагдсан байна.

<sup>1</sup> OECD. Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ. Монгол Улс дахь авлигын эсрэг шинэтгэл. Истанбулын авлигын эсрэг

Улс төрийн намын санхүүжилт нь сонгууль жилийн болон бусад жилийн санхүүжилт гэсэн 2 төрөлд хуваагдаж байгаа бөгөөд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар сонгууль жилийн санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулна. Харин бусад жилийн санхүүжилттэй холбоотой харилцааг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулах бөгөөд уг асуудал нь Сонгуулийн төв байгууллагын эрхлэх асуудалд хамаардаггүй. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7.1.10-т “сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хуралд санал тавих;” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, хуульд сонгууль жилийн санхүүжилтийг ил тод нээлттэй болгох талаарх санал хүргүүлж ажилласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиудад холбогдох зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, Сонгуульд оролцож буй нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг төрийн аудитын дээд байгууллагаас тогтоож нийтэд мэдээлдэг. Төрийн аудитын дээд байгууллагаас зардлын дээд хэмжээ тогтоосон аргачлал буюу хэрхэн тооцож дээд хэмжээг тогтоох асуудлыг тодорхой болгосон. Сонгуулийн тухай хуульд зааснаар нэр дэвшигчийн сонгуулийн зардлын нэг бүрдэл нь хандив бөгөөд хандив нь мөнгөн болон мөнгөн бус хандив байхаар хуульчилсан(Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 55.4). Сонгуулийн санхүүжилтийг ил тод байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд туссанаас гадна сонгуулийн зардлыг бууруулахад чиглэгдсэн үр дүнтэй зохицуулалтуудыг туссан(Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах).

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсаар олон нийтэд нээлттэй байршуулж, Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуульд оролцогчдод хандсан зөвлөмжийг арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингийн тайлан. 2019 он, 132-133 дахь тал. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Нээлттэй нийгэм форум. Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин: дүн шинжилгээ, санал зөвлөмж, 2018 он, 11, 18 дахь тал.

боловсруулан хүргүүлж, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хуулиар чиг үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахаас гадна гадаадын болон дотоодын төрийн бус байгууллага хяналт шинжилгээ, мониторинг хийж, үр дүнгээ нийтэд танилцуулах нь сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой байдаг. Иймд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.13-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.” гэж хуульчлагдсан.

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т зааснаар эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй иргэн төрийн жинхэнэ албанд томилогдох эрхтэй. Гэтэл төрийн улс төрийн өндөр албан тушаалд сонгогдох нэр дэвшигчид уг шаардлага тавигдахгүй байгаа нь зохимжгүй, өмнө нь сонгогдож эрх мэдэл, албан тушаалд хүрсэн хүн сонгогчдын итгэлийг алдаж авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон бол түүнийг дахин нэр дэвших эрхийг нь хязгаарлах шаардлагатай гэж Хууль тогтоогчдоос үзэж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж хуульчилсан. Энэ жишгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн “28.8.Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж хуульчилсан. (Биелэлт 70 хувь)

4.1.9.1-2. Сонгуулийн зардлын тайлангийн хяналт, ил тод байдал, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлд намын сонгуулийн зардлын тайлан, тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах, энэ хүрээнд Төрийн аудитын байгууллагын эрх, үүргийг тодорхой болгон зохицуулсан байна(Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.3, 58.1, 58.3, 58.4).

Түүнчлэн, дээрх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэгт тодорхойлсон бөгөөд тус хуульд 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан байна(Зөрчлийн тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйл). Уг хуульд хариуцлагын арга хэмжээг торгуулийн хэлбэрээр тодорхойлж өгчээ. Өмнөх Сонгуулийн тухай хууль (2019.12.20-ны өдрийн хуулиар хүчингүй болсон, 60 дугаар зүйлийн 60.5)-д “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй” гэж заасан зохицуулалт шинэ хуульд тусгагдаагүй байна. Түүнчлэн сонгуулийнхаас бусад үеийн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтын асуудал шинээр батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд хамаарахгүй байгааг өөрчлөх шаардлагатай.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн 21 дүгээрт Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан бөгөөд уг асуудлыг хуулийн төсөлд тусган боловсруулахаар бэлтгэн ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.2-1. Улс төрийн намуудад төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлыг тайлагнах, ил тод мэдээлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх /ХЗДХЯ, 2017-2019/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг цахим хуудаст ил тод байршуулж, тайлан гаргаагүй нэр дэвшигчид Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулах ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч явуулахаар хуульд зохицуулсан.

Сонгуулийн ерөнхий хорооны хувьд тайлан гаргаагүй нэр дэвшигчдийн талаарх холбогдох мэдээллийг 21 аймаг, нийслэлийн дүүргийн татварын хэлтэст зөвхөн тухайн шатны прокурорын зөвшөөрлөөр 24 удаагийн албан бичгээр нийт 185 нэр дэвшигчийн мэдээллэл өгч хамтран ажиллав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд уг хуулийн 17.1-д Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчлийн төрлүүдийг тодорхой

хуульчилсан. 17.1 дэх хэсгийн 21-27 дугаар зүйлд сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах, хандив өгөх, авах, шилжүүлэх, сонгуулийн явцын болон эцсийн тайланг гаргах хугацаа, журам, сонгуулийн зардлын данс ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлагыг анх удаа тодорхойлон хуульчилсан онцлогтой. (Биелэлт 70 хувь)

4.1.9.2-2. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх /ХЗДХЯ, 2018-2022/

Нэр дэвшигчдийн сонгуулийн явцын тайлан нь сонгогч сонголтоо хийхээс өмнө тухайн нэр дэвшигч ямар зардал, хөрөнгөөр сонгуульд нэр дэвшиж байгаа талаарх мэдээллийг нээлтэй авсны үндсэн дээр сонголтоо хийх боломжийг олгодог ач холбогдолтой зохицуулалт юм. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын явцын тайланг нийтэд ил тод мэдээлж ажиллав. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т “Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 26.3.6, 26.4.6, 38.5-д заасан мэдээллийг дүгнэлт гаргаж дууссан өдрөөс эхлэн, 58.4-т заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгоно.” гэж заасны дагуу Үндэсний аудиийн газар холбогдох мэдээллийг цахим хуудсаараа нээлтэй мэдээлж ажилласан. Харин сонгуулийн бус үед улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох нөхцөл хангалттай бүрдээгүй байна (Биелэлт 30 хувь)

4.1.9.3-1. Парламентад суудалгүй намуудад төрөөс олгох санхүүжилтийг хүртээмжтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх /СЕХ, 2017-2019/

Улс төрийн намын тухай хуулийн төслийг ажлын хэсэг боловсруулж байгаа бөгөөд Сонгуулийн санхүүжилт, улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй, ил тод байлгахад чиглэгдсэн судалгаанууд болон уг эрдэмтэн, судлаачдын саналыг хуулийн төсөлд тусгах талаар хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. (Биелэлт 10 хувь)

4.1.9.3-2. Төрөөс улс төрийн намуудад үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох, сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч, улс төрийн намуудыг төлөвших, санхүүгийн хувьд нөлөөнд автахгүй байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, оновчтой арга замыг тодорхойлох /СЕХ, 2017-2022/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албанд техникийн туслалцаа авах хүсэлтийг хүргүүлж “Улс төрийн намын бүртгэл, санхүүжилт болон хяналт, ЕАБХАБ-ын гишүүн орнуудын “Сайн туршлага”-ын талаар мэдээлэл, судалгаа; түүнчлэн Улс төрийн намын тухай хуулийн төсөлд ЕАБХАБ-аас ирүүлсэн санал, зөвлөмж ирүүлснийг хүлээн авч, хуулийн төсөл боловсруулахад ашигласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, судлаачдын төлөөллийг оролцуулан “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль-Сонгуулийн санхүүжилт” хэлэлцүүлгийн 2019.12.25-ны өдөр зохион байгуулсан. Түүнчлэн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албанаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл болон Улс төрийн намын тухай хуулийн төсөлд ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэн ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Дэлхийн сонгуулийн байгууллагын холбоо (А-WEB)-ноос Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчеон хотноо зохион байгуулсан Сонгуулийн байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн “Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” сэдэвт сургалтад СЕХ, улс төр судлаач, Аудитын ерөнхий газрын төлөөллийг оролцуулсан бөгөөд сургалтын агуулга, сэдвийн хүрээнд “Төсвийн дэмжлэг ба улс төрийн намын дотоод ардчилал” сэдвээр эрдэм шинжилгээний өгүүллийг бэлтгэн, “Бодлогод залуусын оролцоо” ТББ-аар дамжуулан олон нийтэд хүргэж ажиллав. (Биелэлт 30 хувь)

4.1.9.4-1. Сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгох /СЕХ, 2018-2019/

Сонгуулийн үйл ажиллагааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах үзэл баримтлал өөрчлөлт орж, сонгуулийн төрлөөр нь тус тусад зохицуулахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Аймаг, нийслэл,

сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр тус тус Улсын Их Хурлаас баталсан.

Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг ил тод нээлттэй болгох, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой зохицуулалтыг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тусгасан. Үүнд:

- Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг АТГ хүлээн авч, нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулна.
- Төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг батлахдаа түүнийг тогтоосон үндэслэл, аргачлалыг урьдчилан баталж, нийтэд мэдээлнэ.
- Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно.
- Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.
- Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад тусгаж, Төрийн аудитын дээд байгууллагаас баталсан хандивлагчийн мэдүүлгийн баримтыг мэдүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.
- Хуулийн этгээд мөнгөн хандив өгсөн бол уг хандивыг санхүү, татварын тайландаа тусгана. Үүнд Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн хуулийн этгээдийн нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- Хандивлагч хандив өгөх бол хуульд заасан шаардлага хангаж буй эсэхээ хандив хүлээн авагчид нотлох үүрэгтэй.
- Нам, эвсэл нь санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.
- Нэр дэвшигч, нам, эвсэл нь авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн

өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

- Төрийн аудитын дээд байгууллага хуульд заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.
- Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн мөрийн хөтөлбөр, зардлын талаарх хуульд заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, чөлөөтэй танилцах бололцоо олгоно. зэрэг сонгуулийн зардлын хяналт, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, сонгуулийн тухай хуулиудад өмнө нь байгаагүй, шинэлэг зохицуулалтууд орсон.

Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг бууруулах, ил тод мэдээлэх, сонгогчдыг мэдээллээр хангахад чиглэсэн хуулийн зохицуулалтын саналыг Сонгуулийн ерөнхий хорооноос бэлтгэж Улсын Их Хуралд хүргүүлсэн. (Биелэлт 100 хувь)

4.1.9.4-2. Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ, 2018-2019/

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусгаж өгсөн. Тухайлбал, Арван ес дүгээр зүйлийн 191.3.-т “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэсэн заалтыг нэмж тусгасан. Уг заалтын агуулгад нийцүүлэн органик хуулиудыг сайжруулахаар ажиллаж байгаа бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн төсөл батлагдаагүй, боловсруулах шатандаа байна. (Биелэлт 30 хувь)

4.1.9.5-1. Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шинэчлэн боловсруулах, УИХ-ын гишүүдийн шударга байдал, ёс зүйн дүрэм, шийдвэр гаргалтын үйл явцыг шинэчлэх, дагаж мөрдүүлэх үр дүнтэй механизмыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлээр төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зохицуулсан бөгөөд 40.1-д “Энэ хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно” гэж, 40.2-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтын дагуу Төрийн албаны зөвлөлөөс Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлан мөрдүүлж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд харьяа агентлаг, байгууллагууд руу 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр албан бичгээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэх алба руу мөн өдөр албан бичгээр “шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр олгосон, гэм буруутай албан тушаалтнаас хохирол төлбөр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан, шийдвэрлүүлсэн болон төлбөр олгогдоогүй хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгийн судалгаа” авах ажлыг зохион байгуулсан.

“Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийг УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос УИХ-д өргөн мэдүүлсэн. Төслийг УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, С.Ганбаатар, Н.Ганибал, Б.Энх-Амгалан нарын гишүүн санаачлан боловсруулсан ба УИХ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 45 дугаар захирамжаар “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, тогтоолын төслийн хамт өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын багийг УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнээр ахлуулан ажиллуулж байна. Дүрмийн төсөлд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо ёс зүйн зөрчил гаргасан гишүүнд зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулга өгөх, хатуу сануулга өгөх, уучлал гуйхыг үүрэг болгох, албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэлх хугацаагаар 20 хувиар бууруулах зэрэг хариуцлага ногдуулахаар тусгасан байна. “Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль”-ийн төслийг боловсруулж байгаа бөгөөд 2021 оны намрын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөгөөнд тусгагдсан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.9.5-2. Оффшор бүсэд данс эзэмшдэг этгээдийг төрийн албанд ажиллуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт тавих механизмыг бүрдүүлэх /ХЗДХЯ, АТГ, 2017-2019/

Улсын Их Хурал Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 04 дүгээр сард, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 05 дугаар сард тус тус баталсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.3</sup>-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан. АТГ-ын даргын 2017 оны 129 дүгээр тушаалаар 2012 оны 91 дүгээр тушаалд нэмэлт оруулж, «мэдүүлэг гаргагч албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулсан талаарх бүртгэл”-ийн маягт»-ыг баталсан. Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан АТГ-т мэдүүлж, мэдэгдэж бүртгүүлсэн болно. Дээрх хуулийн хэрэгжилт болон хуулийн хугацаанд үүргээ биелүүлж мэдэгдсэн албан тушаалтнуудын талаарх мэдээллийг тус газрын цахим сайтад байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Оффшор бүсэд хамаарах хориглолтын талаар яам, агентлаг, аймаг, нийслэл болон холбогдох албан тушаалтнуудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгч, хуулийг сурталчлан таниулах ажиллагааг зохион байгуулсан.

Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралтын “Оффшор бүсэд хамаарах гадаад

улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт” гэснийг “Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, нутаг дэвсгэрийн жагсаалт” гэж өөрчилж, шинэчлэн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 67 дугаар тогтоолоор баталсан. (Биелэлт 100 хувь)

4.1.9.5-3. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ, 2018-2022/

Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2-т “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол төрийн албанаас халах” зохицуулалтыг, Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлийн 10.1.6-д “гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дусгавар болох үндэслэл” байхаар, түүнчлэн тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” бол, мөн зүйлийн 9.1.2-т “гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан бол” тус тус Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр тусгасан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.6-1. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2018/

Улсын Их Хуралд суудалтай намуудын удирдлага болон гишүүд ХАСХОМ гаргах албан тушаалтнаар хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу гаргаж байна. Улс төрийн бүх намын удирдлагуудаас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хуулийн зохицуулалт байхгүй тул холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар судалгаа хийж байна. Энэ хүрээнд, Улс төрийн намын болон сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах, хяналт хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар “Улс төрийн намын тухай хууль: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг “Транспаренси интернешнл



Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын түншлэл зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран, Нээлттэй нийгэм форум ТББ-аас зохион байгуулсан “Улс төрийн санхүүжилтийн тогтолцоо: олон улсын туршлага” хэлэлцүүлгийг, “Шилэн нам” санаачилгатай хамтран “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, авлигын эрсдлээс сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь” хэлэлцүүлгийг 2019 онд тус тус зохион байгуулсан. Эдгээр хэлэлцүүлгүүдээр “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтууд, олон улсын бусад стандарт, сайн туршлагыг хэрхэн тусгах, шийдэл арга замын талаар талаар хэлэлцүүлэг өрнүүлж, мэдээлэл солилцож, хуулийн төсөлд тусгуулах талаар ажлын хэсэгт санал хүргүүлсэн.

Мөн 2020 онд Үндэсний аудитын ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо болон ТББ-ууд хамтран “Улс төрийн санхүүжилтийн хяналтын тогтолцоо олон улсын туршлага” нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох санал, дүгнэлт гаргасан. (Биелэлт 10 хувь)

4.1.9.6-2. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын талаар олон нийтэд мэдээлэх /АТГ, 2018-2022/

Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтнууд одоогийн байгаа хууль тогтоомжийн хүрээнд хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэг хүлээгээгүй байна. Харин Улсын Их Хуралд суудалтай намуудын дарга, зарим удирдлагууд нь Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн эрхэлж буй улс төрийн албан тушаалтны хувьд хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу гаргаж байгаа бөгөөд хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуйг тус газрын <http://www.xacxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээлж байна.

Улсын Их Хуралд суудалтай Монгол Ардын Намын дарга, Ардчилсан намын дарга нарын ХАСХОМ-ийн мэдээллийг Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор 2019 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын <http://www.xacxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан. (Биелэлт 10 хувь)

4.1.9.7-1. Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэний оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

ХЗДХЯ-наас Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл боловсруулж, уулийн төсөлд санал авах зорилгоор төслийг нийтэд ил тод байршуулж, иргэд, олон нийт, судлаачид болон холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс санал авч, нэгтгэн, төсөлд тусгах ажлыг зохион байгуулж байна.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу уг хуулийн төслийг Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл болгон боловсруулаад байна. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд оролцох, хяналт тавих шаардлага гаргах эрхтэй” гэж, 5.4-т “Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу олж авах, түгээх, өөрийн байр сууриа илэрхийлэх эрхтэй.” гэж, 5.5-д “Холбоо нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор холбогдох эрх бүхий этгээдэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэж тус тус заасан болно. Харин Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбоо, сан нь улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулах; улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчид хандив өгөх, дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой хязгаарлалтуудыг хийсэн бөгөөд иргэний нийгмийн байгууллагын хувьд жагсаал цуглаан хийх эрх нээлттэй байна.

Иргэдийн оролцооны талаархи хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, иргэний оролцоог зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд ирүүлсэн судалгаа, саналтай танилцсан. Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг судлан хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэх талаар холбогдох саналыг боловсруулсан. (Биелэлт 30 хувь).

4.1.9.8-1. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл болон төслийг дагах хуулийн төслийг боловсруулж байна. Мөн Төрийн бус байгууллагаас Монгол Улсын Ерөнхий сайдад гаргасан албан шаардлага, ФАТФ-ын 8 дугаар зөвлөмжийн хүрээнд хуулийн төсөлд зарим өөрчлөлт оруулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дэд сайд, нэгжийн удирдлагад танилцуулж, Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хуулийн төслийг Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл болгон 3 салган боловсруулсан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгыг бэлтгэн танилцуулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.8-2. Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох тогтолцоо бий болгох, иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх хэлбэрийг хуульчлан тогтоох /ХЗДХЯ, 2017-2020/

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан ба уг хөтөлбөр нь 2 үе шаттай хэрэгжих бөгөөд Нэгдүгээр үе шат нь 2018-2020 он, хоёрдугаар үе шат нь 2021-2023 он хүртэл хэрэгжих юм. Хоёрдугаар үе шатаар эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2018 оны 105 дугаар тогтоолоор байгуулагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл” ажиллаж, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх

2020 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажилласан.

Энэ хүрээнд эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй үе шаттай хамтран зохион байгуулж, 2020 онд дээрх сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран цахимаар зохион байгуулж, Завхан аймагт 31, Дорнод аймагт 26, Сүхбаатар аймагт 53 иргэнийг эрх зүйн хөтөчөөр бэлтгэсэн. Нээлттэй нийгэм форумын бэлтгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 150 тусгай сургагч багшид эрх зүйн хөтчийн гэрчилгээ олгосон. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам болон Харьяа агентлаг, байгууллагууд МҮОНРТ-тэй хамтран долоо хоног бүрийн даваа гаригт “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэг, “Иргэдийн эрх зүйн боловсролд” шууд нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 12 агентлаг, байгууллагын нийт 83 инфографик мэдээллийг хүлээн авч, 47 тоон мэдээллийг пэйж хуудаст байршуулан, олон нийтэд хүргэсэн.

Сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, хяналт тавихтай холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа агентлаг, байгууллагуудын цахим хуудас, пэйж хуудасны мэдээллийн урсгал ддүн шинжилгээ хийж, 19 танилцуулгыг бэлтгэн түгээсэн.

Харьяа агентлаг, байгууллагууд өөрийн байгууллагын цахим хуудас, пэйж хуудас, нийгмийн сүлжээгээр дамжуулан цаг үе, үйл явдалтай холбоотой энгийн болон эерэг нийт 2417 удаагийн фото мэдээ, цагаан мэдээ, ярилцлага, нийтлэл, сурвалжлага, нэвтрүүлэг, видео, зурагт хуудас /инфографик/, подкастыг зэргийг бэлтгэн олон нийтэд хүргэж ажиллав. Дээрх мэдээллийг давхардсан тоогоор нийт 12 сая гаруй мянган хүн үзэж, 320 мянган хүн шэйрлэж бусадтай хуваалцсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.9.8-3. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад сайн дураараа оролцож байгаа иргэн, иргэний нийгмийн байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг судалж шийдвэрлүүлэх /СЯ, ХЗДХЯ, 2018-2022/

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл болон төслийг дагах 140 хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах

журам"-ыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэж заасан. Төслийг боловсруулж, олон нийтээс санал авахаар хэлэлцэх шатанд байна. Тус төслийг боловсруулахад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулахад төвлөрлийг сааруулж, зөвлөл болон салбар зөвлөлөөс олгох, зохион байгуулсан ажил, арга хэмжээг тодорхой шалгуурын дагуу бодитой үнэлэх, үр дүнг тооцож урамшуулахад чиглэсэн хэлбэрт шилжих нь зүйтэй гэж үзсэн. Журмын төслийг <https://mojha.gov.mn/newmojha/> цахим хуудсанд байршуулж олон нийтээр хэлэлцүүлж, холбогдох саналыг тусгаж байна. (Биелэлт 30 хувь)

### **Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 10 дугаар зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.10.1.1 Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж байна. Авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2017 онд 11345, 2018 онд 14783, 2019 онд 25007, 2020 онд 13820 нийт 64955 хүнийг сургалтад хамруулсан болно. Харин 2020 онд цар тахлын улмаас улс орны хэмжээнд хатуу хөл хорио тогтоосон тул орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Авлигын эсрэг иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх аян, социал акцийг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тэднийг оролцоог, идэвх санаачилгыг дэмжих ажлыг эрчимжүүлэх хүрээнд тодорхой ахицыг гаргав. Тухайлбал, 2020 оны эхний хагас жилд соён гэгээрүүлэх 1 акц ("Сайхан ирээдүйг

хариуцлагатай ээжүүд бүтээнэ" идэвхжүүлэх акц)-ыг зохион байгуулж байсан бол 2020 оны сүүлийн хагас жилд соён гэгээрүүлэх аян, соён гэгээрүүлэх спорт өдөрлөг, хувийн хэвшлийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах санаачилга тус бүр 1, соён гэгээрүүлэх контент түгээлтийн акц-7 өрнүүлж, нийт соён гэгээрүүлэх 9 цогц арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, идэвх санаачилгыг дэмжиж, тэдний оролцоо, соён гэгээрүүлэх ажлын цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна.

2020 онд "Зөв зөвд шударга зөв" соён гэгээрүүлэх аяныг нийслэл, 21 аймаг, 330 сумыг хамруулан амжилттай зохион байгуулсан: Энэ аян нь хөдөө, орон нутгийн иргэдэд шударга ёсны талаарх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, авлигыг үл тэвчих үзэл санааг төлөвшүүлэх, арга хэмжээг сонирхлын олон бүлгүүдэд чиглүүлснээрээ онцлог байв. "Зөв зөвд шударга зөв" соён гэгээрүүлэх аянд аймаг, сумдыг хамруулснаар хөдөө, орон нутгийн иргэдэд шударга ёсны талаарх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, авлигыг үл тэвчих үзэл санааг төлөвшүүлэхэд дэмжлэг болохуйц чухал арга хэмжээ болсон. Зөвхөн аяны хүрээнд бус цаашид тогтмол явагдах олон төрлийн санал, санаачилгыг аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс гарган хэрэгжүүлснээрээ урьд өмнө хийгдэж байсан арга хэмжээнүүдээс чанар, хүртээмжийн хувьд ахиц гаргасан шинэлэг үйл ажиллагаа болов. Энэ ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэхээс гадна, иргэн бүр Монгол орны хаана амьдарч байгаагаас үл хамааран авлигатай тэмцэх үйлсэд гар бие оролцож, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэгч болохыг таниулсан болно. Уг аяны хүрээнд аймгууд соён гэгээрүүлэх чиглэлийн 15 төрлийн ажлыг зохион байгуулж, сурталчлан давхардсан тоогоор 1,063,456 хүнд хүргэсэн байна. Энэ хүрээнд аймаг бүр онцлох ажлуудыг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд тоймлон танилцуулбал, Дорноговь аймаг "Дорноговь авлигагүй хөгжинө" уриалгыг дэвшүүлж уриалгад аймгийн хэмжээний удирдах албан тушаалтнууд нэгдсэн бол Дундговь, Говьсүмбэр аймгууд "Шинэ үеийн залуус шударга ёсыг юу гэж ойлгодог вэ?" хэлэлцүүлэг өрнүүлж, Хэнтий аймаг "Авлигын эсрэг видео нэвтрүүлэг" хийж, Орхон аймаг ерөнхий боловсролын 5-6

дугаар ангийн сурагчдын дунд “Шударга ёс” видео бичлэгийн, гэрэл зураг сонирхогч залуусын дунд “Авлига ба хүний эрх” гэрэл зургийн уралдааныг зохион байгуулсан бол Баянхонгор аймаг Авто тээврийн төвтэй хамтран “Улаанбаатар-Баянхонгор, Баянхонгор-Улаанбаатар” чиглэлийн автобусанд зорчиж байгаа иргэдэд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг нэвтрүүлэг, контентуудыг хүргэсэн. Түүнчлэн Дорнод аймаг нь 14 сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан чэлленж(давалгаа) өрнүүлэн “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аянд нэгдэхийг уриалсан бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн багш нар, сурагчид, цэцэрлэгийн багш нар, хүүхдүүд Шударга Монголын төлөө #Dancechance бүжгийн чэлленжид хамгийн идэвхтэй хамруулсан зэргээс үзэхэд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажил үр дүнтэй, бусдад үлгэр дуурайлал болохуйц онцлох ажил байв. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд 21 аймгаас ирүүлсэн тоон мэдээгээр нийт 43,596 хүнд мэдээллийн хуудас, брошюр, тараах материал хүрсэн.

“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулган, “Ковид ба авлига: Иргэдийн чөлөөт индэр” цахим хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулав. Мөн аяны хүрээнд хүүхэд багачуудад зориулан бэлтгэсэн видео контент “Шударга ёс: Хичээл дээр...”, “Шударга тоглоё”, “Зөв зөвд шударга зөв” #шударга тоглоцгооё бүжгийн чэллэнж аяныг өрнүүлэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сурагч, хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхчүүдэд цахим хэлбэрээр 9 дүүргийн 164 ерөнхий боловсролын сургууль, 11 цэцэрлэг, 21 аймгийн 552 сургууль, 699 цэцэрлэгийн 560000 сургуулийн багш, ажилчид, сурагчид, эцэг эхчүүд нэгдэж, өөрсдийн дуу хоолойгоо, бүжгээр шударга ёсыг илэрхийлсэн бичлэгүүдийг сошиалд түгээж сурталчилж ажилласан байна. Аяны хүрээнд контент бүтээж, түгээх явцыг дэмжиж, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж, арга зүйн зөвлөгөө өгч боловсролын байгууллагын багш, ажилтнуудыг контент түгээх дэд бүтцийг нэгтгэх зорилгоор “Зөв Зөвд Шударга Зөв” фэйсбүүк группийг үүсгэж, “Авлигын эсрэг сургагч багш” зэрэг групп, пэйжүүдээр мэдээлэл түгээн аяныг идэвхжүүлэв. “Зөв зөвд шударга зөв” аяны баннер бүхий зурагт хуудсыг автобусны буудлын 46 гэрэлт самбар, төв зам дагуух явган 80 самбар, мөн сурталчилгааны 10 байршил том самбарт

байршуулан, 9 төрлийн видео шторкийг авто замын уулзвар дахь 7 лэд дэлгэцээр өдрийн 80-150 удаагийн давтамжтайгаар цацаж сурталчлав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.10.1-д заасан “Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх, шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Үнэгүй фитнес” Төрийн бус байгууллагатай хамтран “Эрүүл бие-Эрүүл нийгэм” спортоор дамжуулан иргэдийн хандлагыг өөрчлөх, шударга байдлыг сурталчлах акцыг зохион байгуулсан. Энэ хүрээнд “Амьдралын хэв маягаа өөрчилъё» уриан доор 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр “Let’s change” соён гэгээрүүлэх спорт өдөрлөгийг Үндэсний соёл, амралтын хүрээлэнд зохион байгуулсан. Энэхүү соён гэгээрүүлэх арга хэмжээг иргэдэд сонирхолтой байдлаар мэдээлэл хүргэх арга хэлбэрийг туршиж, өртөөчилсөн уралдаан тэмцээнээр дамжуулан иргэдэд авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, авлигын эсрэг иргэний оролцоо, боломжийг ухуулан таниулах ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулав. Тус арга хэмжээнд нийт 300 гаруй иргэд оролцсон ба тэдгээрээс 100 иргэнийг хүсэлтээр нь сонгон 10 баг бүрдүүлэн авлигын эсрэг, шударга ёс, зөв дадал, сайн зуршил, эерэг хандлагын талаар мэдлэг олгох агуулгаар бэлтгэсэн 10 төрлийн өртөөчилсөн тэмцээнийг зохион байгуулж, цахимаар шууд дамжуулалт (25,826 хүн үзсэн) хийсэн.

Бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн санаачилгаар авлига болон түүнийг тойрон тэлсээр буй хууль бус, ёс зүйгүй, авлигыг өөгшүүлсэн зохисгүй хандлагыг өөрчлөх, хувийн хэвшил дэх авлигын эрсдлийг бууруулж, шударга, нийгмийн хариуцлагатай бизнесийг төлөвшүүлэхэд уриалах, авлигын эсрэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дотоод хяналтын тогтолцоог дэмжих зорилго бүхий “Шударга ёс хөгжил дэвшилд-хувийн хэвшлийн оролцоо” санаачилгыг эхлүүлэв. Уг санаачилгад нэгдэж, ёс зүйтэй, авлигаас ангид бизнес эрхлэгчдийн дуу хоолой, хамтын ажиллагааг нэгтгэх зорилгоор Хан Уул дүүргийн “Авлигагүй дүүрэг” уриалга гаргасантай уялдуулан тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 150 аж ахуйн нэгжид хамтран ажиллах саналыг хүрүүлж аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэж буй

40 төрлийн бүтээгдэхүүн болон бараа түгээлтийн машины гадна талд, мөн орон нутгийн зоригчийн тасалбар дээр 110 утасны дугаарын сурталчилгааг тус тус байршуулан олон нийтэд хүргэв. АТГ-т гомдол, мэдээлэл хэрхэн гаргах тухай танилцуулга нугалбарыг заримч зочид буудлын өрөөнүүдэд байршуулсан.

2020 онд “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгийн 17 дугаарыг бэлтгэн, МҮОНТ-ээр үзэгчдийн хүртээл болгов. Авлигатай тэмцэх газар 2020 онд авлигын эсрэг видео контентуудыг улсын хэмжээний 25 телевиз, кабелийн сувгаар дамжуулж олон нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж, нийт 2397 удаагийн цацалтыг хийж, түгээсэн байна. “Гэр бүлийн радио 104.5”, “Дэлхийн монголчуудын радио 88.3”, “Таны радио 103.6”, “Зохиост аялгуу 89.3” радиотой хамтран ажилласнаар “Нэг дусал”, “Радио зөвлөгөө”, “Ашигтай мэдлэг”, “Уран зохиолын цаг” зэрэг олон сонсогчтой нэвтрүүлгээр дамжуулан авлигын хор аюулыг ухуулан таниулахад чиглэгдсэн мэдээ, мэдээллийн тогтмол урсгалтай болов. Хаштаг 110 подкаст нэвтрүүлгийг цувралаар хийж, байгууллагын болон trplus.mn сайтад 51 удаагийн мэдээлэл байршуулсан байна.

Авлигатай тэмцэх газраас шударга ёсны сэдэвтэй, авлигыг үл тэвчих агуулга бүхий видео контент, шторк, дуу клип, богино хэмжээний кино, зохиомжит нэвтрүүлэг зэргийг нийслэлийн төв зам дагуух болон автобусны буудал дахь сурталчилгааны дэлгэц, самбарт байршуулан түгээв. Сурталчилгааны өөр нэгэн сувгийг шинээр үүсгэж, Улаанбаатар хотын орон сууцны болон 15 оффисын цахилгаан шатанд байршуулсан 218 дэлгэцээр авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааг нэвтрүүлэх, зурагт хуудас, нугалбар танилцуулга, үзүүлэн тараах материалыг мэдээллийн самбарт байрлуулах зэргээр сурталчилгааны ажлыг тасралтгүй зохион байгуулав.

“АТГ-Олон нийтийн төв” цахим хуудсыг 2020 онд нээж, мэргэжлийн байгууллагатай хамтран идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулснаар 31115 дагагчтай болсон ба тус пэйжээр дамжуулан 335 зурагт хуудас болон бусад мэдээ мэдээллийг байршуулж, 486 мэдээлэл, 151 видео контентийг олон нийтэд хүргэсэн байна. Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Шударга ёсны үнэ цэнэ”, “Авлигын эсрэг олуулаа нэгдье”, “Гэрэл тусгая”, Арын хаалга, Албаны мэдээллээ аминдаа, Гайтай бэлэг, Танилын гуйлт, Авлигын шилэн бөмбөлөг, Авлига хожихгүй нүүдэл, Төрийн албан хаагч танаа 1, 2; 110 дугаарын сурталчилгаа 1, 2, 3 шторкуудыг 21 аймагт хүргэж, орон нутгийн

иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулав. Орон нутагт Авлигын эсрэг хуулийг сурталчилсан 6 төрлийн тараах материал болох 110 дугаарын утасны сурталчилгаа, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох зүйл, Авлигын хэлбэрүүд, Авлигын болон Эрүүгийн хуулийн холбогдох заалтуудаас, Авлигын тухай мэдэгдэх сурталчилгааны материалыг хүргүүлэн сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг болон иргэд, олон нийтэд түгээх, сум бүрт видео контент, шторк, CD зэргийг тусгайлан хүргүүлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан НҮБ-аас “Recover with integrity” уриаг гаргасан бөгөөд цар тахлын үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Stop the virus Stop corruption” хэмээх нэмэлт уриаг зарласан. Энэ дагуу Авлигатай тэмцэх газраас НҮБ-ын “Recover with integrity” аяны санааг тусгасан монгол хувилбарт постерийг гарган мэдээллийн гол сайтуудын топ байршилд 19 өдрийн турш байршуулж хамтран ажиллав.

Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан 41 төрлийн ном, гарын авлага, эмхтгэл, товхимол, тойм танилцуулга зэргийг нийтийн хүртээл болгох, оюутан, судлаачдад танилцах, судлах боломжийг олгох зорилгоор 25 их, дээд сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Тусгаар тогтнолын ордон, мөн 21 аймгийн номын сан, Улаанбаатар хотын 73 байгууллагын номын сан, сэтгүүлчдэд зориулсан сургалт, цэргийн штабын удирдах албан тушаалтнууд, Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш нар, Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын шинээр томилогдсон албан хаагчид, татварын байгууллагаар үйлчлүүлж буй иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд, 6 дүүргийн Татварын хэлтэс, угтах үйлчилгээ, мэдээллийн самбар, иргэдэд үйлчлэх хэсэгт түгээх, байршуулах ажлыг зохион байгууллаа.

2020 онд 37 төрлийн 16962 ширхэг ном, гарын авлага, тараах материалыг төрийн болон төрийн бус байгууллага, оюутан сурагч, уншигч иргэд олон нийт рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зориулан түгээсэн байна. (Биелэлт 100 хувь)

4.1.10.1-2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах; /АТГ, 2017-2022/

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён

гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг олон нийтэд хүргэхэд сэтгүүлчид, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, олон нийтийн оролцоог хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтод арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах чиглэлээр 47 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага боловсруулах, сургалт хийх, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэх, уулзалт, хэлэлцүүлэг хийх зэргээр хамтран ажиллаж, авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх ажлын хүрээнд сурталчилгааны материал, эмхтгэл, товхимол хэвлүүлж тараах, видео шторк, радио спот, социал вирал видео, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг, ярилцлага хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх ажлыг тогтмол хийж хэрэгжүүлж байна. Тухайлбал, Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан НҮБ-ын "Recover with integrity" аяны санааг тусгасан монгол хувилбарт постер хэвлүүлж, лого бичвэр бүхий амны хаалт нийт 3000 ширхгийг захиалгаар хийлгэн, иргэд олон нийт, албан тушаалтнууд, Төрийн тусгай хамгаалалтын газар, хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлчид, цар тахлын хүнд нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдад тараав. Мөн 15 сэтгүүлч оролцсон 15 шторк, 20 постер хийж, телевизүүд болон социалаар олон нийтэд түгээх, аяны баннер бүхий зурагт хуудсыг олон нийтийн газарт байршуулах, 9 төрлийн видео шторкийг лэд дэлгэцээр олон удаагийн давтамжтайгаар сурталчилсан байна. Авлигын хор хөнөөл, шударга зүйлд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зорилгоор зорилтот бүлгүүдэд зориулсан 38 төрлийн видео контентуудыг цувралаар тогтмол бүтээж, цахим хуудас, пэйжээр, болон телевизүүдтэй хамтран түгээх ажлыг зохион байгуулан ажиллалаа. "Салхитын мөнгөний орд", "Зайсангийн хууль бус газар олголт", "Авлигатай тэмцэхэд иргэдийн оролцоо", "Залуу үе авлигын эсрэг" зэрэг 4 төрлийн сэдвээр "Цахим сэтгүүл зүй" ТББ-тай хамтран баримтад суурилсан "Өөр өнцөг" нэвтрүүлгийг бэлтгэв. Арга хэмжээний талаарх мэдээллийг телевиз, радио, цахим хуудас, фейсбүүк болон олон нийтийн мэдээллийн бүхий л сувгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, арга

хэмжээний талаарх мэдээллийг телевиз, радио, цахим хуудас, фейсбүүк болон олон нийтийн мэдээллийн бүхий л сувгаар нэвтрүүллээ.

Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад 2020 онд хэвлэл, мэдээллийн байгууллагууд (22 телевиз, өдөр тутмын 5 сонин, богино долгионы 6 радио, мэдээллийн гол 6 сайт, 21 аймгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл), нийтлэлч, зохиолч, яруу найрагч, соёл урлагийн болон спортын алдартнууд, сэтгэл судлаач нараас гадна нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллав. Тухайлбал, авлигыг жигшээх, хор аюулыг ойлгуулах, шударга ёсны үйл хэрэгт уриалах, дуу хоолойгоо хүргэх чиглэлээр сагсан урлаг, спортын одод, алдартнуудтай хамтран "Үр" богино хэмжээний кино, "Төрийн албан хаагч танаа", "Шударга ёсны үнэ цэнэ", Авлигын шилэн бөмбөлөг", "Авлигын эсрэг улам олуулаа нэгдье" контент, авлигыг мэдээлэх 110 утасны сурталчилгаа, шторк бүтээв.

Шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэх, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Эрүүл бие-Эрүүл нийгэм" аяныг зарлаж, энэ хүрээнд "Амьдралын хэв маягаа өөрчилье" уриан дор 300 гаруй иргэнийг хамруулсан "Let's change" сэдэвт өдөрлөгийг "Үнэгүй фитнес" ТББ-тай хамтран зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газар, "Залуус өөрчлөлтийн төлөө" үндэсний хөдөлгөөн, "Хуулийн хөтөч" клуб хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд «New generation-No corruption» илтгэх ур чадварын нээлттэй тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулав. Уралдаанд оролцогчид бие даан нийгмийн харилцаанд оролцох, нийгэм дэх авлига, хүнд суртал зэрэг сөрөг үзэгдэлд шүүмжлэлт байдлаар хандах, асуудлыг танин мэдэх, шийдвэрлэх арга зүй, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлснээрээ ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Тэмцээнд нийт 125 сурагч видео бичлэгээ ирүүлж оролцлоо.

"Зорилготой залуу" ТББ-тай хамтран "Шударга ёс" хүүхдийн цуврал кино зохиолын уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд цахимаар зохион байгуулж, тус уралдаанд нийт 250 зохиол ирснийг ажлын хэсэг сонгон шалгаруулж, ялагчдыг тодруулав. Хүүхэд багачуудыг зөв шударга, хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн Том хамтлагийн тоглосон "Шударга ёс" богино хэмжээний

үргэлжлэл болох 2 дугаар ангийн кино зохиол бичих уралдааны 8-11 насны ангилалд тэргүүн байр эзэлсэн “Ирээдүй цогцолбор”-ын 5-р ангийн сурагч, 11 настай М.Энхжингийн “Шударга ёс”, “Гар утас” зохиолоор богино хэмжээний цуврал кино контентийг бүтээж байна.

“Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал хакатон”-ыг 2020 оны 5 дугаар сарын 30-ны өдөр онлайн хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд оролцогчид орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сантай холбоотой мэдээлэл ашиглан датад суурилан дүн шинжилгээ хийж үр дүнг танилцуулсан. Нийт 10 багаас 4 шилдэг бүтээл шалгарав. Энэхүү арга хэмжээ нь мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах ач холбогдолтой боллоо.

2020 онд авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөрийг боловсрууллаа. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт сургалтын хөтөлбөр (9 цагийн лекц, 9 цагийн дасгал, 3 цагийн хэлэлцүүлгээс бүрдсэн), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилготой сургалтын хөтөлбөр (төрийн байгууллагын худалдан авах, санхүү, хууль эрх зүй, дотоод хяналт шалгалт, аудитын болон удирдах албан тушаалтанд зориулсан 5 төрлийн сургалтын 20 модуль)-ийг тус тус боловсруулж, хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчдэд зориулсан интерактив модуль бүхий гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр ажиллах аппликэйшн бэлтгэж боловсруулах хүрээнд холбогдох судалгааг хийж, сургалтын модулийн зохиомжийн төслийг бэлтгэв. Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр дэх “Үнэт зүйл, ёс суртахуун: Авлигын шалтгаан”, “Авлига: Системийн өвчин” сэдвээр агуулгын боловсруулалт хийв. Авлигаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг дээшлүүлэх, авлигыг мэдээлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд

тавих хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр “Шударга ёс, хөгжил дэвшилд-Хувийн хэвшлийн оролцоо” сэдвээр сургалтын хөтөлбөр, гарын авлага, сургалтын дараах судалгааны хуудас, сургалтын слайдыг цогцоор шинэчлэн боловсруулсан бөгөөд цаашид хувийн хэвшлийн байгууллагуудад иж бүрэн сургалт зохион байгуулах боломжтой болов.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 2018 онд эрхлэн хэвлүүлсэн “Шударга байдлын боловсрол” гарын авлагыг орчуулан, соён гэгээрүүлэх ажилд ашиглаж байна.

Түүнчлэн авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, эрдэм шинжилгээ болон сургалт судалгааны эргэлтэд оруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглах зорилгоор 2011-2018 оны шүүхийн шийдвэрүүдийг эмхэтгэн “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл”-ийг хэвлүүлж олон нийтэд түгээв.

АТГ-аас 2020 онд шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг таниулах, Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааг мэдээлэх зорилгоор “Улсын Их Хурлын гишүүн Танаа”, шинээр эмхлэн байгуулагдсан Засгийн газрын танхимын гишүүн-сайд нарт зориулсан “Засгийн газрын гишүүн танаа”, орон нутгийн сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч нарт зориулан “ИТХ-ын төлөөлөгч Танаа”, мөн шинээр томилогдон ажиллаж байгаа Засаг дарга нарт зориулан “Засаг дарга Танаа” гарын авлагыг тус тус боловсруулан түгээх ажлыг зохион байгуулав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлэх, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” чиглэлийг үндсэн зорилгын нэг болгон тогтоосон. Энэ дагуу Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаа” гарын авлагыг боловсруулж хэвлүүлээ. Энэ гарын авлагыг гаргаснаар гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаанд гадаад улсын хууль сахиулах байгууллагуудтай харилцахаас өмнө дотоодын хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог зохицуулах зайлшгүй шаардлагын эхлэл болсон гэж үзэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид багш нарт ардын аман зохиолын төрөл болох зүйр цэцэн үг, сургамжит өгүүллэгээр дамжуулан шударга ёсны үзэл хандлагыг бий болгох, шударга үнэнч зан төлөв, ёс суртахуун, нийгмийн харилцааны зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгох чиглэлээр “Авлигын эсрэг боловсрол олгох гарын авлага”, төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлыг шинжлэх, Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн албаны суурь зарчимтай хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрд эргэцүүлэн бодож байх боломжийг олгох, сургалтад ашиглах зорилгоор “Бодлогын хураамж: Төрийн албаны ёс зүй, ашиг сонирхлын зөрчил” гарын авлагыг тус тус боловсруулан хэвлүүлж, авлигын эсрэг сургалтад ашиглаж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.10.1-3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах; /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран зохион байгуулах чиглэлээр холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн ба 2016, 2017 онд 21 аймагт албан томилолтоор ажиллах явцдаа Иргэний танхим хариуцсан ажилтнуудыг Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтад хамруулснаас гадна хувийн хэвшилтэй хамтран аймаг бүрт “Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд хувийн хэвшлийн үүрэг, оролцоо» сэдэвт хэлэлцүүлэг хийв.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр орон нутгийн иргэний танхимын оролцоотойгоор холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг 2017 оны 05 дугаар сард зохион байгуулж, өдөрлөгт нийт 600 орчим хүн оролцсон. Мөн Баянхонгор аймгийн ЗДТГ-аас “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аян өрнүүлэн нийтийн албан тушаалтан, иргэдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба сургууль, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

АТГ нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн төсвөөр авлигын нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр брошур, гарын авлага, зурагт хуудас зэрэг сурталчилгааны материалыг 2018- 2020 онд хэвлүүлж, иргэд, олон нийтэд түгээв.

Иргэний хяналтын төвийг нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Дүнжингарав, Мишээл, Оргил салбаруудад нээн ажиллуулах бэлтгэл ажлыг 2018 онд хангаж, 2019 оны нэгдүгээр улирлаас эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2019 онд 21 аймагт ажиллах явцад болон орон нутаг, нийслэлд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах явцдаа авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ном, гарын авлага зэрэг 20 орчим төрлийн 48275 ширхэг сурталчилгааны материалыг иргэд, төрийн байгууллага, аймаг, нийслэлийн Иргэний танхим, нийтийн номын сангуудад түгээсэн бөгөөд иргэд, төрийн албан хаагчид дээрх байгууллагуудаар дамжуулан авлигын эсрэг ном, гарын авлагатай танилцах, судлах нөхцөл боломжоор хангасан.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг орон нутагт зохион байгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Авлигатай тэмцэх газраас 21 аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг судлан үзэж, салбар зөвлөлүүдийн дарга, нарийн бичгийн дарга нартай цахим уулзалт зохион байгуулсан ба тэдгээрт орон нутагт дахь авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудлуудыг танилцуулж, 2020 онд авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх чиглэлээр зөвлөгөө өгч, мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан. Энэ хүрээнд 2020 онд орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар чиглэл өгөх, судалгаа хийх, сургалт, сурталчилгаа явуулах, хууль тогтоомжийг сурталчлах, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах контент (видео,шторк г.м) түгээх ажлыг зохион байгуулах ажлыг тусгуулах арга хэмжээг авч ажиллав.



Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах, эдгээрийг хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудын шинэчилсэн судалгааг гарган шууд харилцах сүлжээ үүсгэн тэдгээрээр дамжуулан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтын материал, гарын авлага, сурталчилгааг орон нутагт хүргэх, түгээх ажлыг зохион байгууллаа. 2020 онд аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвөөр дамжуулан 12 постер, авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан 6 постер, 3 шторк, Авлигатай тэмцэх газрын 2020 оны онцлох ажлуудын талаарх мэдээллийг хүргүүлэн сурталчлах ажлыг зохион байгуулав. (Биелэлт 70 хувь)

4.1.10.1-4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах; /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан уг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын өөрсдийн хариуцсан үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, төлөвлөгөөг албан ёсны цахим хуудас дээрээ ил тод мэдээлж, үр дүнгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх талаар яам, агентлаг, аймаг, нийслэлд албан бичиг хүргүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллав.

Авлигатай тэмцэх газраас аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн байгууллагуудын Авлигын эсрэг төлөвлөгөө болон авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй танилцан шалган зааварлах, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэж байна.

2020 онд төрийн байгууллагуудаас авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөх, тайлагнах, арга зүйг боловсруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, сайн туршлага солилцох зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын төлөвлөлт, үр дүнг сайжруулах-арга зүйн асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Төрийн байгууллагуудад авлигын эсрэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, олон нийтэд мэдээлэх, үр дүнг дээшлүүлэх зорилгоор авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний загварыг шинэчилэн

боловсруулж, төрийн байгууллагуудад хүргүүлэв. Өнгөрсөн хугацаанд Авлигатай тэмцэх газар нь орон нутаг, яам, агентлагт ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, авлига үүсэх нөхцөл боломж бүрдүүлсэн дүрэм, журмыг хүчингүй болгох, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт 2 удаа, Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 1 удаа, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус бүр 3 удаагийн Зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан болно. (Биелэлт 70 хувь)

4.1.10.2-1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах /БСШУСЯ, АТГ, 2017-2022/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд насан туршийн боловсрол, сургалтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт 2017 онд боловсролын бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, сургалтыг зохион байгуулж эхлүүлэх, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, их, дээд сургууль, коллежийн багш нарт авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын модулийг боловсруулж, үндэсний сургагч багшийг бэлтгэх болон нийт багш нарын сургалтыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгосон.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалын хүрээнд

АТГ, БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн Боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд бүлгийг хамтран боловсруулж сургагч багш нарт зориулсан “Багшийн ёс зүй: ёс суртахууны харилцаа” сэдэвт гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэсэн ба сургагч багш нар аймаг, нийслэлийн 36000 орчим багш нарт ёс зүйн сургалтыг 2017 оны 8 дугаар сард зохион байгуулсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалаар баталсан ерөнхий боловсролын сургуулийн Х ангид судлах “Нийгэм судлал” хичээлийн агуулгад 1) Шударга ёсны ойлголт, түүний шалгуур, 2) Гажуудал ба нийгмийн хяналт, 3) Соёлын олон янз байдал, харилцаан дахь шударга ёсны үнэлэмж, 4) Үл ялгаварлан гадуурхах, 5) Эдийн засгийн өсөлт ба амьдралын чанар, 6) Шударга ёс ба авлига/авилга гэж бичсэн/, 7) Улсуудын орлогын ялгаатай байдал гэсэн сэдвүүдийг тусгасан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалаар баталсан бага ангийн “Хүн ба нийгэм”, дунд, ахлах ангийн “Нийгэм судлал”, бага, дунд, ахлах ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын талаарх агуулгыг тусган ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж байна.

Авлигатай тэмцэх газраас 2020 онд ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв хэрхэн туссан байдалд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид багш нарт ардын аман зохиолын төрөл болох зүйр цэцэн үг, сургамжит өгүүлэгээр дамжуулан шударга ёсны үзэл хандлагыг бий болгох, шударга үнэнч зан төлөв, ёс суртахуун, нийгмийн харилцааны зөв дадлыг төлөвшүүлж, авлигын эсрэг боловсрол мэдлэг олгох чиглэлээр “Авлигын эсрэг боловсрол олгох гарын авлага”-ыг боловсруулав. (Биелэлт 30 хувь)

4.1.10.2-2. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах / БСШУСЯ, АТГ, 2017-2022/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг ажил гүйцэтгэх ёстой байсан боловч их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Их, дээд сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт тусгах талаар судалгаа хийгдэж байна.

АТГ-аас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан “авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” зорилтын хүрээнд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартад ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгадаг эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийсэн. Азийн сан, Хууль сахиулахын их сургуультай хамтран ёс зүйн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх асуудлаар санал солилцох уулзалтад оролцож, сургалтын хөтөлбөр агуулгыг шинэчлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр мэдээлэл өгч, арга зүйн удирдлагаар хангасан. Сургалтын хөтөлбөрийн төсөлтэй танилцаж санал өгч, туршилт сургалтыг 2018 оны 11 дүгээр сард хийсэн ба тус хөтөлбөр батлагдснаар ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн сонсогчдод ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хичээлийн хөтөлбөрийн дагуу заавал хамрагдах боломж бүрдсэн. Хүний хөгжлийг хангах чиглэлээр 3 кредитийн “Хүний үндсэн эрх /шударга ёс, авлигаас урьдчилан сэргийлэх/, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт,

өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшүүлэх” хичээлийг оруулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.10.2-3. Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах / БСШУСЯ, ГБХЗХГ, АТГ, 2017-2022/

Шударга ёсны сэдэвт соён гэгээрүүлэх аян, социал акцийг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэд, хүүхэд, залуучуудын идэвх санаачилга, оролцоог дэмжиж, соён гэгээрүүлэх ажлын цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж ажиллав. Тухайлбал:

“Том толгойтын адал явдал” хүүхэд багачуудад зориулсан соён гэгээрүүлэх акц. Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын хамгаалах өдрийг угтан хүүхэд багачуудад зориулан цуврал контентыг бүтээж, сурталчлах зорилготой акцыг зохион байгуулав. Хүүхэд багачуудад “Том толгойтын адал явдал” олон ангит киногоороо танил болсон “Том хамтлаг”-ийн гишүүдтэй хамтран ажиллаж “Шударга ёс” цувралыг бүтээж, эхний анги “Хичээл дээр” контентыг АТГ-Олон нийтийн төв фэйсбүүк хуудсаар олон нийтэд танилцуулан, уг бүтээлд тоглосон гол дүрийн хүүхдүүдийг АТГ-ын Олон нийтийн төвд урьж хүүхдийн шударга байх, шударга бус, буруу зүйлээс ангид байхын ач холбогдлын талаар харилцан яриа өрнүүлэн шууд дамжуулсан(8796 хүн үзсэн). Мөн гол дүрийн хүүхдүүдийг оролцуулан бэлтгэсэн 6 видео контент, 5 төрлийн постер зурагт хуудас бүтээн түгээв. Хүүхдүүдийг шударга ёсны сэдэвт соён гэгээрүүлэх ажилд татан оролцуулж, “Шударга ёс” цувралын дараагийн ангиудын зохиолын уралдааныг хүүхдүүдийн дунд зарлаж, дүгнэсэн. Уг уралдаанд 3 насны ангиллд нийт 256 гаруй хүүхдээс цахимаар ирүүлсэн уралдааны материалыг хүлээн авч уншиж сонгон шалгаруулалт хийж, уралдаанд түрүүлсэн хүүхдийн бүтээлээр “Шударга ёс” богино хэмжээний цуврал контентийн дараагийн ангийг бүтээж байна. “Шударга ёс” цувралын “Хичээл дээр” контент Авлигатай тэмцэх газрын албан ёсны youtube (<https://www.youtube.com/watch?v=SBnqsBDSNUM>) хуудсанд 673474, АТГ-Олон нийтийн төв фэйсбүүк хуудсанд 127,5 мянган хандалтыг тус тус авсан нь АТГ-аас бэлтгэсэн контентуудаас хамгийн их хандалттай контент болсон.

“Шударга ёс: Хичээл дээр...” соён гэгээрүүлэх акц. Энэхүү акцийг ЕБС, цэцэрлэгүүдийн /

багш, ажилчид, хүүхэд багачууд, эцэг эхчүүдийг хамруулсан/ “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд хүүхэд багачуудад зориулан бэлтгэсэн видео контент “Шударга ёс: Хичээл дээр...”, “Шударга тоглоё”, “Зөв зөвд шударга зөв” аяныг идэвхжүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сурагч, хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхчүүдийг цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш нараар дамжуулан идэвхижүүлэлтийг хийсэн. Тус акцийн хүрээнд 9 дүүргийн 164 ерөнхий боловсролын сургууль, 11 цэцэрлэгийн 386,000 сургуулийн багш, ажилтан, сурагчид, эцэг эхчүүд нэгдэж сургуулийн цахим хуудас, фэйсбүүк групп дээр байршуулан түгээсэн. Тус акцийг 2020 оны 11 сараас эхлүүлсэн бөгөөд Нийслэлийн дүүргийн Боловсролын газар, хэлтэс, сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар хамтран ажилласан.

“Шударга тоглоё” бүжгийн давалгаа (челлэнж). Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн багш, ажилтнуудын болон ангийн фэйсбүүк групп, пэйж хуудсаар дамжуулан сурагчид, эцэг эхчүүдийг авлигын эсрэг контентыг хүргэх, шударга зөв зан чанарыг түгээх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сурагч, хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхчүүдийг хамруулан “Шударга тоглоё” бүжгийн давалгаа (челлэнж) аяныг “RoyalDance” бүжгийн хамтлагтай хамтран цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус бүжгийн давалгаанд хүүхэд багачууд болон эцэг, эхчүүдийг идэвхтэй хамруулах зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагын багш, ажилтнуудтай хамтран ажилласан. Энэхүү давалгаа АТГ-ын Олон нийтийн төв фэйсбүүк хуудас болон #DanceChance фэйсбүүк пэйж хуудас болон #RoyalDance ChanceMongoliaYoutube сувгаар үргэлжилж, 21 аймаг, нийслэлийн сургууль, цэцэрлэг, Засаг даргын Тамгын газрууд хамрагдан, 9 дүүргийн 164 ерөнхий боловсролын сургууль, 11 цэцэрлэг, 21 аймгийн 552 сургууль, 699 цэцэрлэгийн 560,000 сургуулийн багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл нэгдэн өөрсдийн дуу хоолойг бүжгээр шударга ёсыг илэрхийлсэн бичлэгүүдийг олон нийтэд түгээж, сурталчлах ажлыг зохион байгуулсан.

“Зөв Зөвд Шударга Зөв” соён гэгээрүүлэх аян.. Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан соён гэгээрүүлэх аяныг эхлүүлж, хэвлэл мэдээллийн салбарын сэтгүүлчдийг авлигын эсрэг уриалах, олны танил эрхэмүүдтэй шударга байдал, зөв хандлага, авлигаас ангид байхын учир холбогдлын талаар цуврал ярилцлагууд хийлгэх, шударга байх, зөв байх нь нэг удаагийн үйлдэл биш, амьдралын турш баримтлах зарчим, чанар болохыг

тайлбарлан, ухуулах “Зөв дадал 20” чуулган болон уг аяны санааг дэмжсэн видео, аудио контентууд боловсруулах, зурагт хуудсыг бэлтгэх, түгээх олон акцыг нэгтгэн зохион байгуулав.

“Зөв дадал 30” дижитал чуулган. “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Good Habits 20 буюу Зөв дадал 20” дижитал чуулганыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд түгээн сурталчлав. Чуулганыг илтгэгчдээр сонгогдсон үзэл санааны удирдагчид амьдралдаа тохиолдсон явдал, бодит жишээ, түүнийг даван туулсан арга туршлага, өөрийн зөв дадлыг ажил, амьдралдаа хэрхэн мөрдлөг болгож байгааг мэдрүүлэх, тэдний зөв дадлаас залуус үлгэр жишээ авах боломжийг олгоход чиглэсэн болно. Илтгэгчдийн илтгэлээс хэлсэн гол санааг түүвэрлэн эшлэл бүхий, нэг загвартай постер хуудаснуудыг цувралаар оруулж, контентыг сурталчлах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тус арга хэмжээг АТГ-ын болон бусад хамтрагч байгууллагууд, оролцогчдын нийт 10 орчим пэйж хуудсаар шууд дамжуулсан болно. Арга хэмжээний эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд зөвхөн АТГ-ын “Олон нийтийн төв” пэйж хуудасны шууд дамжуулалтын үзэлт 1000 гаруй хүнээс буугаагүй бөгөөд 120 минутын эвэнт өндөрлөхөд нийтдээ 147,000 хүн үзэж, хүртээмж буюу тухайн цагт 350,000 гаруй хүнд мэдээлэл хүрсэн байна.

“Зөв дадал-20” дижитал чуулганыг сурталчлах акц. Шударга ёсны үнэ цэнийг таниулах, нэг удаагийн үйлдлээр биш шударга байдлыг хэмждэггүй харин түүнийг дадал, хандлага, зарчим болгохын учир холбогдлыг олон нийтэд ойлгуулах зорилгоор үзэл санааны соён гэгээрүүлэгчдийг оролцуулсан чуулганыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр цахимаар зохион байгуулахтай холбогдуулан БШУЯ-тай хамтран 12 их, дээд сургуулиудын социал хуудас, группүүдээр дамжуулан оюутан залуус хүргэж, зөв хандлага, шударга байдалд уриалан, татан оролцуулах акцыг зохион байгуулав. Боловсролын байгууллагын багш, ажилтнуудыг цаашид авлигын эсрэг соён гэгээрүүлэх контент түгээхэд татан оролцуулах, зохион байгуулсан аян, акцийн хүрээнд хамтран ажилласан хамтын ажиллагааг тогтмолжуулж, мэдээлэл солилцох дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор “Зөв Зөвд Шударга Зөв” фэйсбүүк групп (<https://www.facebook.com/groups/zuvzuv2021>)-ыг шинээр үүсгэж, гишүүдийг шинээр бүртгэж хамтран ажиллаж байна. “Зөв дадал 2020” цахим арга хэмжээний социал хаяг, хуудас хөтлөлтийн цогц байдлаар төлөвлөж,

зохион байгуулсан бөгөөд “Зөв Зөвд Шударга зөв” аяны хүрээнд фэйсбүүк групп нэгдэл болон 2 эвэнт цэсийг хөгжүүлж, арга хэмжээтэй холбоотой бүхий л мэдээллийг нийтэлж, нэгдсэн загвар дизайн боловсруулж, нийт 80 гаруй контент, 8 төрлийн видеог бэлтгэж албан ёсны хуудас болон твиттер болон инстаграм хуудсуудыг хамтад хөгжүүлэв. “Зөв дадал 20” арга хэмжээний хүрээнд эвэнт суваг хөгжүүлэлт 183 мянган хүнд хүрч, 1244 хүн мэдээлэл авсан. “Зөв зөвд шударга зөв” болон “Зөв дадал” 20 арга хэмжээний хүрээнд 14 хоногийн турш 80 гаруй пост хийгдэж, 700,000 гаруй хүнд фэйсбүүк хуудасны мэдээллээр хүрсэн. Бүтэн нэг сарын хугацаанд бол 1,0 сая гаруй хандалтыг хамтрагч байгууллагуудын хуудсанд орсон пост бүрээр тооцвол давсан байна. Өнгөрөгч нэг сарын хугацаанд 5000+ дагагчдыг эгнээндээ нэгтгэжээ. Аяны уриа лого бүхий фэйсбүүк зургийн хүрээ (frame)-гээр нийтдээ 1000 гаруй хүн нүүр номынхоо зургаа сольж, аянд нэгдсэнээ илэрхийлсэн байна. “Зөв дадал-20” арга хэмжээний шууд дамжуулалтын үр дүнд “АТГ-Олон нийтийн төв” пэйж хуудаснаас гадна “Авлигатай тэмцэх газар” фэйсбүүк хуудаснаас давхар шууд дамжуулалт хийсний үр дүнд пэйж хуудасны дагагчдын тоо 2500, лайкын тоо 2000 гаруйгаар өссөн байна.

World Learning байгууллагын (LEAD) хөтөлбөрийн Авлигатай тэмцэх, ил тод байдлыг сайжруулах багийн “Сайн сургууль” төслийн багтай хамтран Нийслэлийн 2, орон нутгийн 1 сургууль дээр авлига, ил тод байдлын тухай ойлголт, хандлагын талаар хэлэлцүүлэг, сургалт, уралдааныг сургуулийн захиргаа, багш, сурагчид, эцэг эхийг хамруулан зохион байгуулсан.

“New generation-No corruption” илтгэх ур чадварын нээлттэй тэмцээн. Авлигатай тэмцэх газраас “Залуус өөрчлөлтийн төлөө үндэсний хөдөлгөөн”, “Хуулийн хөтөч” клубтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд «New generation-No corruption» илтгэх ур чадварын нээлттэй тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, уралдаанд түрүүлсэн зохиолуудаас шилдгийн шилдэг нэг зохиолыг сонгож “Brosis Pictures” кино компанитай хамтран цуврал, богино хэмжээний кино контентийг бүтээж байна. Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Бодлогод залуусын оролцоо” ТББ-тай хамтран Увс, Ховд, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн залуучуудын дунд “Орон нутгийн төсвийн ил тод байдал” хакатон /тодорхой өгөгдсөн сэдвийн хүрээнд

төрөл бүрийн мэргэжил, чадвартай хүмүүсээр үр дүнтэй багийг бүрдүүлэн, богино цаг хугацаанд шинэ санааг хөгжүүлж асуудлыг оновчтой, бүтээлчээр шийдвэрлэх нэг төрлийн уралдаант үйл ажиллагаа/-ыг зохион байгуулав.

Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 890 сурагчид, МСҮТ-ийн 220 оюутан, сурагчийг хамруулан 6 удаагийн сургалт, 3 хэлэлцүүлэг, 1 өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. Мөн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд жүжигчилсэн тоглолтын уралдааныг амжилттай зохион байгуулсан. Жүжигчилсэн тоглолтоос харахад хууль тогтоомжийг уншиж судалсан байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс гарах арга зам, урьдчилан сэргийлэх чиглэлээр оновчтой агуулгууд тусгасан байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 320 хүүхдийн дунд шударга байдлын үнэлгээ хийж, 13 удаагийн сургалтыг “Ашиг сонирхлын зөрчил, түүнийг зохицуулах хэрэгцээ, үндсэн механизм, шударга ёсонд хэрхэн суралцах вэ?” сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас “Шударга ёс” видео бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын 5-6 дугаар ангийн сурагчдын дунд ба “Авлига ба хүний эрх” гэрэл зургийн уралдааныг гэрэл зураг сонирхогч залуусын дунд тус тус зохион явуулсан бөгөөд дээрх уралдааны зорилго нь хүүхэд залуусын авлигыг харах өнцгийг гэрэл зураг, урлагаар дамжуулан гаргаж ирэх зорилготой байснаараа онцлог байв. (Биелэлт 100 хувь)

4.1.10.3-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар нийтийн албан тушаалтан, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалтыг шинэлэг арга хэлбэрээр үе шаттай зохион явуулах/ АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдснаар соён гэгээрүүлэх ажлыг илүү өргөн хүрээнд зохион байгуулах боломж бүрдсэн. Авлигын эсрэг сургалтыг төрийн байгууллагын хүсэлтээр байгууллага дээр нь очиж мэдээлэл хийх түвшинд хийж байсныг өөрчилж, сэдвийг өргөжүүлэн, практик жишээгээр баяжуулж сургалтад хамрагдагсдыг зорилтот бүлгээр нь ангилан АТГ-ын Олон нийтийн төвд сургалт зохион байгуулах стратегийн дагуу шинэлэг хэлбэрт шилжүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газрын дэргэд Олон нийтийн төвийг 2017 онд нээн ажиллуулж, нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг албан тушаалын ангилал, эрхэлж буй ажил үүргийн онцлогтой нь уялдуулан, сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэн, сургалтыг улирлаар төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. Энэ хүрээнд Олон нийтийн төвд зохион байгуулсан нэг өдрийн хөтөлбөрт сургалтад 2018 онд 8497, 2019 онд 4947, 2020 онд 1019 нийт 14463 төрийн албан хаагчийг хамруулсан. Сургалтыг салбар, мэргэжил, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд тус бүрээр төрөлжүүлэн зохион байгуулсан нь шинэлэг байв. Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2020 онд танхимын сургалтын тоо буурсан байна.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан, тодорхой сэдвээр нэг удаагийн сургалтыг зохион байгуулж 2018 онд 6286, 2019 онд 6381, 2020 онд 6855, нийт 19522 иргэнийг хамруулсан байна.

Авлигын эсрэг сургалтыг зөвхөн нийтийн албан тушаалтнуудад бус оюутан, сурагч, эцэг, эх, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдэд зэрэг зорилтот бүлгүүдэд зориулан үе шаттайгаар зохион байгуулах, нийтийн албан тушаалтанд зориулсан сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулж, зохион байгуулж, холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, 2017 Глоб Интернэшнл төв, “Мэдэх эрхийг хөхиүлэн дэмжих” төслийн хүрээнд “Ус дээшээ урсдаг” олон ангит киног ашиглан авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар кино сургалтыг Азийн сангийн санхүүжилтээр зохион байгуулсан бөгөөд нийслэлийн ЕБС-ийн Ирээдүй цогцолбор сургууль, 23-р сургууль, “Монгени” цогцолбор сургууль, “Хобби” сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчид болон МУИС, Хууль сахиулахын их сургууль, Их засаг Олон улсын их сургуулийн 1, 2-р курсийн нийт 237 оюутан, сурагчид сургалтад хамрагдсан байна. Багшийн хөгжлийн ордонд тус төслийн хаалт “Тусгал” нэртэй туршлага хуваалцах уулзалтыг зохион байгуулж, үр дүнг дүгнэсэн.

Авлигатай тэмцэх газраас хувийн хэвшлийн байгууллагад зориулсан сургалтын хөтөлбөрийг Азийн сан, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран боловсруулж, цуврал сургалтуудыг зохион байгуулсан.

Монголын бизнесийн зөвлөлөөс олон улсын

туршлагыг судалж, хувийн хэвшлийн ажилтнуудад зориулсан онлайн сургалтын хөтөлбөрийг эхлүүлсэн. Түүнчлэн эдгээр сургалтын хөтөлбөрт тулгуурлан хувийн хэвшлийнхэнд зориулсан “Шударга ёс, хөгжил дэвшилд: Хувийн хэвшлийн оролцоо” гарын авлагыг боловсруулан хэвлэж, түгээсэн.

Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах, хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах зорилгоор “Шударга ёс-Иргэний хяналт” сэдэвт, төрийн албаны удирдах албан тушаалтан, худалдан авах алба, хуулийн хэлтэс, санхүү, дотоод хяналт, аудитын албан тушаалтнуудад зориулсан 5 төрлийн 20 сургалтын модулийг боловсрууллаа. Мөн хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчдэд зориулсан гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах сургалтын интерактив модуль бүхий аппликэйшний зохиомжийн төслийг боловсруулсан байдалд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлэв.

Төрийн болон нутгийн захиргааны төв болон тэдгээрийн салбар нэгж байгууллага дээр улсын хэмжээнд нийт 17166 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан ажиллаж байгааг мэргэшүүлэх, чадваржуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр хангаж, “ЭБАТ-тай ярилцах” хөтөлбөрийг боловсруулж, 7 хоног тутмын “Мягмар”, “Пүрэв” гаригуудад онлайн уулзалт, ярилцлагыг хийж, фейсбүүк группээр дамжуулан харилцан мэдлэг, мэдээлэл, туршлага солилцож, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллалаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, Гадаадын иргэн харьяатын газар, нийслэлийн Боловсролын газар, Ашигт малтмал газрын тосны газар, Улаанбаатар хотын Гаалийн газар, Ус сувгийн удирдах газар, Тагнуулын академи, Стандарт, хэмжил зүйн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагын ЭБАТ-ууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар зэргийн нийт 1558 мэдүүлэг гаргагч болон удирдах албан тушаалтанд танхимын сургалт зохион байгуулж, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, мэдээлэл арга зүйгээр арга хангаж ажиллав.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага” номын шинэчилсэн 7 дахь хэвлэл, загвар жишээ бүхий “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ын шинэчилсэн 6 дахь хэвлэлтийг шинэчлэн хэвлүүлж, холбогдох байгууллага, орон нутаг, мэдүүлэг гаргагч нарт түгээсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуультай холбогдуулан 29 тойргийн хорооны дарга болон нарийн бичгийн дарга нийт 160 гаруй албан тушаалтныг хамруулан “Нэр дэвшигчийн ХОМ-ийг цахим системд мэдүүлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, нэр дэвшигчдэд зориулсан гарын авлага боловсруулан түгээв. (Биелэлт 70 хувь)

4.1.10.4-1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас 2019 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулах сургагч багш бэлтгэх хүрээнд Цагдаагийн ерөнхий газартай хамтран цагдаа, дотоодын цэргийн 65 алба хаагчийг сургагч багшаар бэлтгэж гэрчилгээ олгов. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулан “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт бүтэн өдрийн сургалтыг Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохиоу байгуулав. Сургалтад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын 57 албан хаагч хамрагдсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, “Нээлттэй нийгэм форум”-тай хамтран Эрүүгийн хууль тогтоомжийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан байна.

Авлигатай тэмцэх газраас 2020 онд Боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, хууль зүй, сэтгүүл зүй зэрэг зорилтот салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагын удирдлага, гишүүдийг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшаар бэлтгэх, чадваржуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх сургалтыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулав. Сургалтад Боловсролын салбарын Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, Монголын өмгөөлөгчдийн холбоо, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжлийн холбоод, эрүүл мэнд, сэтгүүл зүйн салбарын иргэний нийгмийн байгууллагын удирдлага, гишүүд хамрагдаж,

цахим гарын авлага, сургалтын материалаар хангав. (Биелэлт 100 хувь)

4.1.10.5-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах/ АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг олон улсын академи, "StAR" санаачилга" Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Авлигатай тэмцэх товчоо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны Хээл хахуультай тэмцэх алба зэрэг байгууллагын улсын авлигатай тэмцэх сайн туршлага, оновчтой шийдлийн талаар судлан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тухайлбал, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА) болон тус улсын Прокурорын дээд газраас зохион байгуулсан "Авлигын хэргийг мөрдөн шалгах нь" сэдэвт сургалт, Шри Ланка Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хурал, Франц Улсад Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан уулзалт, Египет Улсын Шарм Эль-Шейх хотод зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон өөрчлөх тухай хэлэлцээрт оролцогч талуудын 6 дугаар хурал, Азербайжан Улсад зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хууль сахиулах сүлжээний уулзалтад, БНСУ-аас Азийн хөгжлийн банк, ЭЗХАХБ-тай хамтран зохион байгуулсан хурал болон "Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага" сэдэвт сургалтад АТГ-ын албан хаагчид тус тус оролцож, харилцан мэдээлэл солилцон, туршлагаа хуваалцсан байна. Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороонд АТГ-ын төлөөлөгчид зочилж, тус хороо, дүүргийн салбар нэгжийн үйл ажиллагаатай танилцан, тэдний сайн туршлагад тулгуурлан нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүд (Дүнжингарав, Саппоро, Оргил, Мишээл) авлигын эсрэг Иргэний хяналтын төвүүдийг байгуулан ажиллаж байна.

"Транспэрэнси Интернэшнл-Бангладеш" олон улсын байгууллагын Иргэдийн хяналт, оролцоо хариуцсан захирал хатагтай Ferhana Ferdous Бангладеш улсад амжилттай хэрэгжиж олон улсад сайшаагдсан авлигын эсрэг иргэдийн бүлэг

байгуулж ажиллуулах туршлагын талаар "Сайн туршлага: Иргэдийн бүлэг" сэдэвт туршлага судлах сургалт зохион байгуулж 89 иргэнийг хамруулсан бөгөөд Авлигатай тэмцэх газраас Бангладеш Улсын эцэг, эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд "Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12 дугаар сургуулийн сурагчид, эцэг, эхчүүдийн шударга байдлыг үнэлэх судалгааны мэдээллийг "Survey monkey" цахим програмд цуглуулан, үр дүнг нэгтгэлээ.

2020 онд "Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга" санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан санаачилга /StAR/-аас "Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй" сэдэвт сургалт, ахисан түвшний сургалт, "Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь" сэдэвт семинар, БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалт, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд "Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монголбанкны албан хаагчдыг хамруулан тус тус зохион байгуулав. (Биелэлт 70 хувь)

**Арван нэг. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11 дүгээр зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 13 арга хэмжээг хэрэгжүүлэв. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.11.1-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Монгол Улсын нэгдсэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны

уялдааг хангах, улмаар Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх арга хэмжээний хүрээнд Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлэг”-ийг 2018 онд зохион байгуулж, холбогдох байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулж, үйл ажиллагааг нь уялдуулах талаар асуудал дэвшүүлсэн ярилцлага өрнүүлэн, санал солилцож, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газартай хамтарч ажиллаж, авлигын хэрэгт холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг нууцын зэрэглэлтэй болон энгийн байдлаар хүлээн авч, конвенцийн дагуу холбогдох улсын эрх бүхий байгууллагад хүргүүлдэг.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг үндэслэл болгож, гадаад улсын эрх бүхий байгууллагад эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг илгээхдээ Хууль зүй, дотоод хэргийн яам болон Улсын ерөнхий прокурорын газар голлох үүргийг гүйцэтгэж байна. 2018 оны байдлаар 2018 онд 4 эрх зүйн туслалцааны хүсэлтийг 7 улс (Англи, Панам, Сингапур, Хонгконг, Австри, Канад, БНХАУ)-д, 2019 оны байдлаар улсын хэмжээнд гадаадын нэр бүхий (Швейцарь, Мэн Арал, ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, Канад, Засаг захиргааны онцгой бүс Хонконг, Франц, Швейцарь, АНУ, Сингапур зэрэг) улсуудад Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг үндэслэл болгосон 26 эрх зүйн туслалцааны 12 хүсэлт хүргүүлжээ.

2020 оны байдлаар 15 эрх зүйн туслалцааны хүсэлтийг БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконг, Британийн Виржинийн арал, Швейцарь, Сингапур, Франц, Солонгос, Америк, Украин, Лавти, Сейшеллийн арлууд, ОХУ, Канад зэрэг улсуудад хүргүүлсэн байна.

Гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний хүрээнд гадаадын эрх бүхий байгууллаас ирүүлсэн 168 эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаварт холбогдох ажиллагааг гүйцэтгэсэн ба Монгол Улс, БНХАУ-ын Хууль зүйн яамдын Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, Ялтан шилжүүлэх тухай асуудлаарх II дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, уулзалтын протоколд гарын үсэг зурсан.

Улсын Ерөнхий прокурорын газраас Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам

хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцааны хүсэлтийг дамжуулах, бүртгэх “Цахим бүртгэл, мэдээллийн сан” бүрдүүлэх, харилцан мэдээлэл солилцох, тайлан, мэдээ гаргах үйл ажиллагааны ил тод, аюулгүй, шуурхай байдлыг хангуулах зорилгоор “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ын төсөл болон холбогдох бүртгэлийн маягтуудын төслийг боловсруулан холбогдох яамдын саналыг авч нэгтгэн, нийт 3 удаагийн хамтарсан уулзалтыг зохион байгуулав. (Биелэлт 100 хувь)

4.1.11.1-2. Гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулах, өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх /ХЗДХЯ, УЕПГ, ГХЯ 2018-2021/

Монгол Улс 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх /16/, Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх /17/, Гэмт этгээд шилжүүлэх /15/, Ялтан шилжүүлэх /9/ асуудлаар 23 улстай 36 гэрээг байгуулсан байна.

2018 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулж, 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон батлав. Мөн “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-г 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан.

2019 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”, “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”, “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-г соёрхон батлав. Мөн “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хоорондын 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ыг Засгийн газрын хуралдаан, холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлэн тус протоколд 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр



сарын 24-ний өдрийн нэгдсэн чуулганаар “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”, “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г, 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн нэгдсэн чуулганаар “Эрүүгийн ял шийтгэлийг гадаад улсад эдлүүлэх тухай Америкийн Улсууд хоорондын конвенц”-ийг тус тус соёрхон баталсан.

Түүнчлэн холбогдох чиглэлээр хоёр талт гэрээ хэлэлцээр байгуулахаас гадна олон улсын конвенцид нэгдэн орох асуудлыг орхигдуулалгүй хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын “Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын Конвенц” болон “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын Конвенц”-д нэгдэн орох чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам ажиллаж байна. Энэхүү конвенцид элссэнээр конвенцид заасан нөхцөлийн дагуу эрүүгийн хариуцлагад татах, шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор хэрэгт холбогдсон этгээдийг шилжүүлэн өгөх, авах эрх зүйн үндэс бий болох юм. Монголын талаас тус конвенцид нэгдэн орохтой холбоотой саналаа Европын зөвлөлийн Нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах саналыг Тайланд, Филиппин Улсад тавьж, төслийг хүргүүлээд байна. Монгол Улсын иргэд олноор зорчдог эдгээр улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулах чиглэлээр ажиллав.

Гадаад улсад илгээх хүсэлтийг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагыг бүрэн хангахуйц, оновчтой, үндэслэлтэй боловсруулах, гадаад улсаас ирүүлсэн хүсэлтийг чанартай гүйцэтгэх ажиллагаанд прокурор, мөрдөгч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг

тус тус боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна.

2019 оны байдлаар Улсын ерөнхий прокурорын газраас эрх зүйн туслалцааны хүсэлт бэлтгэн боловсруулж байгаа прокурор, мөрдөгч нарт тусгайлан анхаарах асуудлуудын талаар тайлбарлах, заавар чиглэл өгөх зэргээр гадаад улсад илгээхээр төлөвлөсөн эрх зүйн туслалцааны 6 хүсэлтэд практик зөвлөмж өгсөн байна.

БНХАУ, Монгол Улсын хооронд 1989 онд байгуулсан “Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэж, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамнаас 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын Хууль Зүйн Яам, Ардын Дээд Прокурорын Газар, Ардын Дээд Шүүхтэй хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах ажиллагаа”-ны талаарх цахим хуралд Улсын Ерөнхий Прокурорын Газраас оролцож, “БНХАУ-д илгээж, хариу ирүүлээгүй хүсэлтийн судалгаа”-г гарган, шийдвэрлүүлэхээр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд хүргүүлсэн. Цахим хурлын үеэр хятадын талаас тус улсад хорих ял эдэлж буй Монгол Улсын 4 иргэнийг ойрын хугацаанд шилжүүлэн өгөхөөр шийдвэрлэсний дагуу Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам, Гадаад Харилцааны Яам, Улсын Дээд Шүүх, Нийслэлийн шүүх, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны Консулын хэлтэс зэрэг байгууллагыг оролцуулан, “Ялтан шилжүүлэх асуудлаарх эрх зүйн зохицуулалт”-ын талаар цахим хурал хийж, хамтран ажилласан байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.1-3. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх / ХЗДХЯ, УЕПГ, 2017-2022/

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр 2018-2019 онд албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Тухайлбал, УЕПГ-аас олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах сургалт, нийслэл, төвийн 6 дүүргийн прокурорын газруудын прокурор, туслах ажилтнуудад “Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, илгээхэд анхаарах асуудал”, “Гэмт этгээдийг шилжүүлэн авах ажиллагаа” сургалт, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас жил бүр Монгол Улсаас гадаад улсад томилогдон ажиллах дипломат ажилтнуудад эрх

зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр тусгай сургалт, 2018 онд олон улсын “StAR” санаачилгын дэмжлэгтэйгээр хуулийн байгууллагуудын албан хаагчдад олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлт, гадаадад хууль бусаар гарсан хөрөнгийг буцаах, мөнгө угаахтай холбоотой сургалтыг тус тус зохион байгуулсан. Авлигатай тэмцэх, мөнгө угаах чиглэлээр 2018 онд Хонг-Конг, Индонези улсад зохион байгуулагдсан «Авлигатай тэмцэх шинэ хандлага» олон улсын семинарт Авлигатай тэмцэх газар болон прокурорын байгууллагын төлөөллийг хамруулав.

Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа хэлэлцүүлэг”-ийг 2018 онд зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар туршлага солилцсон нь хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг болсон.

Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”, аргачлал, зааврын талаар харьяа нэгж прокурорын газруудын хэмжээнд дотоод сургалт зохион байгуулсан.

Улсын ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын хамтын ажиллагааны хүрээнд прокуроруудыг ОХУ-ын Эрхүү хотод жил бүр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаар тохиролцсны дагуу 2019 онд ОХУ-ын Эрхүү муж дахь Прокурорын их сургуульд 5 прокурор, БНХАУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад 30 прокурор тус тус хамрагдсан байна. Дээр дурдсанаас гадна Европын холбооны санхүүжилтээр 2019 онд 6 прокурор Бельги, Нидерланд улсын шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, ажлын туршлага солилцжээ. Улсын ерөнхий прокурорын газар, БНСУ-ын КОЙКА байгууллагын хооронд хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2019 онд БНСУ-ын Хууль зүйн институтэд зохиогдсон “Прокурорын байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” сургалтад 15 прокурор хамрагдсан.

Дэлхийн банкны «StAR» санаачилгын хүрээнд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын мэргэжилтнүүдийн 2019 онд мөнгө угаах, хулгайлагдсан хөрөнгийг буцаах чиглэлээр зохион

байгуулсан сургалтад Нийслэлийн прокурорын газрын 5 прокурор хамрагдсан.

2019 онд Тайландын Вант улсын Бангкок хотод АНУ-ын Хууль сахиулах академиас зохион байгуулсан сургалтад 4 прокурор оролцсон.

“Монгол Улсын ерөнхий прокурорын газар, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ»-гээр Монгол Улсын прокуроруудыг БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын дэргэдэх Эрх зүйн академид жил бүр мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах, хил залгаа муж, аймгийн прокурорын газруудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж буй «Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах» төслийн хүрээнд 2020 оны 9 дүгээр сард “Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж, уг сургалтад цагдаагийн байгууллагын 15 албан хаагч хамрагдсан байна. (Биелэлт 100 хувь)

4.1.11.1-4. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар сүүлийн 2017-2018 жилийн байдлаар нийт Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх мөрдөгчийн даалгаврыг 24 удаа бичиж 12 улсад хүргүүлсэн. Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй 3 улсад 7 мөрдөгчийн хүсэлтийг, Нэгдсэн үндэсний байгууллагын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнуудад болох 9 улс 17 хүсэлтийг хүргүүлж ажилласан. 2018 онд гадаад, дотоодын байгууллагаас ирүүлсэн нийт 174 эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авч зохих ажиллагааг хийсэн.

Эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгавар, бусад материалын орчуулгын зардлын асуудлыг ГХЯ-ны “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”-д тусгуулах саналыг ХЗДХЯ-аас гаргаж, Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас байгуулсан Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газраас төлөөлөл бүхий гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулах үүрэг

бүхий ажлын хэсэг ажил хэргийн уулзалтыг зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байх талаар санал солилцон ажиллаж байна.

Прокурорын байгууллагаас 2020 онд гадаад улсын нутаг дэвсгэрт тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай эрх зүйн туслалцааны 34 хүсэлтийг хүлээн авч, гадаад улсын эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн байна. Харин гадаад улсаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны 20 хүсэлтийг хүлээн авч, 16 хүсэлтийн гүйцэтгэлийг хангаж, хариу хүргүүлсэн байна. Мөн гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг гадаад улсаас шилжүүлэн авах тухай 3 хүсэлт хүргүүлж, гадаад улсаас гэмт этгээдийг шилжүүлэн авах талаар ирүүлсэн 1 хүсэлтийн биелэлтийг ханган, гадаад улсад ял эдэлж буй Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай 7 хүсэлтэд тус прокурорын газраас холбогдох мэдээллийг хүргүүлж, ажилласан.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хэн бичих, орчуулгын зардлыг хэрхэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт тодорхой зохицуулалт байхгүй ба мөн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д "Тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал" гэж заасны дагуу Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэрэгт гадаад улсад тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгавар, түүнтэй холбоотой материалыг орчуулахтай холбоотой зардлыг хамааруулж болохоор байна. Харин гадаад улс орноос эрх зүйн туслалцаа хүсч ирүүлсэн хүсэлт, даалгавар, холбогдох материалыг орчуулах, уг хүсэлт, даалгаврыг биелүүлэх хүрээнд цуглуулж бэхжүүлсэн баримт, материал, тэдгээрийг буцаан хүргүүлэхтэй холбоотой зардлыг тооцох, санхүүжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт байхгүй, тус зардал Прокурорын байгууллагын төсөвт тусгагддаггүй байна. Практикт уг зардлыг даалгавар, хүсэлтийг гүйцэтгэж буй мөрдөн шалгах байгууллагаас гаргуулж байгаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй, хүндрэлтэй асуудал болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар прокурор, мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж цуглуулсан баримтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол үүсээгүй, гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх

нөхцөл байдал тогтоогдсон, яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой тохиолдолд хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэх, мөрдөгчийн томилсон шинжээчийн дүгнэлт тодорхойгүй, бүрэн биш, эсхүл шинжилгээтэй холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд нэмэлт шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох тогтоол үйлдэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж дууссан хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулан өгч, хэргийг шүүхэд шилжүүлэх зэрэг ажиллагааг явуулахаар зохицуулсан. Хуулийн энэхүү заалтын хүрээнд гадаад улсын иргэн холбогдсон хэргүүдэд прокуророос гаргах шийдвэрийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу яллагдагчийн эх хэл дээр орчуулан өгөх шаардлага үүсч байна. Тухайлбал: Нийслэлийн прокурорын газраас 2020 онд хяналт тавьсан гадаадын иргэдийн холбогдсон 1 хэрэгт үйлдсэн прокурорын яллах дүгнэлтийг орчуулахад ойролцоогоор 5 сая орчим төгрөгийн зардал, тус онд нийтдээ гадаадын иргэнд холбогдох хэрэгт үйлдсэн прокурорын яллах дүгнэлт, эрх зүйн туслалцааны хүсэлт, эдийн засгийн болон хүрээлэн буй байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтоолох зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд нийт 80 гаруй сая төгрөгийн зардал гарчээ.

Харин 2020 онд тус прокурорын газрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд 5 сая төгрөг төсөвлөгдсөн байна. Прокурорын байгууллагын 2021 оны төсөвт байцаан шийтгэх ажиллагааны зардалд нийт 498.9 сая төгрөгийг төсөвлөж, баталсан. Прокурорын байгууллагаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын төсвийг бодитой тооцож, төлөвлөхөөр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.2-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг боловсруулж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэн, тайланг хамгаалж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх /АТГ, ХЗДХЯ, УЕПГ, СЯ, ГХЯ, ТАЗ, Монголбанк 2017-2022/

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг гаргахдаа тухайн гишүүн улс өөрийн үнэлгээний тайланг гаргаж, түүний хүрээнд томилогдсон гишүүн улсуудын шинжээчдээр эцсийн үнэлгээг гүйцэтгүүлдэг. Үнэлгээ хийх улс болон үнэлгээнд хамрагдах Конвенцийн хэсэг,

бүлгийг урьдчилан төлөвлөж, хуваарилсан байдаг.

Монгол Улсын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг хуваарийн дагуу тайлагнаж, үнэлгээ хийлгүүлэх зорилгоор Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийг тайлагнах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, тус Конвенцийн 2, 5 дугаар бүлгийн заалт тус бүрээр тайлан боловсруулж, 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлсэн бөгөөд тайланд Монгол Улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр нэмэлт оруулан ажиллаж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 2, 5 дугаар бүлгийг үнэлэх ажлын хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдөр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас энэхүү үнэлгээний ажлын зохион байгуулалтын асуудлыг хариуцсан ажилтан Бадр Эл Банна, Юта Миагишими болон Сингапур, Буркино Фасо Улсын шинжээчидтэй цахим уулзалт хийж. Конвенцийн үнэлгээ хийх хэл, үнэлгээ хийх хугацаа, үнэлгээ хийх ажил үүргийн хуваарь, үнэлгээ явуулах газрын талаар талууд харилцан мэдээлэл солилцов. Конвенцийн 2 дугаар бүлгийг Буркино Фасо Улс франц хэл дээр, 5 дугаар бүлгийг Сингапур Улс англи хэл дээр хариуцан хэрэгжилтэд үнэлгээ хийхээр болсон. Үнэлгээг 2020 оны 2 дугаар улиралд зохион байгуулахаар талууд тохирсон боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.

Энэ хугацаанд тус конвенцийн үнэлгээний тайлангийн төсөлд Монгол Улсын авлигын эсрэг орчин, хууль тогтоомж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, шинэлэг асуудлуудыг бэлтгэн тусгаж байна. Энэхүү тайлангийн төслийг эцэслэж, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд илгээснээр тайланг хамгаалах хугацааг талууд дахин тохиролцох юм. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны энэхүү үнэлгээний ажлын зохион байгуулалтын асуудлыг хариуцсан зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг НҮБ-аас тогтоосон журам, үнэлгээний механизмын дагуу үнэлнэ. (Биелэлт 70 хувь)

4.1.11.2-2. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Авлигатай тэмцэх үйл ажиллагааны Станбулын төлөвлөгөөний тайланг гаргаж хүргүүлэх, тайлагнах, хамгаалах /АТГ 2017-2022/

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнуудад явуулж буй авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийх зорилгоор 2003 онд байгуулагдсан. Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014 онд тус байгууллагын Үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд анх удаа үнэлгээ хийсэн. Үнэлгээний цар хүрээ нь авлигатай тэмцэх байгууллага, худалдан авах ажиллагаа, санхүүгийн дотоод хяналт шалгалт, дотоод аудит, шүүх, прокурорын байгууллага, хувийн хэвшил зэрэг байгууллагуудтай холбоотой үйл ажиллагаа, эрх зүйн орчноос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх асуудлуудыг хамарсан. Авлигатай тэмцэх газраас 2017 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх Монгол Улсын холбогдох тайлан мэдээллийг бэлтгэн, урьдчилсан хамгаалалт хийсэн.

Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг төлөвлөгөөний 2016-2020 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын талаарх явцын мэдээллийг Авлигатай тэмцэх газар жил бүр бэлтгэн тус байгууллагад заасан хугацаанд хүргүүлж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг үнэлэх ээлжит ажил 2018 оны 8 дугаар сард эхэлж, 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр тус байгууллагын Шинжээчдийн багаас мониторингийн ажилд шаардлагатай нэмэлт мэдээллийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газарт ирүүлж, Авлигатай тэмцэх газар төрийн болон төрийн бус 13 байгууллагаас холбогдох мэдээллийг нэгтгэн авч, тус байгууллагад хариу илгээсэн болно. Тус сүлжээнээс 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Парис хотод гишүүн улсуудын төлөөллийг оролцуулсан Удирдах зөвлөлийн уулзалтыг зохион байгуулж, энэхүү

хуралд Монгол Улсын төлөөлж, Сангийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Трансперэнси Интернэшнл-Монгол ТББ-ын нийт 6 төлөөлөгч оролцон, Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн багаас үнэлгээний тайлангийн талаар танилцуулж, талууд харилцан санал солилцсоны дараа Монгол Улсын авлигын эсрэг орчны үнэлгээний тайланг тус сүлжээнээс эцэслэн баталж, Монгол Улсын Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт албан бичгээр ирүүлсэн. Монгол Улсын авлигын эсрэг орчинд хийсэн мониторингийн тайланг баталсны мөрөөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний зөвлөхүүд 2019 оны 7 дугаар сарын 29, 30-ны өдөр Монгол Улсад ажиллаж, мониторингийн тайлан, зөвлөмжийг олон нийт болон төрийн байгууллагуудад танилцуулах, хэвлэлийн бага хурал хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.

Тус сүлжээ нь 2020-2024 онд гишүүн орнуудын авлигын эсрэг орчныг үнэлэхдээ шинэ аргачлал, шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөхөөр болсон бөгөөд энэхүү шинэ аргачлалын дагуу Монгол Улсын авлигатай тэмцэх бодлого, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой хуулийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилт, шүгэл үлээгчийг хамгаалах, шүүх байгууллагын хараат бус байдал зэрэг 13 шалгуур үзүүлэлтээр Монгол Улсын авлигын эсрэг орчныг 2022 онд үнэлэх юм. 2021 онд Армени улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, тогтолцоог тус шинэ аргачлалаар үнэлэхэд Авлигатай тэмцэх газрын төлөөлөгч ажиглагчаар оролцож байна.

2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Авлигын эсрэг сүлжээний гишүүн орнуудын Үндэсний зохицуулагч нарын цахим хурал хийсэн ба энэ хуралд Авлигатай тэмцэх газрын төлөөлөгч нарын оролцож, Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсын авлигын эсрэг үйл ажиллагаанд гарч байгаа өөрчлөлт, онцгой нөхцөлд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тус газрын төсөв санхүү, тэргүүлэх чиглэлд гарсан өөрчлөлтүүдийн талаар бусад оролцогчдод мэдээлэл өгсөн.

2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Авлигын эсрэг сүлжээний 25 дахь удаагийн Удирдах зөвлөлийн уулзалт болж, энэхүү цахим хуралд тус байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Нарийн бичгийн даргын газар, тус Сүлжээний гишүүн орнууд, донор байгууллагын 95 төлөөлөгч оролцсон. Хурлын хөтөлбөрийн дагуу Авлигын эсрэг сүлжээний гишүүн улсуудын авлигын эсрэг орчинд хийх үнэлгээний дараагийн үе шатны талаар оролцогч талууд санал солилцов. Хурлын

үеэр гишүүн улсуудын авлигын эсрэг орчинд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг оролцогч нар эцэслэн баталсан.

Авлигатай тэмцэх газар нь тус сүлжээний авлигын эсрэг асуудлаар өгсөн иж бүрэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нэр бүхий 15 төрийн байгууллагад 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдөд зөвлөмжийн хувийг хүргүүлж, хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. (Биелэлт 100 хувь)

4.1.11.2-3. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран төсөл хэрэгжүүлэх /АТГ 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн банкны «Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга» (StAR)-тай хамтран 2019 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон зарим төрийн байгууллагын эрх бүхий албан хаагчдыг хамруулан хөрөнгө царцаах, хураах, хөрөнгө буцаах, олон улсын хамтын ажиллагаа, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны ахисан түвшний арга хэрэгслүүд зэрэг сэдвээр “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт”-ыг, 2019 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.

2020 оны 4, 5 дугаар сард “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны арга зүй” сэдэвт ахисан түвшний цахим сургалтыг 3 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, Авлигатай тэмцэх газрын 18 мөрдөгчийг хамруулав.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн банкны «Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга» (StAR)-аас Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтсийн нийт мөрдөгчдөд зориулан “Гадаад улсын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системээс мэдээлэл авах нь” сэдэвт семинарыг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд түвшний 10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн

ерөнхий газрын холбогдох 33 албан хаагчийг хамруулсан.(Биелэлт 100 хувь)

4.1.11.2-4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай сургалт, семинар зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллах /АТГ, 2017-2022/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2017 онд зохион байгуулсан Австри Улсад болсон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалт, БНХАУ-ын Хонг Конг мужид зохион байгуулагдсан “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Гүрж улсад зохион байгуулагдсан “Авлигын эсрэг сургалт”, 5 сарын 8-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь” сэдэвт сургалт, 2017 оны 9 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалтыг тус тус хамтран зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалт зохион байгуулж, хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын 35 албан хаагчдыг хамруулсан. Мөн тус байгууллагын “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг Монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад түгээв.

2019 оны 5 дугаар сард Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Цахим мөнгөн тэмдэгийг ашиглан гэмт хэрэг үйлдэх явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалт, 2019 оны 10 дугаар сард “Авлигын гэмт хэргийг шийдвэрлэх туршлага солилцох нь” сэдэвт семинар зохион байгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.11.3-1. Гадаад улсын авлигатай тэмцэх, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, санамж бичиг байгуулах, харилцан туршлага судлах, солилцох ажлыг зохион байгуулах /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2019-2020/

БНХАУ-ын НАХЯ-тай 2011 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2017-2021 онд хамтран ажиллах үйл ажиллагааны хөтөлбөр, ОХУ-ын ДХЯ-тай хамтран ажиллах тухай 2017 оны хэлэлцээрийн хүрээнд 2020 он хүртэл олон улсад гэмт хэрэгтэй тэмцэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хамтран ажиллах протоколыг байгуулан ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газар 2016-2019 оны хооронд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт

хэрэгтэй тэмцэх алба, Авлигын эсрэг олон улсын академи, Авлигатай тэмцэх байгууллагуудын олон улсын холбоо, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох “StAR” санаачилга, ЭЗХАХБ, ЕАБХАБ, Ази, номхон далайн орнуудын хулгайлагдсан хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департамент, Холбооны мөрдөх товчоо, Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, Азербайжан Улсын Авлигын эсрэг газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцаагаа өргөжүүлэн, хөгжүүлж байна.

Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийн гишүүнийнхээ хувьд олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж, гишүүн орнуудын албан хаагчид тус академийн сургалтад хамрагдаж байна.

“StAR” санаачилгатай хамтран санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах анхан шатны сургалт, прокурорын байгууллага, хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын дундах уулзалт, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран УЕПГ, АТГ, ТЕГ, ЦЕГ, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны албан хаагчдыг оролцуулж “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын байгууллагын “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг Монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад түгээсэн.

Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департаментын Олон улсын хамтын ажиллагааны газар, Холбооны мөрдөх товчооны олон улсын ажиллагааны албаны төлөөлөлтэй уулзалт хийж, эрүүгийн хэрэг хамтран мөрдөн шалгаж, харилцан ашигтай мэдээлэл солилцож байна.

Түүнчлэн, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, Азербайжан Улсын Авлигын эсрэг газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

2019 оны 07 дугаар сард Монгол Улсын ерөнхий прокурорын газрын албаны төлөөлөгчид ОХУ-ын

Ерөнхий прокурорын газарт ажлын айлчлал хийж, “Монгол Улсын ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын 2020-2021 оны хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг харилцан гарын үсэг зурж, батлав. 2019 оны 11 дүгээр сард БНХАУ-д ажлын айлчлал хийж, “Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар, БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын Газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ»-г байгуулав.

“Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яамны харьяа Хорих байгууллагын удирдах газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”; “Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Бүгд Найрамдах Беларусь Улсын Шүүхийн шинжилгээний улсын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг тус тус байгуулсан.

ОХУ-ын Москва хотод 2019 онд зохион байгуулагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Евроазийн бүсийн байгууллагын 30 дахь удаагийн хуралд Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөл оролцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ажиллагааны хэв шинж, эдгээр гэмт хэргийг илрүүлэхэд учирч байгаа бэрхшээлийн талаар бусад улсын прокуроруудтай санал солилцож, туршлага судалсан байна.

Улсын Ерөнхий прокурорын газраас 2020 онд гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийн талаар мэдээлэл солилцох, техникийн туслалцаа үзүүлэх Ази, Номхон далайн орнуудын сүлжээ байгууллага болох «ARIN-AP», мөн Eurojust буюу Европын Холбооны Эрүүгийн шүүхийн системийн хамтын ажиллагааны байгууллагад бүртгүүлэн, хууль бусаар олсон хөрөнгийг хураан авах ажиллагаатай холбоотой дотоодын хууль тогтоомж, тогтолцооны талаар мэдээлэл солилцож ажилласан. Мөн сүүлийн 2 жилийн хугацаанд мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хэргүүдэд Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт”-д багтсан оффшор бүсэд хамаарах 6 улсын эрх бүхий байгууллагуудад эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа хүссэн 13 хүсэлтийг хүргүүлж,

хамтран ажилласан.

ЕАБХАБ-ын Ардчилсан институц, хүний эрхийн албаны Сонгуулийн асуудал эрхэлсэн газрын дэд захирал Улви Ахундлу, зөвлөх Кеара Касталдо нарын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн манай улсад хийсэн ажлын айлчлалын үеэр Авлигатай тэмцэх газрын төлөөлөл уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны 2020 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн авлигын эрсдэлийг бууруулах, хариуцлагатай, шударга дэд бүтцийг “Бүс ба зам” санаачилгыг дэмжигч улсуудад бий болгох зорилготой Тогтвортой хөгжлийг хангах, Авлигын эсрэг конвенцийн хэрэгжилтийг дэмжих, “Бүс ба зам” санаачилгын төсөлд манай улс 2020 оны 3 дугаар улирлаас эхлэн хамрагдаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.11.3-2. Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2018/

Гадаад улсад хөрөнгө буцаан авах чиглэлээр илгээх хүсэлтийг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагыг хангахуйц, оновчтой, үндэслэлтэй боловсруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар», “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг тус тус боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.11.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэх тухай дотоодын хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох /ХЗДХЯ, УЕПГ, АТГ 2018-2022/

Гадаад улстай гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэх талаар хамтран ажиллах чиглэлээр дотоодын хууль тогтоомж, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоход

анхаарч, Улсын ерөнхий прокурорын газраас “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”-ыг боловсруулж, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, прокуроруудын үйл ажиллагаанд мөрдүүлж байна.

Мөн 2020 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ын төслийг боловсруулж, Гадаад харилцааны яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамны саналыг авсан ба хамтарсан уулзалтыг 3 удаа зохион байгуулав. Уг журмын төслийн эцсийн хэлэлцүүлгийг 2021 онд зохион байгуулж, батлуулахаар ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.11.5-1. Олон улсын авлигын эсрэг холбоо, сүлжээ, санаачилгуудыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Олон улсад авлигатай тэмцэх чиглэлээр өрнөж буй үйл ажиллагааг судлан гадаад мэдээний тоймыг бэлтгэж, олон нийтэд мэдээлж хэвшсэн. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй Авлигын эсрэг сургалтын агуулгад гадаад улсын сайн туршлагаудыг оруулан танилцуулга мэдээлэл өгч байна.

Дэлхийн банк, Нэгдсэн үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан хурал, сургалтад албан хаагчдыг тогтмол оролцуулан мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн. Ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаар ажил хэргийн уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийн 7 дугаар зүйлд авлигатай тэмцэх асуудлаар АНУ-тай хамтран ажиллах эрх зүйн хүрээг тодорхойлж, хэлэлцээр 2017 оны 3 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болсон. Хэлэлцээрийн

дагуу олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт дахь авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэх санал санаачилгыг урамшуулан дэмжих талаар АНУ-тай хамтран ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай 2013 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд олон удаагийн, үе шат бүхий сургалтыг тус Санаачилгатай хамтран төлөвлөж, зохион байгуулж байна. Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон зарим төрийн байгууллагын эрх бүхий албан хаагчид хамруулан тус Санаачилгын сургагч багш нартай хамтран “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалт”, “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулжээ.

2018 онд Индонези улсын Бали хотод зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хурлаас Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, тус Сүлжээний Бүгд хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах эрхийг авч, 2019 онд даргалагч улсаар томилогдон 2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн хурал, Бүгд хурал болон Австрали Улсын Дотоод хэргийн яамтай хамтран хөрөнгө буцаан авах чиглэлээр олон улсын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Тус арга хэмжээнүүдэд гадаадын гишүүн 24 улс, 5 олон улсын байгууллагын 70, дотоодын 7 хууль сахиулах байгууллагын 56 төлөөлөгч буюу нийт 126 оролцогч хамрагдсан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн баг Монгол Улсын авлигын эсрэг орчныг үнэлж, 2019 оны 3 дугаар 22-ны өдөр тайланг эцэслэн баталсан байна. Энэхүү тайланд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, прокурор, шүүх, хууль сахиулах байгууллагуудын хараат бус байдал, худалдан авах ажиллагааны ил тод байдал, нийтийн алба болон төрийн улс төрийн албан тушаалтны шударга байдал, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, бизнесийн шударга байдал зэрэг сэдвийн хүрээнд 29 хэсэг бүхий 153 зүйл зөвлөмжийг Монгол Улсад өгсөн байна. Авлигатай тэмцэх газраас уг үнэлгээний



ажлыг зохион байгуулахад анхнаас нь оролцож, тайлан гарсны дараа зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2020 оны 1 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-тай хамтран Монгол улсад ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн 7 дугаар хэсгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр, хууль бус мөнгийг илрүүлэх арга” санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны сургалтыг АТГ, ТЕГ, ЦЕГ, ХСИС, УЕПГ, Монгол банкны холбогдох алба хаагчдыг хамруулан зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газар болон Гадаад харилцааны яамнаас Авлигын эсрэг олон улсын академийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд 2020 оны 11 дүгээр сард болсон Оролцогч талуудын Ассамблейн 9 дүгээр чуулганд оролцсон бөгөөд тус чуулганаар Академийн үйл ажиллагааны дунд хугацааны 2021-2024 оны хөтөлбөр болон Академийн 2021 оны хөтөлбөрийг баталсан. (Биелэлт 70 хувь)

4.1.11.5-2. Олон улсын туршлага судлах, чадавхи бэхжүүлэх, үнэлгээ мониторингийн чиглэлээр олон улсын сүлжээ, санаачилгад идэвхтэй оролцох /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Мянган хөгжлийн сангийн Хоёрдугаар компакт гэрээний Монгол Улсын авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд АНУ-ын Элчин сайдын яамны урилгаар Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг тус улсад 2018 оны 3 дугаар сард туршлага судлах сургалтад хамрагдан, авлигатай тэмцэх чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзалт хийж, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай нь танилцан, төрийн байгууллага, төрийн албан тушаалтны үйл ажиллагаан дахь иргэдийн хяналт, оролцооны талаарх туршлагыг судлан, байгууллагууд хоорондын цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна.

2018 онд Бүгд Найрамдах Киргиз Улсын “Станбулын Авлигын эсрэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөх олон улсын шинжээчдийн багт Авлигатай тэмцэх газрын албан хаагч томилогдон ажиллаж, Киргиз Улсын нөхцөл байдлыг үнэлэн тайлан бэлтгэж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад хүргүүлэв. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас томилсон Словени Улсын Конвенцийн хэрэгжилтийн тайланг үнэлэх шинжээчдийн багт Монгол Улсын төлөөлөгчид

ажиллан тайланг хянаж баталгуулан, зөвлөмж хүргүүлэв.

Монгол Улс нь Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнуудад явуулж буй авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийдэг Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орж, үнэлгээ хийлгэж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний шинжээчдийн баг Монгол Улсын авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг 2014, 2018 онд үнэлж, тайланг эцэслэн баталж, Монгол Улсын Ерөнхий сайд, Авлигатай тэмцэх газрын дарга нарт ирүүлсэн. Энэхүү тайланд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, прокурор, шүүх, хууль сахиулах байгууллагуудын хараат бус байдал, худалдан авах ажиллагааны ил тод байдал, нийтийн алба болон төрийн улс төрийн албан тушаалтны шударга байдал, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, бизнесийн шударга байдал зэрэг сэдвийн хүрээнд 29 хэсэг бүхий 153 зүйл зөвлөмжийг Монгол Улсад өгсөн байна. Авлигатай тэмцэх газраас уг үнэлгээний ажлыг зохион байгуулахад анхнаас нь оролцож, тайлан гарсны дараа зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна. Мөн манай улс тус сүлжээний “Хууль сахиулагчдын сүлжээ”-ний гишүүн бөгөөд Авлигатай тэмцэх газрын 2, УЕПГ-ийн 1 албан хаагч төлөөлөн ажиллаж, гишүүн улсуудын ижил чиг үүрэгтэй байгуулагатай мэдээлэл солилцон ажиллаж байна.

АТГ-аас 2017 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх Монгол Улсын холбогдох тайлан мэдээллийг бэлтгэн, урьдчилсан хамгаалалт хийсэн тус байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг төлөвлөгөөний 2016-2020 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын талаарх явцын мэдээллийг жил бүр бэлтгэн тус байгууллагад заасан хугацаанд хүргүүлж байна.

2019 онд Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг газрын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн албан ёсны айлчлал, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны төлөөлөгчдийн айлчлал, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулж, харилцан туршлага солилцов.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конг мужийн Авлигатай тэмцэх бие даасан хороо

байгуулагдсаны 45 жилийн ойн арга хэмжээ, Бүгд Найрамдах Казакстан Улсын Авлигын эсрэг агентлагаас зохион байгуулсан арга хэмжээнд Авлигатай тэмцэх газрын албан хаагчид болон Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо. Олон улсын байгууллагаас Монгол Улсад зохион байгуулсан сургалтад 90 албан хаагч, гадаад улс оронд зохион байгуулагдсан сургалтад 19 албан хаагчийг суралцуулж, чадавхжуулав.

2019 онд БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг Конг мужийн Авлигатай тэмцэх бие даасан хороонд туршлага солилцох сургалт, уулзалтад 9 алба хаагчийг, 7 хоногийн эрчимжүүлсэн сургалтад 10 мөрдөгчийг, Тайваний Тайпей хотод зохион байгуулагдсан Америкийн Нэгдсэн Улсын Холбооны мөрдөх товчооны академийг төгсөгчдийн холбооны бүс нутгийн давтан сургалтад 1 албан хаагчийг хамруулав.

Нидерландын Вант Улсын Гаг хотод зохион байгуулагдсан Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээнүүдийн нэгдсэн хурал, Австрелийн Холбооны Улсын Канберра хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хурал, Тайландын Вант Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн уулзалт, Ази, Номхон далайн бүс нутгийн Авлигын эсрэг санаачилгын Нарийн бичгийн дарга нарын газраас Вьетнам улсын Ханой хотноо Авлигын эсрэг бүс нутгийн хуралд албан хаагчид оролцож, Монгол Улсын авлигатай тэмцэх чиглэлээр гарч буй ололт амжилт, хүндрэл бэрхшээл зэрэг асуудлаар санал солилцож, туршлагаа хуваалцсан.

“Транспэрэнси Интернэшнл-Монгол” олон улсын байгууллагатай хамтран олон улсад сайшаагдсан авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийг оролцуулдаг туршлагаар “Сайн

туршлага: Иргэдийн бүлэг” сэдэвт сургалтыг 2019 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод иргэд, сургуулиудын эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл, “Глоб интернэшнл”, “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан”, “Зориг сан”, “Хүний эрх хөгжил төв”, “Нээлттэй нийгэм форум”, “Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг” “Монголын залуучуудын холбоо” зэрэг ТББ, оюутнууд зэрэг 89 иргэнийг хамруулан зохион байгуулав. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлэх “Монгол улсын Засгийн газарт олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Азийн хөгжлийн банк хамтран 2018 оны 12 дугаар сараас 2 жилийн хугацаатай “Монгол Улс: Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байна.

2020 оны 9 дүгээр сард БНСУ-ын Авлигын эсрэг болон Иргэний эрхийн хорооноос санаачлан зохион байгуулсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар хэсгүүдэд чиглэгдсэн тэтгэлэгт сургалтад Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжийн албан хаагчдыг суралцуулав. Тус хорооноос 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Олон улсын авлигын эсрэг салбарын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт”-д Авлигатай тэмцэх газрын 6 албан хаагчийг хамруулав. Мөн БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Авлигын эсрэг бие даасан хороотой хамтран ажиллах хүрээнд “Санхүүгийн хэмнэлттэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулав. 2021 онд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас үүсгэн байгуулж буй “Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны дэлхий нийтийн сүлжээ” (GlobE)-нд Авлигатай тэмцэх газар гишүүнээр нэгдэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. (Биелэлт 100 хувь)

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН МЭДЭЭ (2020 ОН)

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан билээ. Үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” явдал бөгөөд уг зорилгод хүрэхээр 11 зорилтыг дэвшүүлж, 83 үйл ажиллагааг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Авлигатай тэмцэх газар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг олон арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэн, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн дүгнэх ажлыг гүйцэтгэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 216 арга хэмжээний гүйцэтгэл 2020 онд 68,7 хувьтай үнэлэгдсэн нь 2019 оны үнэлгээ(58.8)-нээс 9,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тайлан, тэдгээртэй холбоотой баримт бичгүүд, үр дүнг нотлох холбогдох материалуудыг ашиглан гүйцэтгэсэн. Үйл ажиллагаа, арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөхдөө:


**“Төлөвлөсөн үр дүнд хүрсэн”** – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн, зохион байгуулалт сайн, бодит үр дүн гарсан бол 100 хувь (90 – 100 хүртэл хувь);

**“Тодорхой үр дүнд хүрсэн”** – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарсан, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (50 – 89 хүртэл хувь);

**“Эрчимжүүлэх шаардлагатай”** – зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ хүрээгүй боловч тодорхой үр дүн гарах нөхцөл бүрдсэн, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 30 хувь (10 – 49 хүртэл хувь);

**“Үр дүн хангалтгүй”** – зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан боловч шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0 – 9 хүртэл хувь) байхаар тооцсон болно.

АТҮХ-ийн хэрэгжилт зорилтуудын үнэлгээний дундаж 2020 он



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2020 ОНЫ БИЕЛЭЛТ  
(СТАТИСТИК МЭДЭЭ)**

№	Хөтөлбөрийн зорилт	Үйл ажиллагаа	Нийт арга хэмжээний	Хэрэгжилтийн үнэлгээ				Дундаж хувь
				100	70	30	0	
1	Зорилт №1.	10	26	20	6	0	0	93.1
2	Зорилт №2.	7	18	6	10	2	0	75.6
3	Зорилт №3.	10	35	9	20	5	1	70.0
4	Зорилт №4.	5	15	9	1	3	2	70.7
5	Зорилт №5.	17	34	7	25	2	0	73.8
6	Зорилт №6.	5	21	3	8	6	4	57.8
7	Зорилт №7.	6	18	5	8	5	0	67.2
8	Зорилт №8.	5	9	0	4	5	0	47.8
9	Зорилт №9.	8	17	3	3	8	3	44.1
10	Зорилт №10.	5	10	3	6	1	0	75.0
11	Зорилт №11.	5	13	6	6	1	0	80.8
<b>Нийт</b>		<b>83</b>	<b>216</b>	<b>71</b>	<b>97</b>	<b>38</b>	<b>10</b>	<b>68.7</b>

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**



# 110

Гомдол, мэдээлэл хүлээн авах  
утас /үнэ төлбөргүй/

*Мударга ёс,  
хөгжил дэвшилд*



**МОНГОЛ УЛС АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

5-р хороолол, Сөүлийн гудамж 41, Улаанбаатар хот 14250



**+976 7011 2474, 110**



**www.iaac.mn**



**АТГ-Олон нийтийн төв**



**АТГ-Олон нийтийн төв**